



## ХОЛБОО БАРИХ АЛБАН ТУШААЛТАН

С.МАГНАЙСҮРЭН

Албан тушаал: Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Емэйл хаяг: [magnaisuren@mcud.gov.mn](mailto:magnaisuren@mcud.gov.mn)

Утас: +976-320528, +976-88110971

Ц. БАЯРБАТ

Албан тушаал: Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Емэйл хаяг: [bayarbat@mcud.gov.mn](mailto:bayarbat@mcud.gov.mn)

Утас: +976-76003333, +976-99172040

Веб сайт: <https://mcud.gov.mn/>

Facebook: <https://www.facebook.com/Barilgiinyam>

## ӨМНӨХ ҮГ



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2016 оны тогтоолоор “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ын хэрэгжилтийг хот байгуулалтын бодлогоор дэмжих “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг баталж, НҮБ-ын гишүүн улсууд энэхүү хөтөлбөрийг үр дүнтэй, цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, ахиц дэвшлийг хянах, үр дүн, хэрэгжилтийн явцыг 4 жил тутамд тайлагнах үүрэг хүлээсэн. Монгол Улс гишүүн улсын үүргээ биелүүлж, 2017-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангаа ийнхүү өргөн барьж байна.

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн өмнөх хөтөлбөрүүд болох Хабитат 1, Хабитат 2-ын хэрэгжилтийн тайланг Монгол Улс 1996, 2016 онд НҮБ-ын Хабитат байгууллагад хүргүүлж байсан бөгөөд дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн хүрээнд НҮБ-ын Хабитатаас зохион байгуулсан “Дэлхийн хотуудын чуулган”, олон улс, бүс нутгийн холбогдох хурал, уулзалт, арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэйгөөр идэвхтэй оролцож, “Хот байгуулалтын үндэсний форум”-ыг 2012 оноос эхлэн хоёр жил тутамд зохион байгуулж, олон төсөл, хөтөлбөр, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж ирсэн түүхтэй билээ.

2016-2036 онд хэрэгжих хот байгуулалтын 20 жилийн бодлого болох “Хотжилтын шинэ хөтөлбөр” нь манай улсын хувьд “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ыг хот байгуулалтын бодлогоор дэмжин хэрэгжүүлэхэд гол чиглэл, үзэл баримтлал болж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын хот байгуулалтын бодлогын баримт бичгүүдэд тухайлбал, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, нийслэл “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулах, “Түрээсийн орон сууц” хөтөлбөр, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, дахин зохион байгуулах, ногоон байгууламж, нийтийн зориулалттай зам, талбайг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг чиглэл болгож байна.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт “Шинэ Зуунмод” хотыг байгуулах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулахаар тусгасан бөгөөд “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн зорилтуудыг бүтээн байгуулалтын үйл ажиллагаандаа тусгаж, олон нийтийн оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлэхээр зорьж байна.

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын Хабитатын Монгол Улс дахь салбар, мөн энэхүү тайланг бэлтгэхэд идэвхтэй оролцсон төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэмтэн, судлаачид, ажлын хэсэг болон зөвлөх багийн гишүүдэд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД

Б.МӨНХБААТАР

# АГУУЛГА

ХОЛБОО БАРИХ АЛБАН ТУШААЛТАН.....	1
ӨМНӨХ ҮГ .....	2
АГУУЛГА.....	3
ГРАФИК.....	6
ЗУРАГ .....	7
ХҮСНЭГТ .....	8
ТОВЧИЛСОН ҮГ.....	9
ХУРААНГУЙ .....	12
ОРШИЛ.....	12
ОРОЛЦОГЧ ТАЛУУД БА ХАМТЫН АЖИЛЛАГАА.....	14
КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19) ЦАР ТАХЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ .....	14
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД.....	15
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОТ, СУУРИНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ТАЛААР ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ .....</b>	<b>16</b>
<b>1.1.НИЙГМИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ТОГТВОРТОЙ ХОТ БАЙГУУЛАЛТ БА ЯДУУРЛЫГ ҮГҮЙ БОЛГОХ .....</b>	<b>16</b>
1.1.1.Нийгмийн оролцоог хангах ба ядуурлыг үгүй болгох .....	16
1.1.1.1.Ядуурлын бүхий л төрлийг арилгах .....	16
1.1.1.2.Боломж, үр ашгийг тэгш хүртэхийг дэмжих замаар хот, суурин газар дахь тэгш бус байдлыг бууруулах.....	19
1.1.1.3.Эмзэг бүлгийн нийгмийн оролцоог хангах (эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшсан иргэд) .....	22
1.1.1.4.Гудамж, явган хүний зам, унадаг дугуйн зам зэрэг нийтийн эзэмшлийн орон зайг ашиглах боломжийг бататгах .....	28
1.1.2.Шаардлага хангасан орон сууцны хүртээмж .....	32
1.1.2.1.Шаардлага хангасан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах.....	32
1.1.2.2.Орон сууцны тогтвортой санхүүжилтийн хувилбаруудыг бий болгох.....	36
1.1.2.3.Эзэмших эрхийн баталгааг бий болгох.....	38
1.1.2.4.Борчуудын хорооллыг өөрчлөх хөтөлбөрүүдийг эхлүүлэх.....	41
1.1.3.Суурь үйлчилгээний хүртээмж.....	45
1.1.3.1.Баталгаатай ундны ус, эрүүл ахуй, хатуу хог хаягдлын зайлуулах нөхцөлөөр хангах .....	45
1.1.3.2.Аюулгүй, шуурхай нийтийн тээврийн системээр баталгаатай хангах .....	48
1.1.3.3.Орчин үеийн сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжоор хангах.....	50
<b>1.2.НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ХОТЫН ХӨГЖИЛ БА БОЛОМЖ.....</b>	<b>52</b>
1.2.1.Нийтэд хүртээмжтэй хотын эдийн засаг .....	52
1.2.1.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг багтаасан бүх нийтийн бүтээмжит ажлын байрыг бий болгох .....	52
1.2.1.2.Албан бус эдийн засгийг дэмжих .....	55
1.2.1.3.Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих .....	57
1.2.1.4.Бизнес, инновацын шударга, хариуцлагатай орчинг бүрдүүлэх ажлыг дэмжих .....	60
1.2.2.Нийтэд хүртээмжтэй тогтвортой хөгжил, цэцэглэлт.....	64
1.2.2.1.Хотын эдийн засгийг төрөлжүүлэх, соёлын болон уран бүтээлийн үйлдвэрлэлийг дэмжих .....	64
1.2.2.2.Орчин үеийн хотын эдийн засгийг хөгжүүлэхийн тулд техникийн болон зохион байгуулах ур чадваруудыг хөгжүүлэх.....	67
1.2.2.3.Бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хот-хөдөөг харилцан уялдаатай хөгжүүлэх.....	69
<b>1.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ, ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРТАЙ ХОТЫН ХӨГЖИЛ .....</b>	<b>73</b>
1.3.1.Хотуудын эрсдлийг даван туулах, нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадвар ба хүн амын нутагшилт, суурьшил.....	73
1.3.1.1.Хотын тэлэлт, түүнээс үүдэж буй биологийн төрөл зүйлийн хохирлыг бууруулах .....	73
1.3.1.2.Уур амьсгалыг өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх .....	76
1.3.1.3.Байгалийн болон хүний оролцоотой гамшгийн нөлөөллийг бууруулах тогтолцоог хөгжүүлэх ....	79

1.3.1.4.Чанартай дэд бүтэц, орон зайн төлөвлөлтөөр хотын байгалийн эрсдэлд тэсвэрлэх нөхцөлийг бий болгох .....	81
1.3.2.Тогтвортой менежмент ба Байгалийн нөөцийн ашиглалт .....	84
1.3.2.1.Хот, суурины байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бэхжүүлэх .....	84
1.3.2.2.Нөөцийг ариглах, хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахыг шаардлага болгох .....	85
1.3.2.3.Усны нөөц, хотын хаяа залгаа далайн эргийн хэсгийн байгаль орчинд ээлтэй ашиглалт, менежментийг хэрэгжүүлэх .....	88
1.3.2.4.Цахимжуулалт, цэвэр эрчим хүч ба технологид түшиглэсэн Ухаалаг-хот хандлагыг хэрэгжүүлэх .....	90
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖИЛТ .....</b>	<b>93</b>
<b>2.1.ХОТЫН ЗАСАГЛАЛЫН БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ: ДЭМЖИХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ .....</b>	<b>93</b>
2.1.1.Төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн захиргаадад өөрсдийн оноогдсон үүргийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх.....	93
2.1.2.Хот байгуулалтын бодлогыг санхүүгийн механизм, төсөвтэй уялдуулах.....	96
2.1.3.Засгийн газар хот байгуулалтын бодлогоо хэрэгжүүлэх боломжийг өргөтгөсөн хууль эрх зүйн болон бодлогын хүрээг хөгжүүлэх.....	97
2.1.4.Бүсийн болон орон нутгийн захиргаадын тухайлсан орон нутгийн болон нийслэл хотын түвшний засаглалыг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх .....	100
2.1.5.Хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд нас болон жендерийн асуудлыг тооцсон, оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлэх .....	100
2.1.6.Шийдвэр гаргалтын бүхий л талбар болон түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн оролцоог хангах .....	102
<b>2.2.ХОТЫН ОРОН ЗАЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ .....</b>	<b>106</b>
2.2.1.Газар нутгийг нэгдсэн бөгөөд тэнцвэртэй хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх .....	106
2.2.2.Хот байгуулалтын баримт бичигт орон сууцыг нэгтгэн авч үзэх .....	108
2.2.3.Хот төлөвлөлтөд соёлыг тэргүүлэх бүрдэл хэсэг болгон авч үзэх.....	110
2.2.4.Хотын нутаг дэвсгэрийн тэлэлт, суурьшуулалт, шинэчлэл, дахин төлөвлөлтийг сайтар төлөвлөн хэрэгжүүлэх.....	113
2.2.5.Засгийн газрын бүхий л түвшинд хот төлөвлөлт, зураг төслийн чадавхыг сайжруулж, хот төлөвлөгчдийг сургах .....	116
2.2.6.Жижиг болон дунд хэмжээний хот, суурин газруудын гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх .....	118
2.2.7.Моторт бус хувилбарыг багтаасан олон төрөлт тогтвортой тээврийн системийг хэрэгжүүлэх .....	121
<b>2.3.ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ.....</b>	<b>122</b>
2.3.1.Санхүүгийн эх үүсвэрийг дайчлах .....	122
2.3.1.1.Засгийн газрын бүхий л түвшинд “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх санхүүжилтийн хүрээг хөгжүүлэх .....	122
2.3.1.2.Санхүүжилтэд дотоод эх үүсвэрийг дайчилж, бүс нутгийн болон орон нутгийн захиргаадын орлогын суурийг өргөтгөх .....	126
2.3.1.3.Санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газраас бүс болон орон нутаг руу хэрэгцээ, эрэмбэ болон зориулалтад үндэслэн шилжүүлдэг найдвартай, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх .....	129
2.3.1.4.Хотжилтын санхүүжилтэд санхүүгийн зуучлалыг (олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, бүс нутгийн хөгжлийн банкууд, бүсийн болон орон нутгийг хөгжүүлэх сангууд; төвлөрсөн санхүүжилтийн механизм гэх мэт.) бий болгож ашиглах .....	131
2.3.2.Чадавхийг бэхжүүлэх, ахисан түвшинд мэдлэг солилцох .....	133
2.3.2.1.Хотууд хоорондын хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлж хотжилтын шийдэл, харилцан суралцах явдалд дэмжлэг үзүүлэх.....	133
2.3.2.2.Чадавхыг бэхжүүлэх ажлыг хот байгуулалтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хариуцах, хянах болон үнэлэх үр дүнтэй, олон талт аргачлал болгон хэрэгжүүлэх .....	135
2.3.2.3.Засгийн газрын бүхий л түвшинд нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтад тоон мэдээллийг ашиглах чадавхыг бэхжүүлэх, үүнд үндэсний цөөнхийн бүлгүүдээс өгөгдөл цуглуулах болон өгөгдлийг тэдний тусын тулд ашиглалт мөн багтана .....	135
2.3.2.4.Засгийн газрын бүхий л түвшинд эмзэг бүлгүүдтэй ажиллах, тэднийг хот байгуулалт болон нутаг дэвсгэрийн хөгжлийн талаарх шийдвэр гаргалтад идэвхтэй татан оролцуулах чадавхыг бэхжүүлэх .....	135
2.3.2.5.Чадавхыг бэхжүүлэх явцад орон нутгийн захиргаадыг дэмжигч болон хэрэгжүүлэгчээр татан оролцуулах .....	137
2.3.2.6.Хууль ёсны эзэмшил газраас олох орлого, санхүүжилт, бусад арга хэрэгслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.....	138

2.3.2.7.Бүс, орон нутгийн захиргаадын санхүүгийн төлөвлөлт ба менежментийг бэхжүүлэх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх .....	140
2.3.2.8.Хот байгуулалтын тогтвортой хөгжлийн тусын тулд шинжлэх ухаан, технологи, инновацын талаарх мэдлэг солилцох хамтын ажиллагааг нэмэгдүүлэх .....	142
2.3.3.Мэдээллийн Технологи ба Инноваци .....	142
2.3.3.1.Цахим засаглал болон хүн төвтэй тоон засаглалын арга хэрэгслэлийг ашиглан хэрэглэхэд хялбар, оролцоонд тулгуурласан өгөгдөл болон програм хангамжийг хөгжүүлэх .....	142
2.3.3.2.Хот, суурин болон бүс нутгуудын хөгжил цэцэглэлтийг жигд бэхжүүлэх хүрээнд тэргүүлэх технологи болон инновацын ашиглалтыг өргөтгөх .....	145
2.3.3.3.Газар зүйн мэдээллийн систем (ГМС) зэрэг цахим арга хэрэгслийг хот, суурин болон газар нутгийн төлөвлөлт, газар ашиглалт, хотын суурь үйлчилгээг сайжруулахад ашиглах .....	145
2.3.3.4.Засгийн газрын бүхий л түвшинд хот байгуулалтын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй хянах чадавхыг бүрдүүлэх .....	148
2.3.3.5.Засгийн газрын бүхий л түвшинд болон иргэний нийгмийн байгууллагын тоон мэдээлэл цуглуулах, ялган ангилах, дүн шинжилгээ хийх явцыг бэхжүүлэх .....	149
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХЯНАЛТ .....</b>	<b>151</b>
<b>3.1.“ХОТЖИЛТЫН ШИНЭ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРУУЛСАН ТОГТОЛЦОО, БОДЛОГО, АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ ТАЙЛБАРЛАХ.....</b>	<b>151</b>
<b>САЙН ТУРШЛАГА .....</b>	<b>153</b>
<b>“ХОТЖИЛТЫН ШИНЭ ХӨТӨЛБӨР”-ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....</b>	<b>169</b>
<b>АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....</b>	<b>193</b>
<b>ҮНДЭСНИЙ ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН .....</b>	<b>197</b>

## ГРАФИК

График 1. Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны тоо (2010-2022 он) .....	34
График 2. 2013-2021 оны ипотекийн зээл олголт .....	37
График 3. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчын тоо (2018-2020) .....	40
График 4. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчын хувиар .....	41
График 5. Хот хоорондын зорчигч урсгалын тоо .....	49
График 6. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарт эзлэх хувь .....	57
График 7. Бизнес орчны үнэлгээ (2020 оны байдлаар) .....	61
График 8. ДНБ-д шинжлэх ухааны салбарын эзлэх хувь .....	64
График 9. Монгол Улсын газрын нэгдмэл сан (2020 оноор) .....	73
График 10. Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ .....	75
График 11. Хүн амын цэвэр шилжилт хөдөлгөөн, (1000 хүнд ногдохоор, 2010-2020 оны дунджаар) .....	114
График 12. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент .....	114
График 13. 2003-2021 онд барилгажсан талбайн өсөлт, хувиар .....	115
График 14. Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ .....	123
График 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх санхүүжилт (эх үүсвэр, салбараар) .....	125
График 16. Орон нутгийн төсвийн бүтэц 2020 он (хувиар) .....	126
График 17. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, (аймгаар, 2017-2020 оны дундаж) .....	128
График 18. Орон нутгийн нэгдсэн төсвийн үзүүлэлт (2017-2020 оноор) .....	130

## ЗУРАГ

Зураг 1. Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн .....	30
Зураг 2. Улаанбаатар хотын 100 айлын хуучин болон шинэ гудамж .....	30
Зураг 3. Аймгийн төвүүдэд барьсан авто зам .....	31
Зураг 4. Улаанбаатар хотын дугуйн зам .....	32
Зураг 5. Улаанбаатар хотын орон сууцны болон гэр хороолол .....	33
Зураг 6. Монгол гэр.....	33
Зураг 7. Хангай хотхон .....	35
Зураг 8. “Буянт-Ухаа 2” хороолол.....	35
Зураг 9. Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын ерөнхий байдал .....	42
Зураг 10. Улаанбаатар хотын гэр хорооллын 3 бүс.....	43
Зураг 11. Хот, суурин газруудын авто замын сүлжээнд холбогдсон байдал .....	72
Зураг 12. “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний .....	77
Зураг 13. Ландфилын байгууламж болон барилгын хог бутлах, ангилах үйлдвэр .....	87
Зураг 14. Улаанбаатар хотод байрладаг “Гандантэгчинлэн хийд” цогцолбор .....	112
Зураг 15. Бүлэг суурины тогтолцоо (санал).....	120
Зураг 16. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалт .....	141
Зураг 17. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн гарын авлага .....	141
Зураг 18. Геопорталын өгөгдлийн харагдах байдал .....	146
Зураг 19. Газрын мэдээллийн сангийн харагдах байдал.....	147
Зураг 20. Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн харагдах байдал .....	148
Зураг 21. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн мэдээлэл.....	149

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Хүн амын амьжиргааны доод түвшин 2017-2020 оноор .....	16
Хүснэгт 2. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулсан байдал .....	17
Хүснэгт 3. Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, жини коэффициент (2017-2020 оноор) .....	20
Хүснэгт 4. Шинээр ашиглалтад орсон орон сууц (2017-2020 оноор) .....	38
Хүснэгт 5. Ус хангамж, 2018 оны эхний хагас жил жилийн байдлаар .....	46
Хүснэгт 6. Хүн амын насны бүтцийн өөрчлөлт (2017-2020 оноор) .....	52
Хүснэгт 7. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт (2017-2020 оноор) .....	53
Хүснэгт 8. 15 ба түүнээс дээш насны ажилгүй хүний тоо (2017-2020 оноор) .....	53
Хүснэгт 9. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүс нутгаар (хувиар) .....	56
Хүснэгт 10. Томоохон хот, суурин газрын хүн амын өөрчлөлт (1990-2019 он) .....	71
Хүснэгт 11. Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол .....	80
Хүснэгт 12. Улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь хэмжээ .....	95
Хүснэгт 13. Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс цалинждаг албан хаагч, ажиллагсад, хувь .....	95
Хүснэгт 14. Улсын нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь (2017-2020 оноор) .....	96
Хүснэгт 15. Засгийн газрын бүтэц дэх төрийн улс төрийн албан тушаалтнуудын тоо, хүйсийн харьцаа, (2016-2020 оноор, Эмэгтэй : Эрэгтэй) .....	104
Хүснэгт 16. Аймаг, нийслэл дэх төрийн улс төрийн албан тушаалтнуудын тоо, хүйсийн харьцаа, (2016-2019 оноор, Эмэгтэй : Эрэгтэй) .....	104
Хүснэгт 17. Төрийн захиргааны удирдах албан тушаалтан, аймаг нийслэл дэх төрийн улс төрийн албан тушаалтны доторх хүйсийн харьцаа 2016-2019 оноор, (Эмэгтэй : Эрэгтэй) .....	105
Хүснэгт 18. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ (2020 оны байдлаар) .....	108
Хүснэгт 19. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, мэргэжлийн инженер, техникийн ажилчдын тоо (2020 оны байдлаар) .....	116
Хүснэгт 20. Эдийн засгийн өсөлт, салбараар (2017-2020 оноор) .....	122
Хүснэгт 21. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого .....	127
Хүснэгт 22. Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон бусад шилжүүлэг (2016-2020 оноор) ..	129
Хүснэгт 23. ОНХС бий болсноос хойшхи хууль эрх зүйн орчны өөрчлөлт .....	131
Хүснэгт 24. Нөхөх олговорт олгосон хөрөнгийн хэмжээ (2017-2020 оноор) .....	139



## ТОВЧИЛСОН ҮГ

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татавар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХБ	Азийн хөгжлийн банк
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БД	Барилгын дүрэм
БНБД	Барилгын норм ба дүрэм
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГОУХАН	Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
ГХЯ	Гадаад харилцааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДБ	Дэлхийн банк
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЗАА	Захирагчийн ажлын алба
ЗГ	Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЖАЙКА	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУИС	Монгол Улсын их сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НХБХГ	Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар
НСУГ	Нийслэлийн Соёл, урлагийн газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮБУАӨСК	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай суурь конвенц

НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУБ	Олон улсын байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЗА	Тусгай замын автобус
ТГБ	Тулгуурт гүүрэн байгууламж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТХҮБ	Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
УЦЦС	Усан цэнэгт цахилгаан станц
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ҮСНХ	Үндэсний санхүүжилтийн нэгдсэн хүрээ
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
УИХ	Улсын Их Хурал
ХКОМ	Хамтарсан Кредит Олгох Механизм
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХАА	Хөдөө аж ахуй
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХЯ	Хүлэмжийн хийн ялгарал
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ЦХХХЯ	Цахим хөгжил, харилцаа холбооны яам
ЦШСГ	Цахилгаан, шугам сүлжээний газар
СЯ	Сангийн яам
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
ШУТ	Шинжлэх ухаан, технологи
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

# ХУРААНГУЙ

## ОРШИЛ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2016 оны тогтоолоор баталсан “Хотжилтын шинэ хөтөлбөр” нь хөгжиж буй улс орнуудад тогтвортой хот байгуулалтыг хэрэгжүүлэхэд гол чиглэл, үзэл баримтлал болж байгаагаараа чухал ач холбогдолтой төдийгүй “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх, нутагшуулах, “хот, суурин газрын хүртээмжтэй, аюулгүй, тэсвэрлэх чадвартай, тогтвортой хөгжлийг хангах” 11 дүгээр зорилт, бусад тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой билээ.

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас (УИХ) 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталж, тус үзэл баримтлалын зорилго, зорилтуудыг Засгийн газар болон нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа хөтөлбөр, үндсэн чиглэл, арга хэмжээний төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал, “Хот, суурин газрын хүртээмжтэй, аюулгүй, тэсвэрлэх чадвартай, тогтвортой хөгжлийг хангах” 11 дүгээр зорилтын хүрээнд Монгол Улсын хот байгуулалт, газрын харилцааны салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” болон нийслэл “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулан УИХ-д өргөн барих, хүн амыг орон сууцаар хангах зорилгоор “Түрээсийн орон сууц”, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих, “Дэд бүтцийн төв”, “Шинэ сумын төв”, “Сумын төвийн шинэчлэл”, ногоон байгууламж, нийтийн зориулалттай зам, талбайг нэмэгдүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, мөн шинээр орон сууцны хотхон, хороолол байгуулах зэрэг бүтээн байгуулалтын цар хүрээтэй томоохон ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах асуудалд нэн чухал ач холбогдол өгч, 2020 онд шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувь байсныг 6 хувь болгож бууруулсан. Тус арга хэмжээний үр дүнд зээлдэгчийн сарын эргэн төлөлтийн хэмжээ, зээлийн шалгуурт тавигддаг өрхийн орлогын доод хэмжээ тус тус 18.3 хувиар буурч, ипотекийн зээлд орлого багатай өрхийн хамрагдах боломж нэмэгдэх, өрхийн орлого өсөх, зээлийн эрсдэл буурах зэрэг эерэг нөхцөл бүрдсэн. 2015 оноос хэрэгжсэн зорилтот бүлгийн иргэдийг орлогод нийцсэн түрээсийн болон түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд бүрдсэн “Төрийн өмчийн орон сууцны сан”-д байгаа 4007 түрээсийн орон сууцаар зорилтот бүлгийн иргэдийг хангасан.

УИХ-аас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн зарим нэмэлт, өөрчлөлтийг баталж, тухайлбал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 25.1.7-д “... Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна...” гэж тусгасан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд баталсанаар Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистой хангах, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх, Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг харилцан уялдаатай, хоорондын нийцлийг ханган боловсруулж батлах шинэ тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой болсон.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлэн 2019-2020 онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад суурь хуулиудыг шинэчлэн баталсан. Мөн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 онд УИХ-д өргөн барьж, хэлэлцэхийг дэмжсэн. “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” болон тус хөтөлбөрийн үндсэн зарчмуудыг тусгасан болно.

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, холбогдох бусад хуулиудтай уялдуулах зорилгоор Газрын багц хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, шинээр Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төсөл, Орон зайн дэд бүтцийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулж байна. Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, хэрэглээний өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлт нь хот, суурин газруудын эрчим хүч, ус, газрын нөөцийн аюулгүй байдлыг улам бүр эрсдэлд оруулж байна. Иймээс байгалийн хязгаарлагдмал нөөц болох ус, эрчим хүч, газрын ашиглалтыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Орон сууцны тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулга, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль зэрэг бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна”, “Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна”, “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгоно” гэсэн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Эдгээр зорилтуудын хүрээнд Засгийн газар сүүлийн жилүүдэд эдийн засгийн идэвхжилийн үед төсвийн алдагдлыг бууруулах замаар эдийн засгийн хэлбэлзлийг тогтворжуулах, мөн 2019 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, төсөв, санхүүгийн орчинг эрүүлжүүлэх, сахилга батыг чангатгахад чиглэсэн “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг баримталж байна. УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 1.5 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлснээр макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, 2018 оны эдийн засгийн өсөлт 7.2 хувь болж нэмэгдсэн.

Манай улсын эдийн засгийн өндөр өсөлтийг цаашид тогтвортой хэмжээнд байлгахад эрчимтэй өсч буй хотын эдийн засаг, түүний дотор үйлчилгээний салбар чухал үүрэгтэй юм. Улсын хэмжээнд 2019 онд ДНБ-ий 39.0 хувийг үйлчилгээний салбар, 39.1 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.0 хувийг ХАА-н салбар, 10.9 хувийг бусад салбараас бүрдүүлсэн байна. Сүүлийн арван жилийн хугацаанд эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь нэмэгдсэн хэдий ч нөгөө талдаа аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс ихээхэн хамаарах хандлагатай байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичгүүдэд тогтвортой хөгжлийн 3 гол тулгуур болох байгаль орчин – нийгэм - эдийн засгийг харилцан уялдаатай, тэнцвэртэй хөгжүүлэх зорилтыг тодорхойлсон. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах” талаар цогц, томоохон зорилт, арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлсэн.

2019 онд “Хот байгуулалтын үндэсний форум”-ыг зохион байгуулж, “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг сурталчлах зорилгоор тус хөтөлбөрийг танилцуулан, англи, монгол хэл дээр ном

болгон тарааж, хурлын төлөөлөгчид болон 21 аймгийн Засаг дарга, хотын Захирагч нар, аймаг, нийслэлийн ГХБХБГ болон хот байгуулалтын баримт бичиг боловсруулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага зэрэг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд, олон нийтэд түгээх, тэдгээрийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр холбогдох сургалт, семинарыг зохион байгуулсан.

УИХ-ын ээлжит сонгуулийг 2020 оны 06 дугаар сард зохион байгуулж, тус сонгуулийн үр дүнд шинэ Засгийн газрыг 2020 оны 07 дугаар сард байгуулсан бөгөөд 2021 оны 06 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг явуулсан. Эдгээр улс төрийн нөхцөл, мөн Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын байдлаас шалтгаалан “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланг цаг хугацаанд нь хүргүүлээгүй болно.

## **ОРОЛЦОГЧ ТАЛУУД БА ХАМТЫН АЖИЛЛАГАА**

“Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ыг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-аас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилго, зорилтуудыг Засгийн газар болон нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга, төрийн болон ТББ, хувийн аж ахуйн нэгж үйл ажиллагааныхаа хөтөлбөр, үндсэн чиглэл, арга хэмжээний төлөвлөгөө, төсөл, хөтөлбөртөө тусган иргэд, олон нийтийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлж байна. Манай улсад “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хөгжлийн олон тулгамдсан асуудлыг салбар дундын уялдаа, зохицуулалт, олон талын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх явдал чухал юм.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 87 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэг болон Зөвлөх баг хамтран “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланг НҮБ-Хабитат байгууллагын удирдамж, аргачлалын дагуу боловсруулсан. Ажлын хэсгийг БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга ахалж, Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох яамд, хэрэгжүүлэгч агентлагууд, орон нутгийн зарим төрийн байгууллага, мөн ТББ-уудын төлөөллөөс бүрдсэн бөгөөд тус үндэсний тайланг боловсруулахад мэдээлэл, судалгаа, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг хүлээсэн (Ажлын хэсэг, Зөвлөх багийн бүрэлдэхүүнийг Хавсралт хэсгийн 197 дугаар хуудаснаас үзнэ үү). Тайлангийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч тусган, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19) ЦАР ТАХЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын хямрал нүүрлэж эхлэхэд Монгол Улсын эдийн засаг 2016 оны эдийн засгийн уналтаас сэргэж байсан. Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө улам бүр идэвхжиж, Монгол Улсын эдийн засаг, иргэдийн амьжиргаанд томоохон цохилт үзүүлсэн. Үүнээс улбаалан үйл ажиллагааны шинэ орчин бий болж, Монгол Улсын хөгжлийн зарим суурь бэрхшээлүүд гарсан байна. Монгол Улс нь богино хугацаандаа яаралтай тусламж үзүүлэх, эрүүл мэндийн салбарт тулгарч буй хүндрэлүүдэд хариу арга хэмжээ авах, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахын зэрэгцээ хямралыг даван туулж, хөгжлийн суурь бэрхшээл, сорилтуудаа шийдвэрлэхүйц эдийн засгийн илүү тогтвортой, хүртээмжтэй, уян хатан сэргэлтийг бий болгох давхар сорилттой тулгарсан.

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийнхээ амьжиргааг дэмжих зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. УИХ-аас 2020 оны 4 дүгээр сард “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг баталсан. Мөн Засгийн газрын 2020 оны 139 дүгээр

тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 167 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 168 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус батлан хэрэгжүүлж байна. Монгол Улс 2020 онд Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын эсрэг арга хэмжээнд улсын төсвөөс 2.4 их наяд төгрөг зарцуулсан.

Улсын хэмжээнд 2019 онд эдийн засаг 5.2 хувиар өсөж, төсвийн орлого 10.9 их наяд төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн алдагдал батлагдсан хэмжээнээс 2.5 дахин бага гарч байсан бол дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (COVID -19) цар тахлын үр нөлөөгөөр эдийн засаг жилийн эхний хагаст 9.7 хувиар агшсан ч Засгийн газраас иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 2020 онд 5.3 хувь болж, сүүлийн хагас жилд эдийн засгийн уналт саарсан байна.

## **ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД**

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ыг УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулиудыг үндэслэн ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталж, тус тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” УИХ-ын тогтоолын хавсралтад тусгагдсан тул “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсон. “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланд ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын талаар дурьдаагүй бөгөөд дараагийн шатны тайланд тус бодлогын баримт бичгийг тусгах болно.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОТ, СУУРИНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ТАЛААР ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

## 1.1.НИЙГМИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ТОГТВОРТОЙ ХОТ БАЙГУУЛАЛТ БА ЯДУУРЛЫГ ҮГҮЙ БОЛГОХ

### 1.1.1.Нийгмийн оролцоог хангах ба ядуурлыг үгүй болгох

#### 1.1.1.1.Ядуурлын бүхий л төрлийг арилгах

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "ядуурлын бүх төрлийг эцэс болгож, 2016-2020 онд "ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах" зорилт дэвшүүлсэн. "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах" зорилтыг тусгасан. Мөн Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого (2016-2025)"-ыг баталж, "орон гэргүй, тэнэмэл, ажилгүй, ядуу хөдөлмөрийн чадвартай иргэдийг мэргэжлийн боловсролын сургалтад хамруулж, ажил хөдөлмөрт татан оролцуулж, байнгын ажил, орлоготой болгох, орлогын тэгш бус байдлыг багасгах, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүргэх" зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын эдийн засаг уул уурхайн салбарт түшиглэн эрчимтэй өсөж байгаа боловч энэхүү өсөлт нь тогтворгүй, бүх хүнд хүртээмжтэй байж чадахгүй байна. Уул уурхайн салбарын сүүлийн үеийн өсөлтийн үр өгөөж ядуус, ялангуяа ур чадвар шаарддаггүй, цалин багатай ажил эрхлэгчдэд хүртэхгүй байна. Манай улсын хүн амын ядуурлын түвшин 2018 онд 28.4 хувь байсан бол 2020 онд 27.8 хувь болж, 0.6 нэгжээр буурч, 903.4 мянган хүн ядуурлын шугамаас доогуур амьдарч байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү). Хөдөө, орон нутгийн 3.3 хүн тутмын 1 нь ядуу амьдарч байгаа бол хот, суурин газрын 3.7 хүн тутмын 1 нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байна. 2020 оны байдлаар ядуурлын шугамаас доогуур хөдөөд амьдарч буй иргэдийн тоо 0.4 нэгжээр, аймгийн төвд 1.3 нэгжээр тус тус буурч, харин нийслэл Улаанбаатар хотод амьдарч буй ядуурлын шугамаас доогуур иргэдийн эзлэх хувь эсрэгээрээ өссөн байна. 2018 онд нийслэл Улаанбаатар хотын нийт хүн амын 41.8 хувь нь ядуурлын шугамаас доогуур амьдарч байсан бол 2020 онд 43.5 хувь болж, 1.7 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт 2-ыг үзнэ үү). Монгол Улсын ҮСХ, ДБ-ны хамтарсан 2018 оны "Ядуурлын дүр төрх" тайланд хүн амын 15 хувь нь ядуурлын шугамаас бага зэрэг дээгүүр амьдарч, гэнэтийн хямралт үйл явдлын нөлөөгөөр ядууралд өртөх эрсдэлтэй байгаа талаар дурдсан байна.

Хүснэгт 1. Хүн амын амьжиргааны доод түвшин 2017-2020 оноор  
(нэг хүн сард ногдохоор)

ХЭМЖИХ НЭГЖ: МЯН.ТӨГ

Бүс	2017	2018	2019	2020
Баруун бүс	166.5	178.0	190.7	203.4
Хангайн бүс	173.5	182.6	194.3	206.0
Төвийн бүс	166.2	175.6	187.1	198.3
Зүүн бүс	165.7	174.0	187.6	201.7



<b>Улаанбаатарын бүс</b>	185.3	198.6	217.9	230.0
--------------------------	-------	-------	-------	-------

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

### Хүснэгт 2. Ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулсан байдал

Бүс/үзүүлэлт	Ядуурлын хамралтын хүрээ (%)		Ядуурлын гүнзгийрэлт (%)		Ядуурлын мэдрэмж (%)		Ядуу хүн амын тоо (мян.хүн)		Ядуу хүн амын эзлэх хувь (%)	
	2016	2018	2016	2018	2016	2018	2016	2018	2016	2018
<b>Улсын дундаж</b>	<b>29.6</b>	<b>28.4</b>	<b>7.7</b>	<b>7.2</b>	<b>2.9</b>	<b>2.7</b>	<b>907.5</b>	<b>904.9</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
<b>Хот</b>	27.1	27.2	7.2	7.2	2.8	2.8	563.8	574.6	62.1	63.5
<b>Хөдөө</b>	34.9	30.8	8.8	7.2	3.2	2.4	343.7	330.3	37.9	36.5
<b>Бүс</b>										
<b>Баруун бүс</b>	36.0	31.8	9.7	7.8	3.7	2.8	150.1	133.2	16.5	14.7
<b>Хангайн бүс</b>	33.6	30.8	8.2	7.3	2.9	2.5	189.6	179.6	20.9	19.8
<b>Төвийн бүс</b>	26.8	26.1	7.0	6.6	2.7	2.4	127.6	131.0	14.1	14.5
<b>Зүүн бүс</b>	43.9	37.4	12.5	10.0	4.8	3.7	97.1	82.8	10.7	9.2
<b>Улаанбаатарын бүс</b>	24.8	25.9	6.4	6.7	2.5	2.6	343.1	378.2	37.8	41.8
<b>Хот, суурин, хөдөө</b>										
<b>Улаанбаатар хот</b>	24.8	25.9	6.4	6.7	2.5	2.6	343.1	378.2	37.8	41.8
<b>Аймгийн төв</b>	31.8	30.1	8.8	8.2	3.4	3.2	220.7	196.4	24.3	21.7
<b>Сумын төв</b>	32.3	28.9	8.5	7.0	3.2	2.4	173.4	166.6	19.1	18.4
<b>Хөдөө</b>	38.0	32.9	9.2	7.4	3.2	2.4	170.4	163.6	18.8	18.1

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа их байгаа нь нийгмийн суурь үйлчилгээ, мэдээлэл, тохилог орон сууц, дэд бүтцийн хүртээмж хотын захын хорооллуудад болон хөдөө орон нутагт хангалтгүй, чанарын хувьд муу, тэгш бус байгаа зэргээр илэрч байна. Хүмүүс илүү таатай нөхцөл, боломжийг эрэлхийлж нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газарт шилжин амьдарч байна. Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын нийт хүн амын 38 хувь нь ядуу байгаа бөгөөд өрхийн тэргүүн нь ажилгүй, боловсролын түвшин багатай, нийгмийн халамж тэтгэмжээр амьдардаг, албан бус салбарт ажилладаг гэр хорооллын өрхүүд хамгийн ядуу байна. 2020 оны байдлаар хамгийн бага орлоготой өрхүүдийн сарын дундаж мөнгөн орлогын 55.9 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж, ядуу иргэд зөвхөн Засгийн газраас олгож буй тэтгэмжийн орлогоос ихээхэн хамааралтай, өөр орлогын эх үүсвэргүй байна. Хөдөлмөрийн багтаамж ихтэй салбарыг хөгжүүлэх, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, жендэрийн тэгш байдлыг хангахад төрийн бодлогыг чиглүүлэх нь ядуурлыг бууруулах гол арга зам юм.

Төрөөс халамжийн чиглэлээр Хүүхдийн мөнгөн тэтгэмж, Хүнс тэжээлийн тусламж дэмжлэг, “Цалинтай ээж хөтөлбөр”, Насны хишиг, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, нөхцөлт мөнгөн тусламж болон бусад халамж, хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Засгийн газраас нийгмийн халамж, тэтгэмжийн 72 төрлийн үйлчилгээ үзүүлж, жилд 800 мянга гаруй иргэн хамрагдаж байгаа нь дөрвөн хүн тутмын нэг нь халамж авч байна. Халамжийн бодлого хавтгайрахын хэрээр иргэдийн амьжиргаанд муугаар нөлөөлж, бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байгаагийн зэрэгцээ ажил, хөдөлмөрт хойрго, харицлагагүй хандах, архинд донтох явдал ядууралд нөлөөлж байна. Энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжилд идэвхтэй оролцогчдыг бус, хараат, идэвхгүй иргэдийг бий болгох сөрөг нөлөөтэй

байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний нэр төрлийг оновчтой тогтоон, зарим хөнгөлөлт, тусламжийг нэгтгэн багцалж, халамжийн үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор ХНХЯ нь Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалыг боловсруулж байна. 2017 онд УИХ-аас Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан.

2020 оноос хойш Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нөлөөгөөр далайд гарцгүй, бүсийн хэмжээний тээврийн коридорт оршдог Монгол Улсын хувьд худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа зогсонги байдалд орсноор өрхийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн боловсруулсан “Нийгмийн халамжийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үзүүлэх Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нөлөөллийн шинжилгээний хүрээнд “Хэрэв цар тахал дэгдээгүй байсан бол ядуурлын түвшин 24.3 хувь болж, 4.1 нэгжээр буурах тооцоог хийсэн байна. Тус тооцоогоор хот, суурин газарт 3.7 нэгжээр, хөдөө орон нутагт 4.9 нэгжээр буурах боломжтой байсан байна. Ядуурлын түвшин 2020 онд 2018 оноос бага зэрэг буурсан хэдий ч цар тахал дэгдээгүй байсан бол 3 орчим нэгжээр буурахаар байв. Үүнээс үзэхэд цар тахал ядуурлыг бууруулах хурдыг удаашруулсан байна.

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед эдийн засгийг эрчимжүүлэх, иргэдийнхээ амьжиргааг дэмжих зорилгоор Засгийн газраас тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, цар тахлын үед эдийн засгийг сэргээх, эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 0-18 насны хүүхэд бүрт сар болгон олгодог 20 мянган төгрөгийг 100 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн. 2019 оны байдлаар Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох үйлчилгээнд 1 сая гаруй хүүхдийг хамруулж, 229.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. 2020 оны байдлаар 1.2 сая хүүхэд хамрагдсан нь мөн оны өмнөх үетэй харьцуулахад 186 мянган хүүхдээр нэмэгдсэн бөгөөд 1053.0 тэрбум төгрөгийг зарцуулсан нь мөн оны өмнөх үеэс 823.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийж үзэхэд ядуурлын хувь 24.9 болж буурч байна. Иймд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдэл нь дангаараа цар тахлаас хамаарсан ядуурлын нөлөөг бууруулахаар байна гэж тооцоолсноос харахад, Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн үйлчилгээний нэмэгдэл нь Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үеийн хамгийн сайн нийгмийн хамгааллын арга хэрэгсэл байж чадсан байна.

Хүн амын хамгийн бага хэрэглээтэй бүлэгт “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ”-г Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу 2012 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ үйл ажиллагаа нь орлого багатай иргэдийг хоол, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлж, хоногт авах шаардлагатай илчлэгийг авах боломж олгож байна. 2020 оны байдлаар хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 264 мянган иргэнийг хамруулж, 55.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай бага орлоготой өрхийн насанд хүрсэн 122.3 мянган хүнд сар бүр 16 мянган төгрөгийн хүнсний талон олгодгийг 32 мянган төгрөг болгож 8 сарын хугацаанд, 118.2 мянган хүүхдэд 8 мянган төгрөг олгодгийг 16 мянга болгож, 5 сарын хугацаанд нэмэгдүүлсэн. Хүнс, тэжээлийн тусламж, дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдаж буй хөдөлмөрийн насны хүн ам нь ажилгүй байгаа нь ихэвчлэн мэргэжил, ур чадвар доогуур байгаатай холбоотой байна. Тиймээс ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийн албаны хооронд мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлж, тэдгээр иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, ур чадвар олгох сургалтад хамруулах шаардлагатай байна.

2018 оны 11 дүгээр сарын байдлаар “Цалинтай ээж” хөтөлбөр буюу 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн тэтгэмжид 154.5 мянган эх хамрагдаж, нийт 83.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. “Нийгмийн халамжийн сан”-гаас халамжийн тэтгэвэр авдаг 3600 өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй 42 мянган иргэн, 116 одой хүн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг 16.5 мянган хүүхэд, 18 хүртэлх насны 4-өөс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх сардаа 188 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 5 сарын хугацаанд 288 мянган төгрөг болгосон.

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын өрхийн амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлсэн нийгмийн халамж, нийгмийн хамгааллын олон талт арга хэмжээ нь ядуурлын өсөлтийг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой харагдаж байна. 2017 онд нийслэл Улаанбаатар хотын 181 өрхийн 427 хүн орон гэргүйн улмаас урц овоохой, шатны хонгил зэрэг зориулалтын бус сууцанд амьдарч байсан 65 өрхийн 119 хүн гэр, байшин сууцтай болсон байна. Орон сууц худалдан авах боломжгүй эдгээр иргэдэд зориулсан 1512 айлын төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг хамруулсан.

Засгийн газрын 2019 оны 159 дүгээр тогтоолоор “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-ийн хүрээнд үйлдвэрлэл дээрх болон мэргэжлийн сургалтад 2017 онд 4877 иргэнийг хамруулж, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас 963.0 сая төгрөгийг зарцуулсан.

#### **1.1.1.2.Боломж, үр ашгийг тэгш хүртэхийг дэмжих замаар хот, суурин газар дахь тэгш бус байдлыг бууруулах**

Тогтвортой хөгжлийн зорилгын “Тэгш бус байдлыг бууруулах” 10 дугаар зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувийг дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтаах”, “орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг 2014 онд 36.5 байсныг 2030 онд 30 хүртэл бууруулах” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Өргөн удам газар нутагтай, ашигт малтмал, хөдөө аж ахуйн арвин нөөцтэй, түүх, соёлын хосгүй өвтэй Монгол Улсын хувьд “Бүсчилсэн хөгжлийн бодлого” нь хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг тэгш, шударга хуваарилах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чухал үүрэгтэй юм.

2001 онд УИХ-аас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, түүний дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн. Улмаар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий хотжилтыг дэмжих зорилгоор эдийн засгийн 4 бүс тус бүрд 2 тулгуур төв хотыг сонгон, тэдгээрийг түлхүү хөгжүүлэхээр тогтсон. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2015 оноор дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоохоор ажиллаж байна. Түүнчлэн, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр

хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж байна.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж, 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ оны үнээр 2017 онд 9 сая төг байсан бол 2020 онд 11.6 сая төг болж нэмэгдсэн хэдий ч хүн амын амьжиргааны түвшин дээшлэхгүй, ядуурал буурахгүй байна. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны дүнгээр хөдөлмөр эрхэлж буй 5 хүн тутмын 1 нь ажилтай ядуу гэсэн ангилалд багтаж байна. Түүнчлэн, Монгол Улсын нийт хүн амын 2/3 нь амьдардаг хот, суурин газарт ядуурлын төвлөрөл нэмэгдэж байна. 2018 оны байдлаар ядуу амьдарч байгаа 10 хүн тутмын 6 нь хот, суурин газарт, 10 хүн тутмын 4 нь нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. Монгол Улсын эдийн засгийн үр өгөөж хүн амд хүртээмжтэй байж ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд хангалттай нөлөө үзүүлж чадахгүй байгаа нь нийгмийн тэгш хүртээмж муу байгааг илтгэж байна.

Улсын хэмжээнд жини коэффициентээр тэгш бус байдлыг хэмжихэд 2017 онд 0.35 хувь, 2020 онд 0.32 хувь болж, бараг өөрчлөгдөөгүй байгаа нь Монгол Улс дахь тэгш бус байдлын түвшинд ахиц гараагүйг харуулж байна (Хүснэгт 3-ыг үзнэ үү). Хүн амын хамгийн чинээлэг өрхийн (20 хувь) 1 хүнд ногдох сарын орлого нь бага орлоготой өрхийн (20 хувь) 1 хүнд ногдох сарын орлогоос 6 дахин их байгаа бол хэрэглээний дундаж хэмжээ ядуу өрхийнхөөс 5 дахин их байсаар байгаа нь хүн амын дундах хэрэглээний тэгш бус байдал буурахгүй байгааг илтгэж байна.

Монгол Улсын “Хүний хөгжлийн индекс” 2017 онд 0.751 байсан бол 2020 онд 0.774 болж, 0.023 нэгжээр, “Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс” 2017 онд 0.66 байсан бол 2020 онд 0.7 болж, 0.04 нэгжээр тус тус нэмэгдсэн байна. “Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс” 2020 онд 0.7 болж, ерөнхий “Хүний хөгжлийн индекс”-ээс 9.6 хувиар бага байгаа нь боловсрол, эрүүл мэнд, орлогын тэгш бус байдлаас шалтгаалж байна (Хүснэгт 3-ыг үзнэ үү).

### Хүснэгт 3. Хүний хөгжлийн үзүүлэлтүүд, жини коэффициент (2017-2020 оноор)

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Хүний хөгжлийн индекс	0.751	0.758	0.762	0.774
Хүний хөгжлийн тэгш бус байдлаар засварласан индекс	0.66	0.67	0.67	0.7
Жендэрийн тэгш бус байдлын индекс	0.282	0.288	0.274	0.286
Жини коэффициент	0.35	0.32	0.33	0.32

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

Хүн амын тоо жилээс жилд өсөж байхад хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурч буй байдал нь эдийн засаг хөдөлмөрийн насны хүн амынхаа хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг хүртээмжтэй хангаж чадахгүй байгааг илэрхийлж байна. 2020 онд Коронавируст халдвар (COVID-19) цар тахал, хөл хорионы улмаас үйл ажиллагаа эрхлээгүй, түр болон бүрэн зогссон аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо өмнөх оноос 13 мянгаар нэмэгдсэн байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 2020 онд 58.8 хувь болж, 2017 (61.1 хувь) оноос буурсан үзүүлэлттэй байна. Эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа боловч 2019 оны байдлаар эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 53.4 хувь, эрэгтэйчүүдийнхээс (68.3 хувь) доогуур байна. Жендэрийн тэгш бус

байдлын индекс 2020 онд 0.286 байсан байна. Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд болон цалин хөлс, орлогын хувьд жендэрийн ялгаатай байдлыг харуулж байна. Мөн улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байна.

Нийт ажиллагсадын 4 хүн тутмын 1 нь бүтээмж, цалин хөлс харьцангуй бага хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, хөрөнгө оруулалт маш ихээр шаардагддаг уул уурхай, барилгын салбарт ажлын байрны шингээлт хангалтгүй байна. Монгол Улсад хөдөлмөрийн хөлсний үнэлэмж хэтэрхий бага байгаагаас иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэх сонирхол буурч байна. Ажил, хөдөлмөр эрхэлсэн ч амьдралын наад захын хэрэгцээг хангахгүй, өрхийн орлогоос зарлага нь хэт давсан байдлын улмаас хөдөлмөр эрхэлж буй хүмүүс ядуучуудын эгнээнд орох эрсдэл нүүрлэж байна. ҮСХ-ны “Орлого, хэрэглээний тэгш бус байдлын тайлан”-д дурдсанаар 1 өрхөд ногдох сарын цалингийн голч хэмжээ дундаж хэмжээтэйгээ харьцуулахад 120-170 орчим мянган төгрөгөөр бага байгаа нь цалингийн тархалт хэвийн бус буюу нийгэмд өндөр цалинтай цөөн хүн, бага цалинтай олон хүн байгааг харуулж байна. Иймд чанартай, хүртээмжтэй, тогтвортой, ажлын нөхцөл сайтай, амьжиргаа хангахуйц цалинтай ажлын байрыг бий болгох шаардлагатай байна.

Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд Засгийн газрын шийдвэрийн дагуу аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг 2018 оноос 5 аймагт хэрэгжүүлж, нийт 470 сая төгрөгийг зарцуулж, 117 ажлын байрыг шинээр бий болгосон.

Орон нутгийн оролцоог дэмжиж, төвлөрлийг сааруулах, ажлын байр шинээр бий болгох зорилгоор “Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл”-ийн тэргүүлэх чиглэлийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 3 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Орон нутгийн онцлогтой зорилтот 29 төслийг шалгаруулж, төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээд болон харьяа аймаг, дүүргийн Засаг даргатай хамтран ажиллах гурвалсан гэрээ байгуулан 3.8 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх санхүүжилтийг олгосноор 900 байнгын ажлын байр шинээр бий болсон. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр тогтоолоор орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэхээр баталсан. 2018 онд уг төслийн хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас 3.3 тэрбум төгрөг зарцуулж, 48 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан байна.

Монгол Улсад орлогын тэгш бус байдлаас гадна хөрөнгийн тэгш бус байдал, боловсролын тэгш бус байдал, эрх мэдлийн тэгш бус хуваарилалт зэрэг шударга ёс, ёс зүйд суурилах тэгш бус байдал их байна. Тухайлбал, улсын хэмжээнд 2019 оны байдлаар нийт хадгаламж эзэмшигчдийн нэг хувь нь нийт хадгаламжийн дүнгийн 60 гаруй хувийг бүрдүүлж байгаа бол хадгаламж эзэмшигчдийн үлдсэн 99 хувь нь нийт хадгаламжийн дүнгийн 40 орчим хувийг бүрдүүлж байна. Боловсролын тэгш бус байдал нь боловсролын хүртээмжийн ялгаатай байдалтай холбоотой бөгөөд манай улсын хүн амын хамгийн бага орлоготой өрхийн (20 хувь) хүүхдүүд нь өндөр орлоготой бүлгийн хүүхдүүдийг бодвол их, дээд сургуульд элсэн суралцах нь 20 дахин бага байна.

Цаашид орлогын хуваарилалтын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, иргэдэд тэгш боломж олгох, ялгаварлан гадуурхалтыг арилгах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийн шинж байдлыг бүхэлд нь илүү хүртээмжтэй болгох, татварын тогтолцоог илүү шударга болгох зэргээр тэгш бус байдлын эсрэг хариу арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ногоон эдийн засаг нь нийгмийн бүхий л давхаргын хүмүүс, ялангуяа нийгмээс гадуурхагддаг бүлэг хүмүүсийн дуу хоолойг шийдвэр гаргалтад тусгах явдлыг нэн тэргүүнд тавьдаг. Ногоон эдийн засгийн холбооны Монгол Улс дахь гишүүн байгууллага болох “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн зүгээс ядуу иргэд, ажилчид, албан бус бизнес эрхлэгчдийн дуу хоолойг бодлого боловсруулагчдад хүргэх зорилгоор “Бидний оролцоот шийдэл” аяныг 2018 оноос эхлэн амжилттай зохион байгуулж байгаа нь үндэсний хэмжээнд сайн туршлага болж байна.

### **1.1.1.3.Эмзэг бүлгийн нийгмийн оролцоог хангах (эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшсан иргэд)**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 33 дахь хэсэгт “Эмзэг бүлгийн иргэдийг нийгмээс тусгаарлагдахаас урьдчилан сэргийлэх, мөн амьдрах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах, нийгмийн харилцаанд тэгш оролцох, орон гэргүй болохоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт хэрэгтэй тэмцэх, бууруулахын төлөө ажиллах” гэж заасан. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна”, “Жендерийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална”, “Залуу гэр бүл, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд шилжүүлэн тооцуулдаг арга хэмжээг үе шаттай нэвтрүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн.

**Эмэгтэйчүүд:** 2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 49.1 хувийг эрэгтэйчүүд, 50.9 хувийг эмэгтэйчүүд эзэлж, эмэгтэйчүүдийн Хүний хөгжлийн индекс 0.765 болж, эрэгтэйчүүдийнхээс (0.731) өндөр байсан бөгөөд Жендэрийн хөгжлийн индекс (ЖХИ) 1.046 байсан байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1.2 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 659.9 (52.8%) мянга нь эрэгтэйчүүд, 590.7 (47.2%) мянга нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөр эрхлэлтийн жендэрийн асуудлын хувьд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр байгаа боловч эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож, олж авсан мэдлэг, боловсрол, чадвараа бүрэн ашиглах байдал эрэгтэйчүүдээс доогуур байна. Мэргэшсэн, өндөр ур чадвартай эмэгтэйчүүд байдаг хэдий ч төрийн эсвэл хувийн хэвшлийн аль ч байгууллагын дээд түвшинд удирдах албан тушаалтнууд ихэнх тохиолдолд эрэгтэйчүүд байдаг. Түүнчлэн, хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн дундаж цалин эрэгтэйчүүдийнхээс бага байгаа бөгөөд жендэрийн цалингийн зөрүү 12.5 хувь болсон байна. Хүүхэд харах үйлчилгээ хангалтгүй, эмэгтэйчүүдийг гэр ахуй, хүүхэд асрах үүрэгтэй мэтээр үздэг зэрэг тулгамдсан асуудлууд байна.

Жендэрт суурилсан болон архи, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдсэн гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэж байна. ҮСХ-ны 2017 оны “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан”-д 15-49 насны эмэгтэйчүүдийн 14.7 хувь, 15-64 насны эмэгтэйчүүдийн 12.7 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна гэжээ. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага 2020 онд 16 хувиар өсөж, цагдаагийн байгууллагад өдөрт дунджаар 150-200, жилд 50 мянга гаруй гэр бүлийн хүчирхийллийн дуудлага ирсэн байна. 2020 оны байдлаар эхийн эндэгдэл 23 байсан байна. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн хувьд өсвөр насныхны жирэмслэлт, үр хөндөлт нь залуу эмэгтэйчүүд, өсвөр насныхны эрсдэлд өртөж буй тохиолдлыг нэмэгдүүлж байна.

Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор "Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүн"-ийг Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулан байгуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр" (2017-2021)-ийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд барилга, хот байгуулалтын салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үнэлгээгээр дэмжих зорилгоор тус салбарт "Жендэрийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичгийг 2017 онд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан. Мөн Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр"-ийг батлан хэрэгжүүлж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2016 онд батлан хэрэгжүүлснээр гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах төрийн бүтэц, механизм, төрийн байгууллага, албан тушаалтнуудын оролцоо, гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог нарийвчлан зохицуулахтай холбогдсон эрх зүйн орчин бүрдсэн.

**Залуучууд:** 2020 оны байдлаар Монгол Улсад 15-34 насны 1 сая залуус байгаа нь нийт хүн амын 30.7 хувь, 15 ба түүнээс дээш насны хүн амын 45 хувийг эзэлж байна. Хот, суурин газрын залуусын өмнө тулгарч буй гол асуудал нь тогтвортой ажлын байр, амьдралд хүрэлцэхүйц цалин хөлс, орон сууцны хангамж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх спорт заал, усан бассейн, номын сан, цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн барилга байгууламжийн хүртээмж хангалтгүй байгаа явдал юм.

2017 онд УИХ-аас Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж, залуучуудын асуудал хариуцсан Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг шинээр байгуулсан. Тус хуульд хувь хүний хөгжил, боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухааны хөгжил, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн 5 чиглэлээр залуучуудын хөгжлийг дэмжихээр зохицуулсан. Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого" (2016-2025)-ын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Мөн 2017 онд Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 158 дугаар тогтоолоор "Нийслэлийн Залуучууд" дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. 2018 оны байдлаар 21 аймаг, 8 дүүрэг, 155 суманд 180 гаруй залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг байгуулан ажиллаж байна.

"Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ыг Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор баталж, залуу гэр бүл амьдарч байгаа түрээсийн орон сууцны нийт өртгийн 30 хувийг 5 жилийн хугацаанд хуваан төлж, урьдчилгаа төлбөр бүрдүүлснээр орон сууцны хөнгөлөлттэй, жилийн 8 хувийн хүүтэй зээлд хамрагдан өмчлөх боломжтой болсон.

2017 онд "Шилдэг гарааны бизнесийг дэмжих" үйл ажиллагааг зохион байгуулж, 1270 гаруй залуучууд бизнесийн санаагаа ирүүлснээс 5 бизнесийн санааг шалгаруулж, нийт 130 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Түр ажлын байранд 2684, байнгын ажлын байранд 843, сургалтад 919, хөнгөлттэй зээлд 6, төсөл, хөтөлбөрт 25, халамжийн үйлчилгээнд 8 иргэнийг тус тус холбон зуучилсан байна.

2019 онд ҮСХ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар "Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх журам"-ыг батлан мөрдөж байна.

Монгол Улс залуучуудаа боловсрол, мэдлэгтэй, мэргэжил мэргэшилтэй, эрүүл, саруул оюун ухаан, бие бялдартай, эх оронч, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлж, баталгаатай ажил, орлоготой, орон байртай, өмч хөрөнгөтэй болгох талаар тогтвортой, цогц бодлого, тодорхой зорилго чиглэл бүхий төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. УИХ-ын 2016 оны ээлжит сонгуульд 18-25 насны залуусын 50 хувь нь оролцоогүйтэй холбогдуулан залуусын улс төр, нийгмийн оролцоог эрчимжүүлэх, засаглалыг боловсронгуй болгох, идэвхтэй, хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэх асуудал чухал байна.

**Ахмад настан:** 2020 оны байдлаар Монгол Улсад 65 болон түүнээс дээш насны 143.7 мянган ахмад настан байгаа нь нийт хүн амын 4.3 хувийг эзэлж, үүнээс 39 хувь нь буюу 56 мянга нь эрэгтэйчүүд, 61 хувь нь буюу 87,7 мянга нь эмэгтэйчүүд байна. Нийт ахмадуудын 45 хувь нь Улаанбаатар хотод оршин суудаг. Мөн ганц бие ахмадын тоо жил бүр нэмэгдэж, тэдний 72 орчим хувийг эмэгтэйчүүд, үлдсэн хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. ҮСХ-ны Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоогоор 2045 онд Монгол Улсын хүн ам 5 сая болж өсөх бөгөөд 65 болон түүнээс дээш насны ахмад настан нийт хүн амын 9 хувийг эзэлж, 2020 оноос 2.1 дахин өсөхөөр байна.

Төрөөс ахмад настнуудыг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулж, тэдний эрхийг баталгаажуулж, хөгжлийг дэмжсэн эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Ахмад настны тухай хууль, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль зэрэг ахмад настантай холбоотой хууль тогтоомжийн шинэчилсэн найруулга, нэмэлт, өөрчлөлтийг батлан хэрэгжүүлж байна. Бүх ахмад настанд “Нийгмийн даатгалын сан”, “Нийгмийн халамжийн сан”-гаас өндөр насны тэтгэвэр олгож, амьжиргааг дэмжих, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн олон төрлийн тэтгэмж, дэмжлэг, хөнгөлөлтийг үзүүлж байна.

Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолоор “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага нь нутаг дэвсгэртээ ахмадын ордон, өргөө, төвийг байгуулан ажиллуулж, ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах, сонирхлын бүлэг, клубыг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зэргээр хамтран ажиллаж байна. Улсын хэмжээнд ахмадын ордон 21, өргөө 188, ахмадын төв 18, танхим Ахмад настны эрүүл, урт насалж байгааг дэмжих, орлогын баталгааг бууруулахгүй байх зорилгоор 2017 оноос эхлэн 5 дахь жилдээ 65 ба түүнээс дээш настай ахмад настанд насны хишиг тэтгэмжийг жилд 2 удаа олгож байгаа бөгөөд 2019 онд 22.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, орлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тус хөтөлбөрт өссөн дүнгээр нийт 1092 ахмад хамрагдаж, 1,1 тэрбум төгрөг зарцуулж, 1027 ажлын байр шинээр бий болсон.

"Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төрөлжсөн асрамжийн үйлчилгээний шинэчлэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж байна. Улсын хэмжээнд ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг хүргэх улсын төсвийн санхүүжилттэй 8, хувийн хэвшлийн 4 асрамжийн газар үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 450 гаруй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд асруулж байна. Сэргээн засах тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн даатгалын сан”-гаас нэг иргэнд 110 мянган төгрөгийн



хөнгөлөлт үзүүлж байна. 2019 оны байдлаар орон нутгийн 28, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 26, нийт 54 эрүүл мэндийн байгууллагад сэргээн засах тусламж, үйлчилгээнд нийт 3.8 тэрбум төгрөг зарцуулж, 34326 даатгуулагч хамрагдсан.

Ахмад настнууд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт, ганц бие, харж хандах хүнгүй ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс, түлш худалдан авах мөнгөн тусламж, протез, ортопед, тусгай хэрэгслийн жишиг үнийн хөнгөлөлт, магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувиллын замын зардал, эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт, нийслэлээс 1000 км зайтай орон нутагт оршин суугаа ахмад настан эмчилгээ, оношилгоо хийлгэхээр нийслэлд ирж, буцах тохиолдолд нэг талын унааны зардлын хөнгөлөлт зэргийг олгож байна. Мөн ахмад настнууд орон нутгийн харьяалал харгалзахгүй нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхийг эдэлж байна. “Ахмадын орон сууц” хөтөлбөрт ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй, гачигдалтай иргэд, байгалийн давагдашгүй хүчин зүйлд орон гэрээ алдсан, нийгмийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай иргэд хамрагдаж, зөвхөн ашиглалтын зардлаа төлөн түрээсийн гэрээгээр амьдрах бөгөөд эхний ээлжинд 300 айлын орон сууцыг ашиглалтад оруулсан байна.

Зарим улс оронд ахмад настныг зохион байгуулалттайгаар дэмжих бүлэг, ялангуяа ахмад настнуудын өдөр өнжүүлэх, гэрт нь очиж асрах сайн дурын үйлчилгээ байдаг боловч манай улсад энэ төрлийн үйлчилгээ, үйл ажиллагаа дутмаг байна.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд:** 2020 оны байдлаар Монгол Улсад 108399 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь нийт хүн амын 3.2 хувийг эзэлж, үүнээс 32.8 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 55.4 хувь нь эрэгтэйчүүд, 44.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн тус тооллогын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амын 32.9 мянга (33.4 хувь) нь ажиллах хүч байгаагийн 20.0 мянга (60.9 хувь) нь эрэгтэйчүүд, 12.9 мянга (39.1 хувь) нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах хүчний ихэнх буюу 46.5 хувийг 25-44 насныхан эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэм, сэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл, урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах зорилгоор УИХ-аас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг шинээр батлан хэрэгжүүлж байна. Мөн төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллага, иргэдийн хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжтэй орчинг бүрдүүлэх зорилгоор Хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан нэгж буюу “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар”-ыг 2018 онд байгуулсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар авах арга хэмжээг эрчимжүүлэх, төр, төрийн бус байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чиглэлээр бодлого, төсөл, хөтөлбөр

боловсруулж хэрэгжүүлэхэд томоохон дэвшил болсон юм. Түүнчлэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд 2018 онд 170 сая төгрөг төсөвлөн, 18 арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг баталж, 2017-2019 онд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 5.4 тэрбум төгрөг зарцуулж, 121.7 мянган иргэнийг хамруулсан бөгөөд 2018-2019 онд 2103 ажлын байр бий болсон байна. 2018 оноос АХБ-тай хамтран “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд 6 аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв”-ийг байгуулж байна. Мөн нийслэл Улаанбаатар хотод “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв” болон “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв”-ийг ашиглалтад оруулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн саадгүй зорчих нөхцөлийг хангах асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хуульд тусгаж, холбогдох норм, нормативын баримт бичгийн дагуу зам, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулж байна. Улаанбаатар хот, бусад хот, суурин газарт шинээр баригдах орон сууцны хотхон, хорооллын барилга байгууламжийн орц, гарцад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулан налуу зам, цахилгаан шатанд брайль үсгэн тэмдэглэгээтэй товчлуур, гадна авто машины зогсоолын 3 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоол, хотхон, хорооллын доторх явган замыг хараагүй хүмүүст зориулсан товгор гадаргуутай хавтан бүхий зам, барилга байгууламжийн нэгдүгээр давхарын хонгилын хананд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул зэргийг барилга байгууламжийн зураг төсөлд заавал тусган төлөвлөх, гүйцэтгэхэд хяналт тавьж байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар баталсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-аар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн түрээсийн квотыг хотод болон орон нутагт 5 хувь байхаар тогтоосон. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 2484 айлын түрээсийн орон сууцны сан бүрдүүлснээс 129 айлын орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан нь нийт түрээслэгчдийн 5.2 хувийг эзэлж байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний 1207 тээврийн хэрэгсэл бүртгэлийн санд бүртгэгдсэнээс 56 нь буюу зөвхөн 4.6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нам шалтай, зориулалтын шаттай байна. “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 283 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрт “Зорилтот бүлгийн иргэд (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон яаралтай тусламж, үйлчилгээ авах шаардлагатай иргэн, 18 хүртэлх насны хүүхэд) орон нутгийн нислэгээр хөнгөлөлттэй үнээр зорчих нөхцөлийг бүрдүүлэх” асуудлыг тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, хүүхдийг яаралтай тусламж, үйлчилгээ авахад агаарын тээврээр хөнгөлөлттэй зорчих эрх зүйн орчинг бүрдүүлсэн.

**Шилжин суурьшсан иргэд:** 2020 оны байдлаар Монгол Улсын хүн амын 69 хувь нь хот, суурин газарт, 31хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Хот, суурин газарт амьдардаг хүн амын 68.9 хувь нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод амьдарч байна. 2018 онд хэвлэгдсэн Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын (ОУШХБ) судалгаагаар Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн сүүлийн 30 жилд хөдөө, орон нутгаас ихэвчлэн

Улаанбаатар хот руу чиглэсэн бөгөөд орон нутгийн хүн ам цөөрч, хотод хүн амын хэт төвлөрөл, ачаалал (ялангуяа гэр хороололд) үүсээд байна гэж дүгнэсэн.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Улаанбаатар хотын хүн амын 68.3 хувь нь Улаанбаатар хотод шилжиж ирсэн байна. Орхон аймагт хамгийн өндөр буюу 7.6 хувь нь, Дархан-Уул аймагт 5.8 хувь нь, Сэлэнгэ аймагт 3.9 хувь нь, Төв аймагт 2.9 хувь нь бусад аймгаас шилжин ирэгсэд байна. 1990 оноос хойш нийслэлд хөдөө, орон нутгаас 692 мянган хүн шилжин ирсэн бөгөөд улсын нийт хүн амд эзлэх нийслэл хотын хүн ам 24.8 хувь байснаас 47.6 хувь болж өссөн. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь гэр хороололд амьдарч байна. Эдгээрийн ихэнх нь ажил хайж, амьдралын нөхцөлөө сайжруулах, боловсролын боломж, илүү дээр эрүүл мэндийн үйлчилгээг эрэлхийлж эсхүл гэр бүлийн гишүүдтэйгээ хамт амьдрахаар ирсэн байна. Хотод төвлөрөл, хөдөөд уул уурхайн салбар эрчимжиж байгаатай холбоотойгоор Монгол Улсад эмэгтэйчүүд хот руу, эрэгтэйчүүд хөдөө рүү чиглэсэн эсрэг урсгал бий болсон байна.

Хүүхдүүддээ боловсрол олгох, эрүүл мэндийн үйлчилгээ авах хүсэл нь шилжилт хөдөлгөөний гол шалтгаануудын нэг юм. 2019-2021 онд БХБЯ, ҮХГ, ЖАЙКА хамтран хэрэгжүүлсэн “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн хүрээнд шилжилт хөдөлгөөнд “татах”, “түлхэх” хүчин зүйлс байна гэдгийг тодорхойлсон. “Түлхэх” хүчин зүйлс нь хүмүүсийг өөрийн оршин сууж байсан газраа орхиход хүргэж буй, амьжиргаа болон сайн сайхан байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсийг хэлэх бөгөөд үүнд зуд, малын тоо, толгойн хорогдол, бэлчээрийн доройтол, уур амьсгалын өөрчлөлт, санхүүгийн хүндрэл болон өвчлөл, эрүүл мэндийн асуудлууд багтаж байна. Хүмүүсийг хот, суурин газар тэр дундаа нийслэл Улаанбаатар хот руу “татах” хүчин зүйлс нь ажил, орлого, хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, хотод амьдарч буй гэр бүлийн гишүүнийдээ очиж амьдрах зэрэг гэр бүлийн шалтгаанууд байна. Чанарын судалгаанаас харахад шилжин суурьшигчид харьцангуй амьжиргаагаа авч явах, хувийн зохион байгуулалт хийх чадвартай бөгөөд энэ нь нүүдэлчин амьдралын хэв маяг эрхэлдэг байсантай холбоотой юм.

2017 оноос нийслэлд шилжин суурьшихыг хориглож, орон сууц, нийгмийн үйлчилгээний нөөцийн хэрэглээг нэмэгдүүлж буй хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хууль бус суурьшилт, газар өмчлөлийг зогсоохыг оролдож байна. Гэтэл энэ нь Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалыг зогсоох эсвэл бууруулахын оронд хотын захад “хууль бус” шилжин суурьшигчид бий болоход хүргэж, гэр хорооллыг улам бүр тэлж байна.

Дотоодын шилжилт хөдөлгөөний урт хугацааны бусад сөрөг үр дагавар нь хөдөөгийн хүн амын тоо буурах үзэгдэл юм. Харин гадаад руу шилжих хөдөлгөөнд ихэвчлэн илүү боловсролтой, идэвхтэй, санаачлагатай хүн ам оролцдог. Ийнхүү эдгээр хүмүүсийн хүчин чармайлт, хувь нэмрийг улсын, орон нутгийн эдийн засагт оруулах боломжийг алдаж байна. ОУШХБ болон ШХА-аас эх орондоо нөхцөл байдлыг сайжруулж, ирээдүйд эдгээр хүмүүсийг олж авсан чадвар, туршлага, мэдлэгтэйгээ буцаж ирэх боломжийг бүрдүүлэхийг зөвлөж байна.

Шилжин суурьшигчдын асуудалд хандсан, ялангуяа Улаанбаатар хотод шинээр шилжин ирсэн иргэдэд зориулсан бодлого одоо болтол боловсруулалтын шатандаа байна. “Монгол Улс дахь шилжилт хөдөлгөөний менежментийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр”-ийн мэдээлэлд тусгаснаар “дотоод шилжилт хөдөлгөөнийг бодлого, салбар, үндэсний хөгжлийн төлөвлөлттэй уялдуулан нэгэн урсгалд оруулсан шилжилт хөдөлгөөний цогц бодлого байхгүй байгаа нь Монгол Улсын хөдөө болон хот, суурин газруудад эдийн засаг, нийгэм, байгаль орчны ноцтой асуудлуудыг үүсгэж байна” гэжээ.

#### **1.1.1.4.Гудамж, явган хүний зам, унадаг дугуйн зам зэрэг нийтийн эзэмшлийн орон зайг ашиглах боломжийг бататгах**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 37, 100 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ”, 2016-2020 онд “Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулж, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэх”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн ногоон байгууламжийг 3 дахин нэмэгдүүлэх бодлого баримтална”, “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан “Гудамж”, “Дугуйн зам” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ”, “Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсацыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ”, “Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорхи болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ”, “Улаанбаатар хот, аймгийн төв, томоохон суурин газрын гудамж, талбайг камержуулж, иргэдийг гэмт халдлага, зөрчлөөс хамгаалах нөхцөлийг сайжруулна” зэрэг зорилтууд дэвшүүлсэн.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хот байгуулалтын тухай хууль, Орон сууцны тухай хууль, Газрын багц хууль, “Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” зэрэг холбогдох бусад хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна. Мөн нийслэл хот, аймаг, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах зургийн даалгаварт ногоон байгууламжийн эзлэх хувийг 15-20 хувьд хүргэсэн байх, нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх нөхцлийг хангах, явган хүний зам, дугуйн зам, авто зогсоол, гэрэлтүүлэг, усан оргилуур зэргийг төлөвлөсөн байх шаардлагыг тусган, экспертиз хийх замаар хянан, хэрэгжүүлж байна.

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жил эрчимтэй явагдаж буй хотжилт буюу хүн амын төвлөрлийг дагасан бүтээн байгуулалтын ажлын явцад ногоон байгууламжийг устгаж, барилга байгууламж барих, зам, барилга, газар доорх инженерийн шугам сүлжээний засварын ажил хийсний дараа нөхөн сэргээх ажил хийгддэггүй зэргээс шалтгаалж нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газруудын ногоон байгууламжийн тоо буурсан байна. Хот, суурин газрын ногоон байгууламжид чиглэсэн үйл ажиллагаа нь зөвхөн одоо байгаа ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн сэргээх, нөхөн тарилт хийхэд чиглэгдэж, харин шинээр байгуулагдаж байгаа ногоон байгууламж нь хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангаж чадахгүй байна. Мөн ногоон байгууламжийн арчилгааг тогтмол хийх мэргэжлийн байгууллага дутмаг, зориулалтын санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэр, менежмент байхгүйн улмаас энэхүү ажил хангалтгүй хийгдэж ирсэн.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийн хэрэгжилтийн хугацаанд нийслэл Улаанбаатар хотод нийт 1852.68 га талбайд ногоон байгууламж бий болсон байхаар төлөвлөсөн. Үүнээс 2020 оны байдлаар нийтийн эзэмшлийн шинээр 40.4 га, арчилгааны 122.4 га, хязгаардагдмал хэрэгцээний 1.2 га, тусгай хэрэгцээний 16 га, нийт 180 га газарт ногоон байгууламжийг шинээр нэмэгдүүлж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг

5.1 м2 хүргээд байна. Улаанбаатар хотын ЗАА-наас гэр хорооллын айл өрхүүд хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах санал, санаачилгыг дэмжин ажиллаж, улмаар 2025 он гэхэд нэг хүнд ногдох ногоон байгууламжийг 8 м2-т хүргэхээр зорьж байна. Нийслэлийн ИТХ-ын 2019 оны тогтоолоор “Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө -2030”-г батлан мөрдүүлж байна. Улаанбаатар хотын дундуур урсах Туул гол, түүнд цутгах Сэлбэ, Улиастай болон бусад жижиг голуудын хөндийг хамасан ногоон байгууламжийн сүлжээг байгуулж, суурьшилд тохиромжгүй нутаг дэвсгэр, гол, горхинуудын хамгаалалтын зурвас газруудыг одоо байгаа суурьшлаас чөлөөлж, мод тарьж ойжуулан цэцэрлэг, байгалийн ногоон байгууламж байгуулахаар ажиллаж байна. Хотын тохижилт, ногоон байгууламжийн төрийн удирдлагын үйл ажиллагаанд анх удаа ISO9001:2016 олон улсын чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлснээр төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтыг гэрээт аж ахуй нэгж, байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшил болгосон.

Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшил газарт тохижилт хийх ажлын хүрээнд иргэн, аж ахуй нэгж, төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2017-2020 онд НХБХГ нийт 916 тохижилтын төлөвлөлтийн даалгавар, 468 тохижилтын загвар зураг баталсан. Иргэдийн амрах, зугаалах, чөлөөт цагаа ая тухтай, зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг бий болгох зорилгоор 84 га талбайг хамарсан “Туул гол дагуу амралт, зугаалгын цогцолбор” байгуулах ажлын зураг төслийг боловсруулсан.

Орон сууцны хорооллууд дундах тохижилт, ногоон байгууламжгүй, сул шороон хөрстэй, хүний хөлд тахлагдсан, борооны ус ихээр тогтдог нийслэлийн 9 дүүргийн 157 байршилд ойн төгөл бүхий бичил тохижилт хийх судалгааг хийж, хот төлөвлөлт, инженерийн шугам сүлжээ, газар олголт зэргийг харгалзаж нийт 38 байршилд ойн төгөл бүхий бичил тохижилт хийсэн. Нийслэлийн иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд шинээр спортын талбай 59, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай 228, ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэн 31, дугуйн зам 10 байршилд, явган алхалт гүйлтийн 69.4 км зам байгуулагдаж байна.

Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэх зорилтын хүрээнд хот, суурин газруудад үндэсний болон хот, дүүрэг, хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэнгүүдийг шинээр барьж байгуулан, тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод хотын чанартай ногоон байгууламж болох “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-г 320 гаруй га талбайд байгуулж (<https://park.ub.gov.mn/>), одоо байгаа 10 цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбайг шинэчлэн тохижуулж, мөн Зүүн бүсийн тулгуур төв Чойбалсан хотод “Найрамдал” цэцэрлэгт хүрээлэн, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод “Галба” цэцэрлэгт хүрээлэн, Төвийн бүсийн тулгуур төв Дархан хотод “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн (44.5 га) зэрэг бүсийн тулгуур төв хот, аймгийн төв хотуудад цэцэрлэгт хүрээлэн байгуулж байна.


Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт дүүргийн чанартай соёл, спорт, амралт, аялал жуулчлалын цогцолбор бүхий “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн”-г байгуулсан. “Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн” нь 30 гаруй нэр төрлийн 70.000 мод, бут, сөөг бүхий 80 мянган га талбай ногоон орчин бүхий томоохон бүтээн байгуулалт юм. Цаашид тус хүрээлэнд олон нэр төрлийн мод, ургамалыг үргэлжлүүлэн тарьж, хүүхэд, залуучуудад танин мэдэхүйн ач холбогдол бүхий Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн болгон хөгжүүлэх юм (Зураг 1-ийг үзнэ үү).

**Зураг 1. Эрдмийн цэцэрлэгт хүрээлэн**



Орчны тохижилтыг сайжруулах ажлын хүрээнд усан оргилуур, амрах талбай, явган зам, спортын талбайг тохижуулж, хаягжуулалт, дугуйн зам, камержуулалт, гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмж, байгууллагуудын гаднах талбайг тохижуулж, оршуулгын газрын орчныг жил бүр үе шаттайгаар ойжуулж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны зарлигаар жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн Бямба гарагийг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр” хэмээн зарлан зохион байгуулж ирсэн бөгөөд бүх нийтээрээ мод, бут, сөөг, цэцэг тарих, арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлж байна.

**Зураг 2. Улаанбаатар хотын 100 айлын хуучин болон шинэ гудамж**



2013 оноос “Гудамж” төслийг нийслэл Улаанбаатар хот, зарим аймгийн төв хотуудад амжилттай хэрэгжүүлж, тус төслийн хүрээнд нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хамгийн ачаалал ихтэй 24 уулзварыг шинэчилж, хөдөлгөөний зөв зохион байгуулалттай болгосон байна. Нийт 50 гаруй байрлалд гудамж, замын сүлжээг сайжруулах, нийтдээ 100 шахам км урт бүхий гудамж замын зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 8 байршилд нийтдээ 21.42 км авто зам өргөтгөн, авто замын сүлжээг шаардлагатай чиглэлүүдэд хөгжүүлж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Архангай аймгийн төв Цэцэрлэг хотод нийт 8.1 км авто зам, 3.25 км дугуйн зам шинээр барьж, 7 уулзварын өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Увс аймгийн төв Улаангом хотод 11.15 км авто зам, 10 уулзвар өргөтгөн шинэчлэхээр төлөвлөснөөс 6.4 км авто зам, 4 уулзварын ажил дууссан. Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотод 12.3 км авто зам, 3 уулзвар өргөтгөн шинэчлэх ажлын зураг төслийг боловсруулж, бусад аймгийн төвүүдийн дэдбүтцийг хөгжүүлэх судалгаа, төлөвлөлтийн ажлуудыг хийсэн (2013 оноос “Гудамж” төслийг нийслэл Улаанбаатар хот, зарим аймгийн төв хотуудад амжилттай хэрэгжүүлж, тус төслийн хүрээнд нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлж, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор

хамгийн ачаалал ихтэй 24 уулзварыг шинэчилж, хөдөлгөөний зөв зохион байгуулалттай болгосон байна. Нийт 50 гаруй байрлалд гудамж, замын сүлжээг сайжруулах, нийтдээ 100 шахам км урт бүхий гудамж замын зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 8 байршилд нийтдээ 21.42 км авто зам өргөтгөн, авто замын сүлжээг шаардлагатай чиглэлүүдэд хөгжүүлж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлсэн. Архангай аймгийн төв Цэцэрлэг хотод нийт 8.1 км авто зам, 3.25 км дугуйн зам шинээр барьж, 7 уулзварын өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. Увс аймгийн төв Улаангом хотод 11.15 км авто зам, 10 уулзвар өргөтгөн шинэчлэхээр төлөвлөснөөс 6.4 км авто зам, 4 уулзварын ажил дууссан. Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотод 12.3 км авто зам, 3 уулзвар өргөтгөн шинэчлэх ажлын Зураг 2, Зураг 3-ыг үзнэ үү).

Зураг 3. Аймгийн төвүүдэд барьсан авто зам




Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 196 дугаар тогтоолоор “Гудамж” төслийн нэгжийг татан буулгаж, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөлд шилжүүлэн, тус төслийн хүрээнд “Хилийн боомт” дэд төсөл, “Аймгийн төв” дэд төсөл, “Гудамж” дэд төслүүдийг Засгийн газрын үнэт цаас, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрийн санхүүжилтээр хэрэгжүүлж байна. “Гудамж” дэд төслийн хүрээнд “Гудамж төсөл”-ийн үлдсэн ажлыг гүйцэтгэж дуусгах, Туулын хурдны замын барилгын ажлыг гүйцэтгэх, Нийслэлийн гэр хорооллын авто замын сүлжээ “Шинэ их тойруу” хөтөлбөр, Гандантэгчинлэн хийд орчмын гэр хорооллын нөхцөлийг сайжруулах төсөл, “Ногоон Улаанбаатар” хөтөлбөр, “Туул, Сэлбэ орчмыг сайжруулах” төслийг тус тус хэрэгжүүлж байна. (<http://diip.mn/gudamjtusul>)

“Дугуйн зам” дэд хөтөлбөрийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотын төвийн хэсэгт болон Сэлбэ, Туул голыг дагасан унадаг дугуйн замын зураг төслийг боловсруулан 2020 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 53.2 км дугуйн замыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд 50.7 км дугуйн замыг барьж байна (Зураг 4-ийг үзнэ үү).

Нийслэлийн Засаг даргын захирамжаар “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай дахь явган хүний зам, гарц, гармыг хаан, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж байгаа зөрчлийг арилгах чиглэлээр ажлын хэсэг байгуулж, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулж байгаа байршлуудын нарийвчилсан судалгааг гаргасан. Дээрх төсөл, хөтөлбөрүүдтэй холбоотой сайн жишээний талаарх мэдээллийг Хавсралт хуудас 153-169 аас үзнэ үү.

Зураг 4. Улаанбаатар хотын дугуйн зам



### 1.1.2. Шаардлага хангасан орон сууцны хүртээмж

#### 1.1.2.1. Шаардлага хангасан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 33 дахь хэсэгт “Орон сууцны хэрэгцээг хангасан хангамжийн асуудлыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцан адилгүй орлоготой бүлгийн гишүүдэд аюулгүй, хямд, хүртээмжтэй, эмзэг бүлгийн орон гэргүй иргэдийг түлхүү анхаарах, эмзэг бүлгийн иргэдийг нийгмээс тусгаарлагдахаас урьдчилан сэргийлэх, мөн амьдрах нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах, нийгмийн харилцаанд тэгш оролцох, орон гэргүй болохоос урьдчилан сэргийлэх” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор 897.4 мян. өрхийн 32.7 хувь нь инженерийн хангамжтай нийтийн зориулалттай болон хувийн орон сууцанд, 29.1 хувь нь инженерийн



хангамжгүй байшин сууцанд, 38.2 хувь нь гэрт амьдарч байна<sup>1</sup>. Гэр бол монголын үндэсний сууц буюу уламжлалт архитектур. Манай улсын хот, суурингуудын гадаад орныхоос ялгагдах нэг онцлог, имидж нь “гэр хороолол” байдаг. 2010 онд “Монгол гэр”-ийг Азийн архитектурын үнэт өвд бүртгэсэн. Гэр нь нүүдэлчдийн ахуй, амьдралд зориулагдаж зохицсон сууц бөгөөд цаашид хотжилтод хэрхэн зохицуулах талаар оновчтой хувилбарыг сонгож, зөв шийдлийг олохоор ажиллаж байна (Зураг 5, Зураг 6-г үзнэ үү).

Улсын хэмжээнд 2017-2020 онд жилд дундаар 15415 айлын орон сууц ашиглалтад оруулсан нь 2016 оныхоос 20.2 хувиар буурсан байна.<sup>2</sup> Энэ нь 2016 оны эдийн засгийн хүнд нөхцөл байдалтай холбогдон буурсан ипотекийн зээлийн санхүүжилттэй шууд хамааралтай байна. Мөн Коронавируст халдвар (COVID-19) цар тахлаас шалтгаалсан хилийн хоригоос хамаарч барилгын материалын хомсдол үүсч, үнэ өсч, барилгажилт удааширсантай холбоотой байгаа хэдий ч Засгийн газраас ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор ашиглалтад орох орон сууцны тоо нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 5. Улаанбаатар хотын орон сууцны болон гэр хороолол




Зураг 6. Монгол гэр



<sup>1</sup> Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого

<sup>2</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2020 он

График 1. Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны тоо (2010-2022 он)



Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс, <https://www.1212.mn>

Орон сууцны барилгууд олноор баригдаж, ашиглалтад орж байгаа боловч бага, дунд орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлт хомс байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, харж, хандах үр хүүхэдгүй ахмад настан, бүтэн өнчин хүүхэд, залуучууд, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр орон гэргүй болсон айл өрх, ажил, амьдралын гараагаа эхэлж байгаа залуу гэр бүл, хот, суурин газарт түр хугацаагаар ажиллаж, суралцаж байгаа оюутан, залуусын түр амьдрах орон байрны асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлага байгааг харгалзан “Түрээсийн орон сууцны сан”-г бүрдүүлж, иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах зорилгоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөр, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор батлан 2015-2021 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2016 оны 169 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрт төрийн болон орон нутгийн өмчийн нэг айлын түрээсийн сууц нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчинг бүрдүүлсэн, инженерийн иж бүрэн хангамжтай, зочны, унтлагын, гал тогоо, ариун цэврийн өрөө бүхий 70 м<sup>2</sup> хүртэлх талбайтай сууц, хувийн хэвшлийн нэг айлын түрээсийн орон сууцны хувьд талбайн дээд хязгаарыг тогтоохгүй бөгөөд талбайн доод хэмжээ 30 м<sup>2</sup>-аас багагүй байхаар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Түүнчлэн, Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор тус хөтөлбөрийн хүрээнд бий болсон түрээсийн орон сууцыг дамжуулан түрээслэх, түрээсийн орон сууцыг өмчлүүлэхтэй холбоотой журамд зааснаас өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалахыг хориглосон зохицуулалтыг нэмж, “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг баталсан. Тус журамд залуу гэр бүл, төрийн албан хаагч, хувийн байгууллагын ажиллагсад, 0-18 насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй, өндөр насны тэтгэвэр тогтоосон ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгалийн гамшигт нэрвэгдсэн иргэдэд түрээсийн орон сууцанд хамрагдах квотыг Улаанбаатар хот, орон нутагт гэж ангилан тусгасан.

Засгийн газрын 2019 оны 216 дугаар тогтоолоор түрээслэгч нь түрээсийн төлбөрөөс гадна түрээсэлж буй улс, орон нутгийн төсөв, “Орон нутгийг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 5 хүртэлх жилийн хугацаанд, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 15 хүртэлх жилийн хугацаанд сар бүр хуваарийн дагуу хэсэгчлэн төлж, түрээсийн орон сууцаа худалдан авч өмчлөх зохицуулалтыг шинээр тусган хэрэгжүүлж байна.

Зураг 7. Хангай хотхон



Зураг 8. “Буянт-Ухаа 2” хороолол



ахуй, инженерийн дэд бүтцийн хангамж, чанар үйлчилгээг нэмэгдүүлэх замаар иргэдийн тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг сайжруулна” гэсэн зорилтыг тусгасны дагуу холбогдох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд Улаанбаатар хотод “Ногоон нуур-1008 айлын орон сууц төсөл”, “Солонго-1”, “Солонго-2” төсөл, “Баянголын ам” төсөл, хотын дэд төвүүдэд нийт 10000 айлын орлогод нийцсэн орон сууцны хороолол барих төслүүдийг хэрэгжүүлж эхлээд байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд олноор баригдаж, ашиглалтад орж байгаа боловч бага, дунд орлоготой иргэдийн худалдан авах чадварт нийцсэн орон сууцны нийлүүлэлт хомс байна Үүнтэй холбогдуулан хот, суурин газарт амьдардаг нийт өрхийн дийлэнх олонхын худалдан авах чадварт нийцсэн, Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, инженерийн бүрэн хангамжтай орон сууцтай болох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор батлан

хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрт орон сууцны санхүүжилтийн тогтолцоо, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөх замаар байгаль орчинд ээлтэй, ашиглалтын зардал багатай инженерийн дэд бүтцэд холбогдсон тохилог гэр, амины болон нийтийн орон сууцны хороолол болгон хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал багатай, ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг дэмжих, төрийн халамж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах зорилтуудыг дэвшүүлэн 2019-2023 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### **1.1.2.2.Орон сууцны тогтвортой санхүүжилтийн хувилбаруудыг бий болгох**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 46 дахь хэсэгт “эдийн засгийн хөгжлийг дэмжихийн тулд нийгмийн орчин бүрдүүлэх, төлбөрийн чадамжид нийцсэн, тогтвортой орон сууц барьж байгуулах, орон сууцны санхүүжилтийг сайжруулснаар эдийн засгийн бусад салбарт оруулах хувь нэмэр дээшилнэ” гэж тусгасан. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчилж, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Орон сууцны зах зээлийн эрэлт талд орон сууц худалдан авах хүсэлтэй маш олон иргэд байгаа бөгөөд нийлүүлэлт талд түүнийг бүрэн хангах хэмжээний шинэ орон сууц баригдаж, ашиглалтад орсоор байна. Улсын хэмжээнд иргэдийн дундаж цалин нэг сая гаруй төгрөг байгаа бөгөөд дунджаар 100 орчим сая төгрөгийн өртөг бүхий орон сууцыг худалдан авахад айл өрхийн худалдан авах санхүүгийн чадавх хангалтгүй байна. Манай улсад иргэд ипотекийн болон арилжааны банкуудын орон сууцны зээл, түүнчлэн барилгын компаниудын санал болгож буй хувь лизингээр орон сууц худалдан авч байна.

**Ипотекийн зээл:** Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 6 дугаар сараас эхлэн “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд давхардсан тоогоор нийт 100 орчим мянган өрх хамрагдсан бөгөөд нийт 5.4 их наяд төгрөгийн санхүүжилтийг хөтөлбөрт зориулсан байна. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд гэр хороололд амьдарч байсан нийт 25 мянга орчим өрх ипотекийн зээлээр орон сууц худалдан авч, орон нутагт 15 мянган өрх орон сууцанд орж, 11 мянган өрхийн зээлийн хүүгийн төлбөр буурч, дунджаар сарын төлбөр 290 мянган төгрөгөөр багассан. Засгийн газраас иргэдийг орон сууцжуулах асуудалд нэн чухал ач холбогдол өгч, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байгаа бөгөөд үүний нэг нь Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-392 дугаар тушаалаар шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 8 хувь байсныг жилийн 6 хувь болгож бууруулсан. Тус арга хэмжээний үр дүнд зээлдэгчийн сарын эргэн төлөлтийн хэмжээ болон зээлийн шалгуурт тавигддаг өрхийн орлогын доод хэмжээ тус тус 18.3 хувиар буурч, ипотекийн зээлд орлого багатай өрхийн хамрагдах боломж нэмэгдэх, цар тахлын эрсдэл өндөр үед зээлийн дарамт буурах, өрхийн амьжиргаа нэмэгдэх, зээлийн эрсдэл буурах зэрэг эерэг нөхцөл бүрдсэн.

Манай улсын хувьд өнгөрсөн хугацаанд ипотекийн зээл олгох үйл явц нэмэгдэж байгаа хэдий ч нэг талаасаа орон сууцны ипотекийн зээлийн шаардлага хангасан иргэдийн тоо буюу өрхийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Жилд дунджаар шинэ орон сууц авч буй нийт айл өрхийн 20 гаруй хувийг ипотекийн зээлд хамруулж, харин үлдсэн 80


орчим хувь нь ипотекийн зээлээс бусад төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээр орон сууцтай болсон байна. Орон сууцны ипотекийн зээлийн ерөнхий нөхцөл, шалгуур үзүүлэлт<sup>3</sup>:

- Орон сууцны ипотекийн зээлийн хүү 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө олгосон зээлд жилийн 8 хувь;
- Орон сууцны ипотекийн зээлийн хугацаа 360 хүртэл сар,
- Урьдчилгаа төлбөр 30 хувиас доошгүй;
- Худалдан авах нийтийн зориулалттай орон сууцны талбайн хэмжээ 80м<sup>2</sup>-ээс ихгүй;
- Орон сууцны зээлийн хэмжээ 100 сая төгрөгөөс хэтрэхгүй.

2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш олгох зээлд жилийн 6 хувь тус тус байхаар журамд өөрчлөлт оруулсан<sup>4</sup>.

**Арилжааны банкуудын орон сууцны зээл:** Энгийн болон тансаг зэрэглэлийн орон сууц худалдан авах, хувийн хаус, хашаа байшин худалдан авах, барих зэрэг олон төрлийн зээлийг арилжааны банкууд санал болгож байна. Ихэнх банкууд хамгийн багадаа урьдчилгаа төлбөрт худалдан авах гэж буй орон сууцны нийт үнийн дүнгийн 20-30 хувийг шаардаж, 10-20 жилийн хугацаатай олгодог. Засгийн газраас орон сууцны ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгохоор шийдвэрлэж, 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол банк болон арилжааны банкуудаас 814.6 тэрбум төгрөгийн зээлийг 11043 зээлдэгчид олгосон байна.

График 2. 2013-2021 оны ипотекийн зээл олголт



Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс

**Барилгын компаниудын хувь лизинг:** Бизнесийн болон санхүүгийн нэмэлт орлоготой бол барилгын компаниудын зүгээс санал болгодог хувь лизингээр байр, орон сууц худалдан авах боломжтой. Гэвч энэ төрлийн зээл нь сар бүр өндөр дүнгээр эргэн

<sup>3</sup> Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-295 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”

<sup>4</sup> Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-392 дугаар тушаалаар баталсан Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам

төлдөг, мөн урьдчилгаа төлбөр 30-50 хувь байдаг тул ихэнх айл өрхөд хүндрэлтэй байна. Иймээс иргэд өөрийн санхүүгийн орлого, зарлагаа эртнээс тооцоолж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж чадвал зээл нь ухаалаг хөрөнгө оруулалт болох боломжтой.

**Төрийн албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ хувилбар:**

“Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” тогтоолыг УИХ-ын 2020 оны нэгдсэн хуралдаанаар баталсан. Уг тогтоолд “Төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх” гэж заасны дагуу Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор 2020-2021 онд нийт 1177 төрийн албан хаагчийг 99.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий орон сууцанд хамруулсны 1025 нь нийслэлд, 152 нь орон нутагт байна.

**Хүснэгт 4. Шинээр ашиглалтад орсон орон сууц (2017-2020 оноор)**

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он
Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууц (айлын тоо)	11023	11161	13999	15639
Улсын хэмжээнд төрийн ипотекийн зээл авсан зээлдэгч	6026	3909	4815	5594
Улсын хэмжээнд гарсан төрийн ипотекийн зээлийн санхүүжилт (тэрбум төг.)	404.00	309.20	443.30	410.00

Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс

2017 онд Монгол банкнаас “Орон сууцны зээлийн тогтолцоо: Олон улсын харьцуулалт” судалгааг хийж, Монгол Улсын орон сууцны зээл, санхүүжилтийг бусад улс орнуудтай харьцуулж, орон сууцны зээлийн нөхцөл болон олон улсад хэрэгжүүлсэн дэвшилтэд туршлагад үндэслэн манай улсад орон сууцны зээлийн санхүүжилтэд тулгарсан тогтвортой санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлж болох санал тусгасан байна. Үүнд: төрөөс богино хугацаанд орон сууцны зээлийг хүүгийн татаасаар дэмжих; хөнгөлөлтийг бага орлоготой өрхүүдэд чиглүүлэх; зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийг өөрчлөх замаар хүүг зах зээлийн түвшинд хүргэх; дунд болон урт хугацаанд гэрээт хадгаламжийн тогтолцоог нэвтрүүлэх; түрээсийн зах зээлийг хөгжүүлэх, орон сууцны зээлийн даатгалыг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Энэ хүрээнд 2015 оноос эхэлж хэрэгжсэн зорилтот бүлгийн иргэдийг орлогод нийцсэн түрээсийн болон түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцаар хангах хөтөлбөрийн хүрээнд бүрдсэн “Төрийн өмчийн орон сууцны сан”-д байгаа 4007 түрээсийн орон сууцаар зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангасан байна. Цаашид уг санг нэмэгдүүлэх, түрээсийн орон сууцны зах зээлийг хөгжүүлэх, зорилтот бүлгийн иргэдийн орон сууцжуулах боломжийг нэмэгдүүлэх, мөн гэр хорооллын дахин төлөвлөлт болон бусад чухал ач холбогдол бүхий бүтээн байгуулалтад шаардлагатай газар чөлөөлөлтийг эрчимжүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**1.1.2.3.Эзэмших эрхийн баталгааг бий болгох**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 35 дахь хэсэгт “Орон нутгийн засаг захиргаа, эзэмших эрхийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, эзэмшлийн олон хэлбэрийг хүлээн

зөвшөөрөх, үр дүнтэй захиргааны тогтолцоогоор дамжуулан эмэгтэйчүүдийг чадавхижуулах, тэдний газар эзэмших эрх, газар болон эд хөрөнгийн эрхээ үргэлжлүүлэхэд онцгой анхаарал хандуулан, зорилготой, нас-хүйс, байгаль орчинд ээлтэй шийдлийг хөгжүүлэх ажлыг Засгийн газрын түвшинд дэмжинэ” гэсэн зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно”, “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Газрын нэгдсэн бодлого, тогтолцоог бүрдүүлж, газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох”, мөн уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Газрын харилцааны талаар иргэдэд үзүүлэх үйлчилгээ, лавлагааны цахим системийг байгуулах”, “Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх”, “Төрөөс цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх”, “Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж тус тус заасныг хэрэгжүүлж байна.

Газрын харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон холбогдох бусад хуулиудтай уялдуулах зорилгоор Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны тушаалаар Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, шинээр Үндэсний орон зайн дэд бүтцийн тухай хуулийн төсөл, Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

“Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлан мөрдөж байна. Тус төлөвлөгөөгөөр нийт 11 зорилт, 86 арга хэмжээ, 526 бүтээгдэхүүн байхаар төлөвлөсөн. Газрыг өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй холбоотой нэгж талбарыг зураглах, бүртгэх, төрийн нэрийн өмнөөс баталгаажуулан үнэ цэнэтэй байлгах зорилгоор 21 аймаг, 330 сумыг хамарсан газрын кадастрын мэдээллийн нэгдсэн цахим системийг БХБЯ, ГЗБГЗЗГ удирдан зохион байгуулж, хэрэглээнд нэвтрүүлж байна. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийн нөөц хувилбарыг “Үндэсний дата төв”-д байрлуулан “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн системд холбосноор иргэн, аж ахуй нэгж, байгууллага орон зай, цаг хугацаанаас үл хамааран, өөрийн газартай холбоотой буюу кадастрын зураг, гэрээ, гэрчилгээ, захирамж гэх мэт мэдээллийг QR кодоор баталгаажуулж, цахимаар авах боломжтой болж, мөн газрын кадастрын мэдээллийн сангийн хэрэглээнд тоон гарын үсгийг нэвтрүүлсэн.

“Газрын кадастрын мэдээллийн сан”-гийн өгөгдлийн нэгдсэн нэг стандарттай мэдээлэл бүхий системийг байгуулж, улсын хэмжээнд нэгдсэн сүлжээнд холбосон. Тус сангийн програм хангамж нь нийт 401 гаруй төрлийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх, 60 гаруй төрлийн тайлан, мэдээ гаргах, 15 төрлийн хяналт шалгалтыг автоматаар хийх, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний дагуу газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох, өргөдлийг хүлээн авсан хугацааны дагуу шийдвэрлэх зэрэг боломжийг бүрдүүлсэн.

Засгийн газраас төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй нэгдсэн портал систем [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn)-д газрын харилцааны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг холбох ажлыг зохион байгуулсан. Ингэснээр иргэд,

олон нийт газартай холбоотой баталгаажсан мэдээлэл, лавлагааг орон зай цаг, хугацаанаас үл хамааран, хүртээмжтэй байдлаар олон эх сурвалжаас авах боломж бүрдсэн. “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан”-гийн үйл ажиллагаа улсын хэмжээнд бүрэн нэвтэрч, олон нийтэд нээлттэй мэдээллийн цахим системийг (egazar.gov.mn) шинэчлэн хөгжүүлсэний үр дүнд иргэд газартай холбоотой бүх төрлийн мэдээллийг баталгаат нэг эх үүсвэрээс авах нөхцөл бүрдэж, 2020 оны байдлаар нийт 618265 хандалт бүртгэгдсэн байна. ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/181 тушаалаар баталсан “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”-ыг 21 аймгийн ГХБХБГ, 330 сумын газрын даамал, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба мөрдөн ажиллаж байна. 2020 оны байдлаар “Газрын кадастрын мэдээллийн сан”-д шинээр 138370 нэгж талбар, 20637 барилга байгууламж бүртгэгдсэн байна.

Мөн иргэд, олон нийтэд газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү ойртуулах зорилгоор гар утасны “egazar” нэртэй аппликейшнийг Андроид болон IOS платформ дээр хөгжүүлж, 2020 оны 11 дүгээр сард хэрэглээнд гаргасан. Уг аппликейшнийг ашиглан иргэд тухайн жилийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд санал өгөхөөс эхлээд 18 төрлийн үйлчилгээг авах боломж бүрдэж, заавал харьяа нутгийн газрын албанд өөрийн биеэр очих шаардлагагүй болсон. Хэрэглээнд гарсан өдрөөс хойш нийт 5304 хэрэглэгч тус аппликейшнийг ашиглаж байна.

График 3. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчын тоо (2018-2020)



Эх сурвалж: ГЗБГЗЗГ

ГЗБГЗЗГ-аас Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ашиглуулах дуудлага худалдаа, газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах, төсөл сонгон шалгаруулалт явуулах журам”, “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалаар баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-ын дагуу улсын хэмжээнд зохион байгуулж байна.


2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 7981268.27 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгосон байна. Үүнээс 65836.28 га өмчилж, 7573997.47 га-г эзэмшиж, 313970.73 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага 27463,79 га газрыг тус тус ашиглаж байна.



Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 1110046 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байна. Хөдөө аж ахуйн газарт 177344, хот, тосгон, бусад суурины газарт 932484, зам, шугам сүлжээний газарт 3133, ойн сан бүхий газарт 4444, усны сан бүхий газарт 68, улсын тусгай хэрэгцээний газарт 1573 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байна. Үүнээс 4920 газар эзэмших эрхээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан байна. УБЕГ-ын судалгаагаар 32612 Монгол Улсын иргэн өөрийн өмчийн газраа банк, санхүүгийн байгууллагад барьцаалсан бөгөөд нийт 37532 нэгж талбар (газар эзэмших эрх, өмчийн газар) буюу нийт нэгж талбарын 4.7 хувийг банк, санхүүгийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд барьцаалсныг бүртгэсэн байна.

Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй газар өмчлүүлэх тухай хуулийн хугацаа 2018 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болох байсныг УИХ-аас иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй газар өмчлүүлэх тухай хуулийн хугацааг 10 жилээр сунгахаар шийдвэрлэсэн. 2018-2020 онд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 11851 иргэний 669.4 га эзэмших эрхтэй газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн байна. ГЗБГЗЗГ-ын эрхэлж буй үйл ажиллагааг цахим орчинд шилжүүлэх зорилгоор “Газрын удирдлагын нэгдсэн систем”-ийг байгуулах ажил 2016 оноос хийгдэж байна.

График 4. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчын хувиар



Эх сурвалж: ГЗБГЗЗГ

#### 1.1.2.4. Борчуудын хорооллыг өөрчлөх хөтөлбөрүүдийг эхлүүлэх

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 25, 27, 28 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ”, 2016-2020 онд “... Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, ...”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд хот, суурин газрын эдэлбэр газар дахь инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн

хангагдаагүй гэр, орон сууц бүхий суурьшлыг “гэр хороолол” гэж тодорхойлсон бөгөөд “Хотжилтын шинэ хөтөлбөр”-т туссан “Борчуудын хороолол” нь манай орны хувьд “гэр хороолол”-той ижил төстэй юм.

1990-ээд оноос хойш Монгол Улсад хот байгуулалт, газрын харилцааны салбарт шинэ хууль, эрх зүйн орчин бүрдэн хэрэгжиж байгаа боловч хот, суурин газрыг дахин төлөвлөж хөгжүүлэх, газрыг шинэчлэн зохион байгуулах асуудал орхигдсоноос хот, суурин газрын хэмжээнд гэр хорооллын тэлэлт нь төлөвлөлт, зохицуулалтгүйгээр ихээхэн нэмэгдсэн. Ялангуяа, сүүлийн 20-иод жилд хөдөөнөөс хот, суурин газарт чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр нийслэл Улаанбаатар хотод 2000 оноос эхлэн суурьшлын төлөвлөлт хийгдээгүй бүсэд шинээр 15 гэр хороолол үүссэн бөгөөд гэр хороололд суурьшсан өрхийн тоо 2005-2010 он хүртэл 19796 өрхөөр, 2010-2015 он хүртэл 29465 өрхөөр нэмэгдэж, 2016 онд 1380 өрх, 2017 онд 865 өрхөөр тус тус буурч 215.2 мянган өрх болсон бөгөөд энэ нь нийслэл Улаанбаатар хотын нийт хүн амын 55.7 хувийг эзэлж байна. Гэр хороололд суурьшсан 215.2 мянган өрхийн 102.9 мянга нь монгол гэрт, 110.1 мянга нь зураг төсөлгүй, гар аргаар барьсан инженерийн хангамжгүй байшин сууцанд амьдарч байна (Зураг 9-ийг үзнэ үү). (Эх сурвалж: Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал-2017, Нийслэлийн Статистикийн газар)

### Зураг 9. Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын ерөнхий байдал




Хот, суурин газруудад орчны бохирдол жилээс жилд нэмэгдэж, тухайлбал нийслэл Улаанбаатар хотын хүн амын 60 орчим хувь нь гэр хороололд суурьшиж, нийт өрхийн дийлэнх хувь нь төвлөрсөн ус, дулааны хангамжид холбогдоогүй, гэр хорооллын хүн амын хэт нягтрал, суурьшлаас хамааран агаар, хөрс, газрын гүний усны бохирдол их байгаа нь усны чанар, орчны аюулгүй байдлыг алдагдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. Үүнээс үүдэн гэр хорооллын иргэдийн хувьд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж, байгалийн гамшигт өртөх магадлал ихэсч, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн үйлчилгээг тэгш хүртэж чадахгүй, үйлчилгээний чанар хангалтгүй зэрэг тулгамдсан асуудлууд бий болсон.

УИХ-аас 2015 онд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг баталсан. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн зорилго нь Монгол Улсын иргэдийн эрүүл, аюулгүй, таатай орчинд амьдрах эрхийг хангах үүднээс “нийтийн эрх ашгийг эрхэмлэн, олон нийтийн оролцоог хангах” зарчмыг баримтлан төсөл хэрэгжүүлэхэд оролцогч талууд төслийн төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргахад оролцох, газар болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчидтэй зөвшилцөх, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хот, суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн

барилгажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. Тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 222, 341 дүгээр тогтоолоор “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам”-ыг баталж, 182 дугаар тогтоолоор “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээ”-г тогтоосон. Барилга, хот байгуулалтын сайдын 2016-2020 оны тушаалаар “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөлд оролцогчдын хооронд байгуулах гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар”, “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааны журам”, “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах үйл ажиллагааны журам”, “Газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлал” зэрэг 10 гаруй дүрэм, журам, загвар, аргачлалыг батлан, мөрдүүлж байна.

УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан нийслэл “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийн хүрээнд гэр хорооллыг байршлын хувьд төвийн, дунд, захын гэж ангилан төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой төвийн гэр хорооллыг дахин төлөвлөж, өндөр болон дунд давхрын барилгаар барилгажуулах, дунд хэсгийн гэр хорооллыг нам давхрын барилгажилтаар дахин төлөвлөж, хэсэгчилсэн инженерийн шугам сүлжээнд холбох, захын гэр хорооллын хэсэгт үе шаттайгаар бие даасан шугам сүлжээтэйгээр газрыг дахин зохион байгуулахаар төлөвлөсөн (Зураг 10-ыг үзнэ үү). Мөн хотын захын хороод, алслагдсан дүүргүүд, дагуул, хаяа хот, тосгодуудыг жигд тэнцвэртэй, эрчимтэй хөгжүүлж, суурьшлын шинэ бүсүүдийг байгуулан, Улаанбаатар хотод бий болсон хэт төвлөрлийг сааруулан, гэр хорооллын эзлэх хувь хэмжээг бууруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Зураг 10. Улаанбаатар хотын гэр хорооллын 3 бүс



Эх сурвалж: Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн, 2013 он

Гэр хорооллын төвийн бүсэд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл; дундын бүсэд 200-300 айлын дунд хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамжийг нэвтрүүлэх “Дэд бүтцийн төв” төсөл; захын бүсэд сэргээгдэх эрчим хүч, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр; Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл; Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл зэрэг төслийн сайн жишээний талаарх мэдээллийг хавсралт хуудас 153 -169 аас үзнэ үү.

Нийслэл Улаанбаатар хотод 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдийн хүрээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар орон сууц, нийгмийн дэд бүтцийн болон инженерийн шугам сүлжээний ажил, авто замын барилга угсралтын ажилд зориулан 1889 айлын газар чөлөөлөлт хийж, төвийн бүсэд 10287 орон сууцыг ашиглалтад оруулж, үүнээс 1484 айл гэр хорооллоос орон сууцанд орж, 192 айл түрээсийн орон сууцанд болон 185 айл түр суурьшуулах байранд амьдарч, 30 айл газар, үл хөдлөх эд хөрөнгөө худалдсан байна. Дундын бүсэд гэр хорооллын айл өрхийн хашаанд нь дэд бүтцийн хангамжийг холбох “Дэд бүтцийн төв” төслийг 3 байршилд хэрэгжүүлж, 600 гаруй айл өрхийг холбосон байна. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд төвийн 6 дүүргийн хэмжээнд 18 байршлын 30 нэгж талбарт гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил хийгдсэн. Гадна инженерийн шугам сүлжээний ажлын санхүүжилтэд улс, нийслэлийн төсвөөс 2013-2016 онд 121.4 тэрбум төгрөг, 2017- 2020 онд 50 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.(Эх сурвалж: Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар, 2020 он, <https://hia.ub.gov.mn/>)

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийг Монгол Улсын Засгийн газар, АХБ, Европын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр нийтдээ 106.1 сая ам.долларын хөрөнгө оруулалтын ажил 2017-2022 онд хэрэгжиж байгаа бөгөөд 2017-2020 онд “Баянхошуу дэд төв”, “Сэлбэ дэд төв”-ийн барилга, 240 хүүхдийн цэцэрлэг, Бизнес инкубатор, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, үерийн хамгаалалтын сувгийн ажил, дулааны станц, шугамын өргөтгөл, авто зам, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил хийгдсэн. Түүнчлэн, АХБ, “Уур амьсгалын ногоон сан”-гийн санхүүжилтээр Улаанбаатар хотын гэр хорооллын бүсэд нийт 100 га орчим газрыг 20 “Эко хороолол” болгон хөгжүүлж, 10000 айлыг орон сууцаар хангах зорилготой “Улаанбаатар хотын төлбөрийн чадварт нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл” (АНURP)-ийг 2020 оноос хэрэгжүүлж эхлээд байна

“Нийслэлийн гэр хорооллын өрхөд цахилгааны тарифын хөнгөлөлт үзүүлэхтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 214 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ЭХЯ, УБЦТС-нээс дэд станцуудад евростандартын тоноглолыг үе шаттайгаар нэвтрүүлж, цахилгаан эрчим хүч түгээх сүлжээг автомат систем буюу ухаалаг сүлжээнд шилжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж байна.

Гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “Айл, өрхөд эко ариун цэврийн байгууламж суурилуулах төсөл”-ийг АХБ-ны санхүүжилтээр БОАЖЯ-наас 2017-2020 онд хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 27 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 6, 7, 40 дугаар хороо, Баянзүрх дүүргийн 27 дугаар хороонд нийт 3000 ширхэг эко ариун цэврийн байгууламжийг суурилуулсан байна.

Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор баталсан “150 мянган айл- орон сууц” үндэсний хөтөлбөрийн хүрээнд аймгуудад хэрэгжүүлж эхэлсэн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үр дүнд 2020 оны байдлаар нийт 664 айлын нийтийн орон сууц, 30 айлын амины орон сууцыг ашиглалтад оруулсан байна. “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг 50 байршилд хэрэгжүүлж, 13500 өрхийг инженерийн бүрэн хангамжид холбох” үйл ажиллагааны хүрээнд аймгуудын хэмжээнд 39 байршилд хэрэгжүүлж, нийт 2526 өрх инженерийн дэд бүтэцтэй болсон байна. “Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээл, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх” үйл ажиллагааны зорилтын хүрээнд Хөгжлийн банкнаас орон сууцны төслийн зориулалтаар нийт 243.6 тэрбум төгрөгийн зээл олгосноос 206.9 тэрбум төгрөгийн зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгосон байна.

### **1.1.3.Суурь үйлчилгээний хүртээмж**

#### **1.1.3.1.Баталгаатай ундны ус, эрүүл ахуй, хатуу хог хаягдлын зайлуулах нөхцөлөөр хангах**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ”, 2016-2020 онд “Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох”, “Хот, суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна”, 2016-2020 онд “Хот, суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх” гэсэн зорилт дэвшүүлсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ”, “Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж ус хангамжийг нэмэгдүүлнэ”, “Нийслэл, хот, суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэж төлөвлөсөн.

**Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80 хувьд хүргэх ажлын хүрээнд:** 2016 оны байдлаар баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 33 хувь байсан бол 2017 онд 50 хувь, 2018 онд 52 хувь, 2019 онд 82.9 хувь, 2020 онд 83.5 хувьд хүрсэн байна. Улсын хэмжээнд шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн ам 80.4 хувь, инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон баталгаат ундны усаар хангагдсан хүн ам 52 хувийг тус тус эзэлж байна.

Нийслэл Улаанбаатар хотын хувьд хүн амын 99.5 хувь нь шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа бөгөөд улсын хэмжээнд 1-д эрэмбэлэгдэж байна. Хотын хэмжээнд нийт хүн амын 36.8 хувь нь төвлөрсөн ус хангамжийн системд холбогдож, үлдсэн хувь нь ундны усаа төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, 15 хүртэлх хувь нь хамгаалагдсан худаг болон зөөврийн үйлчилгээгээр хангагдсан байна. Манай иргэд жилдээ 500 сая.м3 орчим ус хэрэглэдэг. Усны хэрэглээ, ашиглалт хүн ам, эдийн засгийн өсөлтөөс хамаарч улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Одоогийн байдлаар хүн ам, нийгэм, эдийн засгийн салбарын усны хэрэглээ, ашиглалтын 80 гаруй

хувийг газрын доорх усаар, 20 хүрэхгүй хувийг гадаргын усаар хангаж байна. Дэлхийн хэмжээнд нэг хүний хоногийн усны хэрэглээ 100-105 л байдаг бол манай улсын орон сууцанд амьдардаг нэг хүний хоногийн усны дундаж хэрэглээ дэлхийн хөгжингүй орны нэг хүний хоногийн хэрэглээнээс 2 дахин их буюу 230-280 литр байна. Харин гэр хорооллын хэрэглэгчид дэлхийн дундаж түвшинээс 5-10 дахин бага буюу 6-8 литр ус хэрэглэж байна.

2018 оны “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-гаар Монгол Улсын нийт өрхийн 38 хувь нь сайжруулсан, хүртээмжтэй, аюулгүй, найдвартай ундны усаар хангагдсан бол улсын хэмжээнд нийт өрхийн 31 хувь нь ариун цэврийн байгууламжийн суурь үйлчилгээгээр хангагдаагүй гэж гарсан байна. ДЭМБ болон НҮБ-ын “Хүүхдийн сан”-гийн хамтарсан хяналт шинжилгээний хөтөлбөр (JMP) -ийн мэдээгээр 2019 онд Монгол Улсын хэмжээнд нийт сургуулиудын 23 хувь нь гараа савангаар угаах анхан шатны хүртээмжгүй байгаа нь Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед аюулгүй ажиллагааг хангахад хүндрэл учруулж байна. Сургуулиудын 74 хувь нь ундны цэвэр усаар, 63 хувь нь ариун цэврийн байгууламжаар хангагдсан байна.

Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлээр 2016-2020 онд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1). Хүн амын унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгааны ажлыг Улаанбаатар хот болон 14 аймгийн 32 сум, дүүрэгт хийж, усны нөөцийг батлуулсан. 2). Хэрлэн, Увс нуур - Тэсийн гол, Ерөө гол, Сэлэнгэ гол, Буйр нуур-Халхын гол, Онги гол, Орог нуур-Түйн гол, Таац гол, Хараа гол, Шишхэд гол, Хүйсийн говь-Цэцэг нуурын зэрэг 22 сав газрын зөвлөл байгуулагдаж, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн дэглэмийн мөрдөлтөд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн. 3). Баянхонгор, Увс, Төв, Хэнтий, Сүхбаатар, Баян-Өлгий, Дархан-Уул, Говь-Алтай, Өмнөговь, Дорнод, Ховд, Говьсүмбэр аймгийн төвүүд болон Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Багахангай дүүрэгт цэвэр усны 200 орчим км шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, шинээр барих ажлыг гүйцэтгэсэн. 4). “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд нийт 16 аймгийн 16 сумын төвд гүний худаг, усан сан, цэвэр усны 81,2 км, бохир усны 57.1 км шугам хоолой, насосны станц, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барьж, ашиглалтад оруулсан. 5). Гадаадын зээл, тусламжаар Дорноговь, Өмнөговь аймгийн 6 сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлт (АХБ-ны буцалтгүй тусламж), Говь-Алтай аймгийн төвд гадаргын усыг цэвэрлэн унд ахуйн хэрэгцээнд ашиглах төсөл (Австри Улс), АНУ-ын Мянганы сорилтын корпорацитай Усны компакт гэрээг 2018 онд байгуулж, Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 5. Ус хангамж, 2018 оны эхний хагас жил жилийн байдлаар

Ус хангамжийн төрөл	Улаанбаатар	Төвийн бүс	Зүүн бүс	Баруун бүс	Хангайн бүс
Ус түгээх цэгийн тоо	696	469	121	164	403
Ус түгээх машины тоо	74	41	32	17	38
Зөөврийн ус хэрэглэдэг өрхийн тоо	210079	72013	32608	51738	100649

Эх сурвалж: ҮСХ, 2018

**Хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох зорилтын хүрээнд:** Хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох зорилтын биелэлт 2020 оны байдлаар 37.3 хувьтай байгаа бөгөөд улсын хэмжээнд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээнд хамрагдсан хүн ам 41,1

хувийг эзэлж байна. Бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч, цэвэрлэх цогц байгууламжид холбогдсон хүн ам 2016 онд 27 хувь, 2017 онд 31 хувь, 2018 онд 34 хувь, 2019 онд 69 хувь, 2020 онд 69,2 хувийг тус тус эзэлж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд хүн амын 51.8 хувь нь шаардлага хангасан, 48.2 хувь нь шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжтай байгаа бөгөөд хүн амын 36.8 хувь нь ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбогдож, 4.4 хувь нь ямар нэг ариун цэврийн байгууламжгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2020 онд бохир ус, ариутгах татуургын 50 орчим км шугам сүлжээ, цэвэр, бохир усны шинжилгээний 130-аад нэр төрлийн тоног төхөөрөмж, шил сав, урвалж бодис ханган нийлүүлж, шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд хоногт 3.2 мянган км цэвэр усны, 1.4 мянга бохир усны шугам сүлжээгээр дамжуулан 107.5 сая м<sup>3</sup> цэвэр усыг олборлон түгээж, 93.4 сая м<sup>3</sup> бохир усыг татан зайлуулж, цэвэрлэсэн. Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын санхүүжилтээр Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл (Франц Улс), Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул аймгийн зэрэг 10 аймгийн 12 сумын төвийн цэвэрлэх байгууламжийг шинээр (АХБ), Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж, Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл (БНХАУ), Дархан-Уул аймагт “Мо-Мо төсөл” (ХБНГУ), Баян-Өлгий, Говьсүмбэр зэрэг 5 аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг (Польш Улс) шинээр барих төслийг хэрэгжүүлж байна. Хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох зорилгоор газрын доорх усны хайгуул, судалгааг хийж, нийт 192,7 л/с-ийн усны нөөцийг баталж, ашиглалтад өгсөн.

“Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах” төсөл хэрэгжүүлж, нийт 1500 ширхэг сайжруулсан ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулсан. “Сумын эрүүл мэндийн төв”-ийн 71.0 хувь нь гадна байрлах ариун цэврийн байгууламжтай, эдгээрийн дийлэнх нь MNS 5924:2015 стандартын шаардлага хангаагүй, 43.0 хувь нь амбулаториор үйлчлүүлэгчдэд зориулсан тусдаа ариун цэврийн байгууламжгүй, аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн 44.0 хувь нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөгүй байна (ЭМЯ, 2019).

Монгол Улсын насанд хүрсэн хүн амын 41.6 хувь (95%CI: 39.3-43.9), сургуулийн сурагчдын 40.4 хувь (95%CI: 39.9-41.7) нь гараа байнга, зөв угааж дадсан байна (ЭМЯ, НЭМҮТ, 2020). Эндээс харахад насанд хүрсэн хүн ам, хүүхдийн 60 орчим хувь нь гар угаах дадал хангалтгүй байгаа тул өөрчлөлт хийх шаардлагатай байна. Нийт хүн амыг гараа савандаж, зөв, тогтмол угааж хэвшүүлэх зан үйлд нөлөөлөх төсөл, хөтөлбөрийг олон улсын байгууллагын санхүүжилттэйгээр хэрэгжүүлж байна. Бидэнд өнөөдрийг хүртэл бүх нийтийг гар угаах нөхцлөөр хангах төсөл, хөтөлбөр, нөхцөл байдлын судалгаа, зан үйлийг хэвшүүлэх төлөвлөгөө, албан байгууллага, сургууль зэрэг хүн ам олноор цуглардаг газруудад зориулсан бодлогын баримт бичиг, стандартын үнэлгээ, санхүүжилт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх хэрэгцээ тулгамдсан асуудал хэвээр байна.

#### **Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх:**

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуультай нийцүүлэн Хог хаягдлын тухай хуулийг 2017 онд шинэчлэн батлан мөрдүүлж байна.

Анх удаа Монгол Улсад энгийн болон аюултай хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны тушаалаар баталсан маягтаар www.eic.mn сайтад бүртгэн, цахимаар үүсгэгчийн бүртгэлийн дугаарыг олгож байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны тушаалаар баталсан “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аюултай хог хаягдал үүсгэгч, энгийн хог хаягдлын үүсгэгчийг бүртгэж байна.

Эдийн засаг, хүн амын өсөлт эрчимтэй явагдаж, орлого нэмэгдэхийн хирээр хог хаягдлын бүтэц өөрчлөгдөж, мөн нэг хүнээс үүсэх хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байна. Хүн амын өсөлт, хурдацтай явагдах хотжилт болон үйлдвэржилт зэрэг нь хог хаягдлын хэмжээ өсөхөд нөлөөлж, үүнийг дагаад хог хаягдлаас ялгарах хүлэмжийн хийн хэмжээ өсөх хандлагатай байна. Нэг хүнээс өдөрт үүсэх хог хаягдлын хэмжээ, бүтцийн судалгааг цаашид 4 жил тутам хийж, эх үүсвэрээс үүсэх хог хаягдлын норматив хэмжээг шинэчилж, тогтоох болно. Аюултай хог хаягдлын жилийн мэдээг 2019 оноос авч эхлээд байна.

Улсын хэмжээнд 2018 онд зөвшөөрөгдсөн 390 хог хаягдлын төвлөрсөн цэгт нийт 3.4 сая/тонн хог хаягдал тээвэрлэн зайлуулсан. Үүнээс дахин боловсруулах боломжтой 1.5 сая тонн хог хаягдал үүссэн. Хог хаягдлыг төрлөөр нь авч үзвэл нийт зайлуулсан хог хаягдлын 91.8 хувийг ахуйн, 8.2 хувийг үйлдвэрийн хог хаягдал эзэлж байна.

#### **1.1.3.2. Аюулгүй, шуурхай нийтийн тээврийн системээр баталгаатай хангах**

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны уйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн. Тээврийн салбар нь улс орны эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчний нэг бөгөөд өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол орны хувьд тус салбарт автотээвэр зонхилох үүрэг гүйцэтгэж байна. Тээврийн төрлүүдээр гүйцэтгэсэн ачаа, зорчигч тээврийн гүйцэтгэлээс харахад улсын хэмжээний ачаа тээврийн 65 гаруй, зорчигч тээврийн 98.7 хувийг автотээвэрээр гүйцэтгэж байна.

Нийт зорчигч тээвэрлэлтийн ихэнхи хувийг нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээ давхардсан тоогоор эзэлж байна. Бүх төрлийн тээврээр 2020 онд нийт 126.5 сая хүн тээвэрлэснээс төмөр замаар 1.97 сая хүн, автотээвэрээр 124.1 сая хүн, агаарын тээврээр 450 мянган хүн тээвэрлэсэн байна. Нийт зорчигч тээвэрлэлтийг өмнөх онтой харьцуулахад 26.8 хувиар буурсан бөгөөд үүнээс төмөр зам 33.2 хувиар, автотээвэр 26.3 хувиар, агаарын тээвэр 72.2 хувиар тус тус буурсан байна. Усан замын тээврээр 2020 онд 31158 зорчигч тээвэрлэж, өмнөх оноос 204 зорчигчоор өссөн байна. Нийт зорчигчдын 31037 нь дотоодын иргэд, 121 нь гадаадын иргэд байна. Нийт зорчигч эргэлт 3406.2 сая хүн км бөгөөд үүнээс төмөр замаар 579.3 сая хүн км, автотээвэрээр 2178 сая хүн км, агаарын тээврээр 648.9 сая хүн км, усан замын тээврээр 0.4 сая хүн км зорчигч эргэлт хийсэн байна. Өмнөх онтой харьцуулахад нийт зорчигч эргэлт 52 хувиар, үүнээс төмөр зам 47.8 хувиар, автотээвэр 25.5 хувиар, агаарын тээврийн зорчигч эргэлт 79.1 хувиар, усан замын тээвэр 33 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийтийн тээвэр нь замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн 1 хувийг эзэлдэг боловч нийт зорчигчдын 65 хувьд нь үйлчилдэг. Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд 20 орчим аж ахуйн нэгж, 66 чиглэлд 1000 гаруй автобусаар хоногт 630 мянга орчим иргэдэд үйлчилж байгаа бөгөөд одоо нийтийн тээвэрт явж буй автобусны 58 хувь нь 8-аас дээш жилийн насжилттай байна. Нийт зорчигчдын 49.5 хувь нь




үйлчилгээний төлбөр төлж, үлдсэн 50.5 хувь нь улсын хөнгөлөлтөөр үнэ төлбөргүй, 83 мянган ахмад настан, 34 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нөхөн олговрыг иргэдийн өөрсдийх нь дансанд шууд олгож, 113 мянган оюутныг нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчуулах эдгээр хөнгөлөлтийн өртөгийг улсаас нөхөн төлбөр олгож байна. Мөн Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээнд жилд улсаас үнэ төлбөргүй зорчих эрх бүхий этгээдийн нөхөн олговорт 53 тэрбум төгрөгийг нийслэлийн төсвөөс олгосон байна.

Хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 67 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан 60 чиглэлд 897 тээврийн хэрэгсэл, 1863 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгүүлж байна. 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1087142 зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оноос 33 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хот хоорондын тээвэрлэлт хийгдээгүй болно (График 5-ыг үзнэ үү).

Улаанбаатар хотыг бүсийн доторх бусад суурингуудтай нийтийн тээврийн сүлжээгээр холбож, дагуул хаяа суурингууд руу оршин суугчдын тоо болон холбогдох судалгаа, тооцоонд үндэслэн экспресс автобус, экспресс микроавтобус болон галт тэрэг гэх мэт тээврийн хэрэгслүүдийг ашиглан, тодорхой хугацаа, давтамжтайгаар тасралтгүй үйлчилж байна.

График 5. Хот хоорондын зорчигч урсгалын тоо



Эх сурвалж: <https://www.transdep.mn/post.php?p=934>

Нийтийн тээвэрт тулгуурласан хотын бүтцийг дэмжиж, өндөр ашигтай нийтийн тээврийг хөгжүүлэхээр доорх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Тусгай замын автобусны (BRT) зам барьж байгуулах; Тулгуурт гүүрэн байгууламж (LRT)-ны шугамыг барьж байгуулах; Нийтийн тээвэрт том оврын автобусны парк шинэчлэл хийж, шинэ чиглэл нэмэх; Тээврийн сүлжээний төлөвлөлтийг боловсронгуй болгож, үйлчилгээнд орчин үеийн техник, технологийн ололтыг нэвтрүүлэх; Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.

Нийтийн тээврийн хэрэгслийг хийн түлшинд шилжүүлэх, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээнд CNG буюу байгалийн шингэрүүлсэн хийн хөдөлгүүртэй автобусыг туршилтаар явуулж байна. Цаашид нийтийн тээврийн хэрэгслийн бүх автобусыг байгаль орчинд ээлтэй байгалийн шатсан хийн болон цахилгаан тээврийн хэрэгсэлд шилжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

### 1.1.3.3. Орчин үеийн сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжоор хангах

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 14.в)-д “Сэргээгдэх эрчим хүчийг...хэрэглээг дэмжих” зарчмыг удирдлага болгохоор, 34-т “сэргээгдэх эрчим хүчийг хүн бүрт тэгш, хямд өртөгөөр хүргэхийг дэмжинэ”, 54-т “хямд өртөгтэй сэргээгдэх эрчим хүчийг ашиглан .. нөөц, боломж, хүрэлцээг сайжуулж, байгаль орчны асуудлыг шийднэ. Сэргээгдэх эрчим хүчний зардлыг бууруулах нь суурин газруудад эрчим хүчний нийлүүлэлтийн зардлыг бууруулах үр дүнтэй хэрэгсэл болдог” гэж заасан. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, Эгийн голын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ”, “Сумын төвүүдийг төвлөрсөн цахилгаан системд бүрэн холбож дуусган, сэргээгдэх эрчим хүч болон цэвэр технологид суурилсан төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр, бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд “Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, нүүрс боловсруулж ашиглах шинэ технологи нэвтрүүлэн, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан үйлдвэрлэл, бизнесийг олон улсын хамтын ажиллагааны хүрээний дэмжлэгт хамруулах ажлыг зохион байгуулна” гэж төлөвлөсөн.

Манай улсын хувьд нар, салхины арвин нөөцтэй бөгөөд үүндээ түшиглэн бүс нутгийн томоохон тоглогч байх бүрэн боломжтой. Говийн бүсийн нар, салхины эрчим хүчний нөөцийг 2.6 Тераватт байна гэсэн тооцоо, судалгааны дүнгээс харахад, нарны эрчим хүчний нөөц хангалттай байгаа бөгөөд эдийн засгаа тэтгэх, улмаар эрчим хүчний хамаарлаас бүрэн гарах өгөгдөлдөө тулгуурлан, сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлээ эрс нэмэгдүүлэх боломжтой юм. Манай улсын хувьд нарны энергийн нөөцөөрөө дэлхийд Сахарын цөлийн дараа хоёрдугаарт ордог, жилийн 270 хоногт нь цэлмэг нартай байдагаараа бусад улстай харьцуулахад давуу тал ихтэй.

УИХ-аас 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг баталснаас хойш өнөөг хүртэл хугацаанд нийт 120 МВт-ын нар, салхины цахилгаан станцуудыг ашиглалтад оруулж, нэгдсэн сүлжээнд холбосон. 2019 онд шинэчлэн баталсан Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд дамжуулах сүлжээнд холбогдсон нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний худалдаж авах тарифын дээд хязгаарыг 12 ам.цент хүртэл, салхины эрчим хүчээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг худалдаж авах тарифын дээд хязгаарыг 8 ам.цент хүртэл байх, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд техникийн асуудлыг анхаарах, үнээр өрсөлдүүлэх буюу тендер зарлах, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь санхүүгийн чадавхтай байх шаардлагатай зэрэг холбогдох зохицуулалтыг шинээр тусгасан. Мөн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд бага чадлын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг хэрэглэх байдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаатай холбогдуулан үнэ, тариф, урамшууллын тогтолцоог бий болгосон. Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль шинэчлэгдэн батлагдснаар эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэх боломж бий болсон. Төрөөс хаана, ямар чадлын нар, салхины эх үүсвэр барих, ямар хэмжээний цахилгаан эрчим хүчийг худалдаж авах шаардлагатай байгаа талаар төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, өрсөлдөөн бий болсноор төсөл хэрэгжүүлэгчид зардлыг бууруулах талаар анхаарч, тухайн технологийн зах зээлийн бодит ханш бий болох бөгөөд энэ нь төслийн үнэ, тарифыг бууруулж, нар, салхины эрчмийн үнэ, тарифт өөрчлөлт орсноор хэрэглэгчийн эрчим хүчний үнэнд шингээсэн дэмжих тарифыг нэмэгдүүлэхгүй байх зэрэг боломжтой болсон байна.

Эрчим хүчний сайдын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам”-аар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар тогтоосон зарчимд нийцүүлэн, сонгон шалгаруулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулж, уг журмын үйлчлэлд эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах 1 МегаВаттаас дээш суурилагдсан хүчин чадалтай нар, салхины үүсгүүр, усан цахилгаан станц, усан цэнэгт цахилгаан станц, эрчим хүчний хуримтлуур болон сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрийг ашиглан, эрчим хүч үйлдвэрлэх үүсгүүрийг өөрийн хөрөнгөөр барих хуулийн этгээд хамаарахаар заасан. Эрчим хүчний сайдын 2020 оны 159 дүгээр тушаалаар батлагдсан “Хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэсэн эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэх журам” нь иргэн, хуулийн этгээдийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох, хэрэглээнээс илүү гарсан цахилгаан эрчим хүчийг түгээх сүлжээнд нийлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Монгол орны эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинээр хэрэгжүүлж байгаа төслүүдэд эрчим хүчний найдвартай, тогтвортой үйлчилгээг сайжруулахад анхаарлаа хандуулж байна. 2018 онд ДБ үндэсний анхны том хүчин чадлын 10МВт-ын нарны цахилгаан станцыг суурилуулах замаар сэргээгдэх эрчим хүчийг дэмжиж, Олон улсын хөгжлийн ассоциациас хөнгөлөлттэй нөхцлөөр 42 сая ам.доллараар, “Стратегийн уур амьсгалын сан” 12.4 сая долларын буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн. Одоогоор эрчим хүчнийхээ 70 хувийг импортоор авдаг Монгол орны Баруун бүсийн системийг нарны эрчим хүчээр хангаснаар боломжийн үнэтэй, цэвэр эрчим хүчийг үйлдвэрлэнэ. Илүү найдвартай цахилгааны хүртээмж нь иргэдийн амьдралыг дээшлүүлж, бизнесээ хөгжүүлэхэд нь тусалдаг. 2030 он гэхэд сэргээгдэх эрчим хүчийг 30 хувь болгон нэмэгдүүлэх Засгийн газрын зорилтыг дэмжиж, асар их нөөцтэй нар, салхины эрчим хүчний нөөцийг бүрэн ашиглахын тулд сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтыг илүү үр дүнтэй, үр ашигтайгаар хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах зорилтын хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Салхит ууланд 50МВт хүчин чадалтай салхин станцыг 2012 онд ашиглалтад оруулж, жил бүр 180 мянган тонн нүүрс хүчлийн хий, 122 мянган тонн нүүрс шаталт, 1.6 сая тонн цэвэр ус хэмнэн ашигтай ажиллаж байна.

Туул, Сонгино усны нөөцийн цогцолбор 100 мВт хүчин чадалтай УЦЦС, 50 мВт хүчин чадалтай салхин станц байгуулахаар төлөвлөсөн ч уг ажил одоогоор хэрэгжиж эхлээгүй байна. Япон, Монголын хамтарсан хөрөнгө оруулалттай “Everyday Farm” ХХК нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх өөрийн эзэмшлийн талбайд “Моннаран 10 мВт нарны цахилгаан станцын төсөл”-ийг хэрэгжүүлж, бүрэн хүчин чадлаар ажиллуулж эхлээд байна. Төв аймгийн 50 МВт-ын “Салхит”, Дарханы 10 МВт-ын нарны цахилгаан станц, Тайшир, Дөргөний усан цахилгаан станцууд одоо хэвийн ажиллаж байна. Цогтцэций, Сайшандын 50 МВт-ын хүчин чадлын салхин цахилгаан станц, Сонгинохайрхан дүүрэгт “10 МВт-ын нарны цахилгаан станцын төсөл” хэрэгжүүлж байна. Дэлхийн чиг хандлагыг тодорхойлох сэргээгдэх эрчим хүчний салбарт бүл нэмэхээр Эрчим хүчний зохицуулах хорооноос 13 нарны станц, 6 салхин станц барих тусгай зөвшөөрөл олгосон байна.

БНСУ-д үйлдвэрлэсэн сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг утасгүй интернэтийн сүлжээний төхөөрөмж бүхий гудамжны гэрэлтүүлгийг туршиж байна. Энэхүү гэрэлтүүлэг нь 300 Вт чадалтай босоо тэнхлэг (Дариус болон Савониус далбан) бүхий салхин турбин, 300 Вт чадалтай нарны цахилгаан үүсгүүр, 12 В 100 А.цаг багтаамжтай цэнэг хураагууртай, 40 Вт чадалтай LED гэрэлтэй бөгөөд 500 метрт интернет цацах төхөөрөмжтэй юм. Уг гэрэлтүүлэг нь эрчим хүч хэмнэх зориулалт бүхий гэрэлтүүлгийг тохируулах мэдрэгчтэй

бөгөөд хүн болон машины хөдөлгөөнийг мэдэрч, 10 метрийн радиус дотор ойртоход 50 хувиар, 5 метрийн радиуст дотор 100 хувийн тодролтойгоор гэрэлтүүлдэг. Өдрийн цагт нар, салхины энергийг цахилгаан эрчим хүч болгон аккумуляторт хуримтлуулах бөгөөд шөнийн цагт салхины эрчим хүч болон аккумуляторт хуримтлагдсан эрчим хүчээр гудамж, талбайг гэрэлтүүлэх юм. Дуу чимээ багатай генератортой (10 дБ түүнээс бага) салхин турбин нь бага хурдтай (0.6м/с – ээс дээш) салхинд ч эрчим хүч үйлдвэрлэх давуу талтай.

## 1.2.НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ХОТЫН ХӨГЖИЛ БА БОЛОМЖ

### 1.2.1.Нийтэд хүртээмжтэй хотын эдийн засаг

#### 1.2.1.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг багтаасан бүх нийтийн бүтээмжит ажлын байрыг бий болгох

"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулж", 2016-2020 онд "хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувьд, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх" гэсэн зорилт дэвшүүлсэн. Үүнтэй холбогдуулан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах", "хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжих, хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлж, Монгол залуусаа сургаж дадлагажуулан ажлын байраар хангаж, гадаадаас авдаг ажиллагсадын тоог 50-иас дээш хувиар бууруулах" гэсэн зорилтыг тусгасан.

2020 оны байдлаар Монгол Улсын хүн амын 2.29 сая нь хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны хүн ам байгаа нь нийт хүн амын 68.1 хувийг эзэлж байна. 2020 оны байдлаар 15-34 насны 1030.7 мянган залуус байгаа нь нийт хүн амын 30.7 хувь, 15 ба түүнээс дээш насны хүн амын 45 хувийг эзэлж байна (Хүснэгт 6-г үзнэ үү).

#### Хүснэгт 6. Хүн амын насны бүтцийн өөрчлөлт (2017-2020 оноор)

Насны бүлэг	2017		2018		2019		2020	
	мян.хүн	эзлэх хувь	мян. хүн	эзлэх хувь	мян. хүн	эзлэх хувь	мян. хүн	Эзлэх хувь
0-14	976.9	30.7	1002.1	31.0	1038.0	31.5	1070.0	31.9
15-34	1072.1	33.7	1063.1	32.8	1044.8	31.7	1030.7	30.7
35-64	1006.2	31.7	1045.4	32.3	1078.5	32.7	1113.1	33.1
65-аас дээш	122.7	3.9	127.9	3.9	135.6	4.1	143.7	4.3
Нийт	3177.9	100.0	3238.5	100.0	3296.9	100.0	3357.5	100.0

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

2020 онд улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны хүн амын 1250.6 мянга нь ажиллах хүч байгаагийн 1162.9 (93 хувь) мянга нь ажиллагсад, 87.7 мянга (7 хувь) нь ажилгүй иргэд байна (Хүснэгт 7-г үзнэ үү). Улсын хэмжээнд нийт 1250.6 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 659.9 мянга (52.8 хувь) нь эрэгтэйчүүд, 590.7 мянга (47.2 хувь) нь эмэгтэйчүүд байна. 2020 оны байдлаар нийт ажиллагсадын 56.9 хувь нь үйлчилгээний салбарт, 23.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 7.7 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 4.4 хувь нь уул уурхайн салбарт тус тус ажиллаж байна. Манай улсад 2019 оны байдлаар 1.1 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 269.5 мянга нь албан бус хөдөлмөр эрхлэгч байгаа нь нийт ажиллагсадын 24.5 хувийг эзэлж байна. Ажиллах хүчний 65.7 хувь нь хот, суурин газарт, 34,3 хувь нь хөдөө ажиллаж, амьдарч байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 58.8 хувь болж, 2017 оноос 2.3 нэгжээр буурсан байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газарт 58.2 хувь байгаа нь хөдөө орон нутгийн (63.0 хувь) үзүүлэлтээс 4.8 нэгжээр бага байна. Улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 54.6 хувь байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 9.5 нэгжээр бага байгаа бөгөөд хот, суурин газрын хөдөлмөр эрхлэлтийн түвшин хөдөө, орон нутгийнхаас 10.1 нэгжээр доогуур байна.

#### Хүснэгт 7. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт (2017-2020 оноор)

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Ажиллах хүч (мян.хүн)	1375.4	1358.6	1273.9	1250.6
Ажиллагсадын тоо (мян. хүн)	1238.3	1253.0	1146.2	1162.9
Ажилгүй иргэдийн тоо (мян.хүн)	119.1	105.6	127.7	87.7
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	61.1	61.0	60.5	58.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	55.8	56.3	54.4	54.6
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.8	7.8	10.0	7.0

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

Дэлхийн зах зээлд эрдэс баялгийн үнийн огцом хэлбэлзэл болон уул уурхайн салбарын хэт хараат байдлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засгийн өсөлт тогтворгүй байгаа бөгөөд эдийн засгийн өсөлт хөдөлмөр эрхлэлтийг дорвитой нэмэгдүүлэх хүчин зүйл болж чадахгүй байна. Ажилгүйдлийн түвшин үндэсний хэмжээнд 2017 онд 8.8 хувиас 2020 онд 7.0 хувь болж, бага зэрэг буурсан. “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт “Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019”-д дурдсанаар хөдөлмөр эрхэлж байгаа 4 хүн тутмын 1 нь, мөн хөдөлмөр эрхэлж байгаа 15-24 насны залуучуудын гуравны нэг нь “ажилтай ядуу” гэсэн ангилалд багтаж байна (Хүснэгт 8-ыг үзнэ үү).

#### Хүснэгт 8. 15 ба түүнээс дээш насны ажилгүй хүний тоо (2017-2020 оноор)

Бүс	2017	2018	2019	2020
<b>Бүгд</b>	119092	105614	127736	87696
<b>Баруун бүс</b>	20851	17231	19542	15530
<b>Хангайн бүс</b>	27845	20019	21327	16266
<b>Төвийн бүс</b>	19351	17811	16625	13468
<b>Зүүн бүс</b>	9657	8259	11773	7718
<b>Улаанбаатар</b>	41388	42294	58469	34714

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 87696 ажилгүй иргэдийн 34714 (39.6 хувь) нь Улаанбаатар хотод байна. Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр улсын хэмжээнд нийт ажилгүй иргэдийн 99.0 хувь нь боловсролтой, үүнээс эрэгтэйчүүдийн 98.9 хувь, эмэгтэйчүүдийн 99.3 хувь нь ямар нэг түвшний боловсрол эзэмшжээ.

2018 оны статистик мэдээгээр ажилгүй иргэдийг насны бүтцээр нь авч үзвэл ихэвчлэн залуучууд, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орогчид ажилгүйдэлд илүү өртөж байна. Ажил эрхлээгүй нийт хүн амын 56.1 хувь нь 15-34 насныхан, 1,9.5 хувь нь ажиллах хүчинд шинээр элсэн орсон 20-24 насныхан байна. Ажил хайсан боловч ажилд орж чадаагүй сургууль төгсөгчдийн хувьд 23.9 хувь нь Улаанбаатар хотод, 76.1 хувь нь хөдөө, орон нутагт амьдарч байна. Ажилгүй залуучууд орон нутагт их байгаа нь ажлын байрны хүртээмжтэй шууд холбоотой юм. Ажилгүйдлийн шалтгааныг тодруулбал, 30.0 хувь нь ажил хайгаад олдоогүй, 17.7 хувь нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 9.5 хувь нь суралцдаг, 7.1 хувь нь цалин бага зэрэг шалтгаанууд зонхилж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн судалгаагаар улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 7.0 хувьтай байгаа бол залуучуудын ажилгүйдлийн түвшин үүнээс хоёр дахин их байгаа бөгөөд хөдөлмөр эрхэлдэггүй залуусын 58 хувь нь мэргэжилтэй байна. 2019 оны эхний гурван улирлын тайлангаас харахад хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 34.4 мянган ажилгүй иргэн бүртгэлтэй байгаагийн 57.1 хувийг 15-34 насны залуучууд эзэлж байна. Залуучууд илүү өргөн боломж эрэлхийлэн хот, суурин газар руу шилжин суурьшиж байгаа нь хот, суурины ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна. Хот, суурины залуучуудын (15-24 нас) ажилгүйдлийн түвшин нь ажилгүйдлийн улсын дундаж түвшнээс 17.9 нэгжээр өндөр байна.

ХНХЯ хөдөлмөрийн харилцааг зохицуулах, хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулж байна. Түүнчлэн, Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг батлан, хэрэгжүүлж байна. 2017 онд УИХ-аас Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж, залуучуудын асуудал хариуцсан “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-ыг шинээр байгуулсан.

Ажилгүй иргэдийг ажилтай, орлоготой болгох зорилгоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гаас (ХЭДС) “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг тус тус хэрэгжүүлж байна. 2017 онд 48659 ажилгүй иргэнд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлж, 35686 иргэнийг ажилд зуучлах үйлчилгээнд хамруулсан. 2018-2019 онд дээр дурдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд 65.5 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд хөтөлбөрүүдэд давхардсан тоогоор нийт 104.3 мянган хүн хамрагдаж, 12394 байнгын, 40997 түр ажлын байр бий болсон.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Гарааны бизнес эрхлэхийг дэмжих арга хэмжээ”, “Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ”, “Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ”, “Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт” зэрэг арга хэмжээг зохион байгуулсан. Гарааны бизнесийн санааг баяжуулах, өрсөлдүүлэх, багаар ажиллаж, ирээдүйтэй санааг бизнесийн зөвлөх (ментор)-ийн туслалцаатайгаар хөгжүүлэх, шилдэг гарааны бизнесийг сонгон шалгаруулж, 2 жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, 2017 онд 945 залуучуудыг

хамруулан, шалгарсан төслүүдэд санхүүгийн дэмжлэг олгосон. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг төгсөгч хувиараа болон бүлгээр хөдөлмөр эрхэлж, ажлын байр бий болгох залуучуудад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авахад нь зориулж, 2 жилийн хугацаанд 100 хувь эргэн төлөх нөхцөлтэй, нэг төгсөгчид 3 сая төгрөг, бүлэгт 10 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгох арга хэмжээнд 588 төгсөгчийг хамруулж, 1194.5 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосон байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, сургууль, суралцагч хоорондын гурвалсан гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Барилгын салбарын мэргэжилтэй ажилчин бэлтгэдэг 46 Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа 13825 суралцагч суралцах хугацаандаа барилгын салбарын хувийн хэвшлийн байгууллагуудад үйлдвэрлэлийн дадлага, сургалтыг жил бүр зохион байгуулж байна.

Шинээр сургууль төгссөн залуучуудыг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжийг дэмжих ажлын хүрээнд 2017-2019 онд шинээр сургууль төгсөөд ажил хайгчаар бүртгүүлэн, 6-аас дээш сар ажилд орж чадахгүй байгаа 296 залуучуудыг тогтвортой ажиллуулсан ажил олгогчид 935.3 сая төгрөгийн урамшууллыг олгосон нь залуучуудыг ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

### **1.2.1.2. Албан бус эдийн засгийг дэмжих**

Монгол Улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 33 дахь хэсэгт “Албан бус эдийн засагт бага орлоготой иргэд, тэр дундаа эмэгтэйчүүд, цалингүй ажилчид, шилжин ирэгсдийн оруулж буй хувь нэмэр их байдаг. Тэднийг ая тухтай амьдарч, ажиллах орчин, орлогын баталгаат байдал, нийгмийн хамгаалал, чадвараа хөгжүүлэх боломжоор хангах хэрэгтэй. Мөн одоогийн нөхцөл байдлыг сайжруулан, хадгалах, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, уян хатан байдал, санхүүгийн боломжийг нэгтгэх замаар албан бус эдийн засгийг албан ёсны эдийн засаг руу шилжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувийг 2020 онд 14.1, 2025 онд 11.7 болгох, нийгмийн даатгал төлөгчдийн тоог өсгөж, 2020 онд 1129.3 мянга, 2025 онд 1220.1 мянга болгох, мөн “Төрөөс тэтгэврийн шинэчлэлтийн талаар 2015-2030 онд баримтлах бодлого”-ын баримт бичигт малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн баталгааг сайжруулах, түүнчлэн “Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилт дэвшүүлсэн.

Манай улсад 2019 оны байдлаар 1.1 сая хүн хөдөлмөр эрхэлж байгаагаас 269.5 мянга нь албан бус хөдөлмөр эрхлэгч байгаа нь нийт ажиллагсдын 24.5 хувийг эзэлж, эдгээрийн ихэнх нь зохистой хөдөлмөрийн нөхцөл бүрдээгүй, шилжилт хөдөлгөөн ихтэй, орлого тогтмол биш, нийгмийн баталгаа хангалтгүй нөхцөлд ажиллаж байна. Иймд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах шаардлагатай байна. Одоогийн байдлаар нийгмийн даатгалд 188 мянга гаруй сайн дурын даатгуулагчид хамрагдаж байгаа боловч малчдын 70 орчим хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 45 орчим хувь нь нийгмийн даатгалд хамрагдахгүй байна. Олон улсын туршлагад үндэслэн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ангилал, бүлгийг тодорхой болгох, бүртгэлийг нарийвчлан сайжруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөх нөхцөлийг уян хатан болгож, түүнтэй нь уялдуулан тэтгэврийг ялгаатай тогтоох зэргээр тэдний нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, хамгааллыг сайжруулах шаардлагатай юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс 2021 онд хийсэн “Монгол Улсын албан бус хөдөлмөр эрхлэлтийн төлөв байдлын судалгаа”-ны дүнгээр албан бус

хөдөлмөр эрхлэгчдийн 49.7 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 50.3 хувь нь хөдөө, орон нутагт байгаагаас 44.0 хувь нь эрэгтэй, 56.0 хувь нь эмэгтэй, мөн 7.3 хувь нь албан бус салбарын ажилтан, 42.2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 50.5 хувь нь ажил олгогч байгаа-бөгөөд албан бус хөдөлмөр эрхэлсэн дундаж хугацаа 11.8 жил, 64.8 хувь нь ажлын байрандаа 8-аас доошгүй жил ажилласан байна. Албан бус салбарын ажиллагсдад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтийн дутмаг байдал, төрийн байгууллагын дарамт, албан бус салбарын ажиллагчдын нэгдэх боломж хязгаарлагдмал, санхүүгийн хөрөнгө болон шинэ техник, технологи зэрэг бүтээмжит нөөцүүд хомс, бизнесийг хөгжүүлэх үйлчилгээ байхгүй, эрсдэл тодорхой бус, нийгмийн хамгаалал байхгүй зэрэг бэрхшээл тулгардаг.

Боловсролын түвшний хувьд албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 9.9 хувь нь суурь ба түүнээс бага, 51.4 хувь нь бүрэн дунд, 9,8 хувь нь техникийн болон тусгай мэргэжлийн, 28.4 хувь нь дээд боловсролтой байна. Эмэгтэйчүүдийн 32 хувь, эрэгтэйчүүдийн 25 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна.

Монгол Улсад эдийн засгийн төрөлжилт хангалтгүй, албан ёсны салбарт зохистой ажлын байр цөөхөн, албан бус секторыг албан ёсны болгохын тулд тавьдаг шаардлага хэт өндөр, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй зэрэг шалтгааны улмаас албан бус хөдөлмөр эрхлэлт байсаар байна. Судалгаанд хамрагдсан албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн 45.4 хувь, эмэгтэйчүүдийн 30.8 хувь нь ажилд ороход бэрхшээлтэй буюу ажил олдохгүй байсан шалтгаанаар албан бус хөдөлмөр эрхэлж байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 53.7 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин, мотоциклын засвар, үйлчилгээний, 19.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн, 7.4 хувь нь тээвэр, агуулахын үйл ажиллагааны, 6.3 хувь нь үйлчилгээний салбарт, үлдсэн нь зочид буудал, нийтийн хоол, бусад салбарт ажил эрхэлж байна.

#### Хүснэгт 9. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүс нутгаар (хувиар)

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улаан-баатар	Нийт дүнд эзлэх хувь
Боловсруулах үйлдвэрлэл	21.7	20.5	17.2	18.5	19.9	19.7
Барилга	2.6	2.4	3.2	1.3	4.4	3.5
Бөөний болон жижиглэн худалдаа	55.3	54.2	52.0	55.0	53.6	53.7
Тээвэр, агуулахын үйл ажиллагаа	7.1	5.8	11.9	7.5	6.6	7.4
Зочид буудал, нийтийн хоол	5.6	5.8	6.6	8.3	3.8	5.0
Үйлчилгээний бусад	5.8	7.9	5.0	7.8	6.1	6.3
Бусад	1.9	3.4	4.2	1.6	5.6	4.3
Нийт дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0


Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2019-2020 онд “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох”, “Ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх” зэрэг төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр албан бус эдийн засагт үйл ажиллагаа явуулж буй ажилчид болон эдийн засгийн нэгжүүдийг албан бус эдийн засагт шилжихийг дэмжих замаар тэдний хөдөлмөрлөх болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах, эрх ашгийг нь хөндсөн шийдвэр гаргах үйл



явцад дуу хоолойгоо илэрхийлэх боломж бүрдүүлэх зорилгоор “Эдийн засгийг төрөлжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах хүрээнд албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийг 2019-2021 онд хэрэгжүүлсэн.

**График 6. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эдийн засгийн үйл ажиллагааны салбарт эзлэх хувь**



Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын институт

### 1.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д (ТХҮБ 2030) хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулж, 2016-2020 онд “жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 100 тэрбумаас доошгүй төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ”, “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ”, “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж, “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ”, “Гадаад орны өндөр болон дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийг франчайзаар оруулж нутагшуулан, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарт “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулахыг дэмжинэ” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулж, орлогын тэгш бус хуваарилалтыг багасган, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлж, хувийн хэвшлийн хөгжлийг хангахад онцгой хувь нэмрийг үзүүлдэг.

2020 оны байдлаар ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй 94.4 мянган хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаагийн 63.1 мянга буюу 66.9 хувь нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад 785.0 мянган ажиллагчид ажиллаж байгаагийн 198.9 мянга буюу 25.3 хувь нь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн тоог бүсээр авч үзвэл, Улаанбаатарт 43.9 мянга буюу 69.6 хувь, Төвийн бүсэд

6.3 мянга буюу 10 хувь, Хангайн бүсэд 5.5 мянга буюу 8.7 хувь, Баруун бүсэд 5.2 мянга буюу 8.2 хувь, Зүүн бүсэд 2.2 мянга буюу 3.5 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл, бөөний худалдааны салбарт 34.3 хувь, үйлчилгээний салбарт 21.7 хувь, жижиглэн худалдааны салбарт 18.9 хувь, барилгын салбарт 10.5 хувь, аж үйлдвэрийн салбарт 9.0 хувь, хөдөө аж ахуйн салбарт 5.6 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн борлуулалтын орлого нь 8.6 их наяд төгрөг буюу нийт аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогын 11.2 хувийг эзэлж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээдэд бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх зорилгоор УИХ, Засгийн газар жижиг, дунд үйлдвэрийн салбарын бодлогын хүрээнд холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэн батлан мөрдүүлж байна. 2019 онд УИХ-аас Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулга, Засгийн газрын 2019 оны 156, 362, 418 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”, “Ахуйн үйлчилгээний хөтөлбөр”, бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Жижиг, дунд үйлдвэрийн газар”-ыг байгуулсан.

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нөлөөгөөр жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид тодорхой хэмжээгээр үйл ажиллагаагаа зогсоосон, ажлын байраа алдсан, орлого буурсан, бэлэн мөнгөний хомсдол, өр, зээлээ төлөх боломжгүй болсон зэрэг хүндрэлтэй байдалд орсон байна. “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо” ТББ-ын судалгаагаар жижиг, дунд үйлдвэрлэгчдийн 50 хувь нь дампуурсан, 30 хувь нь цомхотгол хийсэн байна. Засгийн газраас жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд бизнесээ үргэлжлүүлэхэд түлхэц үзүүлэхүйц арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд үүнд шууд мөнгөн тусламж, татвар төлөлтийг түр хугацаагаар хойшлуулах, орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжид ногдуулсан татварыг 90 хувиар хөнгөлөх зохицуулалт, зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах зэрэг арга хэмжээ хамаарч байна. Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын нөлөөг бууруулах чиглэлээр Засгийн Газраас хэрэгжүүлсэн цахилгаан, дулааны төлбөрийн хөнгөлөлт олгох 211 дүгээр тогтоол нь бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн чухал арга хэмжээ болсон байна.

Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг 2019 он хүртэл гаалийн албан татвараас чөлөөлөх зорилгоор 2017 онд УИХ-аас Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Тус хуулийн хүрээнд 2017-2018 онд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж 42.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж импортолж, 3.2 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлт эдэлсэн байна.

Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий тэргүүлэх чиглэл”, 2020 оны 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”-гаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг баталсан. 2017 онд нийт 154 зээлдэгчдэд 49.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, 124 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөтгөн, 30 үйлдвэр шинээр байгуулж, 2811 ажлын байр шинээр бий болж, 1373 ажлын байрыг хадгалсан байна. 2018 онд “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” болон “Сум хөгжүүлэх сан”-гаас нийт 409 аж ахуйн нэгжид 99.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосноор 1450 шинэ ажлын байр бий болж, 1489 ажлын байрыг хадгалсан байна. 2020 онд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн “Бичил зээлийн багц”-ын ангиллын 249 төсөлд, 22.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноор 811 ажлын

байрыг хадгалж, 1449 ажлын байр шинээр бий болсон байна. 2020 онд 252 төслийг Зээлийн эрсдлийн болон Үл хөдлөх хөрөнгийн даатгалд хамруулсан.

“Зээлийн батлан даалтын сан” нь 2020 онд 72 аж ахуйн нэгжид 26.5 тэрбум төгрөгийн зээл, 13.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Тус сан АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Эдийн засгийг төрөлжүүлэх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд нийт 231 аж ахуйн нэгж, иргэний 77.2 тэрбум төгрөгийн зээлд 43.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасны үр дүнд 1460 ажлын байр шинээр бий болж, 2499 ажлын байрыг хадгалсан байна.

“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд 2018-2019 онд 55 үйлдвэр шинээр байгуулагдаж, 451 аж ахуйн нэгжид тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлсэн бөгөөд 20 үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Үүнээс 33 үйлдвэр нь шинээр байгуулагдаж, 8 үйлдвэрт өргөтгөл, хүчин чадлыг нэмэгдүүлэх тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдэж байгаа бөгөөд байнгын болон түр 2000 гаруй ажлын байр шинээр бий болсон байна. Мөн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийг нэмэгдүүлэх чиглэлээр нийслэл болон орон нутагт барилгын материалын 39 үйлдвэр шинээр байгуулагдсан. “Хөгжлийн загвар” үйлдвэр байгуулах ажлын хүрээнд 2018 онд 8400 тн хонины бохир ноосоор 11.8 сая евротой тэнцэх үнэ бүхий био бордоо үйлдвэрлэн экспортлох үйлдвэр, өдөрт 400 ширхэг адууны шириг боловсруулж, желатин үйлдвэрлэх шинэ үйлдвэрийг тус тус ашиглалтад оруулсан. 2019 онд өдөрт 96 тонн түүхий эдийг боловсруулж, 24 тонн тэжээлийн уураг, 17 тонн малын гаралтай тос үйлдвэрлэх хүчин чадалтай яс дахин боловсруулах үйлдвэр шинээр байгуулагдсан. Энэхүү үйлдвэр нь хаягдал ясыг дахин боловсруулж, органик хүнсний болон техникийн тос, бордоо, тэжээлийн уураг, угаалгын саван зэрэг 7-8 нэр төрлийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, бүтээгдэхүүний 70 хувийг экспортод гаргаж буй хөгжлийн жишиг болсон үйлдвэр юм.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн 68.5 хувь нь үйл ажиллагаа явуулж буй нийслэл Улаанбаатар хотод “Улаанбаатарт үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Нийслэлд үйлдвэрлэл эрхэлж буй 5557 иргэн, аж ахуйн нэгжийг тооллого, судалгаанд хамруулж, дүүрэг бүрт үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид бараа, бүтээгдэхүүнээ үйлдвэрийн үнээр борлуулах борлуулалтын 9 цэгийг байгуулсан. “Амар и коммерс” ХХК онлайн худалдааны avlaa.mn сайтыг бий болгож, үйлдвэрлэл эрхлэгчдийн 4000 гаруй бүтээгдэхүүнийг байршуулан, худалдаалснаар борлуулалтыг 5 хувиар нэмэгдүүлсэн байна. 2017-2020 онд нийслэлд тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа 18 иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулж, олон улсын үзэсгэлэн худалдаанд 73 үйлдвэрлэл эрхлэгчдийг, дотоодын үзэсгэлэн худалдаанд давхардсан тоогоор 1362 үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулан, шинээр 127 зөөврийн ажлын байрыг бий болгож, 400 гаруй хувиараа үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд бодит дэмжлэг үзүүлсэн байна.

ЕСБХБ-ны “Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах нь” төсөл, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй “БЭСТ” хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах, бизнес оношилгоо хийж байгаагаас гадна бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон мэргэжлийн холбоо, байгууллага ажиллаж байна. ЕСБХБ-ны төсөлтэй хамтран жижиг, дунд үйлдвэрийн салбарын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулж, улсын хэмжээнд жижиг, дунд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй 63131 аж ахуйн нэгжийн нэгдсэн дата мэдээллийн санг үүсгэж, тэдгээрийн ангилал, төрлийг олон улсын жишигт нийцүүлэхээр зорьж байна.

Гэвч бизнесийн статистик тоон мэдээлэл зөрүүтэй, техник, технологийн мэдлэг хангалтгүй, шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургууль, хувийн хэвшлийн үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй байгаагаас үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг амжилттай эрхлэх боломж хязгаарлагдмал байна. Цөөн тооны жижиг, дунд үйлдвэр чанар, аюулгүй байдлын стандартыг хангаж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа боловч олон улс, бүс нутгийн зах зээлд өрсөлдөх чадвар сул байна. ХХААХҮЯ-наас жижиг, дунд үйлдвэрийн салбарт хийсэн ажиглалт, судалгаа болон Монголбанкны “Жижиг, дунд үйлдвэрийн санхүүжилт байдлын судалгаа”-наас үзэхэд жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн зүгээс төрийн үйлчилгээг сайжруулах, татварын таатай орчинг бүрдүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгох нь зүйтэй гэж үзсэн байна.

#### **1.2.1.4. Бизнес, инновацын шударга, хариуцлагатай орчинг бүрдүүлэх ажлыг дэмжих**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 60 дахь хэсэгт “Эдийн засгийн төрөлжүүлэлт, шинэ технологи, инновацийг дэмжих, чанартай, үр ашигтай ажлын байруудыг бий болгох, уламжлалт болон шинэ үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлж, урлаг, соёлын өвийг хамгаалах замаар хотын эдийн засгийн бүтээмж, үр ашгийг сайжруулах” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

**Бизнесийн шударга бөгөөд хариуцлагатай орчныг бүрдүүлэх ажлыг хөхүүлэн дэмжих чиглэлээр:** “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, 2016-2020 онд худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж, гадаад худалдаанд (экспортын) зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны өртөг, зардлыг хямдруулах” гэсэн зорилт дэвшүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эрх бүхий байгууллагуудаас үндэсний аж ахуйн нэгжүүдэд тавигдсан татварын актын хүү, торгууль, алданги, үндсэн татварын нөхөн төлбөр төлөх хугацааг сунгах, хаалгасан дансыг нь нээх зэргээр бизнес эрхлэгчдээ дэмжинэ”, “5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон хөнгөн, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлээр дэмжинэ”, “Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих “Бүсийн хөнгөлөлт”-ийн бодлого хэрэгжүүлнэ”, “Залуучуудад бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна”, “Эдийн засаг, бизнес, худалдаа, өмч, санхүүгийн эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, өмчлөх эрхийн баталгааг алдагдуулсан хууль тогтоомж, шийдвэрийг засч сайжруулна”, “Нэг иргэн, нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлж, төрийн болон цахим бизнес, онлайн банкны үйлчилгээг жигд, тэгш авах нөхцөлийг бүрдүүлнэ”, “Төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулна”, “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана” зэрэг зорилтыг тусгасны дагуу холбогдох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байна.


Манай улсад жижиг, дунд үйлдвэр анх 1990 оноос зах зээлийн нөхцөлийн дүр төрхөөр бий болж эхэлсэн бөгөөд 1993-1994 онуудад олноор байгуулагдсан юм. Хувийн үйлдвэр, аж ахуйн газруудад олонхи нь ХХК хэлбэрээр оршин тогтнож байна.

Бизнесийн шударга, хариуцлагатай орчныг бүрдүүлэх зорилгоор УИХ-аас 2019 онд Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг тус тус шинэчлэн баталсан.

Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, МУИС-ийн Бизнесийн сургууль хамтран “Монгол Улсын бизнесийн орчны судалгаа”-г 2017 онд, мөн 2020 онд хийж, судалгааны үр дүнг УИХ, Засгийн газар, яам, агентлагуудад хүргэж, цаашид бизнесийн орчинг сайжруулах чиглэлд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, бодлогын нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд хамтран ажиллахаа илэрхийлсэн байна<sup>5</sup>.

Бизнесийн орчныг эдийн засаг, засаглал, хууль эрх зүй, дэд бүтэц, технологи, нийгэм, соёл, байгууллагын дотоод орчин гэсэн ерөнхий 5 үзүүлэлт, дэд 12 үзүүлэлтээр, 1-5 оноогоор үнэлэхэд Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ нь 2.91 буюу “дунд” гэж үнэлэгдсэн байна. Үнэлгээг ерөнхий үзүүлэлтээр авч үзвэл, засаглал, хууль эрх зүйн орчин 2.66, эдийн засгийн орчин 2.67, нийгэм, соёлын орчин 2.87, дэд бүтэц, технологийн орчин 3.23, байгууллагын дотоод орчин 3.13 гэсэн үнэлгээтэй гарсан нь (График 7-г үзнэ үү) 2017 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад дундаж үнэлгээ 0.46 пунктээр дээшилж, бага зэрэг сайжирсан байна. Бизнесийн орчны хүчин зүйлсээс сүүлийн 3 жилд хамгийн эерэг өөрчлөлттэй нь дэд бүтэц, технологийн орчин 0.69, байгууллагын дотоод орчин 0.50, нийгэм, соёлын орчин 0.49 пунктээр тус тус дээшилсэн ба эдийн засгийн орчин, засаглал хууль эрх зүйн орчин хамгийн доогуур үнэлэгдсэн хэдий ч 2017 оны үнэлгээтэй харьцуулахад 0.27, 0.38 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

График 7. Бизнес орчны үнэлгээ (2020 оны байдлаар)



Эх сурвалж: “Монгол Улсын бизнесийн орчны судалгаа”, 2017, 2020 он

Монгол Улсын Засгийн газраас 2020 онд Коронавируст халдвар (COVID-19) цар тухлаас эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээг улсын хэмжээнд нийт судалгаанд оролцогсдын 48.3-83.5 хувь нь эерэг үр нөлөөтэй, 27.6-33.2 хувь нь маш их нөлөөтэй гэж үнэлжээ. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх тухай хууль, Татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой аж ахуйн нэгжийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хууль болон Монгол банкнаас зээлийн хугацааг хойшлуулахтай холбоотой гаргасан шийдвэр (ипотек, хэрэглээний зээлийн хугацааг хойшлуулах, гэх мэт), тухайлбал, “Ажлын байраа хадгалсан аж ахуйн нэгжийн ажилтанд 200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх тухай” шийдвэр зэрэг Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээ нь улсын хэмжээнд, хот болон хөдөө орон нутагт, бизнесийн бүх салбарт, бизнес эрхлэгчийн үйл ажиллагааны цар

<sup>5</sup> <https://www.mongolchamber.mn/>

хүрээ зэргээс үл шалтгаалан бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн гэж дүгнэсэн байна. Ялангуяа, Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт нь аж ахуйн нэгжүүдэд чухал нөлөө (77.5-83.5 хувь) үзүүлсэн байна.

**Инновацийн шударга бөгөөд хариуцлагатай орчныг бүрдүүлэх ажлыг хөхүүлэн дэмжих чиглэлээр:** “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, 2016-2020 онд нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлж, 2016-2020 онд инновацийг дэмжиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь хүртэлх түвшинд хүргэх” гэсэн зорилт дэвшүүлсэн.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ”, “Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ”, “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулна”, “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ”, “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ”, “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд үндэслэн хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлнэ”, “Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална” зэрэг зорилт тусгасны дагуу холбогдох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Монгол Улс инновацийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх зорилгоор “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор, “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 2018 оны 233 дугаар тогтоолоор тус тус батлан хэрэгжүүлж байна. Засгийн газрын 2018 оны 234 дүгээр тогтоолоор “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт”-ыг баталсан. Тус тогтоолыг хэрэгжүүлснээр инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид тоног, төхөөрөмжөөр хангагдаж, улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахуйц импортыг орлох, экспортод чиглэсэн, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байр шинээр бий болгох, татварын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

Засгийн газрын 2017 оны 19 дүгээр тогтоолоор “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэлийг байгуулсан.


2019 онд Инновацийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталснаар инновацийн үйл ажиллагаа, дэд бүтэц, түүнд оролцогч талуудын эрх үүргийн хуваарилалт тодорхой болж, талуудын оролцоо тэгш хангагдах, төрөөс олгож буй санхүүжилтийн дэмжлэгийг оновчтой болгох, инновацийн үйл ажиллагаан дахь төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэл өргөжин хөгжих эрх зүйн таатай орчин бүрдсэн. Мөн инновацийн үйл ажиллагааг дэмжих олон талт эх үүсвэрийг бий болгох, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн дэргэд зөвлөх компани байгуулах, гарааны компани, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд бүтээгдэж буй шинэ мэдлэг, инновацийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, эдийн засагжуулах боломж бүрдсэн. Засгийн газрын 2020 оны 33 дугаар тогтоолоор “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”, 95 дугаар тогтоолоор “Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл”, 2019 оны 162 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”, 392 дугаар тогтоолоор “Инновацийн төсөл бүртгэх журам”-ыг тус тус батлан хэрэгжүүлж байна. Цаашид Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Судалгааны их сургуулийн тухай хуулийн төсөл, “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журмын төсөл”-ийг тус тус батлуулахаар ажиллаж байна.

Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх судалгаа шинжилгээ, туршилтын ажлыг дэмжих, өндөр технологит салбаруудыг хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа, боловсруулалтын ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, хөрөнгө, хүчийг төвлөрүүлэн үр ашигтай зарцуулах зорилгоор тэргүүлэх чиглэл, цөм технологийн 20 төслийг санхүүжүүлж, хэрэгжүүлсэн байна. Инновацийн 5 грант төсөл, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 35 төсөл үргэлжлэн хэрэгжиж байна. 2020 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын нэрэмжит инновацийн тэтгэлгийн сонгон шалгаруулалтад 52 залуу судлаач төслөө ирүүлснээс эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн нь үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэн инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгохоор бүтээлч санаа дэвшүүлсэн 10 залуу судлаачийг шалгаруулж, тус бүрд 10 сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

“Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслийг БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

2020 оны байдлаар, шинжлэх ухаан, технологийн 315 төсөл үргэлжлэн хэрэгжиж, 236 төслийг шинээр эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нийтдээ 526 төсөл хэрэгжинэ. Үүнээс, суурь судалгааны төсөл 198, захиалгат 95, цөм технологийн 4, инновацийн 5, туршилт зүгшрүүлэлтийн 36, гадаадтай хамтарсан 119, грант 69 төсөл байна. Эндээс үзэхэд, судалгааны ажлын 35.6 хувийг суурь судалгаа, 17.5 хувийг хэрэглээний судалгаа, 12.8 хувийг технологийн судалгаа, 21.6 хувийг гадаадтай хамтарсан, 12.5 хувийг грант төсөл эзлэж байгаа бөгөөд нэг төсөлд оногдох дундаж санхүүжилт дунджаар 19.8 сая орчим төгрөг байна. Шинжлэх ухааны салбарт ДНБ-ий 0.2 хувийг 2017 онд, 0.2 хувийг 2018 онд, 0.11 хувийг 2019 онд, 0.13 хувийг 2020 онд тус тус зарцуулсан байна (График 8-ыг үзнэ үү).

График 8. ДНБ-д шинжлэх ухааны салбарын эзлэх хувь



Эх сурвалж: <https://cdn.greensoft.mn/>

Төрийн өмчийн их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад олон улсын стандартад нийцсэн үндэсний хэмжээний судалгааны жишиг лабораторийг улсын хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, зээл, тусламжийн хүрээнд байгуулж байна. Үүнд: АШУҮИС-ийн “Цөм лаборатори”, ШУТИС-ийн “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв”, ХААИС-ийн “ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хяналт, үнэлгээний төв лаборатори”, МУИС-ийн “Лазерийн судалгааны лаборатори” зэрэг орчин үеийн өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж бүхий томоохон лабораториуд шинээр байгуулагдан ажиллаж байна.

### 1.2.2. Нийтэд хүртээмжтэй тогтвортой хөгжил, цэцэглэлт

#### 1.2.2.1. Хотын эдийн засгийг төрөлжүүлэх, соёлын болон уран бүтээлийн үйлдвэрлэлийг дэмжих

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 60 дахь хэсэгт “Бид эдийн засгийн төрөлжүүлэлт, шинэ технологи, инновацийг дэмжих, чанартай, үр ашигтай ажлын байруудыг бий болгох, уламжлалт болон шинэ үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлж, урлаг, соёлын өвийг хамгаалах замаар хотын эдийн засгийн бүтээмж, үр ашгийг сайжруулах болно” гэж заасан. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална”, мөн “Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, бүх нийтийн соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёл, урлагийн аялал жуулчлал, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчлах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, монгол контентийг хөгжүүлнэ” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг төрөлжүүлэх бодлогын хүрээнд хөдөө аж ахуйн салбарын хөгжилд анхаарал хандуулж, хот, суурины орчимд эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх, ложистик сүлжээг бий болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэвшилтэт



технологийг түлхүү нэвтрүүлэх, аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөдөө аж ахуйн түүхий эдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, нийт экспортод эзлэх хувийн жинг нь өсгөх зэргээр ажлын байр болон иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, мөн макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Эдийн засгийг тогтворжуулах зорилгоор Оюутолгойн далд уурхай, Тавантолгой, Гацууртын алтны орд, Тавантолгойн цахилгаан станц, Улаанбаатар хотын III цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, эдийн засгийг идэвхжүүлэхээр төлөвлөж байна.

Ойрын жилүүдэд уул уурхай, олборлох салбар Монгол Улсын эдийн засгийн томоохон хэсгийг бүрдүүлсэн хэвээр байх төлөвтэй хэдий ч хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл болон аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, тэдгээрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлийн өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийн бүтцийг бий болгохоор зорьж байна. Засгийн газраас эдийн засгийг төрөлжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдийн нэг бол Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж буй "Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр (2018-2021)" юм. Тус хөтөлбөрийн зорилго нь орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.

ЕСБХБ-наас "Жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн төрөлжилтийг дэмжих хөтөлбөр"-ийг 2016 оноос хэрэгжүүлж байна. ЕСБХБ-наас цаашид донор байгууллага, түнш банк, санхүүгийн байгууллага болон төрийн байгууллагуудтай илүү нягт холбоотой ажиллаж, хамтарсан санхүүжилт болон шууд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг улам өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд "КОВИД-19 дараа эрсдэлд тэсвэртэй жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх" шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ногоон эдийн засгийг түлхүү дэмжих талаар мэдэгдсэн.

Нийслэл "Улаанбаатар хотын Эдийн засгийн хөгжлийн стратеги" баримт бичгийг НИТХ-ын 2015 оны 26/08 дугаар тогтоолоор баталсан. Уг стратегийн цогц байдлыг хангах үүднээс Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжил, дэвшил, санхүү, татвар, дэд бүтэц, тээвэр, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, аялал жуулчлал, засаг захиргаа хоорондын асуудал зэрэг салбарын одоо болон ирээдүйн хөгжлийг олон талаас нь авч үзэж, нэмүү өртөг шингэсэн, өндөр өгөөжтэй үйлдвэрлэл, үйлчилгээтэй, бизнесийг татахад анхаарал төвлөрүүлж байна. Энэ нь хотын эдийн засгийн ирээдүйн тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх давуу талыг хөгжүүлэн өргөжүүлэхэд ач холбогдолтой.

Улаанбаатар хотод бөөний болон жижиглэнгийн худалдаа, ил болон далд уурхай, бага болон дунд хэмжээний нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, тээвэр болон агуулах, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа зэрэг 6 төрлийн эдийн засгийн салбар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр үйл ажиллагаа нь улсын эдийн засгийн нэмүү өртөг шингэсэн ДНБ-ний 64 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд Улаанбаатар хотын эдийн засаг жилд 9.5 хувийн өсөлттэй, харин хотын хүн амын жилийн өсөлт 4 хувьтай байна. Хотын хөгжлийн хэтийн зорилт болон нийтийн үйлчилгээ, дэд бүтцийг сайжруулах, засварлах зэрэг бусад өсөлт, шаардлагуудтай харьцуулахад хүн амын энэхүү өсөлт нь нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлтийг хангаж чадахгүй байгаа юм. Иймд эдийн засгийг төрөлжүүлэх, бүтээмж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

чиглэлд хүчин чармайлт гаргах, илүү өндөр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл рүү шилжих чиглэл баримтлах нь нэн чухал байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дэлхийн зах зээл 2.2 их наяд ам.доллар бөгөөд 30 орчим сая хүнийг ажлын байраар хангаж, дэлхийн нийт экспортын хэмжээ 253 тэрбум сая ам.доллар буюу нүүрсний зах зээлээс гурав дахин том зах зээл шинээр үүсээд байна. Олон улсын судалгаагаар ойрын хугацаанд дэлхийн ДНБ-ий 10 хувийг соёлын бүтээлч үйлдвэрлэл эзэлнэ гэж үзжээ. Харин Монгол Улсын хэмжээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл ДНБ-ий 1.3 хувь буюу 481.4 тэрбум төгрөгийн зах зээлд 33 мянган ажлыг байрыг бий болгоод байна. Тус салбарт нийт 11 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 6500 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Цаашид энэхүү салбарыг хөгжүүлэхэд хүний нөөцийн бодлого, төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын менежмент, төрийн зөв бодлого болон салбар дундын уялдаа холбоо чухал юм.

Монгол Улс 2007 онд Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай 2005 оны ЮНЕСКО-ийн конвенцид нэгдсэн бөгөөд 2008 оноос хойш БНСУ-ын Итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр “Соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, соёлын олон төрөл зүйл-Монголын гар урлалын үйлдвэрлэлийг чадавхжуулах нь” төслийг хэрэгжүүлсэн.

Дэлхий улс орнууд өөрсдийн үндэстний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан үйлдвэрлэл, үйлчилгээг зохиогчийн эрх, инновацид тулгуурлан, бизнес, хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр олон улсын болон үндэстний зах зээлд соёлын үйлдвэрлэлийг өргөжүүлж, түүний эдийн засаг, нийгэмд оруулах бодит үр өгөөжийг нь хүлээн зөвшөөрч, улам бүр дэмжин хөгжүүлснээр ач холбогдол нь улам бүр нэмэгдэж байна. Манай улсын хувьд улс, үндэстнийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, соёлын онцлог, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх, хайрлан хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, дэлхий нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээ авч, өөрийн орны нөөц, бололцоонд тулгуурлан соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Эдгээр нөхцөл байдал, шаардлагыг үндэслэн Засгийн газрын 2015 оны 509 дүгээр тогтоолоор “Соёлын үйлдвэрлэл” үндэстний хөтөлбөрийг баталж, 2020 он хүртэлх хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

“Соёлын үйлдвэрлэл” үндэстний хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор нийслэл болон 21 аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017-2018 оны тогтоолоор тухайн орон нутгийн онцлогийг харгалзсан “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, тус дэд хөтөлбөрийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотод 2020 оны байдлаар “Оюуны өмчийг дээдэлъе”, “Зохиогчийн эрхийг хүндэтгэе” сэдвээр олон нийтийн сүлжээнд давлагаа өрнүүлж, зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг сурталчилсан. Түүнчлэн соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагад тавигдах “Соёл, урлагийн байгууллагуудын дагаж мөрдөх 12 төрлийн стандартыг боловсруулсан байна. “Улаанбаатар хотын соёлын үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалын цахим форум”-ыг зохион байгуулж, уг форумд мэргэжлийн холбоод, үйлдвэрлэл эрхлэгч болон 2000 гаруй иргэд оролцсон. Мөн соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгааг 9 дүүргээр гаргаж, нэгдсэн бүртгэл мэдээллийн сан байгуулан НСУГ-ын цахим хуудсанд байршуулсан. Дүүргүүдийн Соёлын ордонд соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааг улирал бүр зохион байгуулж, 200 гаруй үйлдвэрлэл эрхлэгчийг бараа, бүтээгдэхүүнээ сурталчлан борлуулах боломжоор хангаж, “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьтай хэрэгжиж байна.

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс, Соёл урлагийн газар хамтран “Соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэлийн практик орчинг Монголд бий болгох нь” төслийг 2016 оноос хэрэгжүүлж, энэхүү төсөл нь ЮНЕСКО, БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр Монгол, Вьетнам, Уганда улсад хэрэгжүүлж буй “Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийн соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд хэрэгжсэн. Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг шинэ хэлбэрээр илэрхийлэн танилцуулах замаар хөхиүлэн дэмжих, орон нутгийн бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хөгжих боломжийг дэмжиж чадавх, стратеги болон практик хүрээг бий болгоход уг төслийн зорилго оршино.

Манай улсад “Соёлын бүтээлч үйлдвэрлэл”-ийг дэмжин, Монгол туургатны өв соёлыг дэлхийд таниулах соёл, урлагийн Монгол брэндийг хөгжүүлэхэд байгалийн өвөрмөц дүр төрх, баялаг өв соёлын онцлогоо шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах бүрэн боломжтой бөгөөд энэ нь монгол соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах өргөн боломжийг нээж байна. Цар тахлаас үүдэлтэй дэлхий дахин цахим шилжилтэд хурдтай хөл нийлүүлж байгаатай холбогдуулан технологийн өөрчлөлтийг дагаад соёл, урлагийн менежмент мөн зүгээ өөрчилж, илүү технологид суурилсан байдлаар хөгжих чиг хандлага олон улсад зонхилсон байна. Соёл, урлагийн салбарынхан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засгийн нөлөө, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хөгжлийн чиг хандлагын чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэн гарц, шийдэл эрэлхийлсээр байна. Монгол Улс 24 жилийн дараа буюу 2020 онд Соёлын яамыг бие даан байгуулсан нь олон өөрчлөлтийн эхлэл болсон төдийгүй төр соёл, урлагийг бодлогоор дэмжиж, уран бүтээлчид болон бизнес эрхлэгчидтэй хамтарч соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлснээр Монгол Улс дэлхийн урлагийн далайд гарцтай болох нөхцөл бүрдэж байна.

#### **1.2.2.2. Орчин үеийн хотын эдийн засгийг хөгжүүлэхийн тулд техникийн болон зохион байгуулах ур чадваруудыг хөгжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 56 дахь хэсэгт “Бид ажиллах хүчний мэдлэг, чадварыг дээшлүүлж, хотын эдийн засгийг өрсөлдөх чадвартай болгож, эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлэхээс гадна ажлын байрыг нэмэгдүүлж, бизнэс эрхлэх тааламжтай орчинг бүрдүүлнэ” гэж заасан. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж, “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ”, “Үйлдвэрлэлийн салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог хөгжүүлнэ”, “Мэргэжлийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна” гэсэн зорилтуудыг дэвшүүлж, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

Иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах зорилгоор Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, уг хуулийн төсөлд багш нарыг судалгаа шинжилгээ, өндөр технологи, инновацийн үйл ажиллагаа эрхлэх, байгууллагын түвшинд технологид суурилсан сургалтын орчин бүрдүүлэх талаар тусгахаар судалж байна. 2019 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг, мөн Засгийн газрын 2016 оны 304 дүгээр

тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2016-2021)”-ийг тус тус батлан, хэрэгжүүлж байна.

Нийслэлийн ИТХ-ын 2015 оны 26/08 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын хөгжлийн эдийн засгийн стратеги”-ийг батлан хэрэгжүүлж байна. Тус стратегийн баримт бичигт өрсөлдөх чадвартай, олон тулгуурт, солонгорсон эдийн засагтай ухаалаг хот болох; бизнес, хөрөнгө оруулалт, хууль эрх зүйн тогтвортой орчин бүрдүүлэх замаар Зүүн хойд Азийн санхүү, бизнесийн төв болох; эдийн засгийн хөгжлийг дэмжих зохистой төлөвлөлт, газар зохион байгуулалт бүхий дагуул хотуудыг байгуулах; бизнесийн салбарыг хөгжүүлэх, өндөр боловсрол, мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх; жижиг, дунд үйлдвэрийг хөхиүлэн дэмжих замаар албан бус салбараас бизнесийн албан салбарт шилжүүлэх эдийн засгийг дэмжих зорилтыг дэвшүүлсэн.

2020 оны байдлаар Монгол Улсын томоохон хотууд болох нийслэл Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудын хүн ам хот, суурин газрын нийт хүн амын 77 хувь, улсын ДНБ-ий 71 хувийг эзэлж байна. Нийслэл Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв Эрдэнэт, Дархан хотуудад өндөр чанартай, бие даасан эрдэм шинжилгээний байгууллагууд, их, дээд сургууль, коллежуудыг хөгжүүлэн, шинэ дэвшилтэт техник, технологийг ашиглах мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, кластерыг хөгжүүлж, уул уурхайн салбартай уялдаа бүхий үйлчилгээний салбаруудын хөгжлийг хангаснаар хотуудын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, ажлын байрны өсөлтийг дэмжих боломжтой юм.

Хөдөлмөрийн бүтээмж буюу нэгж хөдөлмөрөөс тухайн салбарт оруулж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, бүх түвшний ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн, робот, хиймэл оюун ухаан, нанотехнологи, квант компьютер, биотехнологи, зүйлсийн интернэт, 3D принтер, автомат жолоодлого гэх мэт “аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал”-ын төрөл бүрийн технологийг ашигласнаар хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, урт хугацаанд хадгалах нь чухал юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/187 дугаар тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”-ыг баталсан. 2019-2020 оны хичээлийн жилийн эхний хагас жилд 22648 суралцагч шинээр элсэн орсон байна. Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбарыг тодорхойлон, тэдгээрт шаардлагатай ажлын байрны тоог богино, дунд (2017-2020 он хүртэл) хугацаанд тодорхойлох судалгааны ажлыг хийж байна. Их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын байгууллагуудад элсэн суралцах суралцагчдын элсэлтийг хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн тогтоох, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийх, мэдээллээр хангах журмын төслийг боловсруулсан.

Хөнгөн үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж, “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийн төслийг боловсруулан олон нийтээр хэлэлцүүлж байна. 2019 оны байдлаар “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-т өссөн дүнгээр 7353 иргэн хамрагдаж, 941 иргэн ажлын байраар хангагдсан байна. Хөнгөн, хүнсний үйлдвэрийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр тооцоо, судалгаа хийж байна. ШУТИС-ийн “Үйлдвэрийн технологийн сургуулийн сургалтын хөтөлбөр”-т нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал боловсруулсан. Дэлхийн банкны “Экспортыг дэмжих” төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн “Шима секи” сургалтын төвд АРЕХ 3-3 дизайн системийн ахисан түвшний сургалтыг Японы Shima Seiki фирмээс зохион

байгуулж, нийт 25 үйлдвэрийн 50 гаруй дизайнер хамрагдаж, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл 2019 онд "Аж ахуйн нэгж, байгууллагад үйлдвэрлэлийн дадлагажуулагч бэлтгэх, ажиллуулах журам"-ыг баталсан. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийг түшиглэн богино хугацааны сургалтын мэргэжлийн чадамж эзэмшүүлэх сургалтаар 434, Хөдөлмөр, бизнесийн үндсэн мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтаар 83, нийт 517 иргэнийг хамруулсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын 47 байгууллагад салбар дундын 14 мэргэжлээр 2415 суралцагч төгсөж, мэргэжлийн үнэмлэх авсан байна. "Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил хөтөлбөр"-ийн хүрээнд 2017 оны хичээлийн жилд 86 сургалтын байгууллага, бүсийн арга зүйн төвүүдэд багш, арга зүйчийг хөгжүүлэх чиглэлээр 1629 багшийг сургалтуудад хамруулан мэргэшүүлсэн. Мөн 469 багшийг мэргэжил, арга зүйн зөвөлгөө, мэдээллээр хангаж, 273 багш, арга зүйчдийг туршлага судлах аялалд хамруулсан байна. Мөн 5 бүсийн арга зүйн төвүүдийн нийт 209 менежер арга зүйчид, мэргэжилтнүүд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна.

2019 онд АХБ-ны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл", ГОУХАН-ийн "Түншлэлд суурилсан Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт төсөл"-ийн хүрээнд нарийн мэргэшил, шинэ техник, технологи, инноваци, сургах зүй, ур чадвар, чадамжид суурилсан сургалт, үнэлгээний арга зүйн чиглэлээр давхардсан тоогоор нийт 3000 гаруй багш, ажилтны чадавхыг дээшлүүлсэн. Нийслэл Улаанбаатар хотод 2016-2019 онд 41.6 мянга гаруй иргэнийг мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулан мэргэшүүлж, "Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр"-ийн мэргэжлийн болон давтан сургалтад 1056 иргэнийг 13 мэргэжлээр 39 сургалтын байгууллагад сургасан байна.

### **1.2.2.3. Бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хот-хөдөөг харилцан уялдаатай хөгжүүлэх**

"Хотжилтын шинэ хөтөлбөр"-ийн 50 дахь хэсэгт "Нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн нэгдмэл, аюулгүй байдлыг бий болгох, байгаль хамгааллыг сайжруулах боломжийг нэмэгдүүлэхийн тулд хот, суурины орон зайн цогц төлөвлөлтийн зорилтод тусгагдсаны дагуу зам, тээвэр, технологи, харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг тогтвортой бий болгох замаар хот, хөдөөгийн харилцан уялдааг дэмжинэ" гэсэн зорилгын хүрээнд "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бизнес эрхлэлтийг дэмжих "Бүсийн хөнгөлөлт"-ийн бодлого хэрэгжүүлнэ", "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна" гэсэн зорилт дэвшүүлсэн.

Өргөн уудам газар нутагтай, ашигт малтмал, хөдөө аж ахуйн арвин нөөцтэй, түүх, соёлын хосгүй өвтэй Монгол Улсын хувьд "Бүсчилсэн хөгжлийн бодлого" нь хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг тэгш, шударга хуваарилах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чухал үүрэгтэй юм.

2001 онд УИХ-аас "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг баталж, түүний дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, "Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги", "Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатарын

бүсийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн. Улмаар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий хотжилтыг дэмжих зорилгоор эдийн засгийн 4 бүс тус бүрд 2 тулгуур төв хотыг сонгон, тэдгээрийг түлхүү хөгжүүлэхээр тогтсон. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2015 оноор дууссан бөгөөд Засгийн газар хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоохоор ажиллаж байна. Түүнчлэн, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх, хүн ам оршин суугаа газартаа ая тохитой ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, шилжилт хөдөлгөөнийг багасгах зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж байна.

2019 онд УИХ-аас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг шинэчлэн баталсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “алслагдсан бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж нийслэл Улаанбаатар хотоос 500 км алслагдсан бол 50 хувиар, 1000 км алслагдсан бол 90 хувиар албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “нийслэл Улаанбаатар хотоос алслагдсан аймаг, суманд оршин суудаг, тухайн орон нутагт бүртгэлтэй Монгол Улсын иргэн нийслэл Улаанбаатар хотоос 500 км алслагдсан бол 50 хувиар, 1000 км алслагдсан бол 90 хувиар албан татварын хөнгөлөлт үзүүлэхээр” тус тус зохицуулсан байна.

2020 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 47.6 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 21.4 хувь нь 21 аймгийн төвд, үлдсэн 31.0 хувь нь хөдөөгийн 309 суманд амьдарч байна. Хүн амын шилжилт хөдөлгөөнийг нийслэл хотод татах нэг том шалтгаан нь нийгэм, эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, аж үйлдвэр, засаг захиргаа, зам тээврийн зангилаа зэрэг бүхий л чиг үүрэг нийслэл хотод төвлөрсөнтэй холбоотой байна.

Засаг захиргааны нэгжүүд, хот, суурин газруудын ангиллын тодорхой шалгуур үзүүлэлт байхгүйгээс хүн амын тоогоор сумаас том баг, аймгаас том сум, дүүргээс том хороо, хотоос том тосгон байсаар байна. Үүнээс хамаарч боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны үйлчилгээний чанар, хүртээмж сул хэвээр байна. Учир нь хэт цөөн хүн амтай засаг захиргааны нэгжид чадавхитай хүний нөөц дутагдалтай байгаагаас үйлчилгээний чанар муу, харин хэт их хүн амтай нэгжид төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна.

Уул уурхайн орд газар, түүх, соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн хөгжиж буй газар нутаг, хот, суурин, мөн хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх хот байгуулалтын бодлогын хүрээнд Засгийг газраас Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Хангимандал, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сүхбаатар аймгийн Бичигт зэрэг хилийн боомтууд, уул уурхай даган хөгжиж буй Өмнөговь аймгийн Цогтцэций, Гурвантэс, Ханбогд зэрэг сумын төвүүд, аялал жуулчлалыг хөгжүүлж буй Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн цагаан нуур орчмын газар, Дундговь аймгийн Өлзийт сумын Цагаан суварга орчмын газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж байна


Хүснэгт 10. Томоохон хот, суурин газрын хүн амын өөрчлөлт (1990-2019 он)

№	Хот, сум, суурин газрын нэр	Хүн амын тоо			Өсөлт
		1990	2010	2019	2019/1990
<b>1. Уул уурхай дагасан хот, суурин газар</b>					
1	Гурвантэс - Овоот толгойн нүүрс, Өмнөговь	2652	4968	5129	193.3
2	Ханбогд - Оюутолгойн зэс, алт, Өмнөговь	1929	4115	8718	450.1
3	Цогтцэций - Тавантолгойн нүүрс, Өмнөговь	1695	3938	8111	478.5
4	Эрдэнэт - Зэсийн орд, Орхон аймаг	48526	87367	105987	218.4
5	Төмөртэйн цайрын орд - Баруун-Урт-Сүхбаатар	18604	15607	21861	117.5
6	Налайх - нүүрсний орд	22833	31458	37715	165.1
7	Багануур - нүүрсний орд	13669	26905	28474	208.3
8	Матад-Тамсагбулагийн газрын тос, Дорнод	2298	2311	3243	141.0
9	Бат-Өлзий – алт - Өвөрхангай	4279	5722	7506	175.4
10	Уянга – алт - Өвөрхангай	5950	8661	9437	158.6
11	Бөмбөгөр – алт - Баянхонгор	2063	2601	3302	160.0
12	Заамар – алт - Төв	3695	4868	5809	157.2
<b>Нийт</b>		<b>130120</b>	<b>182146</b>	<b>245292</b>	<b>188.5</b>
<b>2. Төмөр замын тэнхлэг болон хилийн боомт дагасан хот, суурин газар</b>					
1	Сайншанд-Дорноговь	31477	20526	26048	0.82
2	Сүхбаатар	25346	20830	22505	0.8
3	Чойр-Говьсүмбэр	7367	9699	12553	170.3
4	Дархан-Уул (Дархан хот)	63211	74195	85066	134.5
5	Замын-Үүд-Дорноговь	1332	13402	18740	1406.9
6	Алтанбулаг-Сэлэнгэ	3714	4769	4776	128.5
7	Булган-Ховд	8545	8570	9632	112.7
8	Эрдэнэцагаан-Бичигт -Сүхбаатар	4826	6035	6786	140.6
9	Чулуунхороот-Дорнод	2326	1515	1844	0.77
10	Ханх-Хөвсгөл	1192	2284	2809	235.6
<b>Нийт</b>		<b>149336</b>	<b>161825</b>	<b>190759</b>	<b>127.7</b>
<b>3. Аялал жуулчлалын төв бүхий хот, суурин газар</b>					
1	Хархорин-Өвөрхангай	11404	11589	12026	105.4
2	Хатгал-Хөвсгөл	5897	2973	3418	0.57
<b>Нийт</b>		<b>17226</b>	<b>15855</b>	<b>15434</b>	<b>0.89</b>
<b>4. Газар тариалангийн үйлдвэрлэл дагасан хот, суурин газар</b>					
Төв, Сэлэнгэ аймгийн 17 хот, суурин газар		61764	58432	68700	111.2
1	Улаанбаатар	548393	536594	1469151	267.9
<b>Бүгд (Улаанбаатар орсон)</b>		<b>886557</b>	<b>1694071</b>	<b>1989336</b>	<b>224.3</b>
<b>Бүгд (Улаанбаатар ороогүй)</b>		<b>338164</b>	<b>464071</b>	<b>520185</b>	<b>153.8</b>

Эх сурвалж: БХТ, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”

Монгол Улсын бүх салбар дахь хөдөлмөрийн бүтээмж, нэн ялангуяа хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарын бүтээмж хоцрогдолтой байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын гуравны нэг нь хөдөө аж ахуйн салбарт ажилладаг боловч тус салбарын бүтээмж доогуур, цалин бага, хөдөлмөр эрхлэлтэд улирлын шинж чанар давамгайлж байна. Ажлын байр нь олдоц муутай, дээд мэргэжилтэй хүмүүс хэт олон байгаа нь ур чадвар ба хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ уялдаагүй байгаагийн илрэл юм. Монгол Улс чадварлаг ажиллах хүчнийг татах чадвараар бусад улс орноос сул. Дээд боловсролд хамрагдалтаараа илүү өндөр үзүүлэлттэй ч, хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага байгаа нь цалин хөлсгүй асаргаа арчилгааны болон гэрийн ажлын хүнд ачааллыг үүрдэг, мөн тэтгэвэрт эрт гардагтай холбоотой. 2006 онд эмэгтэйчүүдийн 64.3 хувь нь албан ёсны хөдөлмөр эрхэлдэг байсан бол 2019 онд энэ нь 53.4 хувь болж буурсан байна (харин эрэгтэйчүүдийн 68.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байна). Коронавируст халдвар (COVID-19) цар тахал эхэлснээс хойш 2020 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт дахин 1.6 хувиар буурсан (эрэгтэйчүүдийн энэхүү үзүүлэлт 1.2 хувиар буурсан). Залуучуудын ажилгүйдэл 24.2 хувь байгаа нь улсын дунджаас хоёр дахин өндөр үзүүлэлт юм (Хүснэгт 10, Зураг 11-ийг үзнэ үү).

Зураг 11. Хот, суурин газруудын авто замын сүлжээнд холбогдсон байдал



Эх сурвалж: БХТ, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”

Улсын хэмжээнд тухайн сум, суурин газрын нутаг дэвсгэрээр хатуу хучилттай зам дайран өнгөрдөг 129 хот, суурин байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь Төвийн бүсэд байна. Харин УИХ-аас 2001 онд баталсан “Мянганы зам” төслийн зорилтод тусгагдсан хатуу хучилттай авто зам барихаар төлөвлөсөн 54 хот, суурин, төмөр замын сүлжээ дайран өнгөрсөн 43 хот, суурин байна.

Томоохон хот, суурин газрыг дагасан нийгэм, эдийн засгийн таталцал бий болж, зөвхөн засаг захиргааны үүрэг давамгайлсан хэлбэрийг эдийн засаг, аж ахуйн үүрэг



хосолсон байдалд оруулах, хөдөөгийн хүн амын эрүүл мэнд, сургууль, соёл ахуйн болон банк, санхүү, бөөний худалдааны бичил төвүүд, мал аж ахуйн гаралтай анхан шатны боловсруулалт хийх жижиг үйлдвэрүүдийг бүлэг суурингийн төвд байгуулах шаардлага амьдралаас урган гарч байна. “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд хүн амын жилийн дундаж өсөлт, 2010-2019 онд хот, суурин газрын хүн амын эзлэх хувь, 100 суралцах насны хүнд ногдох сурагчид, 100 хүнд ногдох хэвтэн эмчлүүлэгсэд, нийгмийн бусад дэд бүтэц, засаг захиргааны төвийн байршил, бусад хот, суурин хүртэлх дундаж зай зэргийг харгалзаж, 90 бүлэг суурингийн тогтолцооны саналыг боловсруулж байна.


### 1.3.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ, ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРТАЙ ХОТЫН ХӨГЖИЛ

#### 1.3.1.Хотуудын эрсдлийг даван туулах, нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадвар ба хүн амын нутагшилт, суурьшил

##### 1.3.1.1.Хотын тэлэлт, түүнээс үүдэж буй биологийн төрөл зүйлийн хохирлыг бууруулах

2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 114041.8 мянган га буюу 72.9 хувь, хот, тосгон бусад суурины газар 917.6 мянган га буюу 0.6 хувь, зам, шугам сүлжээний газар 474.8 мянган га буюу 0.3 хувь, ойн сан бүхий газар 14255.9 мянган га буюу 9.1 хувь, усны сан бүхий газар 660.9 мянган га буюу 0.4 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 26060.7 мянган га буюу 16.7 хувийг тус тус эзэлж байна (График 9-ийг үзнэ үү).

График 9. Монгол Улсын газрын нэгдмэл сан (2020 оноор)



Эх сурвалж: ГЗБГЗЗГ, <https://www.gazar.gov.mn>

2020 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнг 2019 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 694.9 мянган га, ойн сан бүхий газар 81.1 мянган га, усны сан бүхий газар 24.9 мянган га-гаар тус тус хасагдаж, хот, тосгон, бусад суурины газар 10.8 мянган га, улсын тусгай хэрэгцээний газар 790.2 мянган га-гаар тус тус нэмэгдсэн байна.

Улсын хэмжээнд нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын тоо 2020 оны байдлаар 2.1 байгаа бол нийслэл хот, томоохон аймаг, сумдад энэ тоо өссөн дүнтэй байна.

Тухайлбал, Улаанбаатар хотын газар нутгийн хэмжээ 4.7 мянган м<sup>2</sup> буюу нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувьтай тэнцдэг. 2020 оны байдлаар нийслэл хотод улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь төвлөрч байгаа бөгөөд хүн амын нягтрал буюу нэгж газар нутагт ногдох хүн амын тоо 339.8 байна.

Манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн 1990-ээд оноос хойш хөдөөнөөс хот, суурин газарт чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөгөөр нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газарт амьдардаг иргэдийн нийт хүн амд эзлэх хувь 1996 онд 52.9 хувь, 2006 онд 62.8 хувь, 2013 онд 68.1 хувь, 2018 онд 67.9 хувь байсан бол 2020 онд 69.0 хувь болж өссөн. Хүн амын шилжилт хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд:

- 1990 оноос өмнө хүн амын шилжилт хөдөлгөөн нь төрийн хатуу хяналт дор байсан бөгөөд төр, засгаас механикаар хязгаарлаж байсан шилжилт хөдөлгөөнийг 1997 онд чөлөөлснөөр эхлэл нь тавигдсан. Нийгэм, соёлын үйлчилгээ илүү хүртээмжтэй хот, сууринд амьдрах хүмүүсийн сонирхол нэмэгдсэнтэй холбоотойгоор шилжилт хөдөлгөөн эрчимжсэн.
- 1999-2001, 2009-2010 онд болсон зудын улмаас олон тооны малчид амьжиргааны эх үүсвэрээ алдсан тул хөдөө, орон нутгаас нийслэл Улаанбаатар хот, бусад томоохон хотуудад шилжин ирэгсдийн тоо эрс нэмэгдсэн.
- Шилжилтийн он жилүүдэд хөдөө орон нутагт байсан улсын өмчийн томоохон үйлдвэрүүд, бааз, нэгдэл задарсанаар ажилгүй иргэдийн тоо огцом өссөн. Орон нутагт ажлын байрны хомсдол үүссэний улмаас иргэд илүү боломж эрэлхийлэн томоохон хот, суурин руу шилжиж эхэлсэн.

Ялангуяа, Нийслэл Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотуудын хүн ам огцом өсч, хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн дийлэнх хувь нь гэр хороололд суурьшин, мөн 2003 оноос Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж, иргэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг нэг удаа үнэгүй өмчилж эхэлсэнтэй холбогдуулан гэр хорооллын газар хяналтгүй, эрчимтэй тэлж, үүний зэрэгцээ тээврийн хэрэгслийн тоо эрс өссөн нь хотын байгаль орчинд сөргөөр нөлөөлөх болсон.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбарт өсөлт бий болсноор Оюутолгой, Тавантолгой, Цагаансуврага зэрэг стратегийн ордуудаас гадна бусад орд, уурхай нээгдэж, тэдгээрийг дагасан шинэ суурьшил үүсч байна. Тухайлбал, уул уурхайн хөгжлийг даган орон нутагт иргэдийн шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, Өмнөговь аймгийн уул уурхайн бүс нутаг болох Цогтцэций, Ханбогд зэрэг сумдад ажлын байр хайх иргэд олноор нүүж байгаа нь төлөвлөлтгүй тэлэлтийг бий болгож байна. Төлөвлөлтгүй хотжилт, түүнээс үүдэлтэй барилгажилт, орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, тээврийн хөдөлгөөн, дэд бүтэц зэрэг нь байгаль, газар нутаг, биологийн төрөл зүйлд аюул учруулах нөхцөл болсоор байна.


Нийслэл Улаанбаатар хотын ногоон бүсийн хилийн нийт урт 350 орчим км бөгөөд хойноос урагшаа 70 км, баруунаас зүүн тийш 75 орчим км, ногоон бүсийн ойн нөөц 19626.4 мян.шоометр, үүнээс 3473.7 мян.шоометр нь Дархан цаазат газрын ойн нөөц, 4630.2 мян.шоометр нь Байгалийн цогцолборт газрын ойн нөөц, 11522.5 мян.шоометр нь ногоон бүсийн ойн нөөц юм. Нийслэлийн ойн сан бүхий газар нь 2000 онд 110.6 га байсан бол 2020 онд 116.2 га болж өссөн. Гэвч Улаанбаатар хотын тэлэлтээс үүдэн экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал улам бүр ноцтой болж байгаа нь ойн нөөц хомсдож агаар, усны бохирдол, хөрсний эвдрэл ихэсч байгаагаар илэрч байна. Энэ нь хотжилтын тэлэлтээс ойн биологийн төрөл зүйлийг хамгаалах нэмэлт төлөвлөгөө, аргачлал шаардлагатайг харуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс хамааран орох хур тунадасны хэмжээ буурч, хуурайших үзэгдэл нэмэгдэж байна. 2018 онд нийслэлийн нутаг дэвсгэрт гол, горхи 48 байгаагаас 1 ширгэсэн, 120 булаг шандын 9 ширгэсэн, 14 рашаан усны хамгаалах шаардлагатай 1, 8 нуур тойромын 1 ширгэсэн байна.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ийг үндэслэн Нийслэлийн ИТХ-ын 2019 оны 21/05 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-г батлан мөрдүүлж байна. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-нд хотын 1 хүнд оногдох ногоон байгууламжийг 2010 онд 15 м<sup>2</sup>, 2020 онд 20 м<sup>2</sup> байхаар тус тус тооцсон боловч энэ үзүүлэлт хэрэгжээгүй. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд Улаанбаатар хотын нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ нь 2016 онд 1.7 м<sup>2</sup>, 2017 онд 2.4 м<sup>2</sup>, 2018 онд 3.2 м<sup>2</sup>, 2019 онд 4.1 м<sup>2</sup>, 2020 онд 5.1 м<sup>2</sup>-т хүрч, өссөн үзүүлэлттэй байна (График 10-ыг үзнэ үү). 2020 онд Улаанбаатар хотын нэг хүнд 5.1 м<sup>2</sup> ногоон байгууламж ногдож байгаа нь олон улсын хотуудын жишгээс 4-5 дахин бага байна.

Нийслэлийн ИТХ-аас суурьшлын бүс тэлж, ой, усны сан хомсдох эрсдлийг багасгах, нийслэлийн ногоон бүсийг хамгаалах зорилгоор ногоон төгөл, мөн голын хөндий, зэрлэг амьтдын тархац, нүүдлийн зам дагасан ойн сан бүхий газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт хамгаалалтад 43 газар хамрагдсанаас 3 нь улсын, 6 нь орон нутгийн, 34 нь дүүргийн тусгай хамгаалалттай газар юм. Эдгээр байршилд газар эзэмших, ашиглах, олгох хориотой бөгөөд зөрчсөн тохиолдолд Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор хориглосон үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийг хамгаалалтын бүсээс нүүлгэн гаргаж байна. Гэсэн хэдий ч ой, усан сан бүхий хэсэгт газар олгох, иргэд, хуулийн этгээд хууль бусаар газар эзэмших зөрчил гарсаар байна.

График 10. Улаанбаатар хотын нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ



Эх сурвалж:НХБХГазар, <https://home.uda.ub.gov.mn/>

Хууль бус мод бэлтгэгчдэд хүлээлгэх хариуцлагыг өндөржүүлэх, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сайн дурын бүлэг байгуулан ажиллуулах, урамшуулал олгох санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох, иргэн, эрх

бүхий албан тушаалтанд урамшуулал олгох зорилгоор Ойн тухай хууль, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан. Хууль бусаар бэлтгэсэн модны хэмжээ 2019 оны байдлаар 150.0 шоометр болж 53.9%-иар буурсан.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2019 онд баталсантай холбогдуулан "Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ" болон "Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээ тогтоох журам"-ыг Засгийн газрын 2019 оны 316 дугаар тогтоолоор батлан мөрдүүлж байна.

### **1.3.1.2. Уур амьсгалыг өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх**

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБҮАӨСК-ын Парисын Хэлэлцээрийг 2016 онд соёрхон баталсан. Тус хэлэлцээрээр гишүүн орнууд хүлэмжийн хийн ялгарал (ХХЯ)-ыг бууруулах, дасан зохицох, үндэсний зорилтоо тодорхойлон, хэрэгжүүлэх нөхцөлийн дагуу Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор “Парисын Хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт” бодлогын баримт бичгийг баталсан. Тус баримт бичигт Монгол Улсын Засгийн газрын баримталж буй уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулах зорилтуудтай уялдуулан, эдийн засгийн тэргүүлэх салбарууд болох эрчим хүч, хөдөө аж ахуй, зам тээвэр, барилга, аж үйлдвэр, хог хаягдлын чиглэлээр хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээг тодорхойлон, үндэсний хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22.7 хувь хүртэл бууруулах зорилтыг дэвшүүлсэн. Хүлэмжийн хийг бууруулах зорилтоос гадна уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох 8 зорилтыг мал аж ахуй, газар тариалан, ой, ус, гамшгийн эрсдлийг бууруулах, нийгмийн эрүүл мэнд, биологийн олон янз байдал, иргэдийн амьжиргаа, нийгмийн хамгааллын салбаруудад тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учрах сөрөг нөлөө, эрсдэлийг багасгах, түүнд дасан зохицоход чиглэсэн зорилтыг тодорхойлсон.

Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн нийт хүлэмжийн хийн ялгаралд 0.09% хувийг эзлэх боловч, нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгарал нь дэлхийн дунджаас 2.7 дахин их юм. Монгол Улс 2014 онд нийт 34,482.73 мян.т CO<sub>2</sub> -эkv. (газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлт ба ойн салбарыг тооцоогүй) ялгаруулсны 50.08 хувь нь эрчим хүч, 48.51 хувь нь хөдөө аж ахуй, 0.95 хувь нь аж үйлдвэр, үлдсэн 0.46 хувь нь хог хаягдлын салбараас ялгарсан байна. Хүлэмжийн хийн ялгарлыг үндэсний хөгжлийн явцтай уялдуулан 2010-2030 оны байдлаар тооцож үзэхэд 2010 онд хүлэмжийн хийн ялгарал 25.8 сая.т CO<sub>2</sub> -эkv. байсан бол 2030 онд 74.2 сая.т CO<sub>2</sub> -эkv. болж, 2.76 дахин өсөх төлөвтэй байна. Тиймээс одоогийн хэрэгжиж байгаа бодлогын хүрээнд 2030 он хүртэл хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах боломжтой гэж үзэж байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого”, “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг бодлогын баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн зорилт, бодлого, хөтөлбөр зэрэг арга хэмжээг тусгасан. Тухайлбал, “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэж, тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилт тавьсан. Ийнхүү эрчим хүчний салбарт уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлийг тусгаснаар зарим эерэг үр дүн гарч байна. Тодруулбал, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, олон улсын жишгийн дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэхээр зохицуулсан нь сэргээгдэх эрчим хүч

нийлүүлэх үнийг бууруулах боломжийг бүрдүүлсэн. Тус хууль нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татахад чухал хөшүүрэг үзүүлж, үүний үр дүнд сүүлийн жилүүдэд нар, салхины цахилгаан станцын тоо нэмэгдэж байна. (<http://www.ccrcc.mn/stat/file/u/ndcmongolia.pdf>.) Нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 2017 онд 4.25 хувь, 2018 онд 7.08 хувь болж өссөн.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах ажлын хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, НҮБХХ-ийн санхүүжилтээр “Монгол Улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төслийг 2017-2020 онд хэрэгжүүлж, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тооцох аргачлал”, “Барилгын хүлэмжийн хийн ялгарлыг тоолох, бүртгэх, мэдээлэх журам”-ыг боловсруулж, батлан мөрдүүлж байна. Эдгээр аргачлал, журмын дагуу барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлын суурь түвшинг тогтоож, вэбэд суурилсан тооллогын анхны цахим системийг бий болгон хөгжүүлж байна. ([https://cdm.unfccc.int/methodologies/standard\\_base/2015/sb147.html](https://cdm.unfccc.int/methodologies/standard_base/2015/sb147.html))

Түүнчлэн, 48 мянга гаруй тонн хүлэмжийн хий ялгарлыг бууруулах 6 загвар төслийг хэрэгжүүлж, 420 гаруй албан хаагч, мэргэжилтнийг сургалтад хамруулан салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан бөгөөд эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд 50 гаруй ажлын байр шинээр бий болгоход дэмжлэг үзүүлсэн. БОАЖЯ, ЖАЙКА хамтран “Хүлэмжийн хийн үндэсний тооллогын системийг бүрдүүлэх чадавхийг бэхжүүлэх” төслийг 2017-2022 онд хэрэгжүүлсэн.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, хот, бусад суурин газрын хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх” зорилттойгоор агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой ажлуудыг тусгасан. Засгийн газраас иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгах, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, агаар, орчны бохирдлыг бууруулах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2017 оны 98 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.

Зураг 12. “Тавантолгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний Зүүн бүсийн үйлдвэр



“Агаарын бохирдлын эсрэг сан” байгуулахаар Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2018 онд баталсан. “Агаарын бохирдлын эсрэг сан” нь агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдуулах

бодисын хаягдлыг багасгах зорилгоор 2019 оноос үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газраас “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2018 оны 43 дугаар тогтоол, “Агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагуурыг гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” 2018 оны 157 дугаар тогтоол, “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 2018 оны 62 дугаар тогтоолыг тус тус батлан хэрэгжүүлж байна. 2018 оны 62 дугаар тогтоолоор боловсруулаагүй нүүрсийг 2019 оноос эхлэн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхийн хэрэглээнд зарцуулахыг хориглосон.

Түүхий нүүрсний хэрэглээг зогсоож, сайжруулсан түвшийг хэрэглээнд нэвтрүүлсэнээр агаарын бохирдлын хэмжээ 2018 оны галлагааны улиралтай харьцуулахад түлшний шаталтаас үүсэх PM2.5 тоосонцор 55 хувиар, PM10 тоосонцорын хэмжээ 38 хувиар багассан. Мөн “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд модлог шахмал үйлдвэр байгуулах зориулалтаар 8 аж ахуйн нэгжид 1,3 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 6 үйлдвэр ашиглалтанд орж, улирлын чанартайгаар ажиллаж шахмал түлш үйлдвэрлэж байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан хэрэгжүүлэх, байгаль орчин, уур амьсгалын санг байгуулж, үндэсний чадавхыг бэхжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд УИХ-ын 2015 оны 303 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” (2015-2025)-ийг батлан хэрэгжүүлж байна.

БОАЖЯ, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр хамтран “Уур амьсгалын ногоон сан”-гийн санхүүжилтээр “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” (NAP) төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлж, “Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох” хичээлийн хөтөлбөр, агуулгыг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, гамшигт эрсдлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэдийн оролцоо чухал байдаг. Засгийн газраас 2018 оны 209 дүгээр тогтоолоор “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тус хөтөлбөрөөр иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор дамжуулан олгож байна. Мөн оюутан, залуус, хүүхэд багачуудад гамшгаас хамгаалах мэдлэг, чадварыг сургуулийн хөтөлбөрөөр дамжуулан олгох зорилгоор их, дээд сургууль, коллеж, политехник коллеж, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс” хичээлийг 2017-2018 оны хичээлийн жилээс зааж эхэлсэн. Түүнчлэн, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан” хичээлийг оруулсан.

Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, цэвэр техник технологи, бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих эрх зүй, эдийн засгийн хөшүүргийг бий болгож, Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн түүхий эд материал ашиглаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Ногоон байгууллага” гэрчилгээ, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн түүхий эд материал ашиглаж, үйлдвэрлэсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээнд “Эко тэмдэг” олгож байна.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр Монгол-Япон Улсын Засгийн газар хооронд “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” байгуулах

тухай баримт бичигт 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр гарын үсэг зурснаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилготой Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ыг хэрэгжүүлэх хоёр улсын хамтран ажиллах боломж нээгдэн амжилттай хэрэгжиж байна. ХКОМ-ыг манай улсад хэрэгжүүлж эхэлснээс хойш өнөөг хүртэл нийт 17 судалгааны төсөл хэрэгжиж, үүнээс албан ёсоор ХКОМ-ын хүрээнд 5 төсөл бүртгэгдэж, 1 төсөл хүсэлт өгсөн, (2021 оноос бүртгүүлэх хүсэлт өгсөн) 3 аргазүй батлагдан, гуравдагч талын этгээд буюу Хөндлөнгийн магадалгаа, нотолгоо хийгч 2 байгууллага бүртгэгдэн зөвшөөрлөө аваад байна.

“Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд дулааны цахилгаан станцуудын гүний усны хэрэглээг бууруулах, бохир ус дахин боловсруулах байгууламжийг барьж байгуулах зорилго бүхий “Хаягдал ус дахин боловсруулж үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн, “Цэвэрлэгдсэн усыг усалгаанд ашиглах заавар багц” MNS ISO 16075-4:2018 стандарт, “Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн шаардлага” MNS 6734:2018 стандартыг батлан мөрдүүлж байна.

### **1.3.1.3. Байгалийн болон хүний оролцоотой гамшгийн нөлөөллийг бууруулах тогтолцоог хөгжүүлэх**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлэн, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ”, 2016-2020 онд “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдлийн менежментийн чадавхыг бэхжүүлэх, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн дасан зохицох болон гамшгаас хамгаалах мэдлэгийг насан туршийн боловсролын тогтолцоогоор олгох” зорилт дэвшүүлсэн. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдлийн үнэлгээ хийж, эрсдлийг бууруулах арга хэмжээ авна”, “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ”, “Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологи нэвтрүүлэх, хяналт шинжилгээний сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах техник хэрэгсэл, хүний нөөцийг системтэйгээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгон эртнээс сэрэмжлүүлэх чадавхыг бүрдүүлнэ ” гэж заасан. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ”, “Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийг эмхлэн зохион байгуулж, орчны хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, олон нийтэд хүрэх мэдээллийн чанар, хүртээмжийг сайжруулна” гэж тус тус заасан.

Монгол Улсад 2017-2021 онд дунджаар 4327 аюулт үзэгдэл, осол тохиолдож, 235 гаруй хүн амь насаа алдаж, 54 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна (Хүснэгт 11-ийг

үзнэ үү). Манай улсад тохиолдож буй гамшгийн нэлээдгүй хувь нь хувь хүний анхаарал болгоомжгүй үйлдэл, сахилга батгүй, хариуцлагагүй байдал, хууль, дүрэм, журмаа биелүүлдэггүйтэй холбоотой байна.

#### Хүснэгт 11. Тохиолдсон гамшигт үзэгдэл, учирсан хохирол

д/д	Нэр	2017	2018	2019	2020	2021	Нийт	2017-2021 оны дундаж
1	Тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоо	4194	4373	4990	4006	4075	21638	4328
2	Нас барсан хүн	203	206	203	248	319	1179	236
4	Хорогдсон мал (мян.толгой)	539	1417	26.1	80.9	163.7	2226.7	445.3
5	Учирсан хохирол (тэрбум.төг)	96.7	81.9	35.8	31.3	25.9 9	271.7	54.3

Эх сурвалж: ОБЕГ

Сүүлийн арван жилийн туршид аюулт үзэгдэл, ослын тоо нэмэгдэж, нийт аюулт үзэгдэл, ослын 80 орчим хувийг объектын болон ой, хээрийн түймэр, харин үлдсэн 20 орчим хувийг бусад аюулт үзэгдэл, осол эзэлж байна. Шалтгаан нь тогтоогдсон ой, хээрийн түймрийн 90 гаруй хувь нь хүний санаатай буюу санамсар болгоомжгүй үйлдлээс, 6 орчим хувь нь байгалийн гаралтай (аянга, цахилгаан гэх мэт), үлдсэн нь техникийн гаралтай (машин механизмын яндангаас үсэрсэн оч гэх мэт) гал түймэр байна.

Монгол Улсад 2020 оны 3 дугаар сард зөөвөрлөгдөж ирсэн Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын анхны тохиолдлоос хойш Засгийн газар тууштай арга хэмжээ авч байна. Тухайлбал, УИХ-аас 2020 оны 4 дүгээр сард Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталсан. Мөн Засгийн газрын 2020 оны 139 дүгээр тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 167 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 168 дугаар тогтоолоор “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус батлан хэрэгжүүлж, цар тахлын эсрэг арга хэмжээнд улсын төсвөөс 2.4 их наяд төгрөг зарцуулсан байна.

Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд 2017 онд УИХ-аас Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. 2020 онд УИХ-д өргөн барьсан Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хот байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах улсын хяналт, онц байдал буюу байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол, гамшгийн үеийн зохицуулалтын асуудлыг шинээр тусгасан. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх стратеги (2017-2030)”-ийг Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор, мөн УИХ-ын 2015 оны 303 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”-ийг тус тус батлан хэрэгжүүлж байна.



Тайлант онд Дэлхийн цаг уурын байгууллагын санхүүжилтээр мэдээлэл боловсруулалтын MSS системийн техник, програм хангамжийн шинэчлэлт, ОБЕГ, НҮБХХ-тэй хамтран цаг агаарын мэдээ, хоногийн нөхцөл байдлын мэдээг иргэд гар утсан дээрээ харах, ашиглах зорилгоор "Ontsgoi" аппликейшн, гамшгийн сэрэмжлүүлэг мэдээ хүргэх зорилгоор "Anhaar" аппликейшнийг нэвтрүүлсэн. Интернетэд суурилсан гамшгийн орон зайн мэдээллийн системийг байгуулах ажлын хүрээнд холбогдох мэдээллийн санг "Үндэсний дата төв"-ийн интернет сүлжээнд байгуулсан. Онцгой байдлын байгууллагын үүрэг, гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор зарим хот, суурин газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 14.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий Гал түймэр унтраах, аврах ангийн барилгыг ашиглалтад оруулсан. Улсын төсвийн 800.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гамшиг, аюулт үзэгдлийн мэдээллийг түргэн, шуурхай хүлээн авах, үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх, шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор "Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв"-ийн техник хэрэгслийг өргөтгөн сайжруулж, зарим аймгийн Онцгой байдлын газар, бүсийн төвүүдэд "Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв"-ийг байгуулсан. "Насан туршийн боловсрол" хөтөлбөр, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох "Аюулгүй амьдрах ухааны үндэс" хичээлийг бүх шатны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж, их, дээд сургуульд "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" хичээлийг заахаар болсон.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр "Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах" төсөл, Европын холбоо, Финляндын "Улаан загалмайн нийгэмлэг"-ийн санхүүжилтээр "Улаанбаатар хотын гамшгийн бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах" төсөл, ЖАЙКА-ын "Орон зайн мэдээлэлд суурилсан веб хандалттай гамшгийн мэдээллийн сан" байгуулах" төсөл, "Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бэхжүүлэх төсөл (2016-2020)", НҮБХХ, Люксембургийн Засгийн газартай хамтарсан "Орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент зохицуулалтын чадавхыг сайжруулах нь" МОН/13/301 төсөл, Япон Улсын "Ядуурлыг бууруулах сан"-гийн санхүүжилтээр "Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл" зэрэг төслүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүдийн хүрээнд "Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв"-ийг байгуулан олон улсын стандартад нийцсэн шинэ техник, технологиор ард иргэдэд үүсэж болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийн талаарх анхааруулгыг хамгийн зөв зохистой хэлбэрээр шуурхай мэдээлэх, "Монгол оронд тохиолддог гамшгийн төрөл бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх арга зүй, эрсдэлийн үнэлгээг дүгнэх шалгуур үзүүлэлт"-ийг боловсруулж, батлуулах, "Орон зайн мэдээлэлд суурилсан веб хандалттай гамшгийн мэдээллийн сан" байгуулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн багц мессеж илгээх төхөөрөмжийг 21 аймгийн 319 сумын Онцгой байдлын газар, Цаг уур, орчны шинжилгээний албадад хүлээлгэн өгөх, газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх төхөөрөмжийг "Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв"-д суурилуулах зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна.

#### **1.3.1.4.Чанартай дэд бүтэц, орон зайн төлөвлөлтөөр хотын байгалийн эрсдэлд тэсвэрлэх нөхцөлийг бий болгох**

Манай улс "Хотжилтын шинэ хөтөлбөр"-ийн 77 дахь хэсэгт "Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Sendai үйл ажиллагааны хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, менежмент хийхэд чиглэсэн мэдээ, мэдээллээр хангах замаар дэд бүтэц, орон зайн төлөвлөлтийг сайжруулан хот, суурины чадавхыг бэхжүүлнэ.

Ядуусын хорооллууд, албан бус суурьшлын нөхцлийг сайжруулсан уян хатан, нөөцийг үр дүнтэй ашиглах, гамшгийн эрсдэл, нөлөөллийг бууруулах дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Орон нутгийн эрх бүхий удирдлага, оролцогч талуудтай хамтран гамшгийн эрсдлийг бууруулах зорилгоор эрсдэл бүхий орон сууцны барилгуудыг хүчитгэх, бэхжүүлэх арга хэмжээг дэмжинэ” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ”, “Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ” гэж тусгасны дагуу холбогдох төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**Газар хөдлөлтийн эрсдэл:** Манай улсын хот, суурин газрын 75 орчим хувь нь газар хөдлөлтийн Рихтерийн 7 ба түүнээс дээш, 12 сум 9 баллаас дээш газар хөдлөлтийн идэвхтэй бүсэд байрладаг. Сүүлийн жилүүдэд нийслэл Улаанбаатар хот орчимд болон улсын хэмжээнд газар хөдлөлтийн тоо, давтамж нэмэгдсээр байна. Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилтын хүрээнд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г Засгийн газрын 2016 оны 282 дугаар тогтоолоор, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”, 2018 оны 125 дугаар тушаалаар “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга байгууламжийг буулган шинээр барих журам”, 178 дугаар тушаалаар “Газар хөдлөлтийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм”-ийг тус тус батлан, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” зэргийг шинэчлэн батлан мөрдүүлж байна. Түүнчлэн, “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж байна.

БХБЯ-ны захиалгаар 2012 оноос эхлэн “Аймаг, сум, суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер- геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгаа”-ны ажлыг Одон орон, геофизикийн хүрээлэн, “Инжгеотех” ХХК гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 12 аймгийн төвд нийт 173259 га талбайд инженер-геологийн нөхцөл, гидрогеологийн судалгаа болон 119895 га талбайд газар хөдлөлтийн судалгааг хийж, зураг төслийг боловсруулсан. Мөн түүнчлэн, нийслэл Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабын газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал, судалгааны ажлыг 79028 га талбайг хамран гүйцэтгэж, ГЗБГЗЗГ-ын “Орон зайн өгөгдлийн дэд бүтэц” <https://geoportalsdi.gov.mn/gzbgzzg/home/>-д байршуулсанаар мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангасан. ГЗБГЗЗГ 2013-2017 онд Монгол Улсын нийт газар нутгийн эрдэс баялгийн нөөц, хөрсний чийгшил, цэвдэг, түүх, археологийн дурсгал, газар хөдлөлтийн байдал, цаг агаар зэрэг 34 төрлийн мэдээллийг агуулсан “Инженер- геологийн мэдээллийн сан”-г байгуулж, газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах суурь мэдээллийг бүрдүүлсэн.

Барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын үнэлгээг улсын хэмжээнд 2011 оноос хийж байна. 2018 оны байдлаар ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй нь тогтоогдсон нийтийн зориулалттай орон сууцны барилга

нийслэлд 349, орон нутагт 702, үүнээс мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглахыг хориглосон нийслэлд 234, орон нутагт 221 барилга байна. 2015 оноос мөрдөгдөж байгаа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын хүрээнд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2019 оны 6 дугаар сарын байдлаар нийт 531 айлын 27 орон сууцыг буулгаж, 875 айлын 9 орон сууцыг шинээр барьж, ашиглалтад оруулсан байна. Аймаг, орон нутгийн хэмжээнд 6 орон сууц, 1 сургууль, 2 хичээлийн байр, 2 соёлын төв, 1 асрамжийн барилгыг буулган шинээр барих ажил хэрэгжиж байна.

2017-2020 онд нийт 138 барилгад барилга, байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргасан. Барилга байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийж, паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлт гаргах ажлыг оноор нь тодорхойлбол, нийслэл Улаанбаатар хотод 2017 онд 43 барилга, 2018 онд 19 барилга, 2019 онд 76 барилга, 2020 онд 48 барилгад тус тус хийгдсэн байна.<sup>6</sup>

**Үерийн эрсдэл:** 1990 оноос хойш томоохон хот, суурин газрууд эрчимтэй барилгажиж, гэр хорооллууд голын татам, уулын энгэр, налуу газраар байрлах болсны зэрэгцээ хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн тоо эрс нэмэгдэж, тэдгээр нь үерийн аюулд өртөх эрсдэлтэй газруудаар суурьших болсноор үерийн аюулыг улам нэмэгдүүлж байна. Тухайлбал, хүн амын статистик мэдээлэл ашиглан хийсэн үерийн эрсдэлийн үнэлгээгээр Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн үерийн аюултай бүсэд суурьшсан нийт өрхийн тоо 2011 онд 1864, 2016 онд 13920 болж, 7.5 дахин өссөн байна. Одоо ашиглаж байгаа ус зайлуулах байгууламж нь 1970-1980 онд байгуулагдан хуучирсан, хүчин чадал нь хангалтгүй, борооны улмаас гэр хорооллын шавар, хог, хаягдал борооны ус дамжуулах хоолой бөглөрснөөр ус гадуур нь хальдаг, гэр хороолол уулын налуу руу тэлж, гэр хорооллын замын 70 хувь нь ус зайлуулах байгууламжгүй байгаа зэрэг нөхцөл байдлыг өөрчлөх шаардлагатай байна.

Дүүргүүдийн 2016 оны нийт хүн ам, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон үзүүлэлтийг ашиглан үерийн аюулын зэрэглэлийг зурагласан. “Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламжийг 2020 хүртэл хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөр”-ийг Нийслэлийн ИТХ-ын 2014 оны 224 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. 2019 оноос эхлэн “Улаанбаатар хотын Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө”-г боловсруулах ажлын бэлтгэлийг хангаж, 2021 онд тус төлөвлөгөөг боловсруулах зөвлөх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан төлөвлөгөөг боловсруулж байна. Цаашид Улаанбаатар хотын хэмжээнд өндөржилтийн нэгдсэн ажлын зураг боловсруулж, үе шаттай хэрэгжүүлэх, Туул гол дээр тохируулагч далан барих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Гал түймрийн эрсдэл:** Хот төлөвлөлтийн болон газар олголт, газар ашиглалтын зөрчил, барилга байгууламжийн хоорондын зайн норм зөрчигдсөн зэргээс шалтгаалан гамшгийн үед гал, түргэний машин очих боломжгүй, гал унтраах ус хангамжийн системийн найдвартай ажиллагааны галын гидрант, галын усны нөөцөлсөн сав хангалтгүй, инженерийн шугам сүлжээ эвдэрч, хангалт тасалдах эрсдэл өндөр зэрэг хүндрэлтэй асуудлууд тулгарч байна. Мөн барилга хоорондын зайг ойртуулсанаар барилга

---

<sup>6</sup> Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт

байгууламжууд нь нэг нэгийгээ сүүдэрлэхээс гадна байгалийн болон гэнэтийн гамшиг болж, барилга байгууламж нурах, гал гарахад хохирол нь илүү өргөн цар хүрээтэй болох үр дагавартай юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гамшгийн эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан хот, суурин газруудад ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх, усан оргилуур, цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс байгуулах чиглэлээр орон нутгийн засаг захиргаа, хувийн хэвшил, иргэд хамтран ажиллаж байна. Мөн БХБЯ-наас хот төлөвлөлт, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд улмаар хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын дэвшилтэт техник, технологи, инновац, бусад арга хэмжээг тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, өндөр барилгад нисдэг тэрэг буух "Н" талбай төлөвлөх, гэх мэт.

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 2019-2020 оны хугацаанд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний индикаторын аргачлалыг ашиглан тохиолдож болзошгүй гамшгийн төрлийг тодорхойлж, ерөнхий үнэлгээг хийсэн. Тус үнэлгээгээр нийслэлийн 9 дүүргийн 30 хороонд газар хөдлөлтийн эрсдэл “өндөр”, 16 хороонд үерийн эрсдэл “өндөр”, 14 хороонд объектын гал түймрийн эрсдэл “өндөр” гэж тус тус дүгнэгдсэн. Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх, түр байршуулах байршлуудыг төлөвлөсний дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт болзошгүй гамшиг тохиолдсон үед нүүлгэн шилжүүлэх 31 байршилд талбайн хэмжээ, эзэмших, ашиглах зориулалтыг нарийвчлан тогтоосон.

2010 оноос нийслэл хот, бусад хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгол хийх, шинээр боловсруулах ажлыг зохион байгуулж, зургийн даалгаварт ногоон байгууламжийн эзлэх хувийг 15-20 хувьд хүргэсэн байх, усан оргилуур, гамшгийн эрсдэлийг бууруулах, инженерийн бэлтгэл ажлын арга хэмжээ зэргийг төлөвлөсөн байх эдгээр шаардлагыг тусган, зураг төсөлд экспертиз хийх замаар хянаж, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн үед авах арга хэмжээний талаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа боловч газар хөдлөлт, үер, гал түймрээс урьдчилан сэргийлэх бүтээн байгуулалтын ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Эрсдэлийг бууруулах чухал хүчин зүйл болох бүтээн байгуулалтын ажлын цар хэмжээ бага, төлөвлөлтөнд тусгагдсан арга хэмжээ хангалтгүй биелэгдэж байна. Цаашид эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, гамшгийн менежментийг боловсронгуй болгох, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

### **1.3.2.Тогтвортой менежмент ба Байгалийн нөөцийн ашиглалт**

#### **1.3.2.1.Хот, суурины байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бэхжүүлэх**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.5-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ” гэж, “Ногоон хөгжлийн бодлого”-ын 6.1-т “Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, хүн амын хэт төвлөрөл үүсэхээс сэргийлсэн, өөрийгөө тэтгэх чадвартай “ногоон”, “ухаалаг” хот,

тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх”, 6.3-д “Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөж, эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 15 хувь, 2030 гэхэд 30 хувьд хүргэх” гэсэн зорилт дэвшүүлсэн

Монгол Улсад ойн сан бүхий газар 14255.9 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг эзэлдэг. 2020 оны байдлаар Монгол орны цөлжилтийн үнэлгээгээр нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га талбай доройтож, үүнээс нэн хүчтэй 4.7 хувь, хүчтэй 18.6 хувийг эзэлж, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт газар нутгийн 50-70 хувь цөлжилт, газрын доройтолд өртсөн. Иймд Засгийн газраас ойжуулалтыг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах зорилтыг бодлого, хөтөлбөрт тусган, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, хот, суурины ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Тухайлбал, улсын хэмжээнд цөлжилтийг бууруулах, ойн бүсийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр Ховд, Баян-Өлгий, Увс, Сүхбаатар, Хэнтий, Завхан, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Говьсүмбэр зэрэг аймгуудад 103 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулсан. Байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг Завхан аймгийн Завханмандал суманд 160 га, Тосонцэнгэл суманд 25 га, Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 60 га, Архангай аймгийн Булган суманд 80 га, нийслэл Улаанбаатар хотын ногоон бүсэд 150 га-д хийсэн. Томоохон ай сав, эхийг хамгаалах зорилгоор 2018 онд нийт 11 аймгийн 15 сум, Улаанбаатар хотын ногоон бүсийн ойн санд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг 1260 га талбайд, ойжуулалтын ажлыг 930 га талбайд хийсэн байна.

Манай улс 2010 оноос эхлэн жил бүрийн тав, аравдугаар сарын хоёр дахь долоо хоногийн бямба гарагийг бүх нийтээр “Мод тарих өдөр” болгосноор хот, суурин газруудад мод, бут, ногоон байгууламжийг байгуулах ажил идэвхитэй өрнөсөн. Олон улсын стандартын дагуу нэг сая хүн амтай хотод нэг хүнд 24 м<sup>2</sup> ногоон байгууламж ноогдож байх шаардлагатай байдаг. Нийслэл Улаанбаатар хотын хувьд нийт хүн амын 40 гаруй хувь буюу 1.5 сая хүн амьдарч, 2020 оны байдлаар нэг хүнд дунджаар 5.1 м<sup>2</sup> ногоон байгууламж ноогдож байгаа нь дэлхийн дунджаас 5 дахин бага үзүүлэлттэй байна.

Нийслэлийн ИТХ-ын 2019 оны 21/05 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 онд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд шинээр 11,8 га талбайг зүлэгжүүлж, 3241 шилмүүст мод, 250000 гоёлын навчит мод, сөөг тарьж, арчилгааг мэргэжлийн байгууллага гүйцэтгэж байна. Нийтийн эзэмшлийн шинээр 40.4 га, арчилгааны 122.4 га, хязгаарлагдмал хэрэгцээний 1.2 га, тусгай хэрэгцээний 16 га, нийт 180га газарт ногоон байгууламжийг нэмсэн.

Мод тарьсан, ногоон байгууламж бий болгосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах зорилгоор 2018-2020 онд нийслэлийн ЗДТГ, ЗАА-наас “Манай хороо-Миний гудамж” аяныг санаачлан хэрэгжүүлсэнээр айл өрх, албан байгууллагуудын хашаандаа мод тарих идэвхийг өрнүүлсэн.

### **1.3.2.2.Нөөцийг ариглах, хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахыг шаардлага болгох**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 74 дэх хэсэгт “хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, боловсруулах, хогийн цэгийг багасгах, хаягдлыг дахин боловсруулах боломжгүй бол хаягдлыг эрчим хүч болгох зэргээр хог хаягдлын менежментийг дэмжинэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл

баримтлал 2030"-д "Хот, суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанар, хог хаягдлын менежментийг сайжруулна" гэж тусгаж, 2016-2020 онд "хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх" зорилтыг дэвшүүлсэн. "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ", "Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ", мөн "Ногоон хөгжлийн бодлого (2014-2030 он)"-ын баримт бичигт "Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувь бууруулах" гэж тус тус туссан. Эдгээр зорилтын хүрээнд Засгийн газраас хог хаягдлын талаарх холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэн баталж, мөн төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагааг сайжруулах, хог дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.

2017 онд шинэчлэн баталсан Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2017-2018 онд холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг батлан мөрдүүлж байна.

Засгийн газрын 2014 оны 298 дугаар тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. Тус хөтөлбөрийн II үе шат 2017-2022 онд хэрэгжиж байгаа бөгөөд хог хаягдлаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, ногоон хэрэглээний соёл, нийгмийн хариуцлагын ойлголтыг төлөвшүүлэх, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бий болгож, цэвэр, эрүүл орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолоор нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй, байгальд ээлтэй 15 төрлийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр баталсан. Мөн Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолын дагуу байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн түүхий эд материал ашиглаж, үйлдвэрлэсэн, бүтээгдэхүүн, үйлчилгээнд "Эко тэмдэг" олгож байна.

Манай улсын хувьд цуглуулсан нийт хог хаягдлын ихэнхийг төвлөрсөн хогийн цэгт устгадаг. Улсын хэмжээнд 2020 онд зөвшөөрөгдсөн 381 хог хаягдлын төвлөрсөн цэгт нийт 2 260.9 мянган тонн хог хаягдал тээвэрлэн зайлуулсанаас 2 016.1 мянган тонныг устгасан. Хог хаягдлын нийт нөөцийн бүтцийг 2019 байдлаар авч үзвэл, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал 41.4 хувь, өрхийн хог хаягдал 50.7 хувь, дахин ашиглаж, дахин боловсруулахаар цуглуулсан хог хаягдал 7.9 хувь, хог хаягдлын импорт 0.1 хувийг тус тус эзэлж байна. Нийт хог хаягдлын зөвхөн 10 хүрэхгүй хувийг дахин боловсруулж байна. Үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд дахин ашигласан, дахин

боловсруулсан хог хаягдлын хэмжээ улсын хэмжээнд 2018 онд 234.6 мянган тонн байсан бол 2019 онд 250.6 мянган тонн, 2020 онд 285.2 мянган тонн болж өссөн дүнтэй байна.

Нийслэл Улаанбаатар хотод 2020 оны байдлаар хог хаягдал дахин боловсруулах чиглэлээр нийт 28 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжсэн “ЭКО парк” байгуулах төслийг 2015 онд санаачлан эхлүүлсэн. Төслөөр 13 төрлийн хог хаягдлыг дахин боловсруулах 19 үйлдвэр, хог хаягдал ангилан ялгах 4 үйлдвэр, нэг авто бааз, засвар үйлчилгээ, ариутгалын төв, нэг үнсний ландфиллын байгууламжийг барьж байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд Цагаан давааны хог хаягдлын төвлөрсөн цэгт баригдах үнсэнд зориулсан ландфилл болон засвар, үйлчилгээ, агуулахын барилгын ажлыг 2020 онд ашиглалтад өгсөн. Мөн нэгдсэн удирдлага бүхий хог хаягдлын үйлдвэр байгуулах саналтай 23 аж ахуйн нэгж, байгууллагын консерциумыг байгуулсан. Эдгээр байгууллагуудаас 10 аж ахуйн нэгж хог хаягдал дахин боловсруулах үйлдвэр барих ажлаа эхлүүлээд байна.

Улаанбаатар хотын төвлөрсөн хогийн цэгүүдийн нэг болох Нарангийн энгэрт үйл ажиллагаа явуулж буй хог хаягдлыг ангилан ялгах үйлдвэр нь сард 1400 тонн хог хаягдлыг хүлээн авч, дунджаар 6400 кг хуванцар сав, 980 кг бохир хуванцар, 554 кг лааз, 690 кг зузаан гялгар уут, 250 кг нимгэн гялгар уут, 2000 ш шил, 50-60 кг хайлш, 40-50 кг төмөр, 70-75 тонн картон цаас зэргийг ангилан ялгадаг. Тус үйлдвэрийн үйл ажиллагаа нь улирлын шинжтэй байсан бөгөөд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОЙКА)-ын буцалтгүй тусламжаар өргөтгөл хийж, хүчин чадлыг нь нэмэгдүүлснээр бүтэн жилийн турш тасралтгүйгээр ажиллах боломжтой болсон. Түүнчлэн, ЕСБХБ-ны санхүүжилтээр Улаанбаатар хотын Морингийн давааны төвлөрсөн цэгийн хүчин чадлыг нэмэгдүүлж, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах байгууламж барих, хатуу хог хаягдал булшлах цэг буюу Ландфилл байгууламж байгуулах төслийг 2019 оноос хэрэгжүүлж байна (Зураг 13-ыг үзнэ үү).

**Зураг 13. Ландфиллын байгууламж болон барилгын хог бутлах, ангилах үйлдвэр**



Морингийн даваа, Цагаандавааны хогийн цэгийг интернетийн сүлжээнд холбон, хог хаягдлыг бүртгэх системийг нэвтрүүлснээр Улаанбаатар хотын төвлөрсөн хогийн цэгт ирж байгаа хог хаягдлын мэдээг 100 хувь бүртгэж, төрөлжүүлэх боломжтой болсон.

Манай улсад ердийн хог хаягдал төдийгүй уул уурхайн үйл ажиллагаанаас гарах хүнд металл, химийн хорт бодис агуулсан хаягдал, чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодис, пестицид, тэдгээрийн сав, баглаа боодол, ашигласан тос, зай хураагуур, мөнгөн ус агуулсан хэмжлийн багаж, хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн лаг, эмнэлгийн хог хаягдал зэрэг үйлдвэрлэл, ахуй, эмнэлгээс гарах аюултай хог хаягдлын хэмжээ ч ихэсч, хур хуримтлал бий болсоор байна. Энэ талаар 2009 онд хэсэгчлэн хийсэн тооллого, судалгааг эс тооцвол улсын хэмжээнд аюултай хог хаягдлын нэгдсэн бүртгэл, хяналтын ажил бараг бүхэлдээ орхигдсон байсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/21, А/444 дугаар тушаалаар баталсан маягтаар үндэсний хэмжээнд энгийн болон аюултай хог

хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг [www.eic.mn](http://www.eic.mn) сайтаар дамжуулан бүртгэж байна.

Аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахын барилгын жишиг зураг төсөл, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын 9,9 сая төгрөгийн гэрээг “ХБХДТ” ХХК-тай байгуулан ажиллаж байна. Гэрээнд заасны дагуу аюултай хог хаягдал хадгалах байгууламжийг байгуулах ажлыг Дархан, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Завхан, Архангай, Өвөрхангай, Дундговь, Дорнод, Дорноговь, Төв зэрэг аймгууд болон Улаанбаатар хотод эхлүүлсэн. АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлсэн “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5”-ийн эмнэлгийн хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Увс, Хэнтий, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн хог хаягдлын барилга байгууламжийг нийт 371,0 сая төгрөгөөр барьж, ашиглалтад оруулсан.

Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн талаар судалгаа хийх, норм норматив боловсруулах ажил, ашиглалтаас гарсан автомашины аккумуляторыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах стандартын зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Эс Ай Си Эй” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2017 онд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 43 дугаар тушаалаар “Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батареиг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага MNS 6783:2019” Үндэсний стандартыг батлан мөрдүүлж байна. Хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, боловсруулахад иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлэх, мөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх зэргээр бүх нийтийн оролцоог хангах зорилгоор “Нийслэлийн шуурхай удирдлага зохицуулалтын төв”-ийг байгуулсан. Тус төв нь хотын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлын талаарх санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаа явуулж байна.

### **1.3.2.3. Усны нөөц, хотын хаяа залгаа далайн эргийн хэсгийн байгаль орчинд ээлтэй ашиглалт, менежментийг хэрэгжүүлэх**

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ”, “Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, гол мөрний болон хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулах, усан сан, хөв, цөөрөм байгуулж, ус хангамжийг нэмэгдүүлнэ”, “Нийслэл, хот, суурин газрын ундны эх үүсвэрийг хамгаалах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэж заасан.

Монгол Улс усны нөөц багавтар орны тоонд багтдаг бөгөөд байгаа багахан нөөц нь нутаг дэвсгэртээ жигд бус тархсан, хяналт, менежмент сул, эрх зүйн орчин нь төдийлөн боловсронгуй бус, ус хангамжийн түвшин доогуур, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн хүртээмж, хүчин чадал хангалтгүй, боловсон хүчин, хүний нөөцийн хомсдолтой орны хувьд тулгамдаад байгаа асуудлуудаа шийдвэрлэх шаардлага тулгараад байна. Нөгөөтэйгүүр, Монгол оронд нүүрлэж байгаа уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, түүнээс үүдсэн цөлжилт идэвхжиж, хүрээгээ тэлж байгаа нөхцөлд түүний сөрөг нөлөөг зөөлрүүлэх, байгалийн нөөцийг хадгалах, амьдралын хэв маяг, аж ахуй эрхлэх оновчтой хэлбэрийг тогтоох, эдийн засгийн тогтвортой өсөлт, тухтай амьдралын хэрэгцээг хангах шаардлагатай байна.



Монгол орны нийт усны нөөц 564.8 км<sup>3</sup>. бөгөөд тус нөөцийн 98 хувь нь гадаргын ус байдаг боловч нийт ус ашиглалтын 70 гаруй хувь буюу 416 сая м<sup>3</sup>/жил газрын доорх усаар хангагдаж байна. Манай оронд жилийн хур тунадасны дундаж 250 мм бөгөөд 2019 онд 457 гол, горхи сэргэж, 1266 ширгэсэн бол 2020 онд 74 сэргэж, 682 ширгэсэн байна. Манай улсын гол мөрний урсацын 60 гаруй хувь ОХУ, БНХАУ-ын нутаг дэвсгэр рүү хил даван урсан гардаг. Өмнөд хэсэгт гадаргын усны нөөц хомс учраас зөвхөн газрын доорх усыг ашиглаж байна. Нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь цөлжилтөд өртсөний ихэнх хувийг гадаргын ус хомс тал хээр, говийн бүс эзэлж байна.

Гадаргын усыг хуримтлуулж, ашиглалтыг дэмжих хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор усны нөөцийг нэмэгдүүлж, гачиг үеийн урсацыг тэтгэж, үерийн эрсдэлийг бууруулж, усны эрчим хүчийг гарган авснаар хүлэмжийн хийн ялгарал, цөлжилтөд өртсөн талбайг багасгаж, шар шороон шуурга үүсэх нөхцлийг бууруулна.

Нийт хүн амын 30.5 хувь нь төвлөрсөн ус түгээгүүрийн сүлжээнээс, 35.8 хувь нь зөөврийн усны тээврийн үйлчилгээнээс, 24.6 хувь нь ус түгээх байр, худгаас, 9.1 хувь нь булаг, шанд, гол, горхиноос усаа авч хэрэглэж байна. Усны хэрэглээний түвшин нь харилцан адилгүй бөгөөд хот, суурин газрын инженерийн хангамж бүхий орон сууцанд оршин суугчид хоногт дунджаар 230-350 л, хөдөө, орон нутаг болон гэр хороололд оршин суугчид дунджаар 5-10 л ус хэрэглэдэг. Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах нь хөгжлийн голлох хүчин зүйл болж байна.

Усны нөөц ашигласны төлбөр ямар нэг хэлбэрээр хийгдэж байгаа ч зарим салбарт усны үнэ цэнийг ахиулах, төлбөрийг хуулийн дагуу зөв зарцуулах шаардлага чухал байна. 2018 оны байдлаар ус ашигласны төлбөрт 46.7 тэрбум төгрөг улс, орон нутгийн төсөвт төвлөрсөн байна. Энэ мөнгөний 96 хувь нь усны хэрэглээний 17 хувийг эзэлдэг уул уурхайгаас оржээ. 83 хувийг эзэлж байгаа бусад хэрэглэгчид нь төлбөрөөс чөлөөлөгдсөн байна. Усны тухай хуулиар энэ төлбөрийн 35 хувь буюу 16.3 тэрбум төгрөгийг жил бүр ус, усан орчныг сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх, бохирдлыг бууруулахад зарцуулах ёстой байтал зөвхөн талыг нь буюу 8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Улсын хэмжээнд ус ашиглалт, усны хэрэглээнд тавих хяналт хангалтгүй, энэ талаарх эрх зүйн орчин, нэгдсэн мэдээлэл, хяналтын тогтолцоо хараахан бүрдээгүй байгаа нь ус ашиглалт, усны хэрэглээний мэдээллийг нарийвчлан гаргаж хянах, менежмент хийхэд хүндрэл учруулж байна. Усны нөөц болон байгалийн бусад нөөцийг зохистой ашиглах, хамгаалах цогц үйл ажиллагаатай уялдуулан менежментийн цогц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, Монгол орны усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулан ус ашиглалт, хэрэглээний өндөр ачаалал бүхий голуудаас авч ашиглах усны боломжит нөөцийг тогтоож, усны салбарын гадаад харилцааг өргөжүүлж, усны нөөц, ашиглалт, хамгаалалтын чиглэлээр олон улсын байгууллага, гадаад орнуудын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслүүдийн үр өгөөжийг дээшлүүлэх, бүс нутаг, олон улсын хурал, чуулган, зөвлөлд аль болох өргөн хүрээнд оролцож, өөрийн орны байр суурийг илэрхийлэн хамтран ажиллах, усны нөөцийн менежментийг гардан хийх, усны талаархи холбогдох хуулиудыг багц байдлаар авч үзэж, усны салбарын олон талт харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

#### **1.3.2.4.Цахимжуулалт, цэвэр эрчим хүч ба технологид түшиглэсэн Ухаалаг-хот хандлагыг хэрэгжүүлэх**

Монгол Улс нь “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 44, 66, 121 дэх хэсэгт заасныг дэмжин, цахимжуулалт, цэвэр эрчим хүч, технологид түшиглэсэн “Ухаалаг хот” хандлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилтыг үндэсний бодлого, төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ” гэж тусгаж, 2016-2020 онд “хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг боловсруулах, ногоон хөгжлийн загварт нийцсэн дэд бүтцийг бий болгох, барилгын дулааны алдагдлыг 20 хувиар бууруулах” зэрэг зорилтыг дэвшүүлсэн. Тус зорилтын хүрээнд ногоон барилгын санхүүжилтийг дэмжих талаар Уур амьсгалын өөрчлөлтийн сан, Ногоон байгаль орчны сан, Даян дэлхийн ногоон хөгжлийн институт зэрэг байгаль орчинд ээлтэй, Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой олон улсын донор байгууллагуудаас “Монголын банкны холбоо” ТББ болон арилжааны банкуудаар дамжуулан хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Мөн барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй буюу эрчим хүчний хэрэглээг 20 хүртэл хувиар бууруулсан тоног төхөөрөмж болон хуучин барилгыг дулаалж, түүнд зарцуулагдах эрчим хүчний хэрэгцээг хэмнэсэн бүтээгдэхүүнд зээл олгож байна. Эрчим хүчний зарцуулалтыг 40-60 хувиар хэмнэх гудамжны лед гэрэлтүүлгийг нэвтрүүлсэн “Аюулгүй гудамж, гэрэлтэй гудамж” төслийг Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад хэрэгжүүлж байна.

Засгийн газраас эрчим хүч хэмнэлтийг дэмжин “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр”-ийг 2017 оны 274 дүгээр тогтоолоор баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчим хүчний хангамжид сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх, эрчим хүчний хангамжийн бүтцийг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийн халаалт, ахуйн хэрэглээний гэрэлтүүлэг, халуун усыг сэргээгдэх эрчим хүчээр хангах ажлыг зохион байгуулж байна.

Манай улсын хувьд цахилгаан эрчим хүчний үндсэн эх үүсвэр нь түүхий нүүрс юм. Засгийн газраас сэргээгдэх эрчим хүчний ашиглагдаагүй их нөөц, усан цахилгаан станцын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор зарим төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд 2013-2019 оны хооронд буюу 6 жилийн богино хугацаанд 7 бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчдийг Төвийн эрчим хүчний системд холбосон. Үүнд нийт 152МВт-ийн 3 салхин парк, 45МВт чадалтай 4 нарны цахилгаан станцыг барьж байгуулан холбосон. 2019 оны байдлаар эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 18.1-д хүрсэн.

Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор “Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам” баталсан. Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/122 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид “Эко тэмдэг”, “Ногоон гэрчилгээ” олгохоор болсон.

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн, агаарын бохирдол өндөр хотуудын нэгд тооцогддог. Нийслэл хотын агаарын бохирдлын 80 орчим хувь нь уламжлалт зуух ашиглан

гал түлдэг гэр хорооллын нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй. Засгийн газар 2018 оны 62 дугаар тогтоолоор боловсруулаагүй нүүрсийг 2019 оноос эхлэн Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн өрхийн хэрэглээнд зарцуулахыг хориглосон бөгөөд ингэснээр агаарын бохирдлын хэмжээг 50 хүртэл хувиар бууруулна гэж үзсэн. Тус зорилтын хүрээнд айл өрхийг сайжруулсан түлшээр хангах, халаалтын зуухыг дэвшилтэт технологиор солих, цахилгаан халаагуурын хэрэглээг дэмжих зэрэг ажлуудыг хэрэгжүүлсэн.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттайгаар нэвтрүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэхүү зорилтын хүрээнд “Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл”-ийг үндэслэн “Үндэсний Дата Төв” УТҮГ төрийн гэрчилгээжүүлэгч байгууллагын үүргийг хариуцаж, байгууллагуудтай бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг авах боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтэрсэн.

2017 онд “Хур” төрийн мэдээлэл солилцооны системийг нэвтрүүлж, нийт 74 вэб сервисийг хөгжүүлж, 29 төрийн байгууллага, 19 хувийн хэвшлийн байгууллага холбогдож мэдээлэл солилцож байна. Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох 176 төрийн үйлчилгээний жагсаалт, төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх 320 төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан. Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарлаж, төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд шуурхай хүрч ажиллах зорилтыг дэвшүүлж, цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг бүрэн холбож, 320 орчим төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлж, шуурхай, цаасгүй, нээлттэй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг бий болгож байна.

Нийслэлийн ИТХ-ын 2014 оны 16/11 дүгээр тогтоолоор “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг I үе шат “Цахимжсан Улаанбаатар - Electron-UB” (2014-2016 он), II үе шат “Технологижсон Улаанбаатар - Digital-UBI” (2015-2018 он), III үе шат “Ухаалаг ногоон хөгжингүй Улаанбаатар - Smart-UB” (2016-2020 он) гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталсан. Гэвч 2016 оноос хойш тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тусгайлан төсөв батлагдаагүй, түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах Удирдах хороо 2016 оны сонгуулийн үр дүнгээр, “Ухаалаг Улаанбаатар” дэд хороо нийслэлийн ИТХ-ын 2018 оны 15/04 дүгээр тогтоолоор тус тус татан буугдсан тул хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Хэдий тийм боловч “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т цахимжуулалт, технологид түшиглэсэн “Ухаалаг хот”-ын хандлагыг дэмжин ажиллах ажлууд багтсан.

ЗТХЯ, АХБ хамтран “Монгол Улсын Тээврийн ухаалаг системийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА-9131 МОН” техникийн туслалцааны төслийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд зорчигчийн тасалбар худалдан авах үйл ажиллагааг хөнгөвчлөх, тээврийн үнэ тарифын хөнгөлөлт үзүүлэх замаар TVM (ticket vending machines)-аар тасалбар олгох үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн, хот доторх болон хот орчмын зорчигч тээврийн үйлчилгээнд ажиллаж буй 1250 автобус, троллейбусанд байрлал тогтоох төхөөрөмж, жолоочийн мэдээлэл дамжуулах консол, зорчигчийн суух, буух хаалганы дэргэд карт уншигч төхөөрөмж, хяналтын камеруудыг байршуулсан. Орчны бохирдлыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын

нийтийн тээврийн автобуснуудад хөө тортог шүүгч DPF төхөөрөмжийг суурьшуулж, үүний үр дүнд хөдөлгөөнт эх үүсвэрээс үүдэлтэй агаарын бохирдлын хэмжээ 20 - 30 хувиар буурсан байна.

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-т заасан цахимжуулалт, цэвэр эрчим хүч болон технологид түшиглэсэн ухаалаг-хот хандлагыг хэрэгжүүлэх үүрэг, амлалтын нэг шалгуур үзүүлэлтийг замын хөдөлгөөний ачааллыг бууруулах нэг шийдэл гэж үзсэн. Энэхүү шалгуур үзүүлэлт нь хотуудын замын удирдлагын системтэй холбогдсон гэрлэн дохио бүхий гудамжны уулзваруудын тоогоор хэмжигдэх юм. Нийслэл Улаанбаатар хотын хүн ам өдөр тутмын зорчилт, хөдөлгөөнийг үндсэндээ авто машинаар хийж, авто замыг ашиглаж байна. Улаанбаатар хотын барилгажсан талбайд нийт 839 км авто замаар, өдөр бүр 420-450 мянган тээврийн хэрэгсэл зорчиж байна. Нийслэл хотын авто замаар зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохион байгуулах үүргийг “Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв” гүйцэтгэдэг. Тус төв нь хөдөлгөөнийг зохицуулж байгаа гэрэл дохионуудаар дамжуулан хотын хөдөлгөөнийг оновчтой удирдан зохион байгуулах, замын хөдөлгөөнийг зохицуулж, хяналт тавьж байгаа сервер, програм хангамж, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж байна. Улаанбаатар хотод 2020 оны байдлаар 155 гэрлэн дохиог авто замын уулзвар болон явган зорчигчийн хөдөлгөөнийг зохицуулах зорилгоор ашиглаж байна.

Манай улсын хувьд эрс тэс уур амьсгалаас шалтгаалан өвлийн улиралд хэрэглэгчдийн дулаан хангамж, эрчим хүчний хэрэглээ ихэсдэг. Иймд эрчим хүчний хэмнэлтийг бий болгох зорилгоор барилга, эрчим хүчний салбарт эрчим хүчний үр ашгийн стандарт, норматив боловсруулах, ангилал, хяналт, шошгожуулалт, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, эрчим хүчний хэмнэлт хийсэн хэрэглэгчдийг урамшуулах тогтолцоог бий болгох, олон нийтэд эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийг сурталчлах шаардлагатай байна. Мөн ногоон дулаан хангамжийг хөгжүүлэх, тухайлбал нүүрсэнд суурилсан зуухны хүлэмжийн хийн ялгарал багатай шийдлүүд болох газрын гүний дулааны насос, нарны коллектор болон цахилгаан бойлер зэргийг ашиглах нь зүйтэй.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖИЛТ**

### **2.1.ХОТЫН ЗАСАГЛАЛЫН БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ: ДЭМЖИХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ**

#### **2.1.1.Төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн захиргаадад өөрсдийн оноогдсон үүргийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 90 дэх хэсэгт “Үндэсний хууль, эрх зүйд нийцүүлэн нутаг дэвсгэрийн хил, үйл ажиллагаанд тулгуурлан орон нутгийн болон хотын бүх түвшний засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх бүс нутгийн ба орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, боломжоор хангах замаар шийдвэр гаргах болон ажиллах явцад бүс нутгийн болон орон нутгийн удирдлагын оролцоог хангахад тусална” гэж заасан. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”-д “төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим” хэмээн тодорхойлсон нь төвлөрлийг сааруулах бодлого, үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт, нийслэл нь нийт 9 дүүрэгт, аймаг нь нийт 330 сумын нутаг дэвсгэрт хуваагддаг. 2001 онд УИХ-аас баталсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол Улсад эдийн засгийн Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн дөрвөн бүсийг тогтоож, нийслэл Улаанбаатар хотыг бие даасан бүсийн жишгээр хөгжүүлэхээр заасан. Эдгээр эдийн засгийн бүс тус бүрд тухайн бүсийн нийгэм, эдийн засгийн томоохон төвлөрөл бий болгон хөгжүүлэх зорилгоор 2 тулгуур төв хот, нийт 8 хот байхаар тогтоосон.

Монгол Улс 1992-1996 онд төвлөрлийг сааруулах бодлогыг идэвхтэй хэрэгжүүлсний үр дүнд 1996-2002 онд нутгийн удирдлагын байгууллага илүү бие даасан байдлаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байсан боловч нутгийн удирдлагын байгууллагын чадавх сул байснаас төвлөрлийг сааруулах бодлого хангалттай сайн хэрэгжээгүй байна. 2002-2013 оны хооронд эрх мэдлийг эргэн төвлөрүүлж, орон нутгийн бие даасан байдал нь бүтэц, зохион байгуулалт, санхүү, төсвийн хувьд суларсан. Иймд сүүлийн жилүүдэд ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцааны шинэ нөхцөлд төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулж, нутгийн удирдлагын бие даасан байдлыг бэхжүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн төвлөрлийг сааруулах, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах чиглэлийн арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталсан. Тус баримт бичигт “нутгийн удирдлагын байгууллагын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх замаар улс төрийн төвлөрлийг сааруулах”, “төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тогтолцоог боловсронгуй болгох, чиг үүргийг дахин хуваарилах, хүний нөөцийн тогтвортой бодлогыг хангах замаар захиргааны төвлөрлийг сааруулах”, “орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх замаар төсвийн төвлөрлийг сааруулах”, “төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, төрийн болон орон нутгийн байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, нийгмийн салбарын хувьчлалыг үргэлжлүүлэх замаар эдийн засгийн төвлөрлийг сааруулах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн. Тус бодлого нь нийтийн хөрөнгийг үр ашиггүй хуваарилах, зарцуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэж, сайн засаглалыг

бүрдүүлэх, шийдвэр гаргах үйл явцад ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчимд үндэслэсэн. Тус бодлогын хүрээнд “Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийг дахин хуваарилах аргачлал”-ыг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Энэхүү аргачлал батлагдсанаар төрийн байгууллагуудын чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийх замаар төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, зарим чиг үүргийг төрийн байгууллагын түвшин болон салбар хооронд оновчтой дахин хуваарилах эсхүл төрийн бус байгууллага, хувийн хэвшилд шилжүүлэх нөхцөл бүрдсэн.

Төрийн байгууллагын орон нутаг дахь удирдлагын босоо тогтолцоог зохицуулсан зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн. Тодруулбал, хуулийн төсөлд нийгмийн даатгал, нийгмийн халамж, аудит, цаг уур, орчны шинжилгээ, татвар, улсын бүртгэл, статистикийн байгууллагын тогтолцоог хэвтээ тогтолцоонд шилжүүлэхээр тус тус заасан. Эдгээр хуулийн төслүүдийг баталснаар тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага томилдог томилгоог аймаг, нийслэл, дүүргийн удирдлагууд нь томилдог болж, ингэснээр орон нутгийн эрх мэдэл нэмэгдэж, засаглалын чадавх сайжирч, орон нутагт төрийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ гэж үзэж байна. Эдгээр бодлого, аргачлал, хуулийн төслүүдийг боловсруулахад Монгол Улсын Засгийн газар Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын гэрээгээр ЗГХЭГ-т хэрэгжүүлж буй “Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг төсөл”-өөс (2015-2019 он) техник, арга зүйн туслалцаа үзүүлж ажилласан.

Төсвийн төвлөрлийг сааруулах үйл явцыг үр дүнтэй болгохын тулд орон нутаг өөрийн орлогын эх үүсвэрийг хянах эрх мэдэлтэй байх шаардлагатай. Төсвийн орлогын үндсэн суурь нь хүн ам төвлөрсөн, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ хөгжсөн нийслэл Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг болон зарим ашигт малтмалын нөөц бүхий аймгуудад төвлөрч байна. Монгол Улсад нийслэл хотоос гадна 5 аймаг өөрийн орлогоороо зарлагаа санхүүжүүлдэг бөгөөд бусад аймаг улсын төсвөөс шилжүүлэг авдаг байна. Орон нутгийн төсөв нь аймаг, сумдын захиргааны урсгал зардал буюу захиргааны албан хаагчдын цалинд дийлэнх хэсэг нь зарцуулагдаж, үлдсэн хэсэг нь ЗДТГ-ын байрны ашиглалтын зардалд (дулаан, цахилгаан, г.м) л хүрэлцэхүйц байна. Аймаг, сумдад хуулиар хариуцсан чиг үүргээ хангалттай биелүүлэх, орон нутгийнхаа хөгжилд зориулах хөрөнгө оруулалт, урсгал зардал маш хомс байна. Орон нутгийн төсөвт хөрөнгийн зардлын эзлэх хувь, хэмжээ бага байгаа нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ажлын байр шинээр бий болгох, улмаар орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг илтгэж байна. Орон нутгийн төсвийн орлогын ихэнхийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хүн амын орлогын татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар зэрэг хэдхэн нэр төрлийн татвараар бүрдүүлж байна. 2019 оноос орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор улсын төсөвт төвлөрч байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөр, түүхий нүүрсний агаарын бохирдлын төлбөрийн орлогоос тухайн орон нутагт нь тодорхой хувийг нь нэмж хуваарилахаар болсон нь орон нутаг өөрөө бие даан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах боломжийг бий болгосон.

Санхүүжилтийн оновчтой хуваарилалт хийсний үр дүнд орон нутгийн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг өөрсдөө бие даан шийдвэрлэх боломж бүрдэх бөгөөд шат дамжлага буурч, төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмж нэмэгдэн хариуцлага сайжирч, улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хэмжээг 2016-2020 онд 32-оос доошгүй хувь, 2020-2024 онд 35 хувьд хүргэх, төрийн

байгууллага, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын чиг үүргийн 20-иос доошгүй хувийг 2016-2020 онд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, төрийн чиг үүргийг аймаг, суманд буюу засаг захиргааны анхан шатны нэгжид шилжүүлснээр 2020-2024 он гэхэд төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, улсын салбарын нийт албан хаагч, ажиллагсдын дунд орон нутгийн төсвөөс цалинждаг албан хаагч, ажиллагсдын эзлэх хувь 60-аас доошгүй хувьд хүргэхээр тогтоосон байна (Хүснэгт 12, Хүснэгт 13-ыг үзнэ үү).

Хүснэгт 12. Улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь хэмжээ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
<b>Орон нутгийн төсвийн орлогын эзлэх хувь</b>	37.2	30.6	27.5	24.5	30.9
<b>Орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хувь</b>	24.5	27.0	29.4	25.1	22.7

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

Хүснэгт 13. Улсын төсөв болон орон нутгийн төсвөөс цалинждаг албан хаагч, ажиллагсад, хувь

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
<b>Улсын нэгдсэн төсөвт цалингийн зарлагын эзлэх хувь</b>	16.7	20	20.3	19.3	19.0
<b>Орон нутгийн төсөвт цалингийн зарлагын эзлэх хувь</b>	32.8	32	30.5	35.2	38.7
<b>Улсын нэгдсэн төсвийн цалингийн зарлагад орон нутгийн төсөв дэх цалингийн зарлагын эзлэх хувь</b>	48.2	43.4	44.2	45.7	46.3

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

2020 оны байдлаар улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хувь 22.7 байгаа нь зорилтот 32 хувь, улсын нэгдсэн төсвийн цалингийн зарлагад орон нутгийн төсөв дэх цалингийн зарлагын эзлэх хувь 46.3 байгаа нь зорилтот 60 хувиас доогуур үзүүлэлттэй байна.

НҮБХХ-ийн “Монгол Улсын төсвийг төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам” судалгаанд дурдсанаар төвлөрлийг үр дүнтэй сааруулахын тулд нутгийн удирдлагыг бэхжүүлэх бодлогыг салбарын бодлогуудтай уялдуулан сайжруулах, орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн татварын болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын татварын эрх хэмжээг өргөтгөх, төв, орон нутгийн удирдах болон захиргааны байгууллагад хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгийг төсөвт тусгаж хуваарилах, төв, орон нутгийн удирдах болон захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, бүх түвшинд чадавхыг бэхжүүлэх, иргэдийн оролцоог хангах шаардлагатай байна.

## 2.1.2.Хот байгуулалтын бодлогыг санхүүгийн механизм, төсөвтэй уялдуулах

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 131, 132 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна” гэсэн зорилгыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн идэвхжилийн үед төсвийн алдагдлыг бууруулах замаар эдийн засгийн хэлбэлзлийг тогтворжуулах, түүнчлэн 2019 онд эдийн засгийн өсөлтийг дэмжих, төсөв, санхүүгийн орчинг эрүүлжүүлэх, сахилга батыг чангатгахад чиглэсэн “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг Засгийн газар баримталж байна. Төсвийн тухай хуульд зааснаар Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сан болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэж, 2020 оны байдлаар улсын нэгдсэн төсвийн орлогын 81.5 хувийг татварын орлого, 9.1 хувийг татварын бус орлого, 8.8 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 0.6 хувийг тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.<sup>7</sup>

### Хүснэгт 14. Улсын нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн орлого, зарлагын эзлэх хувь (2017-2020 оноор)

Хэмжих нэгж: тэрбум.төг

	Үзүүлэлт	Тэнцвэржүүлсэн орлого	Нийт зарлага
2017	Нэгдсэн төсөв	7,274.9	9,017.3
	Орон нутгийн төсөв	2,437.2	2,437.0
	Хувь	33.5	27.0
2018	Нэгдсэн төсөв	9,225.9	9,222.9
	Орон нутгийн төсөв	2,769.4	2,716.4
	Хувь	30.0	29.4
2019	Нэгдсэн төсөв	10,905.5	11,661.7
	Орон нутгийн төсөв	2,947.6	2,904.7
	Хувь	27.0	24.9
2020	Нэгдсэн төсөв	9,421.6	13,960.8
	Орон нутгийн төсөв	3,146.8	3,157.2
	Хувь	33.4	22.6

Эх сурвалж: <https://www.1212.mn>

Улсын нэгдсэн төсөвт сүүлийн 4 жилд орон нутгийн төсвийн орлого 27-33 хувийг, зарлага 22-29 хувийг эзэлж байгаа нь улсын төсвийн нийт зарлагад орон нутгийн төсвийн зарлагын эзлэх хувь 2020 онд 22.6 хувь болж буурсан байна (Хүснэгт14-ийг үзнэ үү).

Орон нутгийн түвшинд дахин хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг холбогдох төсөвт тусгасны үндсэн дээр хуваарилах, орон нутгийн төсвийн орлогын төрлийг нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх, орон нутагт хуваарилсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө болон орон нутгийн өөрийн орлого хоорондын зөрүүг төсвийн тэнцвэржүүлэлтийн аргаар шийдвэрлэх, санхүүгийн

<sup>7</sup> Төрийн санхүү-2020 он, ҮСХ



дэмжлэг болон төсөв хоорондын орлогын хуваарилалтын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг олон арга замаар төвлөрлийг сааруулах төрийн бодлогыг хэрэгжүүлж байна.

2016 оноос мөрдөж эхэлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль (2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан)-ийн хүрээнд хот байгуулалт, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт болон шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэр зохицуулагдаж байна. Тус хуулиар салбарын бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөр зэргийг хөгжлийн бодлого төлөвлөлтийг цаг хугацаагаар нь богино, дунд ба урт хугацааны, газар зүйгээр нь улсын, бүсийн, аймаг болон нийслэлийн гэж ангилсан. Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотын хувьд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр (2016-2020) нь үндсэн төлөвлөлтийн баримт бичиг бөгөөд хотын засаг захиргааны хөгжлийн зорилго, бодлогыг тодорхойлж, тухайн онд Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн суурь болох ба харин эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд тухайн жилд дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тусган хэрэгжүүлсэн.

Хүн амын боловсрол, нөөц, нягтаршил зэргээс шалтгаалж аймгуудыг төрөлжүүлэн хөгжүүлэх хэлбэрийг тодорхой болгох, орон зайн хөгжилд тулгуурлан шинэчлэх, цаашид аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогыг уялдуулан дахин тодорхойлохын тулд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэх, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг, үйлдвэрлэл хөгжүүлэх байршлын улсын хөтөлбөр зэрэг суурь бодлогын баримт бичгүүдийг боловсруулах шаардлага тулгарсан. Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох” бодлогын зорилтыг дэвшүүлж, 2016-2020 онд “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлыг БХБЯ болон ҮХГ (хуучин нэрээр, одоогийн ЭЗХЯ) зохион байгуулж байна.

Хот байгуулалтын тухай хуульд хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр эх үүсвэрийг тодорхой заасан. Тус хуулийн хүрээнд 2016-2020 онд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна” гэсэн зорилтын дагуу “Хот төлөвлөлт, зураг төслийн институт”-ийг байгуулан боловсруулж байна. Түүнчлэн, 2017-2020 онд Завхан, Хэнтий, Архангай, Өвөрхангай Орхон, Дархан-Уул, Сүхбаатар зэрэг аймгийн төв хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх, мөн хилийн боомтуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 2,412.4 мянган төгрөгийн, 2020 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулахад 72,400.0 мянган төгрөгийн, 2020-2021 онд 6 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад 247,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус улсын хөрөнгө оруулалтаас олгосон байна.

### **2.1.3.Засгийн газар хот байгуулалтын бодлогоо хэрэгжүүлэх боломжийг өргөтгөсөн хууль эрх зүйн болон бодлогын хүрээг хөгжүүлэх**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 41, 89, 90 дэх хэсэгт заасан “Засгийн газар нь хот байгуулалтын бодлогоо хэрэгжүүлэх боломжийг өргөтгөсөн хууль эрх зүйн болон бодлогын цар хүрээг хөгжүүлэх” гэсэн зорилгын зорилгын хүрээнд “Монгол Улсын

тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-д "Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно" гэсэн зорилт дэвшүүлсэн. "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Улаанбаатар хотыг хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ", "Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ", "Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, газрыг эдийн засгийн эргэлтэд бодитой оруулах нөхцөлийг бүрдүүлнэ", "Иргэн, хуулийн этгээдийн оюуны болон хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийн баталгааг сайжруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгоно", "Хууль, эрх зүйн актуудын давхардал, зөрчилтэй заалтуудыг илрүүлэх, арилгах, шинэ хуулийн төсөл боловсруулахад эрх зүйн цахим мэдээллийн нэгдсэн санг ашиглах замаар хууль, эрх зүйн баримт бичгийн агуулга, уялдаа холбоог дээшлүүлнэ", "Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ", "Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ" гэсэн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

УИХ-аас 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 25.1.7-д "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна..." гэж туссан.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд баталсан нь нийслэл Улаанбаатар хот болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хувьд эрх зүйн суурь зохицуулалт шинэчлэгдэх үндэслэл болсон. Тус хуулийн зорилт нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтвортой, залгамж чанарыг хангах, үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмыг тодорхойлох, хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээлэх, нэгдсэн, оновчтой тогтолцоог бүрдүүлэх, бодлого, төлөвлөлтийн харилцаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын түншлэлийг зохистой хангах, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төрөл, хэлбэрийг журамлахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд чиглэсэн. Уг хуулиар орон нутгийн болон үндэсний түвшинд мөрдөх хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл, ангилал, хугацааг хуульчилан зааж, тэдгээрийн уялдааг сайжруулснаар улс, орон нутгийн төсвийн, гадаадын зээлийн тусламжийн, хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр илүү оновчтой болж, үрэлгэн зардал хэмнэгдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг сайжрах ач холбогдолтой болсон.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлэн 2020 онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд тус хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүд тус бүрийн эрх зүйн байдлыг тодорхойлж, эрх зүйн байдалд нь тохирсон чиг үүрэг болон түүнийг хэрэгжүүлэх санхүү, эдийн засгийн үндсийг тогтоож өгсөн. Ингэснээр нийслэл хот болон бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад баримтлах зарчим, түүнд тусгах үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн асуудлын цар хүрээ илэрхийлэгдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020 онд УИХ-д өргөн барьж, УИХ-ын намрын чуулганы хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Тогтвортой хөгжлийн зорилт-2030” болон тус хөтөлбөрийн үндсэн зарчмуудыг, мөн дараах зарчмын шинжтэй зохицуулалтуудыг шинээр тусгасан. Үүнд:

- Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, хот байгуулалтын бүсчлэл, түүнд тавигдах шаардлагыг одоо байгаа зохицуулалтаас илүү нарийвчлаж, хот, суурин газрууд өөрсдийн онцлогт нийцүүлэн “Хот байгуулалтын бүсчлэлийн дүрэм”-ийг боловсруулан хэрэгжүүлэхээр зохицуулсан;
- Хот, суурин газрыг шинээр байгуулах, татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг шинээр тусгасан;
- Хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд, төрийн бусад байгууллагуудын чиг үүргийг нарийвчлан зохицуулсан. Мөн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хот, тосгоны Захирагчийн чиг үүрэг, аймаг, сумын Засаг дарга, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бусад байгууллагуудын чиг үүргийг шинээр тусгахаас гадна, хот, суурины хүрээлэн буй орчин, архитектурын түүх, соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг хадгалж хамгаалах, тэдгээрийн зохистой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төлөвлөлтийн зохицуулалтыг тусгасан;
- Хот байгуулалтын салбарын үйл ажиллагааг, ялангуяа хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжил, хот, төлөвлөлт, архитектур, хот байгуулалтын мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийх болон хот байгуулалтын баримт бичиг, төсөл, хөтөлбөр боловсруулах, мэдээлэл, зөвлөмж өгөх чиг үүрэг судалгаа тооцоо, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж байх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Бүс нутаг, хот төлөвлөлтийн хүрээлэн, түүний чиг үүргийг тусгасан;
- Хот байгуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан журмаар тогтоохоор зохицуулсан;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх, дэд бүтцийн хэрэгцээг хангах асуудал, мөн архитектурын түүх, соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг соёлын өвд бүртгэх, хамгаалах, сэргээн засварлахтай холбоотой асуудлыг тусгасан;
- Аймаг, нийслэлд хот байгуулалтын асуудал хариуцсан алба, сум, дүүрэгт асуудал эрхэлсэн мэргэжилтэнтэй байх, түүнчлэн шинээр хотын Захирагчийн болон ерөнхий архитекторын чиг үүрэг, хот байгуулалтын үйл ажиллагаанд оролцогч төрийн бусад байгууллагууд болон хот байгуулалтын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудын чиг үүргийг тусгасан.

Мөн хуулийн төсөлд хот байгуулалтын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоо, хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн чиг үүргийн талаар холбогдох зүйл, заалтууд тусгагдсан. Хот байгуулалтын үйл ажиллагаанд тавигдах улсын хяналт, онц байдал буюу байгалийн давагдашгүй хүчин зүйл, осол, гамшгийн үеийн зохицуулалт, хот байгуулалтын төсөв, санхүүжилт, хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, түүнд тавигдах хяналт, үнэлгээний асуудлыг шинээр нарийвчлан зохицуулсан байна.

УИХ-аас 2015 онд баталсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор “Хот, суурин газрыг

дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”, 2018 оны 341 дүгээр тогтоолоор “Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах зорилгоор өмчлөгч, эзэмшигч газраар хувь нийлүүлэх журам”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016-2020 оны тушаалаар гурван талт гэрээний үлгэрчилсэн загвар, холбогдох бусад дүрэм, журмыг батлан, мөрдүүлж байна. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, түүнийг дагалдах дүрэм, журмыг баталж мөрдсөнөөр хот, суурин газрыг хөгжүүлэхдээ оршин суугч, иргэдийн оролцоог хангаж, хамтран ажиллах, хяналтын тогтолцоо сайжрах, нөгөө талаас газар, үл хөдлөх эд хөрөнгө эзэмшигч, өмчлөгчдийн эрхийг хамгаалах, барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газар, гэр хороолол, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг нэгдсэн бодлого, төлөвлөлтөнд хамруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой болсон юм.

Нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх суурь хуулиудын нэг болох Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2016 онд баталсан. Тус хуульд барилга байгууламжийг ногоон хөгжлийн бодлого, ногоон барилгын шаардлагад нийцүүлэн төлөвлөх, барьж байгуулах харилцааг шинээр зохицуулсан. Барилгын тухай хууль, түүнийг дагалдах 34 дүрэм, журмыг 2016-2018 онд шинэчлэн баталсан нь барилга байгууламжийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрэн томъёолж, харилцаанд оролцогчдын хариуцлагын тогтолцоог үе шат бүрт авч үзэн, “ХҮН” төвтэй салбарын тогтолцоог төлөвшүүлэх нөхцөл бүрдэж байна.

Газрын харилцааны эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон холбогдох бусад хуулиудтай уялдуулах зорилгоор Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, шинээр Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх хуулийн төсөл, Үндэсний орон зайн дэд бүтцийн тухай хуулийн төслийг тус тус боловсруулж, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.

Хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, хэрэглээний өөрчлөлт болон уур амьсгалын өөрчлөлт нь хот, суурин газруудын эрчим хүч, ус, газрын нөөцийн аюулгүй байдлыг улам бүр эрсдэлд оруулж байгаа учраас байгалийн хязгаарлагдмал нөөц болох ус, эрчим хүч, газрын ашиглалтыг нийгэм, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай Орон сууцны тухай, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулиудын шинэчилсэн найруулга, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль зэрэг бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар зорьж байна.

#### **2.1.4.Бүсийн болон орон нутгийн захиргааны тухайлсан орон нутгийн болон нийслэл хотын түвшний засаглалыг хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх**

Дараагийн шатны тайланд тусгах болно.

#### **2.1.5.Хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд нас болон жендерийн асуудлыг тооцсон, оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлэх**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 41 дэх хэсэгт “Хот, суурины удирдлагын, улс төрийн, хууль эрх зүйн болон санхүүгийн механизмыг өргөжүүлэхэд чиглэсэн, Үндэсний бодлогод нийцсэн, бүх нийтийн оролцоог хангахад чухал ач холбогдол бүхий шийдвэр гаргах, төлөвлөх, дагаж мөрдөх, төрийн үйлчилгээ үзүүлэх, хамтарсан үйлдвэрлэлийг

өргөжүүлэхийг дэмжин ажиллана” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Монгол Улсад бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор Нийтийн сонсголын тухай хууль (2015 он), Хууль тогтоомжийн тухай хууль (2015 он), Захиргааны ерөнхий хууль (2015 он), Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль (2017 он), Шилэн дансны тухай хууль (2014 он), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2020 он), Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга (2008 он), Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль (2015 он) зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Нийтийн сонсголын тухай хуульд төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, иргэний хяналтын тогтолцоог бий болгох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, томилгооны, захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн, орон нутгийн сонсголыг хийж, төрийг удирдахад иргэдийн оролцоог хангахаар тусгасан. (<http://forum.parliament.mn/>)

УИХ-аас 2008 онд баталсан Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 17, 18 дугаар зүйлд хот байгуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах талаарх ерөнхий зохицуулалтыг тусган, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны тушаалаар баталсан “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ыг мөрдөж байна. 2015 онд батлан мөрдөгдөж буй Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоог хангах зарчмыг баримтлахаар зохицуулж, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангаж байна.

БХБЯ-наас салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2020 онд УИХ-д өргөн барьж, УИХ-ын хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. Тус хуулийн төсөлд хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд дахь олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг илүү нарийвчлан зохицуулсан. Тухайлбал, “хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах; хот төлөвлөлтийн үйл ажиллагаа нь судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, ил тод, нээлттэй төрийн болон олон нийтийн хяналт хэрэгжих боломжтой байх зарчмыг баримтлах”, гэх мэт. Мөн хуулийн төсөлд хот төлөвлөлт, хот байгуулалтын талаар олон нийтэд боловсрол олгох, сурталчлан таниулах, мэдээлэх ажлыг зохион байгуулах, хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт, түүнд тавигдах хяналт, үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах талаар тусгасан байна.

УИХ-д өргөн барьж байгаа хуулийн төслийн 80 орчим хувийг Засгийн газрын санаачлагаар боловсруулдаг. Хууль батлан гарсантай холбогдуулан нийгэмд дагаж мөрдөх эрх зүйн акт, хөтөлбөрийг Засгийн газрын харьяа байгууллагууд боловсруулж, нийтээр даган мөрдөх дүрэм, журамд нийгмийн харилцааг илүү нарийн зохицуулахаар тусгадаг. Бодлогын баримт бичгийн төсөлд олон нийтийн санал авч тусгах ажлыг веб сайтаар дамжуулан хэлэлцүүлэг өрнүүлэх, харьяа байгууллага, ТББ, олон нийтийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг хийх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг олон хэлбэрээр зохион байгуулж байна. Тухайлбал, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй зураг төслийн аж ахуйн нэгж, байгууллагууд, 21 аймгийн ГХБХБГ, МАЭ-ийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг хийж, эдгээр байгууллагуудын веб сайтад олон нийтийн саналыг авч тусгах зорилгоор тодорхой хугацаагаар хуулийн төслийг байршуулсан. (<https://mcud.gov.mn/a/432>)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017-2021)-ийг батлан хэрэгжүүлж байна. Үүнтэй холбогдуулан барилга, хот байгуулалтын салбарын хүний нөөц, бүтээгдэхүүн, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналт үнэлгээгээр дэмжих зорилгоор тус салбарт “Жендэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг 2017 онд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Тус бодлогод салбарын жендэрийн бодлогын зорилгыг хангахын тулд хот, суурин, барилга байгууламжийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, бүтээн байгуулах үндэсний чадавхийг сайжруулах зорилтыг тусгасан. Эдгээр зорилтын хүрээнд хот, суурин газрын оршин суугчдын эрүүл, аюулгүй амьдралын орчны жендэрийн мэдрэмжтэй багц үзүүлэлт болон амьдралын чанарын суурь стандарт гарган, салбарын оролцогч талуудын үйл ажиллагаанд мөрдлөг болгож, түгээн сурталчлах, сайжруулах, мөн хот, суурин, барилга байгууламжийн төлөвлөлт, бүтээн байгуулалтад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн, нийгмийн бүлгүүдийн оролцох чадвар, боломжийг сайжруулах арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.

Хот байгуулалтын үйл ажиллагаанд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар баталсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар”, “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” зэрэг хот байгуулалт, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдөж байна. Олон нийт, иргэний барилга байгууламжийн 1000 хүнд шаардлагатай нормативт хэрэгцээ болон эдэлбэр газрын хэмжээг “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-д заасны дагуу төлөвлөж, мөн тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, нас, хүйсийн бүтцийн суваргын байдлаас шалтгаалан хүн амын насны онцлогт тохирсон төлөвлөлтийг хийдэг. Цаашид хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд нас, жендерийн болон холбогдох бусад асуудлыг тооцсон, оролцоонд тулгуурласан аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсронгуй болгох, энэ чиглэлээр бусад орны туршлагыг судалж, нэвтрүүлэх, мөн одоогийн мөрдөгдөж буй норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгохоор зорин ажиллаж байна

“Сонголт дизайн” ХХК-ийн санаачлагаар Дундговь аймгийн Гурвансайхан сумын Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран 2014 оноос эхлэн олон улсын төсөл, хөтөлбөр болон аймаг, сумын “Орон нутгийг хөгжүүлэх сан”-гаас нийт 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг босгон Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг олон нийтийн оролцоотой зохион байгуулж, бүтээн байгуулалтыг өрнүүлсэн. Ингэснээр тухайн сумын иргэдийн хандлагыг өөрчлөн, иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор амьдрах орчноо сайжруулж, орон нутгаа хөгжүүлж болдгийг харуулсан үндэсний хэмжээнд сайн туршлага, жишээ болсон. Тус сумын төвийн туршлагыг жишиг болгон бусад аймаг, сумын төвүүдийг иргэдийнхээ оролцоотой хөгжүүлж байна (Дэлгэрэнгүй танилцуулгыг Хавсралт "Сайн туршлага"-ын 153 дугаар хуудаснаас үзнэ үү).

#### **2.1.6. Шийдвэр гаргалтын бүхий л талбар болон түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн оролцоог хангах**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 90 дэх хэсэгт “... орон нутгийн удирдлага болон шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн бүх салбарт тэгш эрхтэй, үр дүнтэй оролцоонд дэмжлэг үзүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэхээр зорьж байна. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.27-д “Жендерийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ”, 5.1.7-

д “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1-д “томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх”, 10.1.2-т “төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх”, 10.1.4-т “төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах” зэрэг квотын түвшин тогтоосон зохицуулалтыг тодорхой тусгасан.

Дэлхийн эдийн засгийн форумас жил бүр тооцон гаргадаг “Жендэрийн тэгш байдлын тайлан”-д дурдсанаар Монгол Улс 2019 оны эцсийн байдлаар жендэрийн ялгаатай байдал (gender gap index)-ын индексээр дэлхийн 153 орноос 79 дүгээр байранд эрэмбэлэгдэж (GGI=0.706), дэлхийн дундаж (0.69)-аас дээгүүр байгаа хэдий ч өмнөх оноос 21 байраар хойшилсон байна. Энэхүү үзүүлэлт нь эдийн засгийн оролцоо, боловсрол, эрүүл мэнд, улс төрийн эрх мэдэл, оролцоо гэсэн 4 гол хэмжүүрээр хэмжигддэг бөгөөд эдийн засгийн оролцоогоор 29 дүгээр байранд (0.751), боловсролын түвшнээр 71 дүгээр байранд (0.993), эрүүл мэндийн байдлаар 1 дүгээр байранд (0.980), харин улс төрийн эрх мэдэл, оролцооны байдлаар 120 дугаар байранд (0.102) тус тус эрэмбэлэгдэж байна. Монгол Улсад эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн боловсролын түвшин илүү өндөр байгаа боловч улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бага хэвээр байна. Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 1,250.6 мянган хүн хөдөлмөр эрхэлж байгаагийн 205 мянган хүн (38.3 хувь нь эрэгтэй, 61.7 хувь нь эмэгтэй) буюу 16.4 хувь нь төрийн албан хаагч байна.

Сонгууль зохион байгуулагдсан онуудаар УИХ-д нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдсэний дагуу сонгогдсон эмэгтэйчүүдийн нийт гишүүдэд эзлэх хувь мөн адил нэмэгдсэн байна. Тухайлбал, УИХ-ын гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 5.3 хувь (4 эмэгтэй) байсан бол 2020 онд 17.1 хувь (13 эмэгтэй) болсон нь дэлхийн дундаж болох 24.9 хувиас доогуур үзүүлэлттэй байна. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо аажмаар өссөн хэдий ч УИХ-ын даргаар ажилласан эмэгтэй гишүүд байхгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 8 удаагийн сонгуульд 23 хүн нэр дэвшсэнээс 1 нь эмэгтэй (2013 оны сонгууль) байсан байна.

Засгийн газарт томилогдох төрийн улс төрийн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын Засгийн газрын гишүүн буюу сайд нар, Шадар сайд, ЗГХЭГ-ын дарга болон дэд сайд нарыг хамруулан авч үзэхэд, УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүтэц дэх төрийн улс төрийн албан тушаалтны хүйсийн харьцаа 16.1 : 83.9 хувьтай байгаа нь хуульд заасан квотыг хангажээ. Засгийн газрын гишүүн, сайдын түвшинд авч үзвэл хүйсийн харьцаа 17.6 : 82.4 хувьтай байгаа нь квотыг мөн хангасан байна. Харин дэд сайд нарын хүйсийн харьцаа 14.3 : 85.7 хувьтай байгаа нь хуульд заасан квотод хүрэхгүй байна.

**Хүснэгт 15. Засгийн газрын бүтэц дэх төрийн улс төрийн албан тушаалтнуудын тоо, хүйсийн харьцаа, (2016-2020 оноор, Эмэгтэй : Эрэгтэй)**

Төрийн улс төрийн албан тушаалтан		Сайд	Дэд сайд
2016-2017	Бүгд	16	13
	Тоогоор	2:14	3:10
	Хувиар	12.5 : 87.5	23.9 : 76.1
2017-2020	Бүгд	16	13
	Тоогоор	2:14	5: 8
	Хувиар	12.5 : 87.5	38.5 : 61:5
2020	Бүгд	17	14
	Тоогоор	3:14	2:12
	Хувиар	17.6 : 82.4	14.3 : 85.7

Эх сурвалж: Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2021

2016 оны байдлаар аймаг, нийслэл дэх төрийн улс төрийн албан тушаалтны хүйсийн харьцаа нийт тоонд 7.6 : 92.4 хувьтай байсан бол 2019 оны байдлаар 8.4 : 91.6 хувьтай болж эмэгтэйчүүдийн эзлэх хувь өссөн байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1-д заасан аймаг, нийслэлд томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны доторх аль нэг хүйсийн төлөөлөл 15 хувиас доошгүй байна гэсэн квот хангагдаагүй хэвээр байна. Харин аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч нарын хүйсийн харьцаа 17.9 : 82.1 хувьтай байсан нь энэ албан тушаалын түвшинд квот хангагдсан байна.

**Хүснэгт 16. Аймаг, нийслэл дэх төрийн улс төрийн албан тушаалтнуудын тоо, хүйсийн харьцаа, (2016-2019 оноор, Эмэгтэй : Эрэгтэй)**

Төрийн улс төрийн албан тушаалтан		Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	Засаг дарга	Засаг даргын орлогч
2016-2017	Бүгд	22	22	35
	Тоогоор	0:22	0:22	6:29
	Хувиар	0:100	0:100	17.1 : 82:9
2017-2020	Бүгд	22	22	37
	Тоогоор	0:22	0:22	5:32
	Хувиар	0:100	0:100	13.5 : 86.5
2020	Бүгд	22	22	39
	Тоогоор	0:22	0:22	7:32
	Хувиар	0:100	0:100	17.9 : 82.1

Эх сурвалж: Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2021

Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудад эмэгтэйчүүдийн эзлэх яамдын Төрийн нарийн бичгийн түвшинд 7.7 хувь, агентлагийн даргын түвшинд 3.3 хувь, аймаг, нийслэлийн ИТХ-ын даргын түвшинд болон Засаг даргын түвшинд байхгүй байна.



**Хүснэгт 17. Төрийн захиргааны удирдах албан тушаалтан, аймаг нийслэл дэх төрийн улс төрийн албан тушаалтны доторх хүйсийн харьцаа 2016-2019 оноор, (Эмэгтэй : Эрэгтэй)**

Албан тушаал	2016		2017		2018		2019	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Яамдын ТНБД	1:12	7.7:92.3	1:12	7.7:92.3	1:12	7.7:92.3	1:12	7.7:92.3
Агентлагийн дарга	0:27	0:100	0:27	0:100	1:29	3.3:96.7	1:29	3.3:96.7
Аймаг, нийслэлийн ИТХ-ын дарга	0:22	0:100	0:22	0:100	0:22	0:100	0:22	0:100
Аймаг, нийслэлийн Засаг дарга	0:22	0:100	0:22	0:100	0:22	0:100	0:22	0:100
Аймаг, нийслэлийн Засаг даргын орлогч	6:29	17.1:82.9	5:32	13.5:86.5	5:32	13.5:86.5	7:32	17.9:82.1

Эх сурвалж: Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2021

Нийслэл, дүүрэг, аймаг, сумын ИТХ-ын даргад эмэгтэйчүүдийн эзлэх хувь дүүрэгт 33.3 хувь, суманд 14.2 хувь байгаа бол нийслэл, аймгийн түвшинд байхгүй байна. ИТХ-ын төлөөлөгч эмэгтэйчүүдийн эзлэх хувь 27.1 байна.

Төрийн албан хаагчдыг байгууллагын төрлөөр авч үзвэл, эрүүл мэндийн байгууллагад ажиллагчдын 81.3 хувь нь эмэгтэй, боловсролын байгууллагад ажиллагчдын 76.7 хувь, яам, яамны харьяа байгууллагад ажиллагчдын 51.2 хувь, шүүх, прокурор, шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллагчдын 54.3 хувь, соёл, урлагийн байгууллагад ажиллагчдын 53.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

БХБЯ-ны албан хаагчдын 43.6 хувь ба тус яамны газар, хэлтсийн дарга нарын 28.5 хувь нь эмэгтэй албан хаагчид байгаа нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.2-т заасан шаардлагыг хангахгүй байна. ГЗБГЗЗГ-ын 47 хувь, “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 43.1 хувь нь эмэгтэй албан хаагчид байна. Төрийн албаны зөвлөлийн БХБЯ-ны дэргэдэх салбар зөвлөлд эмэгтэй 4, эрэгтэй 5, БХБЯ-ны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлд эмэгтэй 3, эрэгтэй 2, БХБЯ-ны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлд эмэгтэй 7, эрэгтэй 6, Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлд эмэгтэй 9, эрэгтэй 15 зэрэг шийдвэр гаргалтын талбарт эмэгтэй, эрэгтэй албан хаагчдын оролцоог тэгш ханган ажиллаж байна. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 208 дугаар тушаалаар “Барилга, хот байгуулалтын салбарт Жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025)”-ын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Уг бодлогын баримт бичгийн агуулга нь хүн төвт, нийгмийн хариуцлагат удирдлага, жендэрийн тэгш байдлыг бүх түвшинд хангах, жендэрийн мэдрэмжтэй салбарын хүний нөөц, бодлого, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн. Үүнтэй уялдуулан барилга, хот байгуулалт, орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлого, бүтээгдэхүүн, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй, эмэгтэйчүүд, охидын эрүүл ахуй болон бусад нийтлэг хэрэгцээг хангахад чиглүүлэн хэрэгжүүлж байна. БХБЯ, ГЗБГЗЗГ, БХТ, 21 аймаг, нийслэлийн ГХБХБГ-ууд

байгууллагынхаа дотоод журамд ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх талаар холбогдох заалтуудыг тусган мөрдөж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтот ажлын хүрээнд Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, Монголын либерал эмэгтэйчүүдийн оюуны сан хамтран “Эмэгтэйчүүдийн манлайлал” хөтөлбөрийг 2021 оноос үе шаттайгаар хэрэгжүүлэн нийт 200 гаруй төрийн эмэгтэй албан хаагчдыг уг хөтөлбөрт хамруулаад байна.

## **2.2.ХОТЫН ОРОН ЗАЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ**

### **2.2.1.Газар нутгийг нэгдсэн бөгөөд тэнцвэртэй хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 49 дэх хэсэгт “Үндэсний болон бүс нутаг, хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоотой уялдуулсан менежмент, байгалийн нөөц, газар ашиглалт, нутаг дэвсгэрийн тогтвортой системийг дэмжинэ. Энэ нь бүс нутгийн буюу хот-хөдөөгийн хэрэгцээг холбосон найдвартай үйлдвэрлэл, Хотжилтын шинэ хөтөлбөрийн үйлчилгээний сүлжээг бий болгон, бүсийн хөгжлийг сайжруулж, нийгэм, эдийн засаг, орон зайн бүтэц, нутаг дэвсгэрийн ялгаатай байдлыг арилгах боломжийг олгоно” гэсэн зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно, 2016-2020 онд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх, аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх”, “Ногоон хөгжлийн бодлого”-ын баримт бичигт “Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг бүс нутаг, бүлэг суурингийн тогтолцоог оновчтой тогтоох чиглэлээр үе шаттайгаар боловсруулна” гэсэн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

2001 онд УИХ-аас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, түүний дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн. Улмаар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий хотжилтыг дэмжих зорилгоор эдийн засгийн 4 бүс тус бүрд 2 тулгуур төв хотыг сонгон, тэдгээрийг түлхүү хөгжүүлэхээр тогтсон. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2015 оноор дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэчилсэн бүсчлэлийг тогтоохоор ажиллаж байна. “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын эрхэм зорилго нь Монгол Улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

2008 онд УИХ-аас шинэчлэн баталсан Хот байгуулалтын тухай хуульд хот байгуулалтын тулгуур баримт бичиг болох “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын

хөгжлийн ерөнхий төсөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг хангасан байна” гэж заасан. Засгийн газрын 2017 оны 05 дугаар тогтоолоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулан батлуулах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хороог Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулж, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулах ажлыг 2018 оноос зохион байгуулсан. “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ тус төслийг боловсруулах ажлын хүрээнд одоогийн байдлын судалгаа, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг хийж, төлөвлөлтийн шийдлийн хувилбаруудыг боловсруулан, 2020 оны байдлаар ажлын гүйцэтгэл 70 орчим хувьтай, 2022 оны 12 сард Засгийн газар, УИХ-д өргөн барихаар ажиллаж байна.

БХБЯ, ҮХГ, ЖАЙКА хамтран 2019-2021 онд “Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах төсөл”-ийг хэрэгжүүлж, тус төслийн хүрээнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлого” боловсруулахад шаардлагатай судалгааг хийсэн. Дээрх бодлогын баримт бичгүүдийг харилцан уялдаатай боловсруулах зорилгоор салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий “Төслийн хамтарсан зохицуулах хороо”-г Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 32 дугаар захирамжаар байгуулан ажилласан.

Нутаг дэвсгэрийн тодорхой орон зайд хүн амын өсөлт нэмэгдэж, нягтрал ихсэж, авто болон төмөр замын дагуух байршилтай жижиг хот, суурин газруудын хүн ам өсөх хандлагатай байна. Сүүлийн 10 жилийн хүн амын өсөлтийг авч үзвэл 260 сумдын хүн ам өссөн, 70 сумдын хүн ам буурсан байна. Хүн ам буурсан сум, сууринд ихэвчлэн баруун болон говийн бүсийн аймгуудын сум, суурин багтаж байна. Хүн ам ихтэй сум болон хотуудад хүн амын өсөлт их, харин жижиг сум, суурингуудад хүн амын тоо хамгийн ихээр буурсан. Аймгийн төв, бусад томоохон хот, суурин газарт ойр орших сумдын хүн ам илүү их буурсан нь гадагш таталцал бүхий орон зайн хамаарлыг харуулж байна.

Нийслэл “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор батлан хэрэгжүүлж байна. Тус баримт бичгийн дагуу Улаанбаатар хотын газар нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх, хотын нягтралыг задлах, дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, шинэ суурьшлын бүсийг бий болгох зорилгоор дэд төв, олон нийтийн төв, шинэ суурьшлын бүс, дагуул хаяа хот, тосгодыг хөгжүүлж, хотын төвлөрлийг сааруулахыг зорьж байна. Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/197 дугаар захирамжаар суурьшлын бүсийн хязгаарыг тогтоож, Улаанбаатар хотын суурьшлын бүсийн дотор талд барилгажилтыг дэмжин, суурьшлын бүсийн гадна хот байгуулалтын үйл ажиллагааг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлж байна. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага” баримт бичгийн дагуу 15 дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийн тэргүүлэх чиглэл, хүн амын тоо, нийгмийн дэд бүтэц, ажлын байрны эрэлтийг нарийвчлан тодорхойлж, 11 дагуул хаяа хот, тосгод (Багануур дүүрэг, Налайх дүүрэг, Багахангай дүүрэг, Аэросити шинэ хот, Туул тосгон, Био-Сонгинотосгон, Аргалант-Эмээлт, Тэрэлж тосгон, Гачуурт тосгон, Хонхор тосгон)-ын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дагуул хаяа хот, тосгодод ажлын байрыг нэмэгдүүлж, бизнес

эрхлэгчдийг дэмжих зорилгоор Багануур дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк, Налайх дүүрэгт барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк байгуулах бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж байна. Түүнчлэн, аймгийн төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зарим аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэн батлан, хэрэгжүүлж байна. “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г нийт 11 зорилтын хүрээнд 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн (Хүснэгт 18-ыг үзнэ үү).

**Хүснэгт 18. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зорилт, арга хэмжээ (2020 оны байдлаар)**

№	Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт, (хувь)
1	Газрын нөөц, нэгдмэл сангийн удирдлага, бодлого, төлөвлөлт, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	4	50.0
2	Хүн амыг баталгаат, эрүүл аюулгүй усаар хангах	7	62.5
3	Хөдөө аж ахуйн салбарыг хэрэгцээт усаар хангах	6	100
4	Үйлдвэр, уул уурхай, эрчим хүчний салбарыг хэрэгцээт усаар хангах	10	70
5	Хүрээлэн буй орчны тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийг хамгаалах	8	91.8
6	Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх	24	39
7	Хот, тосгон, бусад суурин газрыг хөгжүүлэх	170	78.1
8	Ойн сан бүхий газрын төлөвлөлт, хэрэгжилт	7	85
9	Зам, шугам сүлжээний газрын төлөвлөлт, хэрэгжилт	50	79.3
10	Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх	58	35.2
11	Улсын тусгай хэрэгцээний газрын төлөвлөлт, хэрэгжилт	15	81.7
	<b>НИЙТ</b>		<b>59.5</b>

Эх сурвалж: ГЗБГЗЗГ

**2.2.2. Хот байгуулалтын баримт бичигт орон сууцыг нэгтгэн авч үзэх**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 105 дахь хэсэгт “Шаардлага хангасан орон байртай байх эрхээ зохих ёсоор нь хангаж чадахуйц хэмжээнд хүрэх эрхийг бид улам бүр баталгаажуулах болно. Үндэсний болон орон нутгийн хөгжлийн стратеги, газрын бодлого, орон сууцны хангамжийг уялдуулан зохицуулахын тулд орон сууцны бодлогыг бүх түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх, хамтарсан төлөвлөлтийн зарчмыг суурийг бий болгох чиглэлийг баримтлах болно” гэж заасныг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

УИХ-аас 1999 онд “Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг баталсан. Монгол Улсын иргэн "...эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй..." гэсэн Үндсэн хуулийн заалт нь хүний амьдарч, аж төрөх ахуй орчныг бүрдүүлэгч орон сууцанд тавигдаж байгаа үндсэн шаардлага бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогын зорилго оршиж байна. Орон сууцны

асуудал нь улсын хөгжил, нийгмийн амьдралын түвшинг тодорхойлох гол үзүүлэлт, хүн амын эрүүл энх, сайн сайхан амьдрах, үр бүтээлтэй хөдөлмөрлөх язгуур нөхцөлийг бүрдүүлдэг.

Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль, Орон сууцны тухай хууль, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар”, “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” зэрэг холбогдох бусад хууль тогтоомж, норм, нормативын баримт бичигт үндэслэн хот байгуулалтын баримт бичиг болох “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”, Бүсийн хөгжлийн төсөл, хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны төлөвлөлтийг тусган боловсруулж байна.

1999 онд баталсан Орон сууцны тухай хуульд орон сууцны хороолол, бичил хороолол, түүний дэд бүтцийг төлөвлөх, барьж байгуулахыг төрөөс бодлогоор дэмжиж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, гэр хорооллын орон сууцыг тохижсон орон сууцны хороолол болгон хөгжүүлэхээр зохицуулсан. 2008 онд шинэчлэн баталсан Хот байгуулалтын тухай хуульд хот, тосгоны орон сууц, олон нийтийн бүсэд эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх үндсэн шаардлагыг хангаж, байгалийн гэрэлтүүлгийн холбогдох норм ба дүрэм, журамд заасны дагуу төлөвлөгдсөн орон сууц, сургалт, соёл, үзвэр, шинжлэх ухаан, эмнэлэг, амралт, сувилал, спорт, худалдаа, нийтийн хоол, ахуйн үйлчилгээ, тээвэр, холбооны чиглэлийн үйл ажиллагаа явуулах зориулалттай барилга байгууламж төлөвлөж, амьдрах, аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж болохуйц барилга байгууламж төлөвлөхийг хориглоно гэж заасан. Түүнчлэн, “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар”-т орон сууцны хорооллыг хот, суурины төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэмд заасан талбайн хэмжээнд зохион байгуулж, орон сууцны хангамж, төрөл (гэр, нам болон дунд, өндөр давхар сууц), нэг хүнд ногдох сууцны талбай, хүн амын болон барилгажилтын нягтралын нормативыг ханган төлөвлөхөөр заасныг мөрдөж байна.

“Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-д орон сууцны хорооллын нутаг дэвсгэрийн нэг га-д ногдох хүн амын нягтралын тооцоог 450 хүн/га-гаас ихгүй байхаар тусгасныг баримтлан, орон сууц, түүний дэд бүтцийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг нь сайжруулах, хүн амыг эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангасан тохилог орон сууцаар хангах нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөж байна. Сүүлийн жилүүдэд барилгын салбарын бүтээн байгуулалтын ажил улам эрчимтэй хөгжиж, нийслэл хот, бусад хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор орон сууцны хотхон, хорооллыг шинээр барьж байгуулан, нийтийн зориулалттай болон хувийн орон сууцны барилгуудыг олноор барьж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд орон сууцны барилга барих газар хязгаарлагдмал болсон тул орон сууцны талбайн нягтрал ихтэй, олон давхар барилга бүхий хотхон, хорооллуудыг төлөвлөх, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэх, мөн хүн амын төвлөрлийг сааруулах, автозамын түгжрэл, агаар, хөрс, ус, орчны бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд дагуул хот, суурин газруудад шинээр суурьшлын бүс, хотхон, хороолол барьж байгуулах бодлого баримталж байна. Барилгын салбар хурдацтай хөгжихийн хамт орон сууцны барилгын орчны тохижилт, төлөвлөлт, чанар сайжирч, тансаг хотхон, бие даасан худалдаа, үйлчилгээний төвтэй хорооллууд олноор баригдаж, иргэд сонголт хийх боломжтой болж байгаа боловч шинээр баригдаж буй орон сууцны хорооллуудад цэцэрлэг, сургууль, өрхийн эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцийг норм, нормативын баримт бичгийн дагуу төлөвлөж барихгүй байгаа зөрчил гарсаар байна. Иймд орон сууцны хороолол, хотхоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг

төсөлд нийгмийн болон бусад үйлчилгээний барилга байгууламж, ногоон байгууламж, олон нийтийн зам, талбайг тусган хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж, орон сууцны хууль эрх зүй, норм, нормативын баримт бичгийг шинэчлэх, чадавхийг бэхжүүлэх, хяналтын тогтолцоог сайжруулахаар ажиллаж байна.

### **2.2.3.Хот төлөвлөлтөд соёлыг тэргүүлэх бүрдэл хэсэг болгон авч үзэх**

Манай улс “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 38 дахь хэсэгт “Бид хот, суурины нэгдсэн бодлогоор дамжуулан хот, суурин газарт байгалийн өв, биет болон биет бус соёлын өвийг тогтвортой ашиглах хөшүүргийг бий болгохын тулд үндэсний болон орон нутгийн түвшинд соёлын дэд бүтэц болох газар, музей, үндэсний хэл соёлыг хамгаалах, хөгжүүлэх,...”, 45 дахь хэсэгт “... соёлын өв, байгалийн баялгаа хамгаалах,...”, 60 дахь хэсэгт “... урлаг, соёлын өвийг хамгаалах замаар хотын эдийн засгийн бүтээмж, үр ашгийг сайжруулах болно”, 97 дахь хэсэгт “...соёлын өвийг хамгаалсан, ... хот, суурин газрын өргөтгөл, суурьшлын төлөвлөлтийг дэмжинэ” гэж заасныг хэрэгжүүлэхээр зорьж байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Соёл урлагийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгож, соёл урлагийг хөгжүүлэх бодлого, санхүүжилт, удирдлага зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлнэ”, “хот байгуулалт, газрын харилцааны хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн. Монгол Улсын Засгийн газар 2012 онд УИХ-ын 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг хэрэгжүүлж ирсэн бөгөөд 2018 онд Соёлын өвийн үндэсний төвийг (<http://ncch.gov.mn/>) шинэчлэн байгуулж, 2020 онд (хуучнаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бүтцэд байсан) Соёлын яамыг шинээр тус тус байгуулсан. (<https://moc.gov.mn/>, <https://www.facebook.com/Moc.gov.mn>)

2016-2021 онд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгад зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулж, тухайлбал, дараах зохицуулалтыг шинээр нэмж тусгасан байна. Тухайлбал, 37.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга хот, суурин газарт орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын харагдах сүр барааг хадгалах зорилгоор түүний эргэн тойронд шинээр барих барилга байгууламжид өндрийн хязгаар тогтооно. Өндрийн хязгаар тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 45.1.Засгийн газар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах зорилгоор хамгаалалтын бүс тогтооно. Хамгаалалтын бүсийн хилийн заагийг тогтоох шалгуур үзүүлэлтийг хот байгуулалтын болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. 45.5.Түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсэд байгаа үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын байдлыг сайжруулах зорилгоор түүний эх төрх, бүрэн бүтэн байдалд нь хохирол учруулахгүй байх хэлбэрээр шинээр барилга байгууламж барьж, судалгаа, сурталчилгааны зориулалтаар ашиглаж болно.

2008 онд баталсан Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 12.4.1-т “хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө нь ..., түүх, соёлын дурсгалт байгууламж, архитектур-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх шаардлагыг хангасан байна”, 23.1.1-т “түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно” гэж зохицуулсан. Сүүлийн жилүүдэд хот, суурин газруудад эрчимтэй өрнөж байгаа барилгажилт, газар ашиглалтын улмаас эдгээр заалтууд зөрчигдөх явдал ихээр гарч байна.

2010 оноос нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, тодотгол хийх, шинээр боловсруулах ажлын даалгаварт “Түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборын зэрэглэл, байршил”-ын зураг болон “Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах төлөвлөлт” гэсэн хэсгийг дараах нөхцлийг харгалзан боловсруулахаар тусгаж, экспертизээр дамжуулан хянаж байна. Үүнд:

Хотын төлөвлөлтөнд түүх, соёлын дурсгалт газрыг сэргээн засварлах, шинэчлэн сайжруулах, шинээр барьж байгуулах болон инженерийн тоног төхөөрөмжийн хангамжийн асуудлыг тусгана.

Төслөөр хот, түүний орчмын эдэлбэр газар дахь түүх, соёлын дурсгалт газрууд, дархан цаазат болон байгалийн тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрийн бүсчлэлийг барилга байгууламж, уран барилгын цогцолбор, хөшөө дурсгал, нутаг дэвсгэрийн ландшафтын онцлог, түүх, археологи, архитектурын ховор үнэт зүйлсийг хамруулан тогтооно.

2020-2021 онд боловсруулсан “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтын талаарх саналыг, мөн түүнчлэн, БХБЯ-ны захиалгаар боловсруулж буй “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-д улсын хэмжээний “Археологи, түүх, соёлын дурсгал” одоогийн байдлын зураглал, “Хүрээлэн буй орчин, түүх, соёлын дурсгал” хэтийн төлвийн зургийг тус тус боловсруулсан. Үүний зэрэгцээ улс, аймаг орон нутгийн хамгаалалтад байгаа түүх, соёлын дурсгалын байршил, төлөв байдлыг нутаг дэвсгэрийн харьяалал, төрөл, чиглэлээр нь ангилан тодруулж, шинээр хамгаалтад авах, хамгаалалтын бүс тогтоох, сэргээн засварлах, мөн үндэсний өв уламжлалыг сэргээх зориулалтаар ашиглах чиглэлүүдийг тодорхойлж байна.

2020 онд УИХ-д өргөн барьж, УИХ-ын хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хот байгуулалтын үйл ажиллагаанд түүх, соёлын дурсгал, өвийг хамгаалах зарчмыг баримтлах, хот, суурины хүрээлэн буй орчин, архитектурын түүх, соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг хадгалж хамгаалах, тэдгээрийн зохистой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төлөвлөлт болон хот байгуулалтын бүсчлэл, дүрэмтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг нэмж тусгасан. Мөн “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж байна.

“Азийн хотуудын хөгжлийн санаачлага” байгууллагын техник туслалцаагаар 2016-2017 онд хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын гэр хорооллын соёлын өв, аялал жуулчлал, орон нутгийг бэхжүүлэх төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа” төслийн хүрээнд Улаанбаатар хотын гэр хороололд хамгаалан сэргээж болохуйц соёлын өвүүдийг тодорхойлох, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх нөхцөл, боломжийг судалсан. Төслийн үр дүнд 5 багц дэд төслийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнд: Ботаникийн цэцэрлэгээс Дарь-Эхийн сүм хүртэлх коридор, “Гандантэгчинлэн хийд” гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, Гэсэр сүм, Тасганы овоо, Дамбадаржаалин хийдийн цогцолбор ба орон нутгийг хөгжүүлэх, Хамбын овоо, Гүнжийн нүдэн нуур, тоосгоны үйлдвэр, Баянхошуу хийд, түүний орчмын газар тус тус хамрагдсан байна (Зураг 14-ийг үзнэ үү).

БХБЯ, ЖАЙКА-тай хамтран “Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн хүрээнд “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг нь уртасгах” туршилтын төслийг 2020-2021 онд хэрэгжүүлсэн. Тус

төслийн хүрээнд Монгол Улсын түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн газар хөдлөлтөнд тэсвэртэй байдал, аюулгүй байдалтай холбоотой одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, барилгын норм, нормативын баримт бичгийг судлан шинэчлэх, түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн жагсаалтыг боловсруулах, эрэмбэлэх саналыг боловсруулсан. Мөн “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журам”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох заавар”, “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг тодорхойлох үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж батлуулсан. Туршилтын төслийн хүрээнд “Чойжин ламын сүм музейн барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”, “МОНГ-ЭМ” ХХК-ийн эмнэлгийн барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ”-г хийж гүйцэтгэсэн байна.

Зураг 14. Улаанбаатар хотод байрладаг “Гандантэгчинлэн хийд” цогцолбор



Эх сурвалж: НХБХГ, <https://home.uda.ub.gov.mn/>

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасны дагуу цаашид түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүсийг хот байгуулалтын норм, нормативын баримт бичигт тусгасны дагуу шинэчлэн тогтоох, соёлын өвийг хамгаалах чиглэлээр хот төлөвлөгчид, инженерүүд, иргэд, олон нийт, төрийн байгууллага зэрэг бүх талуудыг чадавхжуулах, хүний нөөцийг бэлдэх, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллах, соёлын өвийг хамгаалах, сурталчлах, мэдлэг олгох, олон улсын туршлагыг судалж нэвтрүүлэх, гэх мэт чиглэлээр төсөл, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүх, соёлын дурсгалт газар, барилга байгууламжийг хамгаалах, сэргээн



засварлахад зориулсан төсөв хангалтгүй байдаг тул энэ асуудлыг Засгийн газар, орон нутгийн захиргаа, хувийн хэвшил хамтран шийдвэрлэх нь зүйтэй байна.

#### **2.2.4. Хотын нутаг дэвсгэрийн тэлэлт, суурьшуулалт, шинэчлэл, дахин төлөвлөлтийг сайтар төлөвлөн хэрэгжүүлэх**


“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 52 дахь хэсэгт “Бид орон зайн хөгжлийн стратегийн хүрээнд хотын тэлэлтийг сааруулах зорилгоор хотыг хүртээмжтэй, дэд бүтэц, үйлчилгээ, хүн амын нягтралыг зохистой байдлаар төвлөрүүлэн төлөвлөнө” гэсэн зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ”, 2016-2020 онд “... Улаанбаатар хот болон бусад хот, сууринг дахин төлөвлөх, ...”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

**Хүн амын шилжилт хөдөлгөөн:** 1990-2020 онд Монгол Улсын хүн ам 2.0 саяас 3.3 сая болж, 55 хувиар, тэр дундаа хотын хүн ам 1.0 саяас 2.5 сая болж 2.5 дахин, нийслэлийн хүн ам 0.5 саяас 1.4 сая болж, 2.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үндсэндээ дээрх хугацаанд өссөн хүн ам нь нийслэлийн хүн ам болж байна. Хүн ам ихээр шилжин ирж байгаагаас нийслэл Улаанбаатар хотын дэд бүтэц, нийгэм, төрийн үйлчилгээний ачаалал, даац нэмэгдэж, хотын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх болсон. Сүүлийн 20 жилд шилжин ирэгсдийн тоог аймгуудын хүн амтай харьцуулбал, дунджаар нийт 8 аймгийн хүн амтай дүйцэхүйц буюу 462 мянган хүн орон нутгаас нийслэл Улаанбаатар хотод шилжин ирсэн байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөний балансыг 2010-2020 оны дунджаар авч үзвэл, Улаанбаатар хот, Говьсүмбэр аймагт шилжин ирэгсэд давамгайлсан, харин бусад аймгуудад шилжин явах хөдөлгөөн эрс давамгайлж байна (График 11-ыг үзнэ үү).


Нийслэл Улаанбаатар хотын цэвэр шилжилтийн коэффициент эерэг байгаа бөгөөд шилжин ирэгсэд шилжин явагсадаасаа өндөр үзүүлэлттэй бөгөөд 6.8 промиллээр буурсан байна. Харин бусад бүсийн хувьд сөрөг гарсан нь шилжин явагсад ирэгсэдээсээ өндөр байгаа бөгөөд Зүүн бүсэд 22.1, Баруун бүсэд 21.2, Хангайн бүсэд 12.5 промиллээр тус тус буурчээ. Төвийн бүсийн шилжих хөдөлгөөний цэвэр коэффициентийг 12.3-аас сөрөг урсгалтай болж, 15.2 болсон байна (График 12-ыг үзнэ үү).

График 11. Хүн амын цэвэр шилжилт хөдөлгөөн, (1000 хүнд ногдохоор, 2010-2020 оны дунджаар)



Эх сурвалж: <https://www.1212.mn>

График 12. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент




Эх сурвалж: <https://www.1212.mn>

**Нийслэлийн хүн амын хэт төвлөрлийг сааруулах:** Нийслэл Улаанбаатар хот нь засаг захиргаа, санхүү, бизнес, зах зээл, эдийн засаг, худалдаа, үйлчилгээ, аж үйлдвэр, соёл, урлаг, шашин, спорт, боловсрол, эрүүл мэнд, батлан хамгаалах, зам, тээвэр зэрэг бүхий л үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрсөн улсын төв байгаа нь хүн амын төвлөрлийг татах гол нөхцөл болж байна. Иймд хүн амын шилжилт хөдөлгөөнийг татагч гол хүчин зүйлс болох дээд боловсрол, засаг захиргааны зарим чиг үүргийг дагуул болон хоёрдогч хотуудад шилжүүлэн байршуулах шаардлагатай юм.

2010 онд УИХ-аас баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах чиглэлээр орон нутгаас

Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг сааруулах, хотын төвлөрөл, эмх замбараагүй тэлэлтийг бууруулах зорилгоор Улаанбаатар хот, бүсийн тулгуур төв, аймаг, сумдыг цогцоор хөгжүүлэх; Улаанбаатар хотод суурьшихаар ирж байгаа иргэдийн суурьшлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх; бүсийн тулгуур төвүүдэд оюутны хотхон шинээр байгуулан Улаанбаатар хотод төвлөрсөн их, дээд сургуулиудын тоог цөөрүүлэх замаар нийслэл рүү шилжин суралцах оюутнуудын тоог бууруулах; төвөөс алслагдсан, хөгжлөөр сул бүс нутаг, аймгуудын иргэдэд бүс нутгийн нэмэгдэл олгох, банк, санхүү, татвар, зээлийн бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсний дагуу Засгийн газраас холбогдох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байна.

График 13. 2003-2021 онд барилгажсан талбайн өсөлт, хувиар



Эх сурвалж: ГЗБГЗЗГ, 2022, Газрын нэгдмэл сангийн тайлан

**Нэг төвтэй хотоос олон төвтэй хот руу шилжиж, төвийн хэсгийн хэт төвлөрлийг сааруулах:** УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичигт хотын доторхи төрийн захиргаа, худалдаа, үйлчилгээ, банк, санхүүгийн нэг төвт төвлөрлийг задалж, сарниулах зорилгоор нэг төвт хотоос олон төвт хот болгон хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг салбар бүрт тэгш, хүртээмжтэй байдлаар шийдвэрлэн эрүүл, аюулгүй, тав тухтай орчныг бүрдүүлсэн хотыг бий болгох зорилго дэвшүүлсэн. Улаанбаатар хотыг тэнцвэртэй хөгжүүлэх чиглэлээр 6 дэд төвийг байгуулахаар тусгасны дагуу АХБ-ны санхүүжилтээр “Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийг 2014 оноос хэрэгжүүлж, дэд төвүүдийг бий болгох суурь “Дэд бүтэц”-ийн ажлуудыг гүйцэтгэж байна. Баянхошуу, Толгойт, Сэлбэ, Дэнжийн мянга, Шархад, Дамбадаржаа дэд төвүүд байгуулагдаж, гол авто замуудыг өргөтгөн шинэчлэх, шинээр барих ажлыг инженерийн шугам сүлжээтэй хослуулан гүйцэтгэснээр Улаанбаатар хотын гэр хорооллын дүр төрх өөрчлөгдөж, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний шинэ боломжууд нээгдэн хүрээгээ тэлж, хотын захаас хотын төв рүү зорчих хэрэгцээ, шаардлага багасах юм.

**Хот, суурин газруудын суурьшлын бүсийг тэлэх талаар:** Хүн амын өсөлт, хөдөөнөөс хотыг чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн, эрчимтэй хотжилтын нөлөөгөөр өнгөрсөн 20 жилд хот, суурин газруудын суурьшлын бүс тэлж өргөжсөн. Тухайлбал, 2003-2021 онд хот, тосгон, бусад суурин газрын хэмжээ 2.2 дахин нэмэгдсэн боловч аймгийн төв хотуудын газрын хилийн цэс 1990-ээд оныхоос өөрчлөлтгүй байгаа нь зэргэлдээх сумдтай газрын маргаан үүсэх нөхцөлд хүргэж байна. Тодруулбал, сүүлийн 20 жилд хотжилтын нөлөөгөөр Цэцэрлэг, Зуунмод, Өлгий, Булган, Дархан, Улиастай, Эрдэнэт, Сүхбаатар, Мөрөн, Ховд хотуудын суурьшлын бүс нь зэргэлдээх сумын нутаг дэвсгэрт өргөжин тэлснээр газар ашиглалт, харьяаллын маргаан нэмэгдсээр байна<sup>8</sup>. Иймд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасны дагуу хотуудын 2020-2040 оны хүн амын өсөлттэй уялдуулан суурьшлын бүсийг тэлж, хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх шаардлагатай байна.

Аж үйлдвэр, дэд бүтэц, хотжилт эрчимтэй өрнөж буй Улаанбаатар, Өмнөговь, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Говь-Алтай, Баян-Өлгий, Төв, Сэлэнгэ аймгуудад хот, тосгоны нутаг дэвсгэрийн барилгажсан талбай 2003-2021 онд 2-7 дахин өссөн байна.

### **2.2.5.Засгийн газрын бүхий л түвшинд хот төлөвлөлт, зураг төслийн чадавхыг сайжруулж, хот төлөвлөгчдийг сургах**

2016 онд УИХ-аас баталсан Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу барилгын салбарын ажилтны тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, хүчингүй болгох асуудлыг төрийн захиргааны байгууллагын дэргэдэх мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл хариуцан ажиллаж байна. Мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ, түүнд тавих шаардлага, мэргэшлийн зэрэг, гэрчилгээ олгох хугацааг “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ээр нарийвчлан тогтоосон. Барилгын тухай хуулиар барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох асуудлыг гэрээний үндсэн дээр төрийн бус, мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж болно гэж зохицуулсан. “Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах журам”, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам” зэрэг холбогдох бусад дүрэм, журмыг 2016-2020 онд Барилга, хот байгуулалтын сайдын тушаалаар шинэчлэн батлан мөрдөж байна.

Барилга, хот байгуулалт, геодезийн чиглэлээр тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, тэдгээрт бүртгэлтэй байгаа мэргэжлийн инженер, техникийн ажилчдын тоог 2020 оны байдлаар Хүснэгт 19-д үзүүлэв.

**Хүснэгт 19. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, мэргэжлийн инженер, техникийн ажилчдын тоо (2020 оны байдлаар)**

№	Тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын ажлын хүрээ	Хуулийн этгээдийн тоо	Зөвлөх зэрэгтэй	Мэргэшсэн зэрэгтэй	Нийт мэргэшлийн зэрэгтэй	Нийт ИТА
1	Барилга угсралт	5659				

<sup>8</sup> Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, 2018 он

2	Зураг төсөл	831	1609	5251	6860	25187
3	Өргөх механизм	194				
4	Барилгын материалын үйлдвэрлэл	596	Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо ТББ-ын цахим хаягнаас зөвхөн бүртгэлтэй хуулийн этгээдийн тоог авсан.			
5	Геодези	291	62	399	461	1000
6	Газар зохион байгуулалт	284				
	Бүгд	7855	1189	3937	7321	31687

Эх сурвалж: ГЗБГЗЗГ

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу БХБЯ “аж ахуйн нэгж, байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зохицуулсан. Манай улсад 2020 оны байдлаар хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 110 болсон бөгөөд нийт 1036 хүн ажиллаж, 2012 оны 1 дүгээр улирлын (25 аж ахуйн нэгжид 300 хүн) дүнтэй харьцуулахад аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо 85-аар, ажиллагсадын тоо 736 хүнээр тус тус нэмэгдсэн дүнтэй байна. Үүнээс зөвлөх зэрэгтэй 54, мэргэшсэн зэрэгтэй 165 бүс нутаг, хот төлөвлөлтийн архитектор, эдийн засагч байна. (Эх сурвалж: <http://opendata.gov.mn/dataset/>; <http://license.mcis.gov.mn/>; <http://barilga.gov.mn/>, <https://gazar.gov.mn/>)

Монгол Улсын “Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх зорилт дэвшүүлсэн. Үүний дагуу МАЭ, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо, Зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын Барилгачдын Холбоо зэрэг ТББ-ууд салбарын хүний нөөцийг чадавхыг бэхжүүлэх сургалтыг тус тус хариуцан зохион байгуулж байна.

2020 онд УИХ-д өргөн барьж, УИХ-аар хэлэлцэхийг дэмжсэн Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын бүхий л түвшинд хот төлөвлөлт, зураг төслийн чадавхыг сайжруулж, хот төлөвлөгчдийг сургах тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор дараах зохицуулалтуудыг шинээр тусгасан. Тухайлбал, мэргэжлийн байгууллагын эрх үүрэг, тавигдах шаардлага, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах эрх олгох, хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, мэргэжилтнүүдийн бүртгэлийг хөтлөн нэгдсэн мэдээллийн санд оруулж цахимжуулах, хот байгуулалтын салбарын мэргэжилтний ёс зүй, мэргэшлийн зэрэг, сургалтад тавигдах шаардлага, нөхцөлийг тусгаж, энэ салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд, төрийн бус байгууллага, хот байгуулалтын баримт бичгийн захиалагч, гүйцэтгэгч, хөрөнгө оруулагчийн хариуцлага, баримт бичигт тавигдах хяналтын тогтолцооны талаар шинээр нарийвчлан тусгасан.

БХБЯ, НЗДТГ, ЖАЙКА хамтран 2007 оноос эхлэн хот байгуулалтын салбарт, ялангуяа тус салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хамтран үр дүнтэй ажиллаж ирсэн. Тухайлбал, 2007-2009 онд хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”-ны төслийг үндэслэн “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага”-ын баримт бичгийг боловсруулж, 2013 онд УИХ-аар батлуулсан. 2010-2013 онд “Монгол Улсын Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 1 дүгээр үе шат”-ны төслийг хэрэгжүүлж, үүний үр дүнд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг боловсруулж, 2015 онд УИХ-аар батлуулсан. 2014 оноос хэрэгжсэн “Улаанбаатар

хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний чадавхийг сайжруулах” Дэд төсөл-1-ийн хүрээнд “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2016-2020 оны төлөвлөгөө”-г боловсруулж, Засгийн газрын 2016 оны 174 дүгээр тогтоолоор батлуулсан. Мөн 2015-2018 онд хэрэгжүүлсэн “Хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны төсөл”-ийн хүрээнд Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдах дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор холбогдох сургалт, семинаруудыг зохион байгуулж, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр 34 сургагч-багшийг бэлтгэсэн. Түүнчлэн, 2019-2021 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн хүрээнд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл” боловсруулах ажилд оролцогч талуудыг чадавхижуулах ажлыг зохион байгуулсан.

Үүний зэрэгцээ КОЙКА, ГОУХАН, АХБ, Дэлхийн банк зэрэг бусад олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хот төлөвлөлт, зураг төслийн салбарын хүний нөөцийн чадавхыг сайжруулж, Засгийн газрын бүхий л түвшний хот төлөвлөгчдийг сургаж, шинэ техник, технологи нэвтрүүлж байна.

БХБЯ, ГЗБГЗЗГ, Барилгын хөгжлийн төв, орон нутгийн ГХБХБГ-тай хамтран “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторуудыг чадавхжуулах сургалт”-ыг 2018 онд Эрдэнэт хотод, 2019 онд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. Хот байгуулалтын кадастрын цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Улаанбаатар, Дархан хотуудад нэгдсэн сургалтыг 2017, 2018, 2019 онуудад зохион байгуулж, тус сургалтын хүрээнд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтнүүдийг чадавхижуулсан байна.

Сүүлийн жилүүдэд хот байгуулалт, барилгын салбарын хөгжил эрчимжин барилга угсралт, хот байгуулалтын ажил өргөжиж, барилга угсралт, үйлдвэрлэлийн ажилд шинэ техник, технологи нэвтэрч байгаатай холбогдон тус салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчний эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэхийн хамт тэдгээрийг бэлтгэх тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох асуудал чухлаар тавигдаж байна. Зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн үед өмнө байсан салбарын ажиллах хүчнийг бэлтгэх, сургах, хөгжүүлэх, тогтвортой суурьшилтай ажиллаж байсан уламжлалт тогтолцоо бүрэн алдагдаж, хот төлөвлөлтийн боловсон хүчин бэлтгэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Цаашид хот төлөвлөлтийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцахад төрөөс бодлогын дэмжлэг үзүүлэх; гадаадын өндөр хөгжилтэй орнуудад сургах, дадлагажуулах, туршлага судлуулах; хот төлөвлөлтийн чиглэлээр сургалт явуулж буй их, дээд сургуулийн багш нарыг бэлтгэх, дадлагажуулах үйл ажиллагаанд салбарын дэмжлэгийг үзүүлэх; инженер, техникийн ажилтан нарыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх; боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагын оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### **2.2.6. Жижиг болон дунд хэмжээний хот, суурин газруудын гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хот, суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй,

тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ”, “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх салбар, орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бүрдүүлж, бэхжүүлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УИХ-аас Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд нийцүүлэн 2020 онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн баталж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Тус хуульд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрийн эрх зүйн байдлыг тодорхойлж, эрх зүйн байдалд нь тохирсон чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх санхүү, эдийн засгийн үндсийг тогтоосон.

Түүнчлэн, ЗГХЭГ-аас Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 2020 онд УИХ-д өргөн барьсан. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын ангиллыг тогтоож, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим эрх мэдэл, чиг үүргийг шилжүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн. Уг хуулийн төслийн зорилт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны чиг үүрэг, эдийн засгийн үндэс, өөрийн удирдлага, үйл ажиллагааны зарчим, бүрэн эрх, зохион байгуулалт, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршиж байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах өөрчлөлтийг тусгасан байна. Тухайлбал, 4.1-д “Улсын эдийн засаг, нийгмийн амьдралд гүйцэтгэх үүрэг, үзүүлэх нөлөө, хэрэгжүүлэх өөрийн болон засаг захиргааны чиг үүргийн онцлогийг нь харгалзан хотод улсын болон орон нутгийн зэрэглэл олгоно”, 4.2-т “Улсын зэрэглэлтэй хот нь 100001-ээс доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэцтэй, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд онцгой ач холбогдол бүхий, өөрийн удирдлагатай төвлөрсөн суурин газар мөн”, 4.3-т “Орон нутгийн зэрэглэлтэй хот нь 20001-100000 оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх хувь нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц, өөрийн удирдлага бүхий суурин газар мөн” гэж тус тус тусгасан. Мөн хот, тосгоны өөрийн удирдлагын байгууллага нь оршин суугчдаас шууд, чөлөөтэй, саналаа нууцаар гаргах эрхэд үндэслэн сонгосон хот, тосгоны Зөвлөл байхаар, 5 жилийн хугацаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэх Зөвлөлийн гишүүнд улс төрийн нам нэр дэвшүүлж оролцохгүй бөгөөд тосгонд 100-аас доошгүй, хотод 500-аас доошгүй оршин суугчийн дэмжлэг авсан иргэн хот, тосгоны Зөвлөлийн гишүүнд нэрээ дэвшүүлэхээр зохицуулсан байна. Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар засаг захиргааны анхан шатны нэгж, байгууллагын татварын хувь хэмжээ тогтоох эрх нэмэгдэж, эдийн засгийн чадавх нь нэмэгдэх ач холбогдолтой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2-т “...Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг тогтоох замаар орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах гол нөхцөл болж байна. Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш төсвийн удирдлагыг боловсронгуй болгох зорилгоор 2013 онд Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсөвтэй холбоотой харилцааг зохицуулж, уг хуульд орон нутгийн төсөв, түүний бүрэлдэхүүн, орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн шатлал хоорондын харилцааны асуудлыг шинээр тусгасан. Түүнчлэн, Засгийн газрын 2016 оны 350 дугаар

тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичигт орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн татварын болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлж байна.

Одоо боловсруулж буй “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд дагуул болон хоёрдогч хотуудад дээд боловсролын болон засаг захиргааны зарим чиг үүргийг шилжүүлэн байршуулах, хот, суурины ангилал, зэрэглэлийг оновчтой тогтоож, бие даан хөгжих чадавхыг нэмэгдүүлэх, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлтийн оновчтой зохион байгуулж, орон нутагт хүн ам, зах зээлийн зохистой төвлөрлийг бий болгох зэрэг төлөвлөлтийн шийдлийг тусгасан.

Одоогийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн бүтэц нь анх 1931 онд хуучин Зөвлөлтийн эрдэмтдийн оролцоотойгоор хийгдсэн бөгөөд тухайн үедээ сумын иргэдэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг ойр хүргэж, өдөртөө төв суурин газар руу мориор очоод буцах хэмжээний зайтай байхаар зохион байгуулагдсан. Засаг захиргааны нэгж тус бүр мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэр, модны аж ахуй, зам, тээврийн зангилаа, аялал, жуулчлал, худалдаа, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр эдийн засгийн хөгжлийн чиг үүрэгтэйгээр байгуулагдаж байсан бол одоо ихэнхи нэгжүүдэд эдгээр чиг үүрэг нь алдагдаж, үндсэндээ мал аж ахуй, засаг захиргаа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чиг үүрэг л үлдсэн байна. Иймд зам, тээврийн нөхцөл сайжирч байгааг харгалзан нийгэм, эдийн засгийн таталцал ихтэй зэргэлдээх хот, тосгонд ойрхон жижиг сумдын хүн ам сүүлийн 20 жилд хамгийн ихээр буурч байгаа тул аймгийн төвд 4-40 км хүртэл зайтай хүн амын тоо хэт цөөн 25 сум, хоорондоо 6-30 км зайтай 18 сумдыг тус тус нэгтгэх саналыг “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-д тусган боловсруулсан байна<sup>9</sup> (Зураг 15-ыг үзнэ үү).

Зураг 15. Бүлэг суурины тогтолцоо (санал)



Эх сурвалж: БХБЯ, БХТ, 2022, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн Эцсийн тайлан-1

<sup>9</sup> БХБЯ, БХТ, 2022, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн Эцсийн тайлан-1



### **2.2.7.Моторт бус хувилбарыг багтаасан олон төрөлт тогтвортой тээврийн системийг хэрэгжүүлэх**

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт “Тогтвортой дэд бүтэц, үйлдвэрлэл, инновацийг дэмжих” зорилтыг дэвшүүлж, уг зорилтын хүрээнд улс орнууд тээврийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, тээврийн үйлчилгээг аюулгүй, шуурхай, тав тухтай хүргэх, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай техник, технологийг хөгжүүлэх”-ээр заасан. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д “эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, логистикийн сүлжээг хөгжүүлнэ, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлнэ” гэж зам, тээврийн салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлсон. “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ” гэсэн зорилтыг хэрэгжүүлэхээр “Хот доторх болон хот орчмын тээврийн үйлчилгээний паркийг байгалийн болон шингэрүүлсэн шатдаг хий, цахилгаан, байгаль орчинд ээлтэй бусад эх үүсвэрээр ажилладаг, тэдгээрийн хосолмол хэрэглээ бүхий автотээврийн хэрэгслээр шинэчлэх”-ээр төлөвлөсөн.

Нийслэл Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах, нийтийн тээврийн салбарыг хөгжүүлэх олон төрөлт нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилтын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээг шинэчлэх, чанарыг сайжруулах, төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулахаар агаарын такси тээвэр, цахилгаан соронзон галт тэрэг, тусгай замын автобус зэрэг үндсэн гурван чиглэлд ажиллахаар төлөвлөж байна. “Баянхошуу-Ханын материал-3, 4 дүгээр хорооллын эцэс”, “7 буудал-Дарь эх-Сансар” гэсэн чиглэлд агаарын такси тээврийн (Cable car) нэг бүхээг 8-10 хүний багтаамжтай, цагт 3000 зорчигч тээвэрлэх хүчин чадалтай, хүлээлгийн хугацаа 3-5 минут бөгөөд дээрх чиглэлүүдэд явах хугацаа 16 минут байх юм.

Цахилгаан соронзон галт тэргийг эхний ээлжинд Энхтайвны өргөн чөлөөний дагуу, Амгалангаас Таван шар хүртэл үйлчилгээнд нэвтрүүлэх бөгөөд 12.2 километр урттай, 14 зогсоол бүхий байгууламж барихаар төлөвлөж байна. Ингэснээр Энхтайвны өргөн чөлөөний авто замын ачаалал 68 хувиар буурах боломжтой гэж тооцоолжээ. Энэхүү галт тэрэг нь өдөрт 210 мянга хүртэл зорчигч тээвэрлэх хүчин чадалтай байх бөгөөд хүлээлгийн хугацаа нь ойролцоогоор 3-5 минут байх бөгөөд цаашид Их тойруугаар цахилгаан соронзон галт тэргийг явуулахаар тооцоолж байна. Тусгай замын автобус (BRT) зорчих тусгай замын зурвасыг эхний ээлжинд Нисэх-Долоон буудал чиглэлд 15 буудалтайгаар байгуулахаар төлөвлөж байна. Дараагийн ээлжийн тусгай замын автобусны зурвасыг хотыг тойрог хэлбэрээр хамарсан маршруттай болгож, 60 орчим буудалтайгаар байгуулна. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр авто замын түгжрэл 20-30 хувь буурч, үүний үр дүнд үндсэн зорчих хэсгийн хөдөлгөөний хурд 2-3 дахин нэмэгдэнэ гэж үзэж байна. Гэвч эдгээр зорилт, төлөвлөгөөнүүдийн хэрэгжилт туйлын хангалтгүй байгаа юм.

Түрээсийн дугуйн үйлчилгээ үзүүлэх “UBIKE” төслийг 2018 оноос хэрэгжүүлж, Улаанбаатар хотын 10 байршилд нийт 700 дугуйтайгаар үйлчлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү төсөл нь 3 үе шаттай хэрэгжих бөгөөд 2018-2020 онд 150 зогсоол бүхий 2000 унадаг дугуй, 2021-2026 онд 250 зогсоол бүхий 2500 цахилгаан унадаг дугуй, 2027-2033 онд 5000 бүрэн цахилгаан дугуйг үйлчилгээнд нэвтрүүлэхээр төлөвлөөд байна. Энэхүү зорилтын хүрээнд Улаанбаатар хотод унадаг дугуйн зам барих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

## 2.3.ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

### 2.3.1.Санхүүгийн эх үүсвэрийг дайчлах

#### 2.3.1.1.Засгийн газрын бүхий л түвшинд “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх санхүүжилтийн хүрээг хөгжүүлэх

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх санхүүжилтийн тогтолцооны хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Хөгжлийн санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах, тогтворжуулах хөтөлбөр боловсруулна” гэсэн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Монгол Улсын эдийн засгийн өндөр өсөлтийг цаашид тогтвортой хэмжээнд байлгахад эрчимтэй өсч буй хотын эдийн засаг, түүний дотор үйлчилгээний салбар чухал үүрэгтэй юм. Улсын хэмжээнд 2019 онд ДНБ-ий 39.0 хувийг үйлчилгээний салбар, 39.1 хувийг аж үйлдвэрийн салбар, 11.0 хувийг хөдөө аж ахуйн салбар, 10.9 хувийг бусад салбараас бүрдүүлсэн байна. Сүүлийн арван жилийн хугацаанд эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь нэмэгдсэн хэдий ч нөгөө талдаа аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлээс ихээхэн хамаарах хандлагатай байна. Тухайлбал, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, оны үнээр 2019 онд 2018 оноос 11.2 хувь буюу 3.0 их наяд төгрөгөөр өсөхөд нийт өсөлтийн 54.7 хувь буюу 1.6 их наяд төгрөг нь уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэлийн хэмжээнээс хамаарсан байна.<sup>10</sup>

#### Хүснэгт 20. Эдийн засгийн өсөлт, салбараар (2017-2020 оноор)

Салбараар/ Оноор	2017	2018	2019	2020*
Эдийн засгийн өсөлт (хувь)	5.3	7.2	5.2	-5.3
Хөдөө аж ахуй	1.8	4.5	8.2	6.2
Үйлдвэрлэл	0.7	7.4	2.9	-6.2
Уул уурхай	-5.5	5.7	-0.4	-9.4
Боловсруулах	19.9	15.7	10.9	1.3
Цахилгаан	5.0	8.2	5.3	2.0
Барилга	11.4	2.4	8.0	-7.4
Үйлчилгээ	7.7	5.0	5.8	-7.1
Худалдаа	6.8	3.4	7.9	-11.1
Тээвэр	14.2	7.6	2.0	-20.1
Мэдээлэл, холбоо	13.3	7.8	7.5	0.4
Бусад	5.4	4.8	5.6	-0.8
Цэвэр татвар	18.5	20.1	5.4	-9.8

Эх сурвалж: ҮСХ

УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийг 1.5 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлэн, энэ хөтөлбөрийн үр дүнд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, 2018 оны эдийн засгийн өсөлт 7.2 хувь болж нэмэгдсэн (Хүснэгт 20-ийг үзнэ үү).


Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үр нөлөөгөөр эдийн засаг 2020 оны эхний хагаст 9.7 хувиар агшсан ч Засгийн газраас иргэдийн эрүүл

<sup>10</sup> “Монгол Улсын хөгжил олон улсын түвшинд, харьцуулсан судалгаа” 2020 он

мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх шат дараалсан бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор 2020 оны гүйцэтгэлээр 5.3 хувь болж, сүүлийн хагас жилд эдийн засгийн уналт саарсан байна.

Улс орон хөгжихийн хирээр үйлчилгээний салбар хүрээгээ тэлж, ДНБ-д үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь нэмэгдэх боловч Монгол Улсын хувьд үйлчилгээний салбарын цар хүрээ хумигдаж, 2019 онд ДНБ-д эзлэх хувь 39.0 хувь болж, 2010 оноос 5.8 пунктээр буурсан байна. Харин эсрэгээрээ ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2019 онд 39.1 хувь болж, 2010 оноос 5.9 пунктээр нэмэгдэж, харин хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувь 2019 онд 11.0 хувь болж, 2010 оноос 0.7 пунктээр буурсан.<sup>11</sup>

График 14. Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ (2020 оны байдлаар)



Хотжилт ба эдийн засгийн хөгжлийн асуудлыг нягт уялдаатайгаар авч үзэхгүйгээр нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг бий болгох боломжгүй юм. Өнөөгийн байдлаар ДНБ-ий 72 илүү хувийг зөвхөн Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймаг бий болгож байгаа нь хотын эдийн засгийн нөлөө өндөр байгааг харуулж байна. “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-өөс аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг 2012

<sup>11</sup> “Монгол Улсын хөгжил олон улсын түвшинд, харьцуулсан судалгаа” 2020 он

оноос эхлэн жил бүр үнэлж байгаа бөгөөд Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлох, аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тогтоож, өрсөлдөх чадварын боломж, чадавхийг үнэлж, тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн санг бүрдүүлж байна.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд аймгуудын өрсөлдөх чадварын индекст онцгой өөрчлөлт гараагүй бөгөөд 2020 оны байдлаар Орхон, Дорноговь, Дархан-Уул аймгууд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бол Баянхонгор, Говь-Алтай, Булган аймгууд хамгийн сул үзүүлэлттэй байна. Өрсөлдөх чадварын индексээс үзэхэд аймгуудын эдийн засаг, дэд бүтцийн хөгжил жигд бус, орон нутгийн хөгжлийн ялгаатай байдлыг илтгэж байна.

Аймгуудын өрсөлдөх чадварыг үнэлэхдээ эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц гэсэн үндсэн 4 бүлэг багтах 180 орчим шалгуур үзүүлэлтээр нэгтгэн дүгнэдэг болно.<sup>12</sup>

Төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоох, төсвийн нэгдмэл байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг төсвийн эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээний эргэн төлөлтийн хуваарь зэрэгтэй үйлдүүлэн боловсруулж, Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан.<sup>13</sup>

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013-2022 онд нийт 12.1 их наяд төгрөгийг баталсан байна. Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл, дэд бүтэц болон төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, төр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламжийн төслүүд 88.2 хувь, шинээр ашиглалтад орж байгаа нийгмийн салбарын төслүүд болон төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмжийн зардал 7.5 хувь, барилга байгууламжийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх зориулалт бүхий их засвар болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах зардал 4.3 хувийг тус тус эзэлж байна.<sup>14</sup>

Тухайлбал, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх нийт санхүүжилтийн 48.9 хувь нь орон нутагт, 32 хувь нь нийслэлд хэрэгжихээр төлөвлөсөн ба 36.2 хувь нь боловсролын салбарт, 17 хувь нь зам, тээврийн салбарт, 13.7 хувь нь барилга, хот байгуулалтын салбарт, үлдсэн 33.1% нь бусад салбарт хэрэгжүүлэхээр тусгажээ (График 15-ыг үзнэ үү).


---

<sup>12</sup> Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

<sup>13</sup> Засгийн газрын 2019 оны 290 дүгээр тогтоолоор тус хөтөлбөрийг тодотгон баталсан.

<sup>14</sup> <https://publicinvestment.gov.mn/>

График 15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх санхүүжилт (эх үүсвэр, салбараар)



2020 онд УИХ-аас баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгад орон нутгийн болон үндэсний түвшинд мөрдөх хөгжлийн бодлогын баримт бичгийн төрөл, ангилал, хугацааг хуульчилан зааж, тэдгээрийн уялдааг сайжруулснаар улс, орон нутгийн төсвийн, гадаадын зээлийн тусламжийн, хувийн хэвшлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр илүү оновчтой болж, үрэлгэн зардал хэмнэгдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг сайжрах ач холбогдолтой болсон.

Монгол Улсын СЯ НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Хөгжлийн санхүүжилтийг тогтвортой хөгжилд чиглүүлэх зорилгоор 2018 онд “Хөгжлийн санхүүжилтийн үнэлгээ”-г санаачлан хийж, уг үнэлгээнд цаашид урт хугацааны хөгжлийн зорилтыг хангахын тулд санхүүгийн өргөн хүрээний нэгдсэн удирдлагыг бий болгоход чиглэсэн “Үндэсний санхүүжилтийн нэгдсэн хүрээ” (ҮСНХ)-г нэвтрүүлэхийг зөвлөмж болгосон.<sup>15</sup>

ТХЗ-ыг хангах институцын тогтолцоог бэхжүүлэхтэй холбогдуулан Монгол Улс хөгжлийн бодлогыг төлөвлөх, хэрэгжилтийн зохицуулалтыг хангах, уг тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. ТХЗ-ыг хэрэгжүүлэх үүднээс ТХЗ болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтийг хянах чиг үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн зорилгууд Дэд хороог УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дэргэд, түүнчлэн, ТХЗ-ыг нутагшуулах, түүнтэй холбоотой тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын ахалсан Тогтвортой хөгжлийн Үндэсний хороог 2017 онд тус тус байгуулсан. ТХЗ-ыг урт, дунд, богино хугацааны бодлогод тусган, уялдаа, зохицуулалттай хэрэгжүүлэхэд Засгийн газарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ҮХГ (хуучин нэрээр, одоогийн ЭЗХЯ), ТХЗ-ын хэрэгжилтийг хянах тоо, мэдээллийг бүрдүүлэх үүргийг ҮСХ хариуцан ажиллаж байна.


<sup>15</sup>Энэхүү үнэлгээг эрүүл мэндийн салбарын жишээ дээр харуулсан. Дараагийн жилүүдэд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдийг нэмж хамруулах ба үүнийг жендерийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн хамт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### 2.3.1.2. Санхүүжилтэд дотоод эх үүсвэрийг дайчилж, бүс нутгийн болон орон нутгийн захиргааны орлогын суурийг өргөтгөх

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 136 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн алдагдлыг бууруулна” гэсэн зорилгыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичигт орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахад чиглэгдсэн татварын болон хөрөнгө оруулалтын уян хатан бодлогыг хэрэгжүүлж, “Орон нутгийн хөгжлийн сан” (ОНХС)-гийн тогтолцоог боловсронгуй болгох, төв, орон нутгийн удирдах болон захиргааны байгууллагад хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгийг төсөвт тусгаж хуваарилах, төв, орон нутгийн удирдах болон захиргааны байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэсэн нийтлэг, эсхүл нэг бүрчилсэн тодорхой арга хэмжээг шаардлагатай үед тухай бүр шуурхай авч хэрэгжүүлдэг механизм бүрдүүлэх, чиг үүргийн хэрэгжилтийг шат шатны хяналт, хариуцлагын тогтолцоотой нь нягт уялдуулах зэрэг чиглэлийг баримтлахаар тусгажээ.

График 16. Орон нутгийн төсвийн бүтэц 2020 он (хувиар)



Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2-т “...Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” гэж заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг тогтоох замаар орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг хангах гол нөхцөл болж байна. Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш төсвийн удирдлагыг боловсронгуй болгох зорилгоор 2013 онд Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсөвтэй холбоотой харилцааг зохицуулж, уг хуульд орон нутгийн төсөв, түүний бүрэлдэхүүн, орон нутгийн төсвийн орлого, зарлага, төсвийн шатлал хоорондын харилцааны асуудлыг шинээр тусгасан.

Орон нутгийн төсөв нь орон нутгийн татварын орлогоор бүрддэг суурь төсөв, улсын төсвөөс олгодог санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс олгодог тусгай зориулалтын шилжүүлэг, улсын төсвөөс хуваарилдаг ОНХС, “Сум хөгжүүлэх сан”-гаас бүрдэж байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 81.5 хувийг татварын орлого эзэлж буй бол орон нутгийн төсвийн орлогод 2019 онд 43.7 хувийг татварын орлого, 56.3 хувийг татварын бус орлого, 2020 онд төсвийн орлогын 39.3 хувийг татварын орлого, 60.7 хувийг татварын бус орлого эзэлж байна. Татварын бус орлогын 80 гаруй хувийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” (ОНХНС)-гийн шилжүүлэг болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн орлого тус тус бүрдүүлж байна. Төсвийн тухай хууль батлагдсанаар орон нутгийн орлого, зарлагын бүтцэд өөрчлөлт орж, орон нутгийн татварын болон татварын бус орлого, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоон, алдагдалтай аймгуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ашигтай аймгуудын орлогоос улсын төсөвт татан төвлөрүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. 2017-2019 онд дунджаар орон нутгийн төсвийн орлого 6.3 хувийн өсөлттэй байсан бол зарлага 5.9 орчим хувиар өсч, 2020 онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 175.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна (Хүснэгт 21-ийг үзнэ үү).

**Хүснэгт 21. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого  
(аймаг, нийслэлээр, 2016-2020 оноор)**

Хэмжих нэгж: сая.төг

Аймаг, нийслэл	2016	2017	2018	2019	2020
<b>БҮГД</b>	<b>90,681.2</b>	<b>195,414.8</b>	<b>289,228.4</b>	<b>368,270.3</b>	<b>175,344.6</b>
Хангайн бүс	9,702.6	13,683.7	12,016.8	16,300.9	29,220.1
Булган	-	290.4	-	-	-
Орхон	9,702.6	13,393.2	12,016.8	16,300.9	29,220.1
Төвийн бүс	16,748.7	30,263.9	68,682.7	61,135.7	37,824.8
Говьсүмбэр	-	155.2	-	-	-
Дархан-Уул	-	270.3	458.9	3,010.2	1,824.1
Дорноговь	-	600.0	2,124.1	124.1	-
Өмнөговь	16,748.7	29,238.4	66,099.7	58,001.4	36,000.7
Зүүн бүс	-	-	-	1,686.8	199.7
Дорнод	-	-	-	1,686.8	199.7
Улаанбаатар	64,229.9	151,467.3	208,528.9	289,146.9	108,100.0

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2020


Төсвийн орлого нь хүнам төвлөрсөн, аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ хөгжсөн нийслэл Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь зэрэг ашигт малтмалын нөөц бүхий аймгуудад төвлөрч, зөвхөн Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгуудын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ Монгол Улсын ДНБ-ий 72 хувийг эзэлж байна. Хүн амын өсөлт, төрийн үйлчилгээний цар хүрээ, инфляцтай уялдан орон нутгийн суурь орлого, суурь зарлагын хэмжээ жил бүр өсч, аймгуудад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэж байна. 2013 онд нийслэл Улаанбаатар хот, 3 аймаг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүй, орлогоороо зарлагаа санхүүжүүлж байсан бол 2019, 2020 онд нийслэл Улаанбаатар хотоос гадна 5 (Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өмнөговь, Дорнод) аймаг өөрийн орлогоороо зарлагаа нөхөж, бие даасан байна.

Орон нутгийн төсвийн тэр дундаа татварын орлогын бааз суурь бага учраас орон нутгийн орлогыг зарлагын өсөлтийг даган нэмэгдүүлэх боломжгүй тул улсаас санхүүгийн дэмжлэг авах аймгуудын тоо төдийлөн буурахгүй байна. Улсын төсвөөс орон нутгийн

төсөвт олгосон санхүүгийн дэмжлэгийг сүүлийн 4 жилийн дундажаар авч үзэхэд, Увс аймаг хамгийн их, Говьсүмбэр аймаг хамгийн бага дэмжлэгийг авсан байна (График 17-г үзнэ үү).

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Дотоодын үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжинэ” гэж заасны дагуу өнгөрсөн 2 жилд дараах 3 гол татварын өөрчлөлт хийсэн. Үүнд: Бүсийн хөнгөлөлтийн татвар (аймаг, сумын төв нь нийслэл Улаанбаатар хотоос 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар татварт ногдох орлогын албан татварыг чөлөөлөхөөр болсон ба 2017 оноос хууль хэрэгжиж эхэлсэн); Жилийн орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд 1 хувийн орлогын албан татвар ногдуулах (ногдуулсан татварыг 90 хувиар хөнгөлөхөөр зохицуулалтыг тусгаж, өөрчлөлт хийсэн ба хүнсний үйлдвэрлэл, оёдол, хувцас, нэхмэлийн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл зэрэг 4 салбарыг хамруулахаар тусгасан); Жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн албан татвараас чөлөөлөх (Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолын дагуу 2019 он хүртэл жижиг, дунд үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг Гаалийн албан татвараас чөлөөлж байна) зэрэг асуудлууд тусгагдсан. Энэхүү татварын хөнгөлөлтөд аялал жуулчлалын салбар хамаарахгүй байгаа болно.

График 17. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг, (аймгаар, 2017-2020 оны дундаж)



Эх сурвалж: <https://www.1212.mn>



**2.3.1.3. Санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газраас бүс болон орон нутаг руу хэрэгцээ, эрэмбэ болон зориулалтад үндэслэн шилжүүлдэг найдвартай, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 135 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Төвлөрлийг сааруулж шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим” хэмээн тодорхойлсон. Иймд тогтвортой хөгжлийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хангахад орон нутагт олгож буй төсвийн шилжүүлгүүд нь зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхүйц байх нь чухал ач холбогдолтой юм.

Орон нутгийн төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор Төсвийн тухай хуульд заасны дагуу суурь зардалд тусгаж тооцогдох чиг үүргийг оруулан, орон нутгийн төсвийн нийт орлого, суурь орлого болон суурь зардлуудад үндэслэн санхүүгийн дэмжлэгийн шилжүүлгийг тооцох бөгөөд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд шаардагдах эх үүсвэрийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт тусгай зориулалтын шилжүүлгийг тусгаж байна. Эдгээр зохицуулалтаас хамааран аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, орлогын шилжүүлэг гэсэн ангиллын дагуу шилжүүлдэг бөгөөд улсын дунджаар орон нутгийн төсвийн нийт орлогын 50 гаруй хувийг тусламжийн орлогоор, үлдэх хэсгийг урсгал орлого бүрдүүлж байна (Хүснэгт 22-ыг үзнэ үү).

**Хүснэгт 22. Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон бусад шилжүүлэг (2016-2020 оноор)**

Хэмжих нэгж: сая.төг


Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
<b>Нийт орлогын дүн</b>	<b>2,169,797.0</b>	<b>2,437,177.0</b>	<b>2,769,434.0</b>	<b>2,947,580.0</b>	<b>3,146,849.0</b>
Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	150,987.3	146,162.0	180,700.9	161,002.2	201,721.3
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	995,259.3	1,066,089.4	1,119,094.6	1,140,457.1	1,333,947.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	120,267.7	53,013.5	88,555.0	138,644.6	165,671.8
Тусламжийн орлогын дүн	1,266,514.3	1,265,264.9	1,388,350.5	1,440,103.9	1,701,341.0
<b>Нийт орлогод эзлэх хувь</b>	<b>58.4</b>	<b>51.9</b>	<b>50.1</b>	<b>48.9</b>	<b>54.1</b>

Эх сурвалж: <https://www.1212.mn>

Нийт тусламжийн орлогын 80 орчим хувийг тусгай зориулалтын шилжүүлэг эзэлж, дараах чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлж байна (Хүснэгт 22-г үзнэ үү). Үүнд, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, газрын харилцаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ, нийтийн биеийн тамир болон соёлын үйлчилгээний чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах урсгал зардал орж байна. Чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн Засаг дарга нар бөгөөд орон нутгийн засаг захиргаа эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс шилжүүлэн авч, захиран зарцуулж байна.

Төсвийн тухай хуулиар орон нутгийн татварын болон татварын бус орлого, орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүргийг тогтоож, алдагдалтай аймгуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ашигтай аймгуудын орлогоос улсын төсөвт татан төвлөрүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд 2013-2019 онд дунджаар орон нутгийн төсвийн орлого 6.3 хувийн өсөлттэй байсан бол зарлага 5.9 орчим хувиар өсч, 2020 онд аймгуудад олгох улсын төсвөөс олгосон нийт санхүүгийн дэмжлэгийн хэмжээ 201.7 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 24.7 хувиар өссөн дүнтэй байна (График 18-ыг үзнэ үү)

График 18. Орон нутгийн нэгдсэн төсвийн үзүүлэлт (2017-2020 оноор)



Эх сурвалж: <https://www.1212.mn>

Орон нутгийн төсөвт тулгамдаж байгаа төсвийн тэгш бус хуваарилалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2019 оны төсвийн жилээс эхлэн орон нутгийн онцлог, хэрэгцээнд тохирсон байдлаар төсвийн санхүүгийн дэмжлэг, шилжүүлгийг хуваарилах аргачлалыг туршиж, орон нутгийн сургууль, цэцэрлэг, сумын эмнэлэг зэрэг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын байрны ашиглалтын зардал, мөн нийтийн биеийн тамир, соёлын байгууллагуудын бүх зардлыг орон нутаг өөрөө хуваарилах тогтолцоог бий болгож, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт шилжүүлээд байна. Орон нутгийн нийт зардлын 80 гаруй хувийг урсгал зардал эзэлж, урсгал зардлын 50 орчим хувийг цалин хөлсний зардалд зарцуулж байгаа нь орон нутгийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагааг голлон санхүүжүүлдэг гэдгийг харуулж байна. Орон нутагт шаардлагатай бусад бараа, үйлчилгээний зардлыг цаашид нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх (орон нутгийн төсөвт хөрөнгийн зардлын эзлэх хувь хэмжээ бага), ажлын байр шинээр бий болгох, улмаар орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх явдал чухал байна.

Төсвийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 2018 онд Төсвийн тухай хуульд нэмэлт оруулж, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, мөн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувийг ОНХС-д тус тус төвлөрүүлэх; 2020 онд Малын тоо, толгойн албан татварын тухай хуулийг шинээр баталж, тус татварын орлогыг ОНХС-д төвлөрүүлэх; 2020 онд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймаг, нийслэлийн төсөвт, газрын төлбөр, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг сум, дүүргийн төсөвт шилжүүлэхээр болсон байна.

2017 онд Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлан хэрэгжүүлж, тус журмаар дэд бүтэц, нийгмийн халамж, эрүүл мэнд, боловсролын салбарт хуваарилж байгаа төсөвт дүнд шинжилгээ хийсний дараа зарцуулалтын үр ашгийг тооцохоор зохицуулсан.

**2.3.1.4. Хотжилтын санхүүжилтэд санхүүгийн зуучлалыг (олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, бүс нутгийн хөгжлийн банкууд, бүсийн болон орон нутгийг хөгжүүлэх сангууд; төвлөрсөн санхүүжилтийн механизм гэх мэт.) бий болгож ашиглах**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 139, 145 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтыг үр дүнтэй, ард иргэдэд нээлттэй, ил тод болгоно” гэсэн зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна.

ОНХНС нь төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд хийгдсэн орлогын шилжүүлгийн нэг хэлбэр бөгөөд тус санд хуримтлагдсан эх үүсвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-д хүн амын тоо, төвөөс алслагдсан байдал, нутаг дэвсгэрийн хэмжээ, татварын идэвх санаачилга, орон нутгийн хөгжлийн индекс гэсэн үзүүлэлтийг үндэслэн хуваарилж байхаар Төсвийн тухай хуульд заасан. Мөн аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөрийн бие даасан ОНХС-тай байх зарчмыг тогтоосон. Орон нутгийн хөгжлийн ерөнхий түвшинг тодорхойлох, төсвийн хөрөнгө оруулалтыг аймаг, орон нутгийн хөгжлийн бодит түвшинд тулгуурлан төлөвлөх зорилгоор Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал”-ыг ашиглан ОНХНС-гаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлэг буюу ОНХС-д хөрөнгө хуваарилах хязгаарыг тодорхойлж байна.

Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилготой ОНХС бий болсон боловч улс орны санхүү, эдийн засгийн байдалтай уялдан хууль эрх зүйн орчин тогтворгүй байсан нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Төсвийн тухай хуульд заасны дагуу ОНХНС-гаас аймаг, нийслэлийн ОНХС-д дээрх үүсвэрээс тус тус тооцон орлогын шилжүүлэг олгож байна (Хүснэгт 23-ыг үзнэ үү).

**Хүснэгт 23. ОНХС бий болсноос хойшхи хууль эрх зүйн орчны өөрчлөлт (2016-2019 оноор)**

Орлогын шилжүүлэг	2016	2017	2018	2019	2020
Дотоодын НӨАТ	10%	5%	5%	5%	5%

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)	5%	5%	5%	5%	5%
Газрын тосны Нөөц ашигласны төлбөр	30%	30%	30%	30%	30%
Аймаг нийслэлээс дахин хуваарилах (үндсэн тэнцлийн ашгаас)	Үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж үлдэх хэсгийг ОНХНС-д төвлөрүүлнэ.	(ОНХС-д бус дээд шатны төсөвт төвлөрүүлэх)			“Тогтвортой амьжиргаа төсөл”-өөс олгох гүйцэтгэлд суурилсан урамшуулал-шалгуур үзүүлэлт хангасан сумдын тухайн оны батлагдсан төсвийн гүйцэтгэлийн 25 хувь хүртэл хэмжээнд урамшуулал тооцно.
АМНАТ (мега-аас бусад)	-	10%	10%	10%	100%
Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	50%	50%	50%		50%
Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	30%	0%	0%	0%	10%
Олон улсын төслөөс олгох урамшуулал(үр дүнгийн үзүүлэлтээр)	-	Шалгуур хангасан сумдад ОНХНС-гаас хуваарилагдах хөрөнгийн сумдад оногдох хэсгийн 25 хувьтай тэнцэх хэмжээгээр хуваарилна.			
Олон улсын төслөөс олгох дэмжлэг (итгэлцүүрээр)	-	-	Төслийн эх үүсвэрийн дүнг ОНХНС-гийн үндсэн аргачлалаар хуваарилна.		

Эх сурвалж: СЯ

ОНХС нь нутгийн иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл юм. Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тус сангийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт жил бүр хуваарилж байна. ОНХС-гаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх цогц мэдээллийн системийг 2013 оноос бий болгож, энэхүү системийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх талаар байнга анхаарч, системийг хөгжүүлсээр ирсэн. Аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрийн ОНХС-гаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг <http://shilendans.gov.mn> болон [www.tusuv-oronnutag.mn](http://www.tusuv-oronnutag.mn) цахим хуудсаар тогтмол мэдээлж, арга хэмжээ бүрийн дэлгэрэнгүй мэдээллийн хэсэгт иргэдийн санал, гомдлыг хүлээн авах нэмэлт талбар нээн ажиллуулж байна. Уг мэдээллийг нэгдсэн байдлаар сар бүр СЯ-ны шилэн дансны “орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл арга хэмжээ тус бүрээр” хэсэгт тогтмол байршуулж, ил тод мэдээлж байна.

ОНХС-гийн эх үүсвэр анх бий болсон үеэс жил бүр буурч, ОНХС-гийн хэрэгжилтэд хүндрэл гарч байсан тул ДБ, Швейцарын хөгжлийн агентлагын санхүүжилтээр 2015 оноос “Тогтвортой амьжиргаа-3 төсөл”-ийг Монголын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол

бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготойгоор хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд “Сайн засаглал-Үр дүнд суурилсан урамшууллын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, ОНХС-гийн үйл ажиллагааг “Сайн засаглал”-ын хүрээнд хэрэгжүүлсэн сумдад үр дүнд суурилсан санхүүжилт болон санхүү, хөрөнгө оруулалтын нэмэлт хөрөнгийг хуваарилсан. Тухайлбал, орон нутгийн хөгжлийг дэмжих, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 2017-2019 онд 6.2 тэрбум төгрөгийн урамшуулал, 2018-2019 онд 26.9 тэрбум төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. Мөн үр дүнд суурилсан санхүүжилтийг сумдад хуваарилах зорилгоор ОНХС-гийн үйл ажиллагааны хэрэгжилтэд жил бүр хөндлөнгийн үнэлгээ хийж, сайн гүйцэтгэлтэй гарсан сумдад ОНХС-гийн урамшууллыг 2017 оноос олгож эхэлсэн бөгөөд 2017 онд 165 сум, 2018 онд 154 сум, 2019 онд 222 сум урамшуулал авах болзлыг хангасан байна. Харин ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сумдын орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус төслөөс нийт 330 суманд 10.6 тэрбум төгрөгийн ерөнхий дэмжлэгийг олгосон.

СЯ, ДБ, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд 2016 оноос эхлэн жил бүр сумдын ОНХС-гийн үйл ажиллагаанд “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”-г хийхдээ “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн нийт 34 үзүүлэлтээр дүгнэж байна. Санхүүгийн “дэмжлэг” болон “урамшуулал”-ыг сумдад олгосноор иргэд орон нутгийнхаа тулгамдсан асуудлыг тодорхойлон, тэдний төсвийн төлөвлөлтөд оролцох оролцоо нэмэгдэж, хөрөнгө оруулалтын тоо, хэмжээ, чанар, үр ашиг сайжрах ач холбогдолтой болсон юм. ОНХС-гийн “Удирдлагын мэдээллийн систем” болон олон нийтэд зориулсан портал сайтыг шинэчлэн боловсруулж, ашиглалтад оруулсан. Үүнтэй уялдуулан системийг хэрхэн ашиглах, мэдээлэл оруулах талаар холбогдох мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгуулж, аймаг, сумдын ОНХС-гийн 2018-2020 оны шаардлагатай мэдээллийг системд оруулаад байна.

Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сан хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд СЯ “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлал”-ыг боловсруулж, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдэд шинжилгээ хийж, шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгаж байх энэхүү аргачлалыг анх удаа боловсруулан баталсан бөгөөд уг аргачлал нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой төслүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдүүлж байна.

### **2.3.2. Чадавхийг бэхжүүлэх, ахисан түвшинд мэдлэг солилцох**

#### **2.3.2.1. Хотууд хоорондын хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлж хотжилтын шийдэл, харилцан суралцах явдалд дэмжлэг үзүүлэх**

Манай улс нь “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 96, 146 дахь хэсэгт заасныг хот хоорондын хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал үүрэг, амлалт гэж үзэн ажиллаж байна.

Олон улсын түвшинд хот хоорондын хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нь хот хоорондын эгч дүү хотуудын хамтын ажиллагаа, олон улсын хотуудын холбооны гишүүнчлэл, форум, хурал, сургалт зэргээс бүрдэж байна. Эгч дүү хотууд болох эрх зүйн зохицуулалт, олон улсын байгууллагатай хамтран ажиллах харилцааг ГХЯ-ны холбогдох

тушаалаар зохицуулж байна. Үндэсний хэмжээнд хот хоорондын хамтын ажиллагаа нь нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, харилцан туршлага солилцох боломжийг бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхижуулах, хотын шийдэл солилцох, эв нэгдэл, харилцан суралцахыг дэмжин ажиллахад чиглэгдэж ирлээ. Манай улсын хувьд 1996 оноос Дэлхийн эрүүл хотуудын чиг хандлага, үзэл баримтлалыг дэмжиж, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд өөрийн орон нутгийн онцлогт тохируулан “Эрүүл хот” орон нутгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх анхны санаачлагыг гаргасан. Харин хотуудын хамтын ажиллагааг дэмжих, тогтвортой хөгжилд ээлтэй, ухаалаг, эрүүл хотуудыг бүтээн байгуулахад дэмжлэг үзүүлэхэд төрийн бус байгууллагууд идэвхтэй үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хүн амын нутагшилт, суурьшлын асуудлаарх төрийн бодлогод нийцүүлэн, дэлхий нийтийн хандлагыг харгалзаж, “Монголын Хотуудын Холбоо” ТББ-ыг анх 2003 онд Монгол Улсын хотын захирагч нарын санаачлагаар байгуулсан. Үе үеийн нийслэлийн Засаг дарга нар тус холбоог удирдаж, хотуудын хөгжлийн асуудал, хамтын ажиллагааг хөгжүүлж ирсэн бөгөөд тус ТББ нь хот, суурин газар бүрийн хөгжил, харилцан суралцах үйл ажиллагааг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах, хотуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хот, суурины тулгамдсан асуудлыг төрийн бодлогын түвшинд танилцуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Нийслэл Улаанбаатар хот нь олон улсын 40 гаруй хоттой хамтын ажиллагаатай байдаг.

“Эрүүл хот хөтөлбөрийг чадавхижуулах төв” ТББ (Монголын Эрүүл хотуудын сүлжээ [www.healthycity.weebly.com](http://www.healthycity.weebly.com)) нь хот, суурин газруудад эрүүл орчныг бий болгох, эрүүл мэндэд ээлтэй хотын хөгжлийн үйл ажиллагааг дэмжин ажилладаг. Тус байгууллага нь 2017 онд үүсгэн байгуулагдсан хэдий ч үндэсний болон олон улсын түвшинд хамтын ажиллагаагаа бэхжүүлэн, Монгол Улс дахь “Эрүүл Хот” үүсгэл санааг хэрэгжүүлж буй хот, орон нутгийн захиргааны тоог нэмэгдүүлэх, цар хүрээг өргөжүүлэх, чадавхийг бэхжүүлэх зорилгоор 18 хоттой хамтран ажиллах санамж бичгийг байгуулан ажиллаж байна. Тус хамтын ажиллагааны хүрээнд “Эрүүл хот” санаачилгыг дэмжигч хотуудын сайн туршлага солилцох, хотуудад нийтлэг тулгарч буй асуудлуудыг хэрхэн даван гарах талаарх хэлэлцүүлэг, цуврал сургалт, уулзалт, семинарыг Улаанбаатар, Дархан, Чойбалсан хотуудад зохион байгуулсан. Түүнчлэн, “Тамхигүй хот”-ын бодлого, үйл ажиллагааг хотуудад түгээн дэлгэрүүлэх, тэдний оролцоог хангах ажлын хүрээнд лобби сургалт, семинаруудыг хотуудын удирдлагуудын дунд зохион байгуулж, 11 хот тамхигүй хотын санаачлагад нэгдэж, санамж бичиг байгуулсан. Тамхигүй хот санал, санаачилгын үр дүнд 11 хотын 350 орчим байгууллага, аж ахуйн нэгж тамхигүй ажлын байрт нэгдэж, 628 байгууллагын 4680 иргэн тамхидалтын нөхцөл байдлын судалгаанд хамрагдаж, үнэлгээ хийсэн. Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэг, Сайншанд, Арвайхээр хотууд Ази Номхон далайн бүсийн “Тамхигүй хотуудын холбоо”-нд гишүүнээр элссэн.

Хотуудын эрүүл мэндийг дэмжих зан үйлийг өөрчлөх сургалт, семинарыг ЭМЯ, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын бүсийн хороо, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулж, аймаг, нийслэл, хотын удирдлага, холбогдох албан хаагчдыг чадавхижуулсан. 2018 онд “Хотын ногоон байгууламж ба тохижилт” сэдэвт сургалт семинарыг БХБЯ-тай, 2019 онд хот, хөдөө, орон нутгийн түншлэл, хот хоорондын хамтын ажиллагааны механизмыг дэмжих, хотын засаглал, хот нь хотоос суралцах сургалтыг Мандалговь хот, Улаанбаатар хотын ЗАА-тай хамтран зохион байгуулсан. Түүнчлэн, үндэсний хэмжээнд хот хоорондын хамтын ажиллагаа, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхээс гадна олон улсын ижил төстэй хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, эрүүл хотуудын сайн туршлагаас судлах уулзалт, сургалтад хотын дарга, холбогдох албан

хаагчдыг хамруулж байна. Монголын Эрүүл Хотуудын Сүлжээ нь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Туркийн орон нутгийн захиргаадын холбоо, СИТИНЕТ олон улсын байгууллага, Тамхигүй хотуудын холбоо, Хотын гэрэлтүүлгийн байгууллага, Ухаалаг хотуудын холбоо, Олон улсын эрүүл хотуудын холбооны үндэсний сүлжээ, “Бид тогтвортой хөгжлийн төлөөх орон нутгийн захиргаадын холбоо”, “Тамхигүй хотуудын Холбоо”, Тайваний Ченг Кунгийн үндэсний Их сургуультай хамтран ажиллаж байна.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр 2019 онд “Хотжилт ба эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, “Хотын тэгш байдлын нөхцөл байдлыг үнэлэх” судалгааг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Эрүүл хотын засаглал ба хамтын ажиллагаа, зохицуулалтын талаар тодорхой ажлууд манай улсад хэрэгжиж, тухайлбал, дүүрэг, аймаг бүр тухайн жилдээ эрүүл хотын санаачлагыг хэрэгжүүлснээр тодорхой ахиц, дэвшил гарсан байна. Цаашид эрүүл хотын санаачлагыг дэмжихэд хувийн хэвшлийн түншлэл, дэмжлэгийг бий болгох, хотын тогтвортой хөгжлөөр дамжуулан эрүүл мэндийг дэмжих санхүүжилтийн тогтвортой механизмыг бий болгох, салбар дундын хамтарсан санхүүжилт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах гэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

**2.3.2.2. Чадавхыг бэхжүүлэх ажлыг хот байгуулалтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хариуцах, хянах болон үнэлэх үр дүнтэй, олон талт аргачлал болгон хэрэгжүүлэх**

Дараагийн шатны тайланд тусгах болно.

**2.3.2.3. Засгийн газрын бүхий л түвшинд нотолгоонд суурилсан бодлого боловсруулалтад тоон мэдээллийг ашиглах чадавхыг бэхжүүлэх, үүнд үндэсний цөөнхийн бүлгүүдээс өгөгдөл цуглуулах болон өгөгдлийг тэдний тусын тулд ашиглалт мөн багтана**

Дараагийн шатны тайланд тусгах болно.

**2.3.2.4. Засгийн газрын бүхий л түвшинд эмзэг бүлгүүдтэй ажиллах, тэднийг хот байгуулалт болон нутаг дэвсгэрийн хөгжлийн талаарх шийдвэр гаргалтад идэвхтэй татан оролцуулах чадавхыг бэхжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 148 дахь хэсэгт “Үндэсний, бүсийн болон орон нутгийн засаг захиргаа, түүний дотор орон нутгийн засаг захиргааны холбоо, эмэгтэйчүүд, охид, хүүхэд, залуучууд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нутгийн уугуул иргэд, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Эмзэг байдал, түүнчлэн иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын зохион байгуулалт, засаглалын үйл явцыг бий болгох, тэдгээр нь хотын болон нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар шийдвэр гаргахад үр дүнтэй оролцох боломжийг олгодог” гэж заасан.

Монгол Улсад бодлого боловсруулах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангах зорилгоор сүүлийн жилүүдэд Нийтийн сонсголын тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль зэрэг бусад холбогдох хууль тогтоомжийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал, Нийтийн сонсголын тухай хуульд төрийн

байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, иргэний хяналтын тогтолцоог бий болгох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, томилгооны, захиргааны хэм хэмжээний болон төлөвлөлтийн, орон нутгийн сонсгол гэсэн сонсгол хийж, төрийг удирдахад иргэдийн оролцоог хангахаар тусгасан. (<http://forum.parliament.mn/>)

УИХ-аас 2008 онд баталсан Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 17.1-д “Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоотой төлөвлөлтийн зарчмыг тусгаж ажиллана”, 17.2-т “Хот, тосгоны захирагч нь хот төлөвлөлтийг хэрэгжүүлэхдээ иргэд болон холбогдох мэргэжлийн хүмүүсийн оновчтой саналыг авч хот төлөвлөлтөд тусгана”, 18.1-д “Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, хотын захирагчийн ажлын алба нь энэ хуулийн хүрээнд гаргасан аливаа шийдвэрийн талаар тухай бүр олон нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан. БХБЯ-наас салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2020 онд УИХ-д өргөн барьж, УИХ-ын хуралдаанаар хэлэлцэхийг дэмжсэн. Тус хуулийн төсөлд хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоотой холбоотой харилцааг илүү нарийвчлан зохицуулсан.

УИХ-аас 2015 онд батлан мөрдөж буй Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоог хангах зарчмыг баримтлахаар зохицуулж, 14.2-т “... төсөл хэрэгжүүлэхээр сонгох талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, батлуулах ажлыг Хот байгуулалтын тухай хуулийн дагуу зохион байгуулж, уг төлөвлөгөөнд хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн, хөндөгдөж болзошгүй иргэн, хуулийн этгээдийн саналыг авч тусгах”, 14.7.1.г-д “төслийг сонгосон талбай дахь газар, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигчдэд танилцуулж, 80-аас доошгүй хувийн зөвшөөрлийг авах”, 14.7.1.д-д “иргэдийн төлөөллийн байгууллагыг байгуулах”-аар заасан. Тус хууль, түүнийг дагалдаж батлагдсан дүрэм, журмын хүрээнд нийслэл Улаанбаатар хот, бусад хот, суурин газруудад хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангаж, ялангуяа эмзэг бүлгийн саналыг тусгахад илүү анхаарч байна.

ЖАЙКА-аас 2015-2018 онд БХБЯ, НЗДТГ-тай хамтран хэрэгжүүлсэн техник туслалцааны “Монгол Улсын хот байгуулалтын салбарын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дахь үе шатны төслийн хүрээнд хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор холбогдох сургалт, семинаруудыг зохион байгуулж, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны 3 төрөл тус бүрээр гарын авлага, видео танилцуулга хийж, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль болон хуулийг дагалдаж батлагдсан дүрэм, журмыг сурталчлах ажлыг зохион байгуулж, мөн хот, суурин газрыг дахин хөгжүүлэх чиглэлээр 34 сургагч-багш нарыг бэлтгэсэн.

Хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 183 дугаар тушаалаар баталсан “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ыг мөрдөж байна.

Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоолоор баталсан «Орон сууц» үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө” үндэсний зөвлөлийн төлөөлөл ажилласан. Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 19 дүгээр тушаалаар Сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд, мөн 153 дугаар тушаалаар “Барилга байгууламжийн норм, нормативын сан”-гийн удирдах зөвлөлийн



бүрэлдэхүүнд “Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо” ТББ-ын төлөөлөл тус тус ажиллаж байна.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу НХБХГ-аас барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, тус комиссын бүрэлдэхүүнд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах” ТББ-ын төлөөллийг байнга оролцуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ын дагуу “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлыг зохион байгуулах байгууллага болон ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-д Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөллийг оролцуулдаг.

“Швейцарийн Ардчилал судлалын төв”-ийн техникийн туслалцаатайгаар иргэдийг төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхийг хангахад чухал ач холбогдолтой оролцооны шинэ арга механизмыг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилготой “Иргэдийн оролцоог дэмжих төсөл”-ийг 2016 оноос хэрэгжүүлж байна. Хот төлөвлөлт, хот байгуулалт, нутаг дэвсгэрийн хөгжлийн талаарх шийдвэр гаргалтад эмзэг бүлгийн иргэдийн тэгш оролцоог хангах зорилгоор тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах, оролцооны чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, нийгмийн ажилтнуудыг өргөнөөр татан оролцуулж, дадлагажуулах шаардлагатай байна. Энэ чиглэлээр олон улсын туршлагыг нэвтрүүлэх, олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

### **2.3.2.5. Чадавхыг бэхжүүлэх явцад орон нутгийн захиргаадыг дэмжигч болон хэрэгжүүлэгчээр татан оролцуулах**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 90 дэх хэсэгт “Үндэсний хууль, эрх зүйд нийцүүлэн нутаг дэвсгэрийн хил, үйл ажиллагаанд тулгуурлан орон нутгийн болон хотын бүх түвшний засаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх бүс нутгийн ба орон нутгийн удирдлагын чадавхыг бэхжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, боломжоор хангах замаар шийдвэр гаргах болон ажиллах явцад бүс нутгийн болон орон нутгийн удирдлагын оролцоог хангахад тусална” гэж заасан. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”-д “төвлөрлийг сааруулж, шийдвэр гаргахад бүх талын оролцоог хангах нь тогтвортой хөгжлийн засаглалын үндсэн зарчим” хэмээн тодорхойлсон нь төвлөрлийг сааруулах бодлого, үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн.

Орон нутгийн иргэдийн хурлын төлөөллийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлж, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д сонгогдон ажиллаж буй төлөөлөгчдийг манлайллын сургалтанд хамруулан эрх мэдэлжүүлж, тэдэнд улс төрийн шийдвэр гаргахад илүү үр дүнтэй оролцох боломжийг олгосон. Сургалтын явцад тэдний олон төрлийн үүсгэл санаачилгыг удирдан чиглүүлэх, үзэл санаа нэгтэй хэсэгтэйгээ хамтран лобби бүлэг байгуулах, нутгийн иргэдтэй эв зүйтэй хамтран ажиллах зэргээр орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх ур чадвар, өөртөө итгэх итгэл нь сайжирсан. Эдгээр санаачилгын заримаас дурдвал, нийтийн аж ахуйн үйлчилгээний газруудын үйлчилгээнд хяналт тавих, төрийн байгууллагуудын шийдвэрийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор мэдээлэл солилцох уулзалтууд зохион байгуулах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг орон нутгийн зөвлөлөөр батлуулахад чиглэсэн нөлөөлөл сурталчилгааны олон ажил хийсэн. Хүртээмжтэй, хариуцлагатай хотыг

хөгжүүлэх зорилгоор орон нутгийн засаг захиргааны шийдвэр гаргах, төлөвлөх, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн иргэдийн оролцоог хангах “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн байгууллага”-ыг байгуулсан. Тус байгууллага нь эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тухайн орон нутгийн бизнес эрхлэгчдийн онцлог хэрэгцээг шийдвэрлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байна.

2017 оноос хэрэгжүүлсэн “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд ИТХ-ын төлөөлөгчдөд Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийг чадавхжуулах суурь сургалт, Манлайллын сургалт, Эмэгтэй төлөөлөгчдийг чадавхжуулах сургалт, Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зориулсан сургалт, Үндэсний сургагч багш нарын сургалт зэрэг олон төрлийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 20 мянга орчим төлөөлөгчийг хамруулсан. Судалгаанаас харахад 4 жил тутам орон нутгийн сонгуулиар сонгогдож байгаа 8000 гаруй ИТХ-ын төлөөлөгч нарын 60 орчим хувь анх удаа сонгогддог тул төлөөлөгч нарыг чадавхжуулах суурь сургалтыг тасралтгүй зохион байгуулах шаардлагатай байна. Төлөөлөгчдийг тасралтгүй чадавхжуулах бололцоог бүрдүүлэхийн тулд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана гэсэн заалт шинээр тусгаад байна. Төслийн хүрээнд ИТХ-ын хяналт, чадавхийг дээшлүүлэх зорилгоор жил бүр тэтгэлэгт хөтөлбөр зарлаж, 2017-2020 онд нийт 73 ИТХ, мөн нутгийн удирдлагын чиглэлээр ажилладаг 23 ТББ-д тэтгэлэг олгосон. Тэтгэлэгийн хүрээнд ИТХ-ын үйл ажиллагаанд оролцох эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо нэмэгдэж, байгаль орчны нөхөн сэргээлт, орон нутгийн төсвийн зарцуулалтад тавих хяналт сайжирсан зэрэг үр дүн гарсан. ИТХ-ын тухай иргэдийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, төлөөлөгчдийн сайн туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор 21 аймаг, 330 сум, 9 дүүргийг нэгтгэсэн khural.mn сайтыг төслийн хүрээнд бий болгон, идэвхтэй ажиллуулж байна.<sup>16</sup>

### **2.3.2.6.Хууль ёсны эзэмшил газраас олох орлого, санхүүжилт, бусад арга хэрэгслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 152 дахь хэсэгт “Газар ашиглалтад үнийн өсөлтийн хуваарилалт, хууль эрх зүй, газарт суурилсан орлого, санхүүжилтийн хэрэгсэл, түүнчлэн бодлого боловсруулагчид, орон нутгийн төрийн албан хаагчид үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, үнэлэмжийг үнэлэх эрх зүйн болон эдийн засгийн суурийг анхаарч, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг бид дэмжинэ” гэж заасан.

Монгол Улсын Газрын төлбөрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Засгийн газрын 2018 оны “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоол, ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны 187 дугаар тушаалаар баталсан “Газрын төлбөр ногдуулах аргачилсан заавар”, ГЗБГЗЗГ, ТЕГ-тай хамтран 2019 онд баталсан “Мэдээлэл солилцох журам”, “Мэдээлэл харилцан солилцох тухай гэрээ”-ний дагуу газрын төлбөрийг дундын мэдээллийн сангаар дамжуулан төвлөрүүлж байна. 2020 оны байдлаар Газрын төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш газрын төлбөрийн орлогоос орон нутгийн төсөвт өссөн дүнгээр нийт 726 тэрбум 837 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр газрын төлбөрийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн

<sup>16</sup> Эх сурвалж:<https://www.mn.undp.org/content/mongolia/>

Татварын алба хураан барагдуулах үүрэг хүлээн ажиллаж эхэлсэн бөгөөд Газрын албад “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн систем”-ээс газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэл (egazar.gov.mn, egazar app, e-mongolia.mn)-ийг үүсгэн, дундын мэдээллийн системд илгээж, Татварын алба татвар төлөгч нараас цахимаар (etax.mta.mn, ebarimt app) нэхэмжлэн төсөвт төвлөрүүлэх ажлыг эхлүүлсэн.

Газрын төлбөр, татварын системийг ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны 1/05 дугаар тушаалаар улсын хэмжээнд нэвтрүүлж, 21 аймгийн ГХБХБГ, нийслэл, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 330 сумын газрын даамлууд өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж байна. 2020 оны байдлаар улсын хэмжээнд 333279 нэгж талбарын 126 тэрбум 334 сая төгрөгийн ногдуулалт хийснээс 110 тэрбум 54 сая төгрөгийн ногдуулалтыг Татварын системд илгээж, газрын төлбөрийн орлогоос нийт 108 тэрбум 85 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 86.4 хувьтай байна.

Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлснээр том дэвшил гарсан. Үүний нэг жишээ бол иргэд нэг жилийн өмнө газрын төлбөрөө төлөхөд олон шат дамжлага дамжин, банкинд дугаарлан 3-8 цагийг зарцуулдаг байсан бол өнөөдөр цахим хэлбэрээр нэг минутын дотор газрын төлбөр, татварыг төлөх боломжтой болсон.

ГЗБГЗЗГ-аас газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем (www.mle.mn)-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг системийг 21 аймгийн ГХБХБГ, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 330 сумын газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Иргэд, хуулийн этгээд газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтад байршил харгалзахгүй оролцож, олон шат дамжлагагүй, түргэн, шуурхай үйлчилгээг авах боломжтой болсон. 2020 оны байдлаар Газрын биржийн цахим системд нийт 6746 газрын дуудлага худалдаа, 431 газрын эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 19425 газрын барьцаа, 36699 газрын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэдээг бүртгэсэн байна. Газрын өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаас жилд дунджаар 4 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрдөг байсан бол тус системийг хэрэглээнд нэвтрүүлснээс хойш жил бүр нэмэгдэж, 2020 оны жилийн эцсийн байдлаар 10.5 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрсөн байна.

Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба нь иргэн, хуулийн этгээдийн эзэмшил, өмчлөлийн газрыг улсын шинж чанартай томоохон бүтээн байгуулалт болон нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн эргүүлэн авч, нийслэлийн Засаг даргын захирамжаар нөхөх олговор олгож, газар чөлөөлөх үйл ажиллагааг хариуцан ажилладаг. 2017-2020 онд нийт 277 бүтээн байгуулалтын ажил хэрэгжиж, эдгээр ажлын нөхөх олговорт 106.5 тэрбум төгрөг зарцуулсан байна (Хүснэгт 24-г үзнэ үү).

**Хүснэгт 24. Нөхөх олговорт олгосон хөрөнгийн хэмжээ (2017-2020 оноор)**

Хугацаа	Бүтээн байгуулалтын ажлын тоо	Нөхөх олговорт олгосон хөрөнгийн хэмжээ (тэрбум төг)
2017	79	10

2018	105	47.7
2019	53	26.0
2020	40	22.8
Нийт дүн	277	106.5

Эх сурвалж: ГЗБГЗЗГ

2020 оны байдлаар газрын харилцааны салбарт нийт 1083 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр жил бүр сургалт, семинар зохион байгуулж байна. Тухайлбал, 2017 онд “Газрын тогтвортой менежмент ба нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө” сэдэвт сургалт, 2018 онд “Аймаг, нийслэл, хотын ерөнхий архитекторын сургалт”, 2019 онд “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг улсын хэмжээнд нэвтрүүлэх” ажлын хүрээнд “Arcgis Desktop”, “ArcGis Pro” болон “Урбан менежер” программ хангамжийн чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтыг тус тус зохион байгуулсан байна. Мөн газрын төлбөр, татварын системийн чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулж, 21 аймгийн ГХБХБГ, нийслэл, дүүргүүдийн Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтнүүд, сумын газрын даамлууд хамрагдаж, давхардсан тоогоор нийт 166 мэргэжилтнийг хамарсан байна. 2020 онд 21 аймгийн хэмжээнд хот, суурин, ойн сан, газар тариалан, усны сан, бэлчээр зэрэг газрын нэгдмэл сангийн ангиллаар газар ашиглалтын мониторинг хийх цэгүүдийг аймаг тус бүрээр тодорхойлж, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийг чадавхижуулах, мэргэжил, арга зүйгээр хангах цахим сургалтыг “Zoom” програм ашиглан зохион байгуулсан.

### **2.3.2.7.Бүс, орон нутгийн захиргааны санхүүгийн төлөвлөлт ба менежментийг бэхжүүлэх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 149 дэх хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна”, мөн “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Төсвийн нэгдмэл байдлыг ханган, төсвөөс гадуурх санхүүжилтийг зогсоож, хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар үр ашгийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн.


Нийслэл, аймаг, сум, дүүргийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болон тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх зардал болох төсвийг батлах, хэрэгжүүлэх хугацаанд захиран зарцуулах төсвийг батлах, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлах зэргээр нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх, үүргийг тодорхойлж өгснөөр төвлөрлийг сааруулах чухал алхам болж, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэхийн тулд хууль эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, орон нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтнуудын чадавхыг сайжруулах ажлуудыг хэрэгжүүлж байна.

СЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн хүрээнд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сургалтыг 2015 оноос хойш зохион байгуулж, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, үр ашиг, тулгамдсан болон цаашид хэрэгжүүлэх, анхаарах асуудал, мөн Монгол Улсын төсвийн тухай хуулиар тухайн жил батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаарх аргачлал, арга зүйг таниулан сурталчилж, чадавхыг бэхжүүлж байна. Тухайлбал, 2020 онд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалтыг улсын төсвийн хөрөнгө оруулалтын

мэдээллийн [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) системээр дамжуулан анх удаа цахимаар зохион байгуулж, 21 аймаг, нийслэл, агентлаг болон яамдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт болон тайлагналт хариуцсан 180 гаруй албан хаагчийг хамарсан.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, Олон улсын валютын сангийн хамтран хэрэгжүүлж байгаа “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд СЯ “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлал”-ыг анх удаа боловсруулж, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан. Уг аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2019 онд зохион байгуулсан сургалт, семинар, хэлэлцүүлэгт яам, агентлаг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт хариуцсан 170 гаруй албан хаагч хамрагдсан байна.

Зураг 16. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг” сэдэвт сургалт



Орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор хууль эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах, орон нутгийн төр, захиргааны байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд 21 аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, мэргэжилтэн, сумдын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, ОНХС хариуцсан мэргэжилтэн, аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн, аймгийн чадавх бэхжүүлэх багийн төлөөлөл болох нийт 1043 албан хаагчийг хамруулсан

Зураг 17. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн гарын авлага



сургалтыг 2018 онд СЯ-наас үе шаттайгаар зохион байгуулсан.

Нийслэл Улаанбаатар хотын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл явцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл эрэмбэлэх үйл ажиллагаатай нэгтгэн, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг харгалзан үздэг болгох, уг үйл явцын ил тод, бодитой байдлыг нэмэгдүүлэн, нийслэл хотын санхүүгийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын гарын авлага”-ыг 2018 онд ДБ-ны техникийн туслалцааны хүрээнд боловсруулсан. Тус гарын авлагыг

Улаанбаатар хотын засаг захиргаанд хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар практик зөвлөмжүүдийг нэгтгэн, нийслэл, дүүргийн шат шатны бүх төрийн байгууллагуудын шийдвэр гаргагч удирдлагууд болон мэргэжилтнүүдэд зориулсан.

### **2.3.2.8. Хот байгуулалтын тогтвортой хөгжлийн тусын тулд шинжлэх ухаан, технологи, инновацын талаарх мэдлэг солилцох хамтын ажиллагааг нэмэгдүүлэх**

Дараагийн шатны тайланд тусгах болно.

### **2.3.3. Мэдээллийн Технологи ба Инноваци**

#### **2.3.3.1. Цахим засаглал болон хүн төвтэй тоон засаглалын арга хэрэгслэлийг ашиглан хэрэглэхэд хялбар, оролцоонд тулгуурласан өгөгдөл болон програм хангамжийг хөгжүүлэх**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 160 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд “Цахим засгийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах”, Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2025”-ын баримт бичигт “төрийн байгууллагын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацийг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох замаар цахим засаглалыг хөгжүүлнэ” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улс 2005-2016 оны хугацаанд “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”, “Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”, “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. “Цахим Монгол үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээг салгах, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг үүсгэн байгуулах, цахилгаан холбооны салбарыг либералчлах, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлэх, мэдээлэл холбооны сүлжээг олон улсын интернэтийн урсгалд холбох, бүх нийтийг компьютержүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Монгол Улсын интернэтийн гадаад гарцын багтаамж 2005 онд 78Мбит/с, интернэт хэрэглэгч 22000, өргөн зурвасын шилэн кабелийн урт 3251 км, үүрэн холбооны хэрэглэгч 551000 байсан бол 2012 онд интернэтийн гадаад гарцын багтаамж 22Гбит/с, интернэт хэрэглэгч 654009, өргөн зурвасын шилэн кабелийн урт 18123.8 км, үүрэн холбооны хэрэглэгч 3409005 болж өсчээ. 2020 оны байдлаар гадаад гарцын багтаамж 45Гбит/с, интернэт хэрэглэгч 3579800, өргөн зурвасын шилэн кабелийн урт 18156 км, үүрэн холбооны хэрэглэгч 4363900 болоод байна. “Бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Үндэсний дата төв”-ийг байгуулан иргэний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг төгөлдөржүүлж, хөрөнгийн арилжаа солилцоог баталгаажуулан бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамрагдах төрийн байгууллагын бүртгэл, мэдээллийн сан, системийг шинэчилсэн. 2010 оноос эхлэн улс даяар иргэний шинэчилсэн бүртгэлийг эхлүүлж, иргэдэд цахим иргэний үнэмлэх олгосон. “Цахим засаг үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд мэдээллийн систем, мэдээллийн санг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдийн өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр авч

шийдвэрлэх, төрийн үйлчилгээг ТҮЦ машинаар дамжуулан иргэдэд хүргэх, гамшгийн аюулыг урьдчилан мэдээлэх, шилэн данс, нэмэгдсэн өртгийн албан татварын систем хөгжүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой төрийн үйлчилгээг тодорхойлж, 25 үйлчилгээг Төрийн үйлчилгээний цахим машинаар, иргэдийн зүгээс хамгийн их хүндрэл, чирэгдэлтэй гэж үзсэн 18 үйлчилгээг цахим хэлбэрээр төрийн үйлчилгээний нэгдсэн портал болох [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) цахим хуудсаар хүргэж байна. ТҮЦ машины үйлчилгээг нэвтрүүлснээр давхардсан тоогоор 2018 онд 2.2 сая иргэн үйлчлүүлж, нэг үйлчилгээ авахад 1 цаг 40 минут хэмнэсэн байна. Цаашид цахим засаглалыг хөгжүүлэх хатуу болон зөөлөн дэд бүтцийг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй зохион байгуулж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн бүтэн, нэгдмэл, аюулгүй байдлыг хангаж, нээлттэй өгөгдлийн сан үүсгэж, хэрэглээг дэмжих, төрийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн цахим оролцоог хангах, хүний хөгжлийг дэмжиж, ухаалаг төхөөрөмж ашиглан орон зай, цаг хугацаанаас үл хамааран цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эдийн засаг, нийгмийн салбарт мэдээллийн технологийн дэвшлийг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй нэвтрүүлж, тунгалаг, өрсөлдөх чадвартай, өндөр бүтээмж бүхий хариуцлагатай төрийг бий болгох зорилгоор иргэн төвтэй цахим засаглалыг хөгжүүлэхээр Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор “Цахим засаглал үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудаас дурьдахад: цахим засаглалыг хөгжүүлэх удирдлагын тогтолцоо, зохион байгуулалтыг боловсронгуй болгох; төрийн мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөх; төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг сайжруулан хөгжүүлэх; цахим төлбөр тооцооны нэгдсэн системийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системтэй холбох; төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх бизнес процессын ре-инженеринг хийх; үйлчилгээний нэгдсэн төвийг операторын горимд шилжүүлэн төрийн зарим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн тоог нэмэгдүүлэх; төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайтыг боловсронгуй болгох; хөдөлгөөнт холбооны технологи ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх; төрөөс цахим хэлбэрээр иргэнд хүргэх үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх; төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлэх; төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

Манай улсын цахим хөгжлийн индекс дэлхийн дунджаас дээш гарч чадахгүй, зарим жил буурах хандлагатай байна. Энэ нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны захирамжаар “Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл” байгуулж, даргаар нь Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргыг томилсон. Тус зөвлөл төрийн үйлчилгээг иргэн төвтэй, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлэх, цахим шилжилттэй холбоотой зорилтыг хэрэгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, мэдээллийн технологийн аж ахуйн нэгжүүдийг дэмжих чиглэлээр ажиллаж байна.

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттайгаар нэвтрүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүн сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд “Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл”-ийг үндэслэн “Үндэсний Дата Төв” УТҮГ-т төрийн гэрчилгээжүүлэгч байгууллагын үүргийг олгож, төрийн байгууллагуудтай

бүртгэлийн нэгжийн гэрээ байгуулан тоон гарын үсэг авах боломжийг бүрдүүлж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтэрч эхэлсэн.

2017 оноос “Хур” төрийн мэдээлэл солилцооны системийг хөгжүүлж, тус системд нийт 74 вэб сервисийг хөгжүүлж, 29 төрийн байгууллага, 19 хувийн хэвшлийн байгууллага холбогдон мэдээлэл солилцож байна. Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолоор төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох 176 төрийн үйлчилгээний жагсаалт, төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх 320 төрийн үйлчилгээний жагсаалтыг баталсан. Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарлаж, төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд шуурхай хүрч ажиллах зорилтыг дэвшүүлсэн. Тус зорилтын хүрээнд цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг бүрэн холбож, 320 орчим төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар үзүүлэн, шуурхай, цаасгүй, нээлттэй, хүнд сурталгүй төрийн үйлчилгээг бий болгохоор ажиллаж байна. Тухайлбал, Цахим засаглалыг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний цогц бодлогын баримт бичиг болох “E- MONGOLIA хөтөлбөр”-ийн хүрээнд газрын харилцаатай холбоотой төрийн бүх үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах, иргэн, хуулийн этгээдийн гарт нэг цонхоор хүргэх зорилготой газрын удирдлагын цахим систем буюу гар утасны аппликэйшнийг хөгжүүлж, нийтийн хэрэглээнд нэвтрүүлсэн. (<https://e-mongolia.mn/home>; <http://www.e-mongolia.mn/>; <https://www.facebook.com/emongolia>)

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас (хуучин нэрээр) гаргасан судалгаагаар, 2019 оны байдлаар Монгол Улсад үүрэн холбооны хэрэглэгч давхардсан тоогоор 3.8 сая байгаагаас ухаалаг утас хэрэглэгч 2.4 сая, харин интернэт хэрэглэгч 2.9 сая байна. Монгол Улсад 2019 оны байдлаар, фэйсбүүк хэрэглэгчдийн тоо 2.2 сая байгаагаас гар утсаараа холбогддог 2.1 сая хэрэглэгч байна. Энэ нь Монгол Улсын 3.3 сая хүн амтай харьцуулахад маш өндөр тоо юм.

Манай улсын 2016 онд нэвтрүүлсэн “E-barimt” цахим татварын системийг өнөөгийн байдлаар 1.7 сая хүн ашиглаж, өдөрт 500 мянган хүн тогтмол нэвтэрдэг гэсэн судалгаа байна. Өөрөөр хэлбэл, манай улсын насанд хүрсэн 2.1 сая хүний 85 орчим хувь нь цахим татварын систем ашигладаг гэсэн үг. Энэ нь монголчууд төрийн үйлчилгээг хэдийн цахимаар авах боломжтой болсныг илтгэнэ. Иргэд өнөөдрийг хүртэл төрийн үйлчилгээг цахимаар ашиглах идэвх, оролцоо өндөр байна. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар буюу үйлчилгээ нээлтээ хийснээс хойш 2 сарын дотор “E- MONGOLIA” цахим үйлчилгээний нэгдсэн системээс 250 мянга орчим хэрэглэгч төрийн үйлчилгээг цахимаар авсан бөгөөд зөвхөн нэг өдрийн статистикаар 4957 иргэн тус нэгдсэн системээс цахимаар үйлчилгээ авсан байна. Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын хөл хорионы үед иргэд төрийн үйлчилгээг цахимаар авч, иргэний үнэмлэх, гадаад паспорт болон жолооны үнэмлэх зэрэг захиалсан бичиг баримтаа шуудангаар гэртээ хүргүүлэн авсан байна.

Цахим засаглалыг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний цогц бодлогын баримт бичиг болох “E- MONGOLIA хөтөлбөр”-ийн хүрээнд газрын харилцаатай холбоотой төрийн бүх үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулах, иргэн, хуулийн этгээдийн гарт нэг цонхоор хүргэх зорилготой газрын удирдлагын цахим систем буюу гар утасны аппликэйшнийг хөгжүүлж, нийтийн хэрэглээнд нэвтрүүлсэн. Ингэснээр иргэн, аж ахуй нэгж газартай холбоотой эхний ээлжинд 8 төрлийн үйлчилгээг 2 минутын дотор авах боломж бүрдсэн байна.



### **2.3.3.2. Хот, суурин болон бүс нутгуудын хөгжил цэцэглэлтийг жигд бэхжүүлэх хүрээнд тэргүүлэх технологи болон инновацын ашиглалтыг өргөтгөх**

Дараагийн шатны тайланд тусгах болно.

### **2.3.3.3. Газар зүйн мэдээллийн систем (ГМС) зэрэг цахим арга хэрэгслийг хот, суурин болон газар нутгийн төлөвлөлт, газар ашиглалт, хотын суурь үйлчилгээг сайжруулахад ашиглах**

“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн 156, 157 дахь хэсэгт заасан зорилгын хүрээнд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “...үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах...”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулна”, Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025)”-ын баримт бичигт “гео орон зайн мэдээллийн дэд бүтцийг ашиглан төрийн байгууллага, иргэдэд үнэн зөв, нарийвчлалтай мэдээлэлд үндэслэсэн орон зайн дүн шинжилгээ, ухаалаг төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлнэ”, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д “Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх”, Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ын баримт бичигт “барилгын салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд тулгуурлан газрын харилцааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх” гэсэн зорилтыг тус тус дэвшүүлэн хэрэгжүүлж байна.


Мэдээллийн технологи хөгжихийн хэрээр их өгөгдөл (big data), нээлттэй өгөгдөл (open data), геопортал зэрэг их хэмжээний мэдээлэл агуулсан дэд бүтцийг бий болгох нөхцөл бүрдсэн. Дэлхийн банкнаас 2019 онд хийсэн судалгаагаар манай улс орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулан ашиглавал эхний 2 жилд орлого зарлагаасаа бага, түүнээс цааш 10 жилийн хугацаанд 2.6 дахин их үр ашиг хүртэнэ гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

2018 онд АНУ-ын Нью-Йорк хотод зохион байгуулсан НҮБ-ын Орон зайн мэдээллийн менежментийн Зөвлөхүүдийн хорооны наймдугаар хурлаар “Орон зайн мэдээллийн нэгдсэн хүрээ”-г баталсан. Энэхүү баримт бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Зөвлөхүүдийн хорооноос “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын орон зайн мэдээллийн менежментийн чадавхыг бэхжүүлэх” төслийг Африк, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж буй 6 улсыг сонгож, үүнд Монгол Улсыг сонгосон нь манай улсын үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн мэдээллийн хэрэглээг өргөжүүлэх ажлын эхлэл болсон юм.

“Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад орон зайн өгөгдлийн дэд бүтцийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдол” сэдэвт олон улсын зөвлөгөөнийг 2018 онд Улаанбаатар хотод зохион байгуулж, НҮБ-аас орон зайн мэдээллийн 14 суурь өгөгдлийн жагсаалтын дагуу орон зайн өгөгдөл, мэдээллийг ангилан тодорхойлох ажлыг хийж байна. Түүнчлэн, үндэсний хэмжээний орон зайн суурь өгөгдөл, мэдээллийн санг нэгдсэн стандартын дагуу нэгтгэж, геопорталаар дамжуулан веб үйлчилгээг тогтмол хэрэглээнд нэвтрүүлж, НҮБ-ын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн Зөвлөхүүдийн хороотой хамтран “Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөгжиж буй орнуудын орон зайн мэдээллийн менежментийн чадавхийг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж байна.

“Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 онд Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг баталсан. Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахтай холбоотой 18 стандартыг шинээр батлан мөрдөж байна. Үндэсний ГЕОПОРТАЛ цахим системийг бий болгож, байгууллага хоорондын уялдаа холбоог ханган, нэгдсэн стандартын дагуу орон зайн өгөгдлийг бүрдүүлж ашигласнаар төсвийн давхардал, мэдээллийн шинэлэг, баталгаатай байдал хангагдсан. ГЗБГЗЗГ-аас геодезийн тулгуур сүлжээ, байр зүйн зураг, хил зааг, хаяг, барилга, суурин, өндөр, гүн, газарзүйн нэр, газар ашиглалт, газрын бүрхэвч, нэгж талбар, дэд бүтэц, тээврийн сүлжээ, ус зүй, орто зураг, хөрс, геологи, түүх, соёлын өв зэрэг 18 суурь орон зайн өгөгдлийг тодорхойлсон. Орон зайн өгөгдөл, мэдээллийн агуулга, нууцлалын зэрэг, ач холбогдлоос хамааран хандах эрхийн төрөл харилцан адилгүй нээлттэй, төлбөртэй, хаалттай гэсэн 3 төрөлтэй байхаар зохицуулсан бөгөөд орон зайн мэдээллийг харах (ГМС үйлчилгээ), серверт хандаж хэрэглэх (харах, нэмэх, өөрчлөх, устгах), татаж авах (Системээс нээлттэй тавигдсан мэдээллийг зөвшөөрлийн дагуу татаж авах) гэсэн төрлийг ашиглаж байна (Зураг 18-г үзнэ үү).

Зураг 18. Геопорталын өгөгдлийн харагдах байдал




Эх сурвалж: [nsdi.gov.mn](http://nsdi.gov.mn)

2017 онд Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн нэг дэд сан болох “Нийгэм, эдийн засгийн мэдээллийн сан”-г нийгэм, эдийн засгийн 27 салбарын 642 үндсэн үзүүлэлтийн 2532 утга бүхий дэд үзүүлэлтүүдээс бүрдсэн мэдээллүүд, орон зайн өгөгдөлтэй буюу зурагтай холбогдох, төрийн байгууллагууд мэдээллийн санд мэдээллээ оруулах болон байнга шинэчлэх, цаг хугацаа, орон зай хамаарахгүй онлайн хандалттай байх, төрийн бүх шатны байгууллага дундаа ашиглах онцлогтой уг мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг дуусгаж, геопортал <https://geoportals.ndi.gov.mn> сайтаар дамжуулан иргэд, олон нийтэд нээлттэй ашиглаж болохоор вэб аппликейшнийг хөгжүүлж эхэлсэн. Мөн “Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн систем”-ийг 21 аймаг, 330 сумын хэмжээнд амжилттай нэвтрүүлснээр

“Газрын кадастрын мэдээллийн сан”-гийн цахим системийг бүрдүүлж, олон нийтэд ашиглах боломжтойгоор үйлчилгээнд гаргасан (Зураг 19-г үзнэ үү). Тус онд ГЗБГЗЗГ-аас нийслэлийн Газрын алба, 9 дүүргийн Газрын алба, 21 аймгийн ГХБХБГ-тай шилэн кабель ашиглан тусгайлсан холболт, (VPN)-ыг хийж, өндөр хурдны интернет үйлчилгээг нэвтрүүлсэн. 330 сум, суурин газрын даамлыг гэр интернет төхөөрөмж ашиглан тусгайлсан холболт (VPN)-ыг үүсгэж, салбарын хэмжээнд нэгдсэн нэг сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлсэнээр олон төрлийн системд сум, дүүргээс шууд хандаж, өгөгдөл, мэдээллийг аюулгүй шинэчлэх боломжтой болсон.

Хот байгуулалтын салбарын хөгжлийг хурдасгах, хот төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй хийхэд шаардлагатай мэдээллээр хангах, байрлалд суурилсан орон зайн болон орон зайн бус өгөгдлийг ашиглах боломжийг бүрдүүлэх, иргэд, олон нийтийг хот төлөвлөлт, хот байгуулалтын сүүлийн үеийн мэдээ, мэдээллээр хангах зорилгоор БХБЯ, ГЗБГЗЗГ 2019 оноос “”-програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж байна. цахим хуудсаар дамжуулан барилга байгууламж барих зөвшөөрөл хүсэж буй иргэн, хуулийн этгээд хүсэлт гаргахаас эхлээд барилга байгууламж ашиглалтад өгөх хүртэлх бүхий л үйл ажиллагааны явцыг цаг алдалгүй хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох боломж бүрдсэн.


Зураг 19. Газрын мэдээллийн сангийн харагдах байдал



Эх сурвалж: egazar.gov.mn

Орон зайн мэдээллийн системд суурилсан “Хот байгуулалтын дундын мэдээллийн сан” нь төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулан, нийслэлийн харьяа байгууллагуудын төрөл бүрийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, иргэд, олон нийтэд нээлттэй мэдээ, мэдээллээр хангах боломжийг бүрдүүлсэн систем юм. Орон зайн мэдээллийн системд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн сан байгуулах төслийг НЗДТГ, НМТГ, нийслэлийн нутгийн захиргааны 26 байгууллагатай хамтарч хэрэгжүүлсэн (Зураг 20-г үзнэ үү). 2017-2018 онд нийслэлийн хэмжээний мэдээллийг нэгтгэх ажил хийгдсэн бөгөөд Улаанбаатар хотын физик газарзүйн мэдээлэл, нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд, инженерийн байгууламжийн мэдээллийг нийслэлийн орон зайн дундын мэдээллийн сантай холбон өргөжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.

## Зураг 20. Нийслэлийн Хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн харагдах байдал



Эх сурвалж: <https://dms-ulaanbaatar.opendata.arcgis.com/>

Мөн олон нийтэд нээлттэй (opendata) өгөгдлийг онлайнд байршуулж, шаардлагатай мэдээллийг ашиглах боломжтой 54-н аппликейшн гаргасан. Тухайлбал, нийслэлийн газрын усан сан бүхий газар, хөв, цөөрөм, нуур, рашаан, булаг, голын энгийн болон онцгой хамгаалалтын бүс, усан сангийн хориглолтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар, Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газрын олон нийтэд нээлттэй өгөгдлийг вебэд суурилсан аппликейшн нэвтрүүлсэн.

“Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол гарснаар газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын хяналтын үндэсний мониторингийн сүлжээ, газрын бирж, газрын үнэлгээ, төлбөр, татвар хураамж, газрын кадастрын бүртгэл цахимд шилжих үндсэн нөхцөл бүрдэж, төрийн үйлчилгээг иргэдэд цаг хугацаа, орон зай хамаарахгүй үзүүлэх боломжтой болсон. Улсын хэмжээнд ажиллах вебэд суурилсан “Газар зохион байгуулалтын болон хот байгуулалтын”, “Газрын цахим биржийн”, “Газрын үнэлгээ, татвар, төлбөрийн КАМА”, “Газрын кадастрын нэгдсэн мэдээллийн”, “Улсын газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээний”, цахим мэдээллийн системийг хөгжүүлж, тэдгээрийг “ХУР”, “ДАН” системд холбон хэрэглэж байна.

### 2.3.3.4. Засгийн газрын бүхий л түвшинд хот байгуулалтын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй хянах чадавхыг бүрдүүлэх


Дараагийн шатны тайланд тусгах болно.

### 2.3.3.5. Засгийн газрын бүхий л түвшинд болон иргэний нийгмийн байгууллагын тоон мэдээлэл цуглуулах, ялган ангилах, дүн шинжилгээ хийх явцыг бэхжүүлэх

2017 онд ҮСХ-ноос “Тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх гарын авлага”-ыг боловсруулсан<sup>17</sup>. Гарын авлагын үндсэн зорилго нь орон нутгийн статистикийн болон хөгжлийн бодлого хариуцсан ажилтнуудын тоон мэдээллийн шинж чанар, түүврийн үндсэн зарчим, тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн энгийн арга хэрэгслийг ашиглах чадавхийг сайжруулахад чиглэгдсэн. Тус гарын авлагад тоон мэдээлэл цуглуулах, түүнийг ашиглах арга замууд, тоон мэдээллийг хэрхэн ашиглах, тоон мэдээлэлд үндэслэн ямар мэдээллийг гаргаж болох, тухайн мэдээллийг боловсруулах аргуудаас цаг хугацаа хэмнэсэн хамгийн тохиромжтойг хэрхэн сонгох, цуглуулсан тоон мэдээллийг боловсруулж, түүнд үндэслэн шаардлагатай мэдээллийг гаргах талаар тусгасан.

Түүнчлэн, ҮСХ нь “Үндэсний дата төв” (ҮДТ)-ийн “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн системийг ашиглан тоон гарын үсэг, гар утасны дугаар, үндэсний цахим шуудангаар дамжуулан систем хөгжүүлэх техникийн тохиргоо, дэд кодчиллыг хийсэн. Энэхүү системийн /registration.nso.mn/ “Хүн ам, өрхийн мэдээлэл”-ийг иргэн өөрөө шалгахар хөгжүүлсэн.

Зураг 21. ТХЗ-ын шалгуур үзүүлэлтийн мэдээлэл



Эх сурвалж: <https://www.1212.mn>

Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ)-ын хэрэгжилтийг дүгнэх 247 үзүүлэлт тодорхойлсноос манай улсад хамаарах 233 үзүүлэлтээс 132 үзүүлэлтийг тооцож, ТХЗ-ын хэрэгжилтийг хянах нэгдсэн систем (sdg.gov.mn)-ийг баяжуулсан.

2020 онд Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn -д тооллого 54, судалгаа 112, жилийн эмхэтгэл 21, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга 26, Статистикийн 1960-2000 оны эмхэтгэл, ном, сэтгүүл зэрэг нийт 324 материалыг байршуулж, тархаасан.

Тооллого, судалгаа болон албан ёсны статистикийн мэдээллийг цуглуулах, боловсруулах үйл ажиллагаанд мэдээллийн технологийг өргөнөөр ашиглаж, 11 програмыг шинээр, 10 програмд нэмэлт засвар, өөрчлөлтийг хийсэн байна. Статистикийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (SPS)-ийн системийн тусламжтайгаар утсаар ярилцлага хийх арга (CATI)

<sup>17</sup> www.nso.mn

модулийг ашиглан утсаар судалгаа авах боломжийг бүрдүүлж, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС+2020)-ны мэдээлэл цуглуулалтыг анх удаа утсаар авч, судалгааг амжилттай явуулсан.

Дэлхийн банкны “Ухаалаг засаг төсөл”-ийн хүрээнд 6 сервер компьютер, 1 нөөцлөх сервер (storage server), 41 сүлжээний төхөөрөмж (san switch, managed switch), 33 firewall төхөөрөмжийг худалдан авч, сервер бэлтгэн зохион байгуулалт, хаягийн тохиргоог хийж, суурилуулан, орон нутгийн статистикийн хэлтсүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХЯНАЛТ**

### **3.1. “ХОТЖИЛТЫН ШИНЭ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЧИГЛЭЛЭЭР БОЛОВСРУУЛСАН ТОГТОЛЦОО, БОДЛОГО, АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛЫГ ТАЙЛБАРЛАХ**

Манай улс “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ыг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-аас 2016 онд баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилго, зорилтуудыг Засгийн газар, нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нар, аж ахуйн нэгж, байгууллагууд, ТББ-ууд үйл ажиллагааныхаа хөтөлбөр, үндсэн чиглэл, арга хэмжээний төлөвлөгөө, төсөл, хөтөлбөртөө тусган иргэд, олон нийтийн оролцоотойгоор хамтран хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хянах, тайлагнах чиглэлээр боловсруулсан тодорхой тогтолцоо, бодлого, арга зүй, аргачлал байхгүй байна.

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 87 дугаар тушаалаар байгуулсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланг боловсруулахад мэдээлэл, судалгаа, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсэг болон энэхүү үндэсний тайланг боловсруулсан Зөвлөх багийн гишүүдээс гарсан саналын дагуу цаашид олон улсын туршлагад үндэслэн олон талын оролцоог хангасан, Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөс үл хамаарсан ТББ-ыг байгуулж, “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг сурталчлах, дараагийн шатны хэрэгжилтийн явцын тайланг боловсруулах, “Хот байгуулалтын үндэсний форум”-ыг зохион байгуулан холбогдох талууд болон иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, олон нийтэд зориулсан цахим мэдээллийг нээлттэй, ил тод ажиллуулах зэрэг ажлыг хариуцуулах саналтай байна. Иймд тус ТББ-ыг байгуулан, 2 жил тутамд зохион байгуулдаг “Хот байгуулалтын үндэсний форум”-аар “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын үндэсний тайланг хэлэлцүүлж, оролцоог үндэсний, бүсийн, орон нутгийн зэрэг бүх түвшинд хангаж байхаар тус ажлын хэсгээс санал гаргаад байна.

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийн 3-т “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгох”, 4-т “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, УИХ-ын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх”, мөн 3 дахь хэсэгт “Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай” гэж тус тус заасан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолыг үндэслэн “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталж, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичиг батлагдсантай холбогдуулан 2020 оны 206 дугаар тогтоолоор тус журмыг шинэчилж батлан мөрдөж байна. Тус журамд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа, төрөл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байгууллага, тайлан хүлээн авах байгууллага, тайлагнах байгууллага, хугацаа, давтамжийг нарийвчлан зохицуулсан.

Иймд “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн зорилго, зорилтуудыг Засгийн газар болон нийслэл, аймаг, сум, дүүргийн Засаг дарга нар, аж ахуйн нэгж, байгууллагууд, ТББ-ууд үйл ажиллагааныхаа хөтөлбөр, үндсэн чиглэл, арга хэмжээний төлөвлөгөө, төсөл, хөтөлбөртөө тусган баталж, дээрх хууль тогтоомж, журмын хүрээнд хэрэгжилтийг хянах, тайлагнах ажлыг зохион байгуулах боломжтой гэж үзэж байна. Манай улсад “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”, “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд тулгарч буй хөгжлийн олон тулгамдсан асуудлыг салбар дундын уялдаа, зохицуулалт, олон талын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх явдал чухал ач холбогдолтой юм.

Цаашид “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг өөрийн улсын хот, суурин газрын түвшинд гаргах талаар холбогдох талууд илүү анхаарч хамтран ажиллах шаардлагатай байна. Тухайлбал, олон улсын туршлагыг судлан БХБЯ, ГЗБГЗЗГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ, 21 аймгийн ГХБХБГ болон нийслэлийн ХБХГ, ГЗБГ зэрэг болон холбогдох бусад байгууллагууд хот, суурин газруудтай холбоотой статистик үзүүлэлтүүдийг гаргаж байх, шалгуур үзүүлэлтийн дагуу нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг ТББ-аас хэрэгжүүлж, тогтмол ажиллуулах арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй байна.



## САЙН ТУРШЛАГА

### 1.1.1.2.Боломж, үр ашгийг тэгш хүртэхийг дэмжих замаар хот, суурин газар дахь тэгш бус байдлыг бууруулах

Ногоон эдийн засаг нь нийгмийн бүхий л давхаргын хүмүүс, ялангуяа нийгмээс гадуурхагддаг бүлэг хүмүүсийн дуу хоолойг шийдвэр гаргалтад тусгах явдлыг нэн тэргүүнд тавьдаг. “Ногоон эдийн засгийн холбоо”-ны Монгол Улс дахь гишүүн байгууллага болох “Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв”-ийн зүгээс ядуу иргэд, ажилчид, албан бус бизнес эрхлэгчдийн дуу хоолойг бодлого боловсруулагчдад хүргэх зорилгоор “Бидний оролцоот шийдэл” аяныг 2018 оноос эхлэн амжилттай зохион байгуулж байгаа нь үндэсний хэмжээнд сайн туршлага болж байна.

Тус аяны хүрээнд гэр хорооллын иргэдэд тулгарч буй асуудлыг тодорхойлох, хөршийн холбоог сайжруулах, хөршүүд хамтарснаар олон асуудлыг шийдэх боломжтойг харуулсан бодит туршлагыг бий болгож, бодлого боловсруулагчидтай хамтран ажиллахаар зорьж байна.Тухайлбал, 2018 онд нийслэлийн Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны 54 өрхийг хамруулан чөлөөт ярилцлагын арга ашиглан иргэдэд тулгарч буй асуудлуудыг нэгтгэн зураглал бий болгож, түүнээс асуудлуудын шалтгаан, үр дагавар, хоорондын харилцан уялдаа зэргийг тодорхойлсон.



Веб сайт:

<https://ecrc.mn/>

<https://www.nogoonhutuch.mn/a/82>

<https://www.facebook.com/Ursulduhchadvar/>

<http://www.aimagindex.mn/>

#### 1.1.1.4.Гудамж, явган хүний зам, унадаг дугуйн зам зэрэг нийтийн эзэмшлийн орон зайг ашиглах боломжийг бататгах (Зарим жишээг дурьдав)

##### Завхан аймгийн төв Улиастай хот

Завхан аймгийн төв Улиастай хотод хэрэгжүүлсэн “Гудамж” төслийн хүрээнд Яруугийн гудамжны дагуу мод тарьж, зүлэгжүүлэн тохижуулж, мөн Богдын гол багийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарьж, зүлэгжүүлсэн байна.




##### Өвөрхангай аймгийн төв Арвайхээр хот



Өвөрхангай аймгийн ИТХ-ын 2018 оны 4 дүгээр тогтоолоор 2019 оныг “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ээр зарлан ажилласан. Аймгийн Засаг даргын шийдвэрээр “Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жил”-ийн ажлыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хороог байгуулж, ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн байна. Энэ хугацаанд 13 төрлийн 79300 мод, бутыг шинээр тарьж, ургуулсаны үр дүнд аймгийн хэмжээнд төв, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ нэг жилийн хугацаанд 13.8 га-гаар нэмэгджээ. Энэ нь 2016 оны суурь түвшингээс 40 хувиар өссөн үзүүлэлт юм. Аймгийн төвд Дэлгэрэх гол дагуу 8.7 га талбайд “Хунбобса” “Дэлгэрэх гарден”, “Ногоон төгөл” цэцэрлэгт хүрээлэнгүүд, мөн

Хархорин суманд Хөдөлмөрийн баатар Л.Гомбосүрэнгийн нэрэмжит, Богд суманд “Арц гурван богдын мөнхийн шүтээн” зэрэг цэцэрлэгт хүрээлэнг байгуулж, Баянгол, Тарагт, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл сумын Баянтээг багт бичил цэцэрлэгт хүрээлэн, Хужирт, Баруунбаян-Улаан, Хайрхандулаан, Баянгол сумдад шинээр цэцэрлэгт гудамжийг тус тус байгуулсан.

### Т.Намнансүрэнгийн гудамж




“Хунбобса” цэцэрлэгт хүрээлэн



2018-2019 онд “Орон нутгийн хөгжлийн сан”-гийн хөрөнгө оруулалтаар багийн иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, гэр хороололд хүүхдийн тоглоомын талбайнуудыг шинээр байгуулж тохижуулсан.

## Гэр хороололд байгуулсан хүүхдийн тоглоомын талбай



Веб сайт:

<https://fliphtml5.com/cwftv/pquv/basic>

### 1.1.2.1. Шаардлага хангасан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах

Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд бий болсон түрээсийн орон сууцыг дамжуулан түрээслэх, түрээсийн орон сууцыг өмчлүүлэхтэй холбоотой журамд зааснаас өөр бусад хэлбэрээр бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалахыг хориглосон зохицуулалтыг нэмж, “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”-ыг баталсан. Тус журамд залуу гэр бүл, төрийн албан хаагч, хувийн байгууллагын ажиллагсад, 0-18 насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эрэгтэй, эмэгтэй, өндөр насны тэтгэвэр тогтоосон ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байгалийн гамшигт нэрвэгдсэн иргэдэд түрээсийн орон сууцанд хамрагдах квотыг Улаанбаатар хот, орон нутагт гэж ангилан тусгасан.

Засгийн газрын 2019 оны 216 дугаар тогтоолоор түрээслэгч нь түрээсийн төлбөрөөс гадна түрээсэлж буй улс, орон нутгийн төсөв, “Орон нутгийг хөгжүүлэх сан”-гийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 5 хүртэлх жилийн хугацаанд, гадаад, дотоодын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан орон сууцны үнийг 15 хүртэлх жилийн хугацаанд сар бүр хуваарийн дагуу хэсэгчлэн төлж, түрээсийн орон сууцаа худалдан авч өмчлөх зохицуулалтыг шинээр тусган хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотод “Хангай” хотхоны 223 айлын, “Буянт-Ухаа-2” хорооллын 564 айлын орон сууц ашиглалтад орсны 44 хувийг түрээслэхээр, 56 хувийг түрээслэн өмчлөхөөр, Дархан-Уул, Увс, Ховд, Архангай, Хэнтий, Сэлэнгэ аймгийн төвүүдэд 733 айлын орон сууц ашиглалтад орсны 57.6 хувийг түрээслэхээр, 42.4 хувийг түрээслэн өмчлөхөөр олгосон байна.

#### “Буянт-Ухаа 2” хороолол, “Хангай” хотхон



Веб сайт:

<https://tosk.gov.mn/>



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ  
КОРПОРАЦИ**

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ  
Чингэлтэй дүүрэг, VI хороо, Их тойруу 53/3  
"ТОСК"-ийн байр, Утас: 976-11-313898


Веб сайт: [info.tosk.gov.mn](http://info.tosk.gov.mn)

### 1.1.2.3.Эзэмших эрхийн баталгааг бий болгох

Засгийн газраас төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засаглалыг хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй нэгдсэн портал систем [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn)-д газрын харилцааны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг холбох ажлыг зохион байгуулсан. Ингэснээр иргэд, олон нийт газартай холбоотой баталгаажсан мэдээлэл, лавлагааг орон зай цаг, хугацаанаас үл хамааран, хүртээмжтэй байдлаар олон эх сурвалжаас авах боломж бүрдсэн. “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан”-гийн үйл ажиллагаа улсын хэмжээнд бүрэн нэвтэрч, олон нийтэд нээлттэй мэдээллийн цахим системийг ([egazar.gov.mn](http://egazar.gov.mn)) шинэчлэн хөгжүүлсэний үр дүнд иргэд газартай холбоотой бүх төрлийн мэдээллийг баталгаат нэг эх үүсвэрээс авах нөхцөл бүрдэж, 2020 оны байдлаар нийт 618265 хандалт бүртгэгдсэн байна. ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/181 тушаалаар баталсан “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”-ыг 21 аймгийн ГХБХБГ, 330 сумын газрын даамал, нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба мөрдөн ажиллаж байна. 2020 оны байдлаар “Газрын кадастрын мэдээллийн сан”-д шинээр 138370 нэгж талбар, 20637 барилга байгууламж бүртгэгдсэн байна.

Иргэд, олон нийтэд газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү ойртуулах зорилгоор гар утасны “egazar” нэртэй аппликейшнийг Андроид болон IOS платформ дээр хөгжүүлж, 2020 оны 11 дүгээр сард хэрэглээнд гаргасан. Уг аппликейшнийг ашиглан иргэд тухайн жилийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд санал өгөхөөс эхлээд 18 төрлийн үйлчилгээг авах боломж бүрдэж, заавал харьяа нутгийн газрын албанд өөрийн биеэр очих шаардлагагүй болсон. Хэрэглээнд гарсан өдрөөс хойш нийт 5304 хэрэглэгч тус аппликейшнийг ашиглаж байна.

### Газрын мэдээллийн сангийн харагдах байдал



Веб сайт:

<https://e-mongolia.mn/>

<https://egazar.gov.mn/>

E-Mongolia application

egazar application


#### 1.1.2.4. Борчуудын хорооллыг өөрчлөх хөтөлбөрийг хэрэгжүүлэх (Зарим жишээг дурьдав)

##### Дорнод аймгийн төв Чойбалсан хотын гэр хороололд хэрэгжүүлсэн ажил



Дорнод аймгийн төв Чойбалсан хотын гэр хорооллын гудамжинд авто зам, явган зам, гэрэлтүүлэг, чийрэгжүүлэх болон хүүхдийн тоглоомын талбайн бүтээн байгуулалтыг хийж, иргэдийн эрүүл, аюулгүй, таатай амьдрах орчинг бүрдүүлсэн.

##### Хөвсгөл аймгийн гэр хороололд хэрэгжүүлсэн ажил



Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод 2011-2021 онд нийт 13.74 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ төсөл”-ийг хэрэгжүүлсний үр дүнд 8 км

цэвэр усны төв магистрал шугам, 15.1 км салбар шугамд нийт 858 айл, 6 км бохирын төв магистрал шугам, 12.4 км салбар шугамд нийт 622 айлыг тус тус холбосон байна.



“Жишиг гудамж” төслийг 2, 3 дугаар багт хэрэгжүүлснээр 2020 онд нийт 1.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй дулаан хангамжийн бие даасан эх үүсвэр, цэвэр ус хангамжийн болон ариутгах татуургын төвлөрсөн шугамд 25 айлыг холбосон байна.



### **2.1.5. Хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд нас болон жендерийн асуудлыг тооцсон, оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлэх**

Дундговь аймгийн Гурвансайхан сум 1924 онд байгуулагдсан, 637 өрх, 2149 хүн амтай. Нийт өрхийн 20 хувь нь сумын төвдөө, 80 хувь нь хөдөөд амьдардаг хэдий ч хөдөөгийн өрхүүдийн дийлэнх нь сумын төвд хашаа, байшинтай.

Монгол Улсын Засгийн газар 2012 оноос “Шинэ сум” төслийг 18 аймгийн 19 суманд хэрэгжүүлж эхэлсэн. Дундговь аймгийн Гурвансайхан сум Засгийн газраас хэрэгжүүлсэн энэхүү төсөлд хамрагдаагүй боловч тус сумын Нутгийн зөвлөл санаачлан иргэдийнхээ оролцоотойгоор 2014 оноос эхлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, бүтээн байгуулалтыг өрнүүлэн сумаа шинэчилж чадсан туршлага нь түгэн дэлгэрч, энэ жишгээр бусад аймаг, сумдад төсөл хэрэгжүүлж байна.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Сонголт дизайн” ХХК орон нутгийн удирдлага, олон нийтийн саналыг тусган боловсруулж, тэдгээрийн оролцоотойгоор эхний ээлжинд хэрэгжүүлэх ажлыг тодорхойлсон. Үүний дагуу төр, засаг, аймаг, сумын удирдлага, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг урьж, орон нутгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, хөтөлбөрөө танилцуулан, хот байгуулалтын олон улсын хурал, уулзалт, семинарыг зохион байгуулж, АХБ, НҮБХХ, Туркийн олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага, ЖАЙКА, орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж болон “Сум хөгжүүлэх сан”, иргэдээс нийт 4.3 тэрбум төгрөг босгон, бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлсэн. Эхний ээлжинд сумын төвийн айл өрхүүд гудамжны дагуух хашаагаа блокон суурьтай сараалжин хашаагаар сольж жигдрүүлэн, цэвэр, бохир усны шугам, дулааны нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж болон гэрэлтүүлэг бүхий 3 км засмал зам зэргийг барьж ашиглалтанд оруулсан байна.

#### **Гурвансайхан сумын төвийн бүтээн байгуулалтын өмнөх байдал**



#### **Гурвансайхан сумын төвийн бүтээн байгуулалтын үеийн байдал**



## Шинээр барьсан авто зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламж



## Жижиг, дунд үйлдвэрийн парк



Сумын төвийнхөө өнгө үзэмжийг сайжруулж, иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дэлгэрцогт сумын нутгаас үржил шимт хөрс татан, сумынхаа төвийн хатуу хөрсийг сольж, зүлэгжүүлж, мод, бут тарин арчилж байна. Соёл, спортын цогцолбор, 12 жилийн сургууль, цэцэрлэг, 12 айлын орон сууц зэрэг орон сууц, угаалгын газар, халуун усны газар зэрэг олон нийтийн барилга байгууламжийг шинээр барьж, дулааны нэгдсэн шугам сүлжээ, цэвэр, бохир усны шугамд холбосон. Сумынхаа мянгат малчин гэр бүл бүрээс нэг сая төгрөгийн өгсөн хандиваар “Мянгатын сан”-г байгуулж, “Жижиг, дунд үйлдвэрийн парк”-ийг барьж, ашиглалтанд оруулсан. “Сумын шинэчлэл”-ийг хийсэнээр тухайн сумын иргэдийн хандлагыг өөрчлөн, иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор амьдрах орчноо сайжруулж, орон нутгаа хөгжүүлж болдгийг харуулсан үндэсний хэмжээнд сайн туршлага, жишиг болсон.

## Соёл, спортын цогцолбор



## Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа



Веб сайт:

[http://ldi.nda.gov.mn/?province\\_id=11&region\\_id=188](http://ldi.nda.gov.mn/?province_id=11&region_id=188)

<https://www.montsame.mn/en/read/180839>

### **2.3.2.1.Хотууд хоорондын хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлж, хотжилтын шийдэл, харилцан суралцах явдалд дэмжлэг үзүүлэх**

Монгол Улсын Засгийн газар 1996 оноос дэлхийн “Эрүүл хот”-ын чиг хандлага, үзэл баримтлалыг дэмжин, нийслэл Улаанбаатар болон Дархан, Эрдэнэт зэрэг бусад томоохон хотуудад “Эрүүл хот” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. “Эрүүл хот хөтөлбөрийг чадавхижуулах төв” нь 2017 онд Олон улсын Эрүүл Хотуудын холбооны Монгол Улс дахь үндэсний сүлжээний хүрээнд байгуулагдсан бөгөөд “Эрүүл хот” санаачилгыг дэмжигч хотуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр олон улс, үндэсний хэмжээнд идэвхтэй ажиллаж байна. Тус сүлжээ нь хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсад “Эрүүл Хот”-ын санаачилгыг идэвхтэй дэмжин үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ хүрээнд 18 хоттой санамж бичиг байгуулан, хамтын ажиллагааг эхлүүлж, хот нь хотоосоо суралцах, сайн туршлагаа харилцан солилцох үндэсний болон бүсчилсэн сургалт, семинар, зөвлөлдөх уулзалт, бусад арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулсан.

#### **Эрүүл мэндийг дэмжих зан үйлийг өөрчлөх сургалт, Улаанбаатар хот, 2019 он**



**“Эрүүл хот”-уудын сайн туршлага солилцох уулзалт, семинар,  
Чойбалсан хот, 2020 он**



Вэб сайт: [www.healthycity.weebly.com](http://www.healthycity.weebly.com)


Түүнчлэн, Эрүүл Хотуудын Сүлжээ нь олон улсын хотуудын сүлжээ, орон нутгийн захиргаадын холбоодтой хамтран ажиллаж, Монголын хотууд “Эрүүл хот”-ын талаар олон улсын хотуудаас суралцах, холбоонд гишүүнээр элсэх, үйл ажиллагаанд нэгдэх боломжийг бүрдүүлсэн. Хотуудын хамтын ажиллагаа, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанаас гадна хүний эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар судалгаа шинжилгээ, үнэлгээний ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Тухайлбал, 2017 онд “Хотын орчин хүний эрүүл мэнд хоорондын харилцан хамаарал ба нөлөөллийн үнэлгээ: Монгол Улсын жишээн дээр”, 2019 онд Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамны дэмжлэгтэйгээр “Хотжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, Хотын тэгш байдлын нөхцөл байдлыг үнэлэх судалгааг гүйцэтгэсэн.

Коронавируст халдвар (COVID-19) цар тахлын үед дэлхийн хотууд цар тахлаас урьдчилан сэргийлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах үйл ажиллагаагаа үргэлжилүүлсээр байна. Энэ нөхцөлд Монгол Улсад “Эрүүл хот”-ын санал санаачилгыг дэмжин, зохион байгуулалтаар ханган ажиллах үндэсний сүлжээ нь хотуудын хамтын ажиллагаа, манлайллын нэг сайн жишээ болж байна.


### 2.3.2.6. Хууль ёсны эзэмшил газраас олох орлого, санхүүжилт, бусад арга хэрэгслийн чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Татварын ерөнхий хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу газрын төлбөрийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Татварын алба хураан барагдуулах үүрэг хүлээн ажиллаж эхэлсэн бөгөөд Газрын албад “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн систем”-ээс газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэл (egazar.gov.mn, egazar app, e-mongolia.mn)-ийг үүсгэн, дундын мэдээллийн системд илгээж, Татварын алба татвар төлөгч нараас цахимаар (etax.mta.mn, ebarimt app) нэхэмжлэн төсөвт төвлөрүүлэх ажлыг эхлүүлсэн.

<https://egazar.gov.mn> веб сайт



<https://e-mongolia.mn/home> веб сайт




Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлснээр том дэвшил гарсан. Үүний нэг жишээ бол иргэд нэг жилийн өмнө газрын төлбөрөө төлөхөд олон шат дамжлага дамжин,


банкинд дугаарлан 3-8 цагийг зарцуулдаг байсан бол өнөөдөр цахим хэлбэрээр нэг минутын дотор газрын төлбөр, татварыг төлөх боломжтой болсон.

ГЗБГЗЗГ-аас газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр түргэн шуурхай, ил тодоор зохион байгуулах, газрын барьцаа, түрээсийн бүртгэл хийх, газрын зах зээлийн үнийн мэдээ цуглуулж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээ, статистик мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх, зорилгоор Газрын биржийн цахим систем (www.mle.mn)-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг системийг 21 аймгийн ГХБХБГ, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, 330 сумын газрын даамлууд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

<https://mle.mn/home> веб сайт



<https://auth.itc.gov.mn/auth/realms/ITC/protocol/openid-connect/> вэб сайт



<https://ebarimt.mn/> вэб сайт

The image shows two parts of the ebarimt.mn website. On the left is the login page with the ebarimt logo and the text 'Цахим төлбөрийн баримтын систем'. It features buttons for 'Баримт шалгах', 'Онлайн туслах', and 'Бүртгэл шалгах'. There are also fields for 'Хувь хүн / Бизнес эрхлэгч', 'Хэрэглэгчийн код эсвэл имэйл', and 'Нууц үг'. On the right is a promotional banner for the 'Цахим төлбөрийн баримтын систем НЭВТРЭЛТИЙН НЭГДСЭН СИСТЕМД нэгдлээ. 2.0' version. The banner includes the text 'Шинэчлэгдсэн хувилбар тун удахгүй.' and 'ИЛҮҮ ХЯЛБАР ИЛҮҮ ХУРДАН'. At the bottom of the banner, there are icons and text for 'БАРИМТЫН СТАНДАРТ, ЕРӨНХИЙ ШААРЦАГА', 'КАССЫН ТӨХӨӨРӨМЖ, СИСТЕМД ХОЛБОГЛОХ', 'БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ БҮРТГҮҮЛЭХ', and 'ТАТВАРЫН УДИРДЛАГЫН НЭГДСЭН СИСТЕМ'. The URL <https://e-invoice.ebarimt.mn/> is also visible.

Веб сайт:

<https://e-mongolia.mn/>

<https://egazar.gov.mn/>

<https://mle.mn/>

<https://etax.mta.mn/>

<https://ebarimt.mn/>

<https://auth.itc.gov.mn/auth/realms/ITC/protocol/openid-connect/>



# “ХОТЖИЛТЫН ШИНЭ ХӨТӨЛБӨР”-ИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХОТ, СУУРИНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ТАЛААР ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

### 1.1.НИЙГМИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН ТОГТВОРТОЙ ХОТ БАЙГУУЛАЛТ БА ЯДУУРЛЫГ ҮГҮЙ БОЛГОХ

#### 1.1.1.Нийгмийн оролцоог хангах ба ядуурлыг үгүй болгох

##### 1.1.1.1.Ядуурлын бүхий л төрлийг арилгах

1.Олон улсын ядуурлын түвшнээс доогуур амьдралтай хүн амын эзлэх хувь, хүйс, насаар ялгасан, үндэсний хэмжээнд хот, хөдөөгөөр (Proportion of population below the international poverty line, by sex, age at national urban level (urban/rural))

Эдгээр үзүүлэлт Монгол Улсын статистикийн мэдээлэлд тусгагддаггүй.

##### 1.1.1.2.Боломж, үр ашгийг тэгш хүртэхийг дэмжих замаар хот, суурин газар дахь тэгш бус байдлыг бууруулах

10. Ажилгүйдлийн түвшин (%), хүйс, аймаг, нийслэлээр (Unemployment rate by sex, age, persons with disabilities and by city)

Хүснэгт. Ажилгүйдлийн түвшин, хүйс, аймаг, нийслэлээр (2016-2020 оноор)

Хэмжих нэгж: хувь

Аймаг	2016		2017		2018		2019		2020	
	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм
Бүгд	10	8.2	8.8	7.8	7.8	7.1	10.0	8.9	7.0	6.7
Баян-Өлгий	9.3	11.7	12.4	16.1	12.6	17.9	24.2	27.5	20.9	21.4
Говь-Алтай	10.1	9.3	8.6	8.7	6.0	6.1	10.7	11.8	9.2	8.7
Завхан	11.4	12.6	4.4	5.3	4.3	4.2	5.0	6.2	1.6	0.7
Увс	14.2	14.5	13.0	14.6	10.2	9.2	6.6	8.5	11.2	14.2
Ховд	15.1	14.4	13.5	13.3	8.4	8.0	11.3	8.5	7.4	3.1
Архангай	5.0	4.0	5.4	5.4	5.2	4.8	4.8	5.1	3.3	1.5
Баянхонгор	11.2	11.2	5.6	5.8	7.3	8.4	7.3	8.7	6.0	6.8
Булган	8.2	7.9	10.7	10.9	7.4	7.1	5.7	5.1	6.8	6.8
Орхон	22.4	17.7	23.5	21.8	12.7	16.1	11.7	8.7	7.0	9.0
Өвөрхангай	8.9	9.0	7.6	6.1	5.3	5.2	6.3	6.6	6.7	6.2
Хөвсгөл	8.5	6.7	8.5	6.9	6.4	5.7	12.4	9.4	8.9	10.3
Говьсүмбэр	18.1	12.9	7.8	7.8	11.7	11.8	10.0	11.7	9.9	9.7
Дархан-Уул	15.4	11.0	14.2	11.0	19.6	16.9	18.7	18.0	12.6	9.3
Дорноговь	9.9	7.1	6.1	4.8	5.3	4.7	3.9	5.2	4.1	2.9
Дундговь	5.1	3.4	4.4	2.8	5.0	4.7	4.9	7.5	3.1	3.3
Өмнөговь	14.3	12.1	16.4	13.5	7.3	5.9	6.0	6.1	5.6	3.9
Сэлэнгэ	8.1	5.3	6.6	7.5	5.6	5.1	4.7	3.4	10.9	9.7
Төв	2.7	1.8	3.2	1.9	2.6	1.7	4.1	5.4	2.8	1.7
Дорнод	11.2	11.2	10.1	11.8	6.3	5.4	20.9	20.5	14.0	10.2
Сүхбаатар	9.9	9.1	10.9	7.7	8.5	7.9	7.6	6.2	5.3	6.5
Хэнтий	12.9	8.3	10.3	8.5	11.3	10.3	7.1	8.8	4.0	5.1
Улаанбаатар	9.1	6.3	7.5	5.9	7.6	5.9	11.0	8.2	6.3	6.2

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

### 33. Жини коэффициент, улирлаар (Gini coefficient at national/city/ urban levels)

Хүснэгт. **Жини коэффициент, хөгжлийн 5 бүсээр (2016- 2020 оноор)**

Бүс	2016	2017	2018	2019	2020
Баруун бүс	0.34	0.32	0.28	0.31	0.3
Хангайн бүс	0.33	0.32	0.31	0.32	0.32
Төвийн бүс	0.36	0.33	0.32	0.31	0.3
Зүүн бүс	0.35	0.36	0.35	0.37	0.35
Улаанбаатар	0.35	0.37	0.32	0.33	0.33
Улсын дундаж	0.35	0.35	0.32	0.33	0.32

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

#### **1.1.1.3.Эмзэг бүлгийн нийгмийн оролцоог хангах (эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшсан иргэд)**

4. Эмэгтэйчүүд эд хөрөнгө өвлөх, эзэмших эрх байгаа эсэх (Presence of Women’s recognized legal right to property inheritance and ownership)

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 9.3 дугаар зүйлд “Иргэний хуулиар зохицуулсан иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцаанд жендэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно” гэж заасан.

34. Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрөлх болон бусад байдлаар нь орон сууц, нийтийн үйлчилгээний хүртээмж, нийгмийн үйлчилгээгээр ялгаварлан гадуурхахыг хориглосон үндэсний хууль тогтоомж байгаа эсэх (Presence of national legislation forbidding discrimination in housing, access to public facilities and social services on the basis of race, colour, sex, language, religion, political or other opinion, national or social origin, property, birth or other status)

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан.

#### **1.1.1.4.Гудамж, явган хүний зам, унадаг дугуйн зам зэрэг нийтийн эзэмшлийн орон зайг ашиглах боломжийг бататгах**

19. Хотуудын барилгажсан талбайд нийтийн эзэмшлийн ногоон бүсийн эзлэх хувь, хүйс, насны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүнээр (Average share of the built-up area of cities that is open space for public use for all, by sex, age and persons with disabilities)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

35. Нийт замын уртад дугуйн замын эзлэх хувь (Percentage of road length that has dedicated bike lanes (excluding motorways))

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

36. Нийт замын уртад явган хүний замын эзлэх хувь (Percentage of road length that has dedicated sidewalks (excluding motorways))

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

### **1.1.2.Шаардлага хангасан орон сууцны хүртээмж**

#### **1.1.2.1.Шаардлага хангасан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцаар хангах**

31.Өрхийн орон сууц, унааны зардалд зарцуулсан дундаж мөнгөн дүн өрхийн жилийн дундаж орлогын хувиар (Median amount of money spent on housing and transportation per household as a percentage of the median annual household income of tenants)

2020 оны байдлаар өрхийн орон сууцны зардалд 28.1 хувь, унааны зардалд 22.0 хувийг зарцуулсан байна. (Эх сурвалж: <https://1212.mn/>)

32.Орон сууцны зах зээлийн дундаж үнэ болон өрхийн жилийн дундаж орлогын харьцаа (Ratio of the median free-market price of a dwelling unit and the median annual household income)

Орон сууцны зах зээлийн дундаж үнэ болон өрхийн жилийн дундаж орлогын харьцаа 6.8 жил байна. (Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс)

Тайлбар: 2020 оны байдлаар орон сууцны 1м<sup>2</sup> -ийн үнэ 2.2 сая төгрөг, орон сууцны зах зээлийн дундаж үнэ 110 сая төгрөг (Үнэ 2.2\*50 м<sup>2</sup>=110), өрхийн жилийн орлого 1343.4\*12=16.1 сая төгрөг байна.  $110 : 16.1 = 6.8$  жил (Эх сурвалж: [http://hmc.mn/pdf/4\\_\\_Tenkhleg\\_zuuch.pdf](http://hmc.mn/pdf/4__Tenkhleg_zuuch.pdf))

38.Өндөр өртөгтэй орон сууцанд амьдардаг хүн амын хувь (Percentage of people living in unaffordable housing)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

#### **1.1.2.2.Орон сууцны тогтвортой санхүүжилтийн хувилбаруудыг бий болгох**

37. Орон сууцны зээлийг ДНБ-д харьцуулахад (Mortgage debt relative to GDP)

2020 оны байдлаар орон сууцны зээлийг ДНБ-д харьцуулахад 7.9 хувь байна. (БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс)

#### **1.1.2.3.Эзэмших эрхийн баталгааг бий болгох**

2. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх нь а) хууль ёсны баримт бичгээр баталгаажсан, б) баталгаатай гэж үздэг насанд хүрсэн хүний эзлэх хувь, хүйс болон газар эзэмших эрхээр (Proportion of total adult Population with secure tenure rights to land with (a) legally recognized documentation; and (b) who perceive their rights to land as secure, by sex and type of tenure)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

### **1.1.2.4.Борчуудын хорооллыг өөрчлөх хөтөлбөрүүдийг эхлүүлэх**

39.Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах хөтөлбөртэй хотуудын эзлэх хувь (Proportion of cities with slum upgrading programmes)

2015 онд УИХ-аас Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль батлан хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд нийслэл Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул, Булган, Говьсүмбэр, Увс, Хөвсгөл, Өвөрхангай, Дорнод, Завхан зэрэг 21 аймгийн төв, зарим сумдын төвд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслийг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж байна.

40.Борчуудын хорооллын 5 хомсдолын аль нэгийг болон борчуудын хорооллын нийтийн эзэмшлийн талбайн асуудлыг шийдвэрлэхэд зориулж жил бүр төсөв хувиарилдаг хотын тоо ( Number of cities having annual budget allocations addressing any of the 5 slum deprivations and inclusive public spaces in known slum areas)

Нийслэл Улаанбаатар хот, 21 аймгийн төв, зарим сумдын төвд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төсөл, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах төсөл хэрэгжүүлэхэд жил бүр улс, орон нутгийн төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт хувиарилж байна. Тухайлбал, нийслэл Улаанбаатар хотод гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд төвийн 6 дүүргийн хэмжээнд 18 байршлын 30 нэгж талбарт гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтэд улс, нийслэлийн төсвөөс 2013-2016 онд 121.4 тэрбум төгрөг, 2017- 2020 онд 50 тэрбум төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

### **1.1.3.Суурь үйлчилгээний хүртээмж**

#### **1.1.3.1.Баталгаатай ундны ус, эрүүл ахуй, хатуу хог хаягдлын зайлуулах нөхцөлөөр хангах**

5. Шаардлага хангасан ундны ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь (Proportion of population using safely managed drinking water services)

Монгол Улсад 2016 оны байдлаар баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 33 хувь байсан бол 2017 онд 50 хувь, 2018 онд 52 хувь, 2019 онд 82.9 хувь, 2020 онд 83.5 хувьд хүрсэн байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд хүн амын 99.5 хувь нь шаардлага хангасан ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа бөгөөд улсын хэмжээнд 1-д эрэмбэлэгдэж байна.

6.Саван, устай гар угаах хэрэгсэлтэй шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээтэй хүн амын эзлэх хувь (Proportion of population using safely managed sanitation services, including a hand-washing facility with soap and water)

Монгол Улсын хэмжээнд шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн үйлчилгээнд хамрагдсан хүн ам 41.1 хувийг эзэлж байна. Бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч, цэвэрлэх цогц байгууламжид холбогдсон хүн ам 2016 онд 27 хувь, 2017 онд 31 хувь, 2018 онд 34 хувь, 2019 онд 69 хувь, 2020 онд 69,2 хувийг тус тус эзэлж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд хүн амын 51.8 хувь нь шаардлага хангасан, 48.2 хувь нь шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламжтай байгаа бөгөөд хүн амын 36.8 хувь нь ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбогдож, 4.4 хувь нь ямар нэг ариун цэврийн байгууламжгүй байна.

18. Хотын хог хаягдал менежментийн системээр цуглуулж хаясан хог хаягдлын хувь (Proportion of Municipal solid waste collected and managed in controlled facilities)

Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээ 2014 оны түвшинтэй харьцуулахад 2016-2020 онд 20 хувьд (нийт хог хаягдалд эзлэх хувь) хүрсэн байна.

### 1.1.3.2. Аюулгүй, шуурхай нийтийн тээврийн системээр баталгаатай хангах

44. Нийтийн тээврээр зорчигчдын хувь (Percentage of commuters using public transport)

Хүснэгт. Нийтийн тээврээр зорчигчдын тоо, хувь хэмжээ (2019-2020 оноор)

Үзүүлэлт	2019 он (сая хүн)	2020 он (сая хүн)	Өмнөх онтой харьцуулсан (%)
Нийт зорчигчдын тоо, үүнээс:	173.02	126.51	-26.3
Төмөр замын тээвэр	2.95	1.97	-33.2
Автотээвэр	168.44	124.1	-26.3
Агаарын тээвэр	1.62	0.45	-72.2
Усан замын тээвэр	0.03	0.03	+0.6

Эх сурвалж: <https://mrt.d.gov.mn/i/2599>

### 1.1.3.3. Орчин үеийн сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжоор хангах

7. Нийт эрчим хүчний зарцуулалтанд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь (Renewable energy share in the total final energy consumption)

Хүснэгт. Эрчим хүчний системийн үйлдвэрлэлийн мэдээ 2019-2020 он (2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар)

№	Байгууллагын нэр	Хэмжих нэгж		2019 он	2020 он			Өссөн дүн
				Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь (%)	
1	Дөргөн УЦС	цах.	мян.кВтц	5,960.3	4,552.0	7,504.9	164.9	55,500.9
2	Тайшир УЦС	цах.	мян.кВтц	3,787.3	1,488.0	1,501.6	100.9	22,837.7
3	Гуулин УЦС	цах.	мян.кВтц	-	-	-	0.0	615.9
4	Богдын голын УЦС	цах.	мян.кВтц	-	-	-	0.0	2,783.3
5	Тосон-цэнгэл УЦС	цах.	мян.кВтц	22.2	15.0	19.3	128.8	1,261.3
6	Хүнгүйн УЦС	цах.	мян.кВтц	-	-	-	0.0	73.7
7	Галуутайн УЦС	цах.	мян.кВтц	-	-	-	0.0	161.5
8	Баянтоорой Алтай сум	цах.	мян.кВтц	33.3	25.0	40.5	162.2	356.3
9	"Салхит СЦС" ХХК	цах.	мян.кВтц	12,706.6	13,020.5	15,863.8	121.8	138,313.9
10	"Цэций СЦС" ХХК	цах.	мян.кВтц	12,642.2	17,269.9	18,388.4	106.5	152,203.0
11	"Нар НЦС" ХХК	цах.	мян.кВтц	871.4	314.9	989.5	314.2	15,737.4
12	"Моннаран НЦС" ХХК	цах.	мян.кВтц	709.9	258.5	908.9	351.6	15,002.7
13	Гэгээн СЦС	цах.	мян.кВтц	2,017.2	1,114.5	2,129.3	191.0	24,650.3

14	Сайншанд СЦС	цах.	мян.кВтц	11,996.7	14,326.3	18,485.3	129.0	160,651.5
15	Сүмбэр НЦС	цах.	мян.кВтц	958.2	345.2	1,275.6	369.5	16,521.2
16	Бөхөг НЦС	цах.	мян.кВтц	1,768.1	1,130.9	1,909.6	168.8	23,961.5
	Дүн	цах.	мян.кВтц	53,473.2	53,861.1	69,016.9	128.1	630,632.2
<b>ЭХС НИЙТ ДҮН</b>		<b>дул</b>	<b>гКал</b>	<b>1,425,870</b>	<b>1,465,796</b>	<b>1,550,930</b>	<b>105.8</b>	<b>9,279.501</b>
		<b>цах</b>	<b>м.кВтц</b>	<b>651,406</b>	<b>625,170</b>	<b>679,473</b>	<b>108.7</b>	<b>6,254.283</b>

Эх сурвалж: <http://www.energy.gov.mn/c/1211>

## 1.2.НИЙТЭД ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ ХОТЫН ХӨГЖИЛ БА БОЛОМЖ

### 1.2.1.Нийтэд хүртээмжтэй хотын эдийн засаг

#### 1.2.1.1.Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг багтаасан бүх нийтийн бүтээмжит ажлын байрыг бий болгох

8. Бодит ДНБ-ийн жилийн өсөлтийн хувь (хөдөлмөр эрхэлж буй нэг хүнд оногдох) (Annual growth rate of real GDP (per employed person)) Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

11.Ажил, сургууль, сургалтанд хамрагдаагүй 15-24 насны залуучуудын хувь (Proportion of youth (aged 15-24 years) not in education, employment or training)

#### Хүснэгт. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин (2016-2020 оноор)

Хэмжих нэгж: хувь

Хугацаа	15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин, (хувь)
2016	25.1
2017	22.7
2018	20.4
2019	25.3
2020	17.9

Эх сурвалж: <https://www.1212.mn>

#### 1.2.1.2.Албан бус эдийн засгийг дэмжих

9. ХАА-н бус ажил эрхлэлт дэх албан бус хөдөлмөр эрхлэлтийн хувь, хүйсээр (Proportion of informal employment in non-agriculture employment, by sex)

2020 оны байдлаар улсын хэмжээнд нийт 133478 эрэгтэй буюу 63.6 хувь, 76399 эмэгтэй буюу 36.4 хувь нь хөдөө аж ахуйн бус ажил эрхлэлт дэх албан бус хөдөлмөр эрхэлж байна. (Эх сурвалж: <https://www.1212.mn/>)

#### 1.2.1.3.Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих

45. Жижиг, дунд үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь

График. Жижиг, дунд үйлдвэрийн ДНБ-д эзлэх хувь (2016-2020 оноор)



Эх сурвалж: ХХААХҮЯ

#### 1.2.1.4. Бизнес, инновацын шударга, хариуцлагатай орчинг бүрдүүлэх ажлыг дэмжих

26. Шинэ бизнесийг бүртгэх хугацаа, өдрөөр (Number of days to register a new business in the country)

Шинэ бизнесийг ажлын 14 өдрийн дотор бүртгэж байна. (Эх сурвалж: <https://mta.mn/c/view/11600>)

#### 1.2.2. Нийтэд хүртээмжтэй тогтвортой хөгжил, цэцэглэлт

##### 1.2.2.1. Хотын эдийн засгийг төрөлжүүлэх, соёлын болон уран бүтээлийн үйлдвэрлэлийг дэмжих

12. Хөдөлмөр эрхлэлтийн дотор үйлдвэрлэлийн эзлэх хувь (Manufacturing employment as a proportion of total employment) 9.2.2

Монгол Улсын хэмжээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл ДНБ-ий 1.3 хувь буюу 481.4 тэрбум төгрөгийн зах зээлд 33 мянган ажлыг байрыг бий болгоод байна. Тус салбарт нийт 11 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас 6500 нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. (Эх сурвалж: Соёлын яам, <https://mcc.gov.mn/>)

#### Хүснэгт. Соёл, урлагийн байгууллагын ажиллагсад (2016-2020 оноос)

д/д	Байгууллага	2016	2017	2018	2019	2020
	<b>Бүгд</b>	<b>7140</b>	<b>7005</b>	<b>7041</b>	<b>7202</b>	<b>7318</b>
1	Эмэгтэй	3902	3922	3920	4017	4004
2	Театр, чуулга, цирк	2886	2563	2566	2701	2678
3	Музей	699	724	639	658	671
4	Номын сан	548	808	482	500	509
5	Соёлын төв	2578	2339	2385	2603	2611
6	Киноны байгууллага	429	571	913	666	646
7	Бусад	-	-	56	74	203

Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 2020 он

##### 1.2.2.2. Орчин үеийн хотын эдийн засгийг хөгжүүлэхийн тулд техникийн болон зохион байгуулах ур чадваруудыг хөгжүүлэх

47. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшсэн хүний тоо, жилээр

**Хүснэгт. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагсад (2016-2020 оноор)**

<b>Сургалтын байгууллагын ангилал</b>	<b>2016/2017</b>	<b>2017/2018</b>	<b>2018/2019</b>	<b>2019/2020</b>	<b>2020/2021</b>
Техникийн боловсрол	6329	4771	6833	6362	4649
Мэргэжлийн боловсрол	26946	30181	28551	30492	35142
Мэргэжлийн сургалт	6859	879	1655	952	374
Бүгд	40134	35831	37039	37806	40165

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2020

**1.2.2.3. Бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хот-хөдөөг харилцан уялдаатай хөгжүүлэх**

20. Танай улс (а) хүн амын динамикийг тооцсон, (б) нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах, (в) орон нутгийн санхүүг нэмэгдүүлэх Үндэсний хот байгуулалтын бодлого эсвэл бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй юу? (Does your country have a National Urban Policy or Regional Development Plan that (a) responds to population dynamics, (b) ensures balanced territorial development, and (c) increase in local fiscal space.)

2001 онд УИХ-аас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, түүний дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн. Улмаар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий хотжилтыг дэмжих зорилгоор эдийн засгийн 4 бүс тус бүрд 2 тулгуур төв хотыг сонгон, тэдгээрийг түлхүү хөгжүүлэхээр тогтсон. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2015 оноор дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоохоор ажиллаж байна. Түүнчлэн, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж байна.

**1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУВЬД ТОГТВОРТОЙ, ТЭСВЭРЛЭХ ЧАДВАРТАЙ ХОТЫН ХӨГЖИЛ**

**1.3.1. Хотуудын эрсдлийг даван туулах, нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадвар ба хүн амын нутагшилт, суурьшил**

**1.3.1.1. Хотын тэлэлт, түүнээс үүдэж буй биологийн төрөл зүйлийн хохирлыг бууруулах**

15. Хүн амын өсөлтөд харгалзах газрын зарцуулалтын харьцаа (Ratio of land consumption rate to population growth rate)



“Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ын 11.3.1-д заасан “Газар ашиглалтын хувийг хүн амын өсөлтийн хувьд харьцуулсан харьцаа” хөгжлийн шалгуур үзүүлэлт нь мэдээллийн эх үүсвэр байхгүй тул Монгол Улсаас одоогийн байдлаар гаргах боломжгүй байна.

48. Тусгай хамгаалалттай байгалийн бүсэд хамаарах газрын эзлэх хувь (Proportion of land under protected natural areas)

Хүснэгт. **Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, тоо, талбайн хэмжээ (2018 он)**

Таних тэмдэг	Ангилал	Газрын тоо	Талбайн хэмжээ (га)	Монгол Улсын нийт газар нутагт ТХГН-ын эзлэх хувь
	Дархан цаазат газар	20	12,411,057.44	7.9
	Байгалийн цогцолборт газар	32	11,884,605.59	7.6
	Байгалийн нөөц газар	36	3,528,824.17	2.3
	Дурсгалт газар	14	128,962.78	0.09
НИЙТ ДҮН		102	27,953,449.98	17.8

Эх сурвалж: БОАЖЯ, Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018. Улаанбаатар хот. 2019 он

**1.3.1.2. Уур амьсгалыг өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх**

3. Гэр орон болон гадаад орчны агаарын бохирдлоос хамааралтай нас барсан хүний эзлэх хувь (Mortality rate attributed to household and ambient air pollution)


Хүснэгт. **Хүн амын нас баралтын зонхилох шалтгаан (2017-2020 оноор)**

Өвчний бүлэг	Хүйс	2017	2018	2019	2020
<b>Нийт:</b>	Бүгд	15812	17331	17205	15922
Үүнээс: Амьсгалын тогтолцооны өвчлөл	Бүгд	1155	752	1173	593

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn>

Сүүлийн 10 жилийн байдлаар 10 000 хүн амд ногдох хатгалгаа өвчнөөр нас барсан хүн амын тоо харьцангуй тогтмол (1-2) байгаа хэдий ч үүнд 5 хүртэлх насны хүүхдийн хатгалгаагаар нас баралт (3-8) өндөр байсаар байна. 5 хүртэлх насны 10 000 хүүхдэд ногдох хатгалгаагаар нас баралт 2011 онд хамгийн их буюу 8 байсан бол үүнээс хойш буурч 2018 онд 3 болж, 5 жилийн өмнөхөөс 1-ээр, 10 жилийн өмнөхөөс 2-оор тус тус буурсан байна.

График. Улаанбаатар хотын 10 000 хүн амд ногдох хатгалгаа өвчнөөр нас барсан нийт хүн ам, 5 хүртэлх насны хатгалгаагаар нас барсан хүүхэд (2008-2018)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд, 2019 он

30. Хотуудын нарийн ширхэгт тоосонцрын жилийн дундаж түвшин (жишээ: PM2.5 ба PM10) (Annual mean levels of fine particulate matter (e.g. PM2.5 and PM10) in cities (population weighted))

50. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээнд зориулагдсан орон нутгийн захиргааны төсвийн хувь (Percentage subnational/local government budgets dedicated to climate change mitigation and adaptation actions) 11b.2

### 1.3.1.3. Байгалийн болон хүний оролцоотой гамшгийн нөлөөллийг бууруулах тогтолцоог хөгжүүлэх

51. Олон төрлийн аюул, эрсдэлийн газрын зурагтай хотуудын хувь (Percentage of cities with multi-hazard mapping)

Монгол Улсын нийт хот, суурин газрууд гамшгийн эрсдэлийн газрын зурагтай, 100 хувь.

52. Тус улсад олон төрлийн аюулыг хянах, урьдчилан таамаглах систем бий юу? (Does the country have a multi-hazard monitoring and forecasting system?)

Монгол Улс гамшгийн аюулыг хянах, урьдчилан таамаглах системтэй.

53. Олон төрлийн аюулыг урьдчилан сэрэмжлүүлэх системд хамрагдсан хотын тоо болон хүн амын хувь (The number of cities that have / percentage of urban population that is covered by multi-hazard early warning systems)

Дэлхийн цаг уурын байгууллагын санхүүжилтээр мэдээлэл боловсруулалтын MSS системийн техник, програм хангамжийн шинэчлэлт, ОБЕГ, НҮБХХ-тэй хамтран цаг агаарын мэдээ, хоногийн нөхцөл байдлын мэдээг иргэд гар утсан дээрээ харах, ашиглах зорилгоор "Ontsgoi" аппликейшн, гамшгийн сэрэмжлүүлэг мэдээ хүргэх зорилгоор "Анхаар"

аппликейшнийг нэвтрүүлсэн. Иймд олон төрлийн аюулыг урьдчилан сэрэмжлүүлэх системд нийт хот, суурин газрууд болон хүн ам хамрагдсан гэж үзэх боломжтой, хамрагдалт 100 хувьтай байна.

#### **1.3.1.4.Чанартай дэд бүтэц, орон зайн төлөвлөлтөөр хотын байгалийн эрсдэлд тэсвэрлэх нөхцөлийг бий болгох**

49. Үндэсний стратегитай уялдуулан орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийг сонгон хэрэгжүүлж буй орон нутгийн засаг захиргааны хувь (Percentage of local governments that adopt and implement local disaster risk reduction strategies in line with national strategies)

Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг, Шадар сайдын 2021 оны 51 дүгээр тушаалаар “Гамшгийн эрсдэлийг бууруулах сендайн үйл ажиллагааны дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шатны төлөвлөгөө болон Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжүүлж байна.

51. Олон төрлийн аюул, эрсдэлийн газрын зурагтай хотуудын хувь (Percentage of cities with multi-hazard mapping)

Монгол Улсын нийт хот, суурин газрууд гамшгийн эрсдэлийн газрын зурагтай, 100 хувь.

#### **1.3.2.Тогтвортой менежмент ба Байгалийн нөөцийн ашиглалт**

##### **1.3.2.1.Хот, суурины байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бэхжүүлэх**

21. Түүхий эдийн олборлолт, нэг хүнд ногдох, ДНБ-д ногдох байдлаар (Material Footprint, material footprint per capita, and material footprint per GDP)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

22. Дотоодын түүхий эдийн ашиглалт, нэг хүнд ногдох, ДНБ-д ногдох байдлаар (Domestic material consumption, domestic material consumption per capita, and domestic material consumption per GDP)

##### **Хүснэгт. ТХЗ 12.2.2. Дотоодын материалын хэрэглээ, нэг хүнд ногдох дотоодын материалын хэрэглээ, ДНБ-д ногдох дотоодын материалын хэрэглээ**


<b>Ангилал</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>	<b>2020</b>
ТХЗ 12.2.2. Нэг хүнд ногдох дотоодын материалын хэрэглээ, (тн)	76	74.4	74.9	74

Эх сурвалж: <https://www.1212.mn>

27. Нэг хүнд ноогдох ногоон бүсийн хэмжээ (Green Area Per Capita)

Нийслэлийн хэмжээнд нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ нь 2016 онд 1.7 м2, 2017 онд 2.4 м2, 2018 онд 3.2 м2, 2019 онд 4.1 м2, 2020 онд 5.1 м2-т хүрч өссөн үзүүлэлттэй байна.

График. Нийслэлийн нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ (м2)



Эх сурвалж: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт

### 1.3.2.2. Нөөцийг ариглах, хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахыг шаардлага болгох

23. Дахин боловсруулах хэмжээ, дахин боловсруулсан материал тонноор (Recycling rate, tons of material recycled)

Дахин ашигласан, дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ 2018 онд 234.6 мянган тонн байсан бол 2019 онд 250.6, 2020 онд 285.2 мянган тонн болж өссөн.

#### Хүснэгт. Дахин ашигласан, дахин боловсруулсан хог хаягдал, төрлөөр

Хэмжих нэгж: мян.тн

Дахин ашигласан, боловсруулсан хог хаягдал, төрлөөр	2018	2019
Энгийн хог хаягдал	235.2	250.6
Цаас, цаасан бүтээгдэхүүний хаягдал	69.3	74.3
Шил, шилэн бүтээгдэхүүний хаягдал	16.4	17.6
Хаягдал төмөр	58.6	62.6
Хуванцар бүтээгдэхүүний хаягдал	28.0	28.2
Барилгын хог хаягдал	9.0	9.7
Хүнсний бүтээгдэхүүний хаягдал	2.9	3.1
Цахилгаан барааны хаягдал	0.1	0.1
Автомашины эд анги	1.0	1.1
Бусад хаягдал	49.9	53.9

Эх сурвалж: ҮСХ, Хатуу хог хаягдлын данс 2018-2019

### 1.3.2.3. Усны нөөц, хотын хаяа залгаа далайн эргийн хэсгийн байгаль орчинд ээлтэй ашиглалт, менежментийг хэрэгжүүлэх

54. Тус улсад эргийн болон /эсвэл газрын менежментийн төлөвлөгөө байгаа эсэх (Existence of an enforced coastal and/or land management plan in the country)

Монгол Улсын Газрын тухай хуулийн дагуу Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г шинэчлэн батлан мөрдөж байна.

### 1.3.2.4.Цахимжуулалт, цэвэр эрчим хүч ба технологид түшиглэсэн Ухаалаг-хот хандлагыг хэрэгжүүлэх

55.Ухаалаг хяналтын системийг ашиглан айл өрхийн жилийн эцсийн эрчим хүчний хэрэглээг бууруулсан хувь (Percentage reduction in annual final energy consumption in homes using smart monitoring systems)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

56.Замын хөдөлгөөний удирдлагын системд холбогдсон гэрлэн дохио бүхий гудамжны уулзварын эзлэх хувь (Share of street junction with traffic lights connected to traffic management systems)


#### Хүснэгт. Замын хөдөлгөөний удирдлагын системд холбогдсон гэрлэн дохионы тоо (2016-2019 оноор)

Д/д	Төхөөрөмж	2016	2017	2018	2019	Нийт
1	Хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио	141	150	152	155	155

Эх сурвалж: Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төвийн 2016 – 2020 оны үйл ажиллагааны хураангуй тайлан

2019 оны байдлаар нийслэл Улаанбаатар хотод нийт 408 уулзвар байдгаас 155 цэг дээр гэрлэн дохионы зохицуулалттай уулзвар байна.

#### Зураг. Улаанбаатар хотын авто замын уулзварын байршил



Эх сурвалж: Нийслэлийн замын хөдөлгөөний удирдлагын төв, ЖАЙКА ОУБ, “Улаанбаатар хотын зам тээврийн дэд бүтцийг бэхжүүлэх суурь судалгаа”, 2022 он

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖИЛТ

### 2.1.ХОТЫН ЗАСАГЛАЛЫН БҮТЦИЙГ БИЙ БОЛГОХ: ДЭМЖИХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ

#### 2.1.1.Төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн захиргаадад өөрсдийн оноогдсон үүргийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх

57.Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу нутгийн удирдлагууд бүрэн эрхээ хэрэгжүүлж, үүргээ биелүүлж байна уу? (Do local authorities exercise their authority and fulfil their responsibilities in accordance with such procedures and in such cases as provided for by the constitution or by law)

“2.1.1.Төвлөрлийг сааруулж, бүс, орон нутгийн захиргаадад өөрсдийн оноогдсон үүргийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх” гэсэн хэсэгт холбогдох мэдээллийг тусгасан.

58.Тэргүүлэх чиглэлийг шийдэж, төсөв хуваарилах орон нутгийн захиргааны эрхийн хувь (санхүүгийн бие даасан байдал) (Percentage of the total budget that the local / sub-national government have discretion over to decide on priorities (financial autonomy)

#### Хүснэгт. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, ( аймаг, нийслэлээр)

Хэмжих нэгж: сая.төг

Аймаг, нийслэл	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
<b>БҮГД</b>	90,681.2	195,414.8	289,228.4	368,270.3	175,344.6
<b>Хангайн бүс</b>	9,702.6	13,683.7	12,016.8	16,300.9	29,220.1
<b>Булган</b>	-	290.4	-	-	-
<b>Орхон</b>	9,702.6	13,393.2	12,016.8	16,300.9	29,220.1
<b>Төвийн бүс</b>	16,748.7	30,263.9	68,682.7	61,135.7	37,824.8
<b>Говьсүмбэр</b>	-	155.2	-	-	-
<b>Дархан-Уул</b>	-	270.3	458.9	3,010.2	1,824.1
<b>Дорноговь</b>	-	600.0	2,124.1	124.1	-
<b>Өмнөговь</b>	16,748.7	29,238.4	66,099.7	58,001.4	36,000.7
<b>Зүүн бүс</b>	-	-	-	1,686.8	199.7
<b>Дорнод</b>	-	-	-	1,686.8	199.7
<b>Улаанбаатар</b>	64,229.9	151,467.3	208,528.9	289,146.9	108,100.0

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2020

59.Орлогын дотоод эх үүсвэрээс бүрдүүлсэн орон нутгийн захиргааны санхүүгийн эх үүсвэрийн хувь (Percentage of the local/sub-national government's financial resources generated from endogenous (internal) sources of revenue)

#### Хүснэгт. Улсын нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн орлого, (зарлагын эзлэх хувь, 2017-2020 оноор)

Хэмжих нэгж: тэрбум.төг

	Үзүүлэлт	Тэнцвэржүүлсэн орлого
<b>2017</b>	Нэгдсэн төсөв	7,274.9
	Орон нутгийн төсөв	2,437.2
	Хувь	33.5
<b>2018</b>	Нэгдсэн төсөв	9,225.9
	Орон нутгийн төсөв	2,769.4

	Хувь	30.0
2019	Нэгдсэн төсөв	10,905.5
	Орон нутгийн төсөв	2,947.6
	Хувь	27.0
2020	Нэгдсэн төсөв	9,421.6
	Орон нутгийн төсөв	3,146.8
	Хувь	33.4

Эх сурвалж: <https://www.1212.mn>

### 2.1.2. Хот байгуулалтын бодлогыг санхүүгийн механизм, төсөвтэй уялдуулах

59. Орлогын дотоод эх үүсвэрээс бүрдүүлсэн орон нутгийн захиргааны санхүүгийн эх үүсвэрийн хувь (Percentage of the local / sub-national government's financial resources generated from endogenous (internal) sources of revenue)

#### Хүснэгт. Улсын нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн орлого, (зарлагын эзлэх хувь, 2017-2020 оноор)

Хэмжих нэгж: тэрбум.төг

	Үзүүлэлт	Тэнцвэржүүлсэн орлого
2017	Нэгдсэн төсөв	7,274.9
	Орон нутгийн төсөв	2,437.2
	Хувь	33.5
2018	Нэгдсэн төсөв	9,225.9
	Орон нутгийн төсөв	2,769.4
	Хувь	30.0
2019	Нэгдсэн төсөв	10,905.5
	Орон нутгийн төсөв	2,947.6
	Хувь	27.0
2020	Нэгдсэн төсөв	9,421.6
	Орон нутгийн төсөв	3,146.8
	Хувь	33.4

Эх сурвалж: <https://www.1212.mn>

### 2.1.3. Засгийн газар хот байгуулалтын бодлогоо хэрэгжүүлэх боломжийг өргөтгөсөн хууль эрх зүйн болон бодлогын хүрээг хөгжүүлэх

60. Хуулийн чанар (Quality of law)

2015 онд УИХ-аас шинэчлэн баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн зорилго нь хууль, УИХ-ын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд оршино. Тус хуульд зааснаар хууль тогтоомжийн төслийг Засгийн газраас баталсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал; хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал; үр нөлөөг үнэлэх аргачлал; хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал; хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал; хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу боловсруулж, хууль тогтоомжийн

төслийн хэлэлцүүлгийг зохион байгуулан олон нийтийн саналыг авч тусгаснаар хууль тогтоомжийн чанарыг сайжруулж байна.

### 2.1.5. Хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд нас болон жендерийн асуудлыг тооцсон, оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлэх

16. Хот төлөвлөлт, зохион байгуулалтанд иргэний нийгмийн тогтмол ардчилсан оролцоо бүхий бүтэцтэй хотуудын эзлэх хувь (Proportion of cities with a direct participation structure of civil society in urban planning and management that operate regularly and democratic)

Хот төлөвлөлт, зохион байгуулалтанд иргэний нийгмийн тогтмол ардчилсан оролцоо бүхий бүтэцтэй хотуудын эзлэх хувь 100 хувьтай байна. (Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс)

### 2.1.6. Шийдвэр гаргалтын бүхий л талбар болон түвшинд эмэгтэйчүүдийн бүрэн оролцоог хангах

24. Төрийн байгууллагууд (үндэсний болон орон нутгийн хууль тогтоох байгууллага, төрийн алба, шүүх эрх мэдлийн байгууллага) дахь албан тушаалын эзлэх хувь (хүйс, нас, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүн амын бүлгээр) улсын хэмжээтэй харьцуулахад (Proportions of positions (by sex, age, persons with disabilities and population groups) in public institutions (national and local legislatures, public service, and judiciary) compared to national distributions)

Хүснэгт. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэйчүүд

Сонгуулийн жил	Нийт нэр дэвшигчдийн тоо	Нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо, хувь		Сонгогдсон эмэгтэйчүүдийн тоо, хувь	
1992	293	-	-	3	3.9%
1996	302	-	-	8	10.5%
2000	602	-	-	9	11.8%
2004	244	40	16,3%	5	6.6%
2008	356	66	18,5%	3	3.9%
2012	544	174	32.0%	11	14.5%
2016	498	129	26.0%	13	17.1%
2020	606	151	24.9%	13	17.1%

Эх сурвалж: Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороо. 2020 он

Хүснэгт. ИТХ-ын 2016-2020 оны сонгуулийн дүн, хүйсээр

	2016		2020	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
Нийслэл	77.7%	22.3%	82.3%	17.7%
Дүүрэг	71.4%	28.6%	70.7%	29.3%
Аймаг	84%	16.0%	84.4%	15.6%
Сум	71.5%	28.5%	71.4%	28.6%

Эх сурвалж: ЖҮХ-ны мэдээлэл. 2020 он



Хүснэгт. Төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа (Эмэгтэй : Эрэгтэй )

Он	Бүгд	Тоо	Хувь
2010	155679	88,690 : 66,989	57 : 43
2011	161612	96,014 : 65,598	59 : 41
2012	162769	97,971 : 64,798	60 : 40
2013	169448	101,330 : 68,118	60 : 40
2014	183601	108,545 : 75,056	59 : 41
2015	186458	110,775 : 75,683	59 : 41
2016	188974	112,269 : 76,705	60 : 40
2017	192475	115,293 : 77,182	60 : 40
2018	193557	116,908 : 76,649	60 : 40
2019	198463	120,864 : 77,599	61 : 39

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл

## 2.2.ХОТЫН ОРОН ЗАЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИЦУУЛАЛТ

### 2.2.1.Газар нутгийг нэгдсэн бөгөөд тэнцвэртэй хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх

20. Танай улс (а) хүн амын динамикийг тооцсон, (б) нутаг дэвсгэрийн тэнцвэртэй хөгжлийг хангах,(в) орон нутгийн санхүүг нэмэгдүүлэх Үндэсний хот байгуулалтын бодлого эсвэл бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөтэй юу? (Does your country have a National Urban Policy or Regional Development Plan that (a) responds to population dynamics, (b) ensures balanced territorial development, and (c) increase in local fiscal space.)

2001 онд УИХ-аас “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, түүний дагуу Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги”, “Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлсэн. Улмаар бүсчилсэн хөгжилд тэргүүлэх үүрэг бүхий хотжилтыг дэмжих зорилгоор эдийн засгийн 4 бүс тус бүрд 2 тулгуур төв хотыг сонгон, тэдгээрийг түлхүү хөгжүүлэхээр тогтсон. Бүсчилсэн хөгжилтэй холбоотой эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2015 оноор дууссан бөгөөд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бодлогыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор эдийн засгийн шинэ бүсчлэлийг тогтоохоор ажиллаж байна. Түүнчлэн, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байгалийн нөхцөл, нөөц, экологийн тэнцвэрт байдал, хот байгуулалтын сөрөг үр дагаварт иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн үндсэн сүлжээний үйлчлэлийн зохистой хүрээнд тулгуурласан бүс нутгийн оновчтой бүтэц, хот, тосгоны тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийг боловсруулж байна.

43.Орон сууц, нийтийн тохижилтод зориулсан улсын төсвийн зардлын хувь (Percentage of government expenditure dedicated to housing and community amenities)

### Хүснэгт. Орон сууцтай холбоотой ажилд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, хувь (2018-2020)

Хэмжих нэгж: төгрөг

Хугацаа	Орон сууцтай холбоотой ажилд зориулсан хөрөнгө	БХБСайдын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт гүйцэтгэл	Эзлэх хувь, %
2018	23,009.500.000.0	67,408.352.272.0	34.13

<b>2019</b>	19,084.574.447.0	138,491.617.718.0	13.78
<b>2020</b>	14,832.280.802.0	138,491.617.718.0	10.71
<b>НИЙТ ДҮН</b>	<b>56,926.355.249.0</b>	<b>344,391.587.708.0</b>	<b>19.54</b>

Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс

62. Төлөвлөлт, зураг төсөл нь оршин суугчдад нээлттэй (онлайн) болон ямар ч үед зөвлөлдөх боломжтой улс, орон нутаг, хотуудын тоо (Number of countries, regional governments and cities in which plans and designs are publicly accessible to residents (online) and can be consulted at all times)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

### **2.2.2.Хот байгуулалтын баримт бичигт орон сууцыг нэгтгэн авч үзэх**

13.Борчуудын хороолол, албан бус суурьшлын бүс эсвэл үйлчилгээгүй сууцанд амьдарч буй хотын хүн амын эзлэх хувь (Proportion of urban population living in slums, informal settlements or inadequate housing)

2020 оны байдлаар гэр хороолол, албан бус суурьшлын бүс эсвэл үйлчилгээгүй сууцанд амьдарч буй хот, суурин газрын хүн ам улсын нийт амын 38.2 хувийг эзэлж байна.(Эх сурвалж:<https://1212.mn/>)

41.Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөндөө орон сууцжуулах бодлого, зохицуулалтыг тусгасан хотуудын хувь (Percentage of cities that have integrated housing policies and regulations in their local development plans)

Орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөндөө орон сууцжуулах бодлого, зохицуулалтыг тусгасан хотуудын хувь 100%-тай байна. (Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс)

42.Орон сууцанд оруулсан нийт хөрөнгө оруулалт (хот, суурин газрын албан ба албан бус салбарт) дотоодын нийт бүтээгдэхүүний хувиар (Total investment in housing (in both formal and informal sectors in the urban area), as a percentage of gross domestic product )

2020 оны байдлаар барилгын салбар ДНБ-д 4.2 хувийг, хөрөнгийн үйлчилгээ ДНБ-д 5.4 хувийг тус тус эзэлж байна. (Эх сурвалж: БХБЯ, Орон сууц, санхүүжилтийн хэлтэс)

43.Орон сууц, нийтийн тохижилтод зориулсан улсын төсвийн зардлын хувь (Percentage of government expenditure dedicated to housing and community amenities)

### **2.2.3.Хот төлөвлөлтөд соёлыг тэргүүлэх бүрдэл хэсэг болгон авч үзэх**

17. Нэг хүнд ногдох соёлын болон байгалийн өвийг хадгалах, хамгаалах чиглэлээр зарцуулсан улсын болон хувийн хөрөнгө, өвийн төрөл, орон нутгийн захиргааны түвшин, зарцуулалтын хэлбэр, хувийн хөрөнгө оруулалтын төрөл (Total expenditure (public and private) per capita spent on the preservation, protection and conservation of all cultural and natural heritage, by type of heritage, level of government, type of expenditure and type of private funding) Эх сурвалж: ҮСХ, Соёл, урлагийн салбарын танилцуулга- 2019 он

ТХЗ-ын Хот, хүн амын суурьшлыг бүх талын оролцоог хангасан, аюулгүй, эрсдэлийг даван туулах чадвартай, тогтвортой болгох гэсэн Зорилго 11-ийн шалгуур үзүүлэлтээр 11.4.1 буюу Үндэсний соёл, байгалийн өвийг хадгалах, хамгаалахад зориулагдсан нэг хүнд

ногдох нийт зардлын хэмжээг тооцохоор тодорхойлсон байдаг. Энэхүү үзүүлэлтийг тооцох зардлын төрөлд улсын болон хувийн зардлын эх үүсвэр, түүний дотор орон нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хийсэн хөрөнгө оруулалтыг дангаар нь эсвэл иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран хийсэн хөрөнгө оруулалтуудыг тус бүр нэгтгэн оруулж ойлгоно гэж заасан байдаг.

ТХЗ-ын 11.4.1 дүгээр үзүүлэлтийг 2019 оны байдлаар тооцсон дэлхийн 59 улс, орнуудын үр дүнгээс харахад ихэнх улс орнуудад энэхүү үзүүлэлтийг тооцох зардлын талаарх мэдээлэл байгаа хэдий ч үзүүлэлтийг тооцон гаргах боломжтой нарийвчилсан өгөгдлийн хэмжээ, мэдээллийн эх үүсвэр маш их ялгаатай, цаашлаад өв, соёлын хувийн зардлын талаарх мэдээллийг цуглуулах, нэгтгэн авах боломж хязгаарлагдмал байна.


Судалгаанд хамрагдсан улс, орнуудын үр дүнгээс харахад 71.0 хувь нь нийгмийн өвийн зардлын мэдээллийн нэг эх үүсвэртэй буюу хувийн байгууллагуудын өв, соёлыг хамгаалахад зарцуулж буй зардлын мэдээллийг авах боломжгүй байна. Харин зөвхөн 29.0 хувь нь хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудаас өв, соёлыг хамгаалахад зарцуулж буй зардлын мэдээллийг авах эх үүсвэртэй байгаагаа дурдсан байна.

ҮСХ-ноос салбар бүрийн албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны статистикийн мэдээллийг ашиглан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг тооцон гаргадаг.

Соёл, урлагийн байгууллагуудын орлого, зарлагын мэдээллийг нэгтгэн гаргах багц үзүүлэлтүүдийг 2018 онд шинэчлэн батлагдсан албан ёсны статистикийн мэдээний маягтуудад тусгасан нь дээрх үзүүлэлтийг тооцох мэдээллийн эх үүсвэр болсон байна.

Энэхүү үзүүлэлтийг хариуцан тооцож гаргах байгууллага нь Соёлын яам (хуучнаар БСШУСЯ) бөгөөд тус үзүүлэлтийг тооцохдоо соёлын салбарын арга хэмжээний зардлын ангилалд түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалахад зарцуулсан төсөв болон Дэлхийн өв, Орхоны соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргааны байгууллагын төсвүүдийн нийлбэрийг ҮСХ-ны жилийн суурин хүн амын тоотой харьцуулсан байна.

**График. Нэг хүнд ногдох үндэсний соёл, байгалийн өвийг хадгалах, хамгаалахад зориулагдсан зардал, (мян.төг)**



Эх сурвалж: БСШУСЯ-ны тооцоолол

Манай улсын хувьд дээрх үзүүлэлтийн сүүлийн 5 жилийн үр дүнгээс харахад, үндэсний соёл, байгалийн өвийг хадгалах, хамгаалахад зориулагдсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээ 2015 оноос хойш өсөж байсан хэдий ч 2019 онд буурч 154.5 мянган төгрөг болж, 2017 онтой харьцуулахад 47.4 (23.5%) мянган төгрөгөөр буурсан байна.

## 2.2.4. Хотын нутаг дэвсгэрийн тэлэлт, суурьшуулалт, шинэчлэл, дахин төлөвлөлтийг сайтар төлөвлөн хэрэгжүүлэх


### 28 Хүн амын нягтрал (Population density)

2020 оны байдлаар нийслэл Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хүн амын нягтрал 1 км<sup>2</sup>-д 4260 хүн байна. 21 аймгийн төв хотуудын хүн амын нягтралыг доорх зурагт үзүүлэв.

### 29. Газрын холимог ашиглалт (Land-use mix)

Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 13 дугаар зүйлд “хот, тосгоны нутаг дэвсгэрт дараах бүсчлэлийг хот байгуулалтын норм, дүрэм, журмын дагуу төлөвлөж тогтооно” гэж заасан. Үүнд: 1. орон сууц, олон нийтийн бүс; 2. үйлдвэрлэлийн бүс; 3. инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн бүс; 4. ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс; 5. хөдөө аж ахуйн бүс; 6. зуслангийн бүс; 7. тусгай зориулалтын бүс. Үүний дагуу тухайлбал, орон сууц, олон нийтийн бүс, үйлдвэрлэлийн бүс зэрэгцээ байрлаж, газрыг холимог байдлаар ашиглаж байна.

График. Аймгийн төв хотуудын хүн амын нягтрал, 1 км<sup>2</sup>-д ногдох хүний тоо, (2020 он)



Эх сурвалж: <https://www.1212.mn>

“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн хүрээнд “Шинэ Зуунмод” хот (2040-35000), Зуунмод дагуул хот (2040-100000), “Шинэ Хархорин” (2040-100000), 21 аймгийн төвийн тэлэлтэд тусгасан шинэ суурьшлын бүсэд (2040-150000) нийт 385000 хүн шинээр суурьшихаар төлөвлөсөн бөгөөд энэ нь улсын нийт хүн амын 11 хувийг, хот, суурин газрын нийт хүн амын 15 хувийг тус тус эзэлж байна. (Эх сурвалж: БХБЯ, БХТ, 2022, “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн Эцсийн тайлан-1)

## **2.2.5.Засгийн газрын бүхий л түвшинд хот төлөвлөлт, зураг төслийн чадавхыг сайжруулж, хот төлөвлөгчдийг сургах**

64. 100,000 хүнд ногдох хот төлөвлөгчдийн тоо (Number of urban planners per 100,000 persons)

Манай улсад 2020 оны байдлаар хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын тоо 110 болсон бөгөөд нийт 1036 хүн ажиллаж байна. 3.3 сая хүн амтай манай улсын хувьд 100 мянган хүнд 31 хот төлөвлөгч ногдож байна.

### **2.3.ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ**

#### **2.3.1.Санхүүгийн эх үүсвэрийг дайчлах**

##### **2.3.1.2.Санхүүжилтэд дотоод эх үүсвэрийг дайчилж, бүс нутгийн болон орон нутгийн захиргааны орлогын суурийг өргөтгөх**

58.Тэргүүлэх чиглэлийг шийдэж төсөв хуваарилах орон нутгийн захиргааны эрхийн хувь (санхүүгийн бие даасан байдал) (Percentage of the total budget that the local / sub-national government have discretion over to decide on priorities (financial autonomy))

2019, 2020 онд нийслэл Улаанбаатар хотоос гадна Орхон, Дорноговь, Дорнод, Дархан-Уул, Өмнөговь аймаг өөрийн орлогоороо зарлагаа нөхөж, санхүүгийн дэмжлэг авахгүйгээр бие даан хөгжиж байна.

#### **Хүснэгт. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, (аймаг, нийслэлээр, 2016-2020 оноор)**

Хэмжих нэгж: сая.төг

<b>Аймаг, нийслэл</b>	<b>2016</b>	<b>2017</b>	<b>2018</b>	<b>2019</b>	<b>2020</b>
<b>БҮГД</b>	90,681.2	195,414.8	289,228.4	368,270.3	175,344.6
<b>Хангайн бүс</b>	9,702.6	13,683.7	12,016.8	16,300.9	29,220.1
<b>Булган</b>	-	290.4	-	-	-
<b>Орхон</b>	9,702.6	13,393.2	12,016.8	16,300.9	29,220.1
<b>Төвийн бүс</b>	16,748.7	30,263.9	68,682.7	61,135.7	37,824.8
<b>Говьсүмбэр</b>	-	155.2	-	-	-
<b>Дархан-Уул</b>	-	270.3	458.9	3,010.2	1,824.1
<b>Дорноговь</b>	-	600.0	2,124.1	124.1	-
<b>Өмнөговь</b>	16,748.7	29,238.4	66,099.7	58,001.4	36,000.7
<b>Зүүн бүс</b>	-	-	-	1,686.8	199.7
<b>Дорнод</b>	-	-	-	1,686.8	199.7
<b>Улаанбаатар</b>	64,229.9	151,467.3	208,528.9	289,146.9	108,100.0

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2020

59. Орлогын дотоод эх үүсвэрээс бүрдүүлсэн орон нутгийн захиргааны санхүүгийн эх үүсвэрийн хувь (Percentage of the local / sub-national government's financial resources generated from endogenous (internal) sources of revenue)

**Хүснэгт. Улсын нэгдсэн төсөвт орон нутгийн төсвийн эзлэх хувь (2017-2020 оноор)**

Хэмжих нэгж: тэрбум.төг

Үзүүлэлт		Тэнцвэржүүлсэн орлого
2017	Нэгдсэн төсөв	7,274.9
	Орон нутгийн төсөв	2,437.2
	Хувь	33.5
2018	Нэгдсэн төсөв	9,225.9
	Орон нутгийн төсөв	2,769.4
	Хувь	30.0
2019	Нэгдсэн төсөв	10,905.5
	Орон нутгийн төсөв	2,947.6
	Хувь	27.0
2020	Нэгдсэн төсөв	9,421.6
	Орон нутгийн төсөв	3,146.8
	Хувь	33.4

Эх сурвалж: <https://www.1212.mn>

**2.3.1.3. Санхүүжилтийн эх үүсвэрийг Засгийн газраас бүс болон орон нутаг руу хэрэгцээ, эрэмбэ болон зориулалтад үндэслэн шилжүүлдэг найдвартай, тогтвортой тогтолцоог бүрдүүлэх**

66. Сүүлийн 5 жилд улсаас авдаг орон нутгийн төсвийн хэмжээ онцын өөрчлөлтгүй (10 гаруй хувиас бага өөрчлөлттэй) (Stable existence of "transfer formula" in the last 5 years, without major changes, meaning reductions of more than 10%)

**Хүснэгт. Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг болон бусад шилжүүлэг (2016-2020 оноор)**

Хэмжих нэгж: сая.төг

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	150,987.3	146,162.0	180,700.9	161,002.2	201,721.3
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	995,259.3	1,066,089.4	1,119,094.6	1,140,457.1	1,333,947.9
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	120,267.7	53,013.5	88,555.0	138,644.6	165,671.8
Тусламжийн орлогын дүн	1,266,514.3	1,265,264.9	1,388,350.5	1,440,103.9	1,701,341.0
<b>Өсөлт, бууралт -; + (хувь)</b>	<b>-5.9</b>	<b>-2.7</b>	<b>23.6</b>	<b>-10.9</b>	<b>24.7</b>

Эх сурвалж: <https://www.1212.mn>

#### **2.3.1.4.Хотжилтын санхүүжилтэд санхүүгийн зуучлалыг (олон талт хамтын ажиллагааны байгууллагууд, бүс нутгийн хөгжлийн банкууд, бүсийн болон орон нутгийг хөгжүүлэх сангууд; төвлөрсөн санхүүжилтийн механизм гэх мэт.) бий болгож ашиглах**

67. Орон нутагт дор хаяж нэг хотын санхүү эсвэл дэд бүтцийн сан байгаа эсэх (Existence of at least one municipal finance or infrastructure fund available for local governments)

Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу ОНХНС-гаас аймаг, нийслэлийн ОНХС-д дээрх үүсвэрээс тус тус тооцон орлогын шилжүүлэг олгож байна (Хүснэгт 23-г үзнэ үү). ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн 59 болон 60 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу тус сангийн хөрөнгийг аймаг, нийслэл, сум, дүүрэгт жил бүр хуваарилж байна.

68. Олон талт институцүүд, бүс нутгийн хөгжлийн банкууд, дэд болон орон нутгийн хөгжлийн сан, эсвэл нэгдсэн санхүүжилтийн механизм зэрэг санхүүгийн зуучлагчдаас бүрдүүлсэн орон нутгийн засгийн газрын санхүүгийн эх үүсвэрийн хувь (Percentage of local/sub-national government’s financial resources generated from financial intermediaries such as multilateral institutions, regional development banks, subnational and local development funds, or pooled financing mechanisms)

ДБ, Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр 2015 оноос “Тогтвортой амьжиргаа-3 төсөл”-ийг Монголын хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, түүнд засаглал болон иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготойгоор хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд 2017-2019 онд 6.2 тэрбум төгрөгийн урамшуулал, 2018-2019 онд 26.9 тэрбум төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн байна. Мөн ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, сумдын орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор тус төслөөс нийт 330 суманд 10.6 тэрбум төгрөгийн ерөнхий дэмжлэгийг олгосон ба сүүлийн 3 жилд сумдын засаглалын түвшинг жилийн гүйцэтгэлээр үнэлэн, болзол хангасан сумдад ОНХС-гийн 25 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгож байна.


#### **2.3.2.Чадавхийг бэхжүүлэх, ахисан түвшинд мэдлэг солилцох**

##### **2.3.2.1.Хотууд хоорондын хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлж хотжилтын шийдэл, харилцан суралцах явдалд дэмжлэг үзүүлэх**

69. Хот хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөрт хамрагдсан хотуудын тоо (Number of cities participating in city-to-city partnership programmes)

Олон улсын “Эрүүл хотуудын холбоо”, СИТИНЕТ ОУБ, дэлхийн Ухаалаг хотуудын холбоо, Тогтвортой хөгжлийн төлөөх орон нутгийн захиргаадын холбоо, Тамхигүй хотуудын холбоо зэрэг хотуудын хамтын ажиллагааг дэмжсэн олон улсын байгууллагуудад нийслэл Улаанбаатар хот, бусад томоохон хотууд, аймаг, сумдууд элсэн, хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна.

График. Монгол Улс 2018 - 2020 онд байгуулсан, хянасан, бүртгэсэн хот, байгууллага хоорондын хамтын ажиллагааны гэрээ



Эх сурвалж: ГХЯ, Монгол Улсын Гадаад бодлогын “Хөх ном”, 2017-2020

### 2.3.2.7. Бүс, орон нутгийн захиргааны санхүүгийн төлөвлөлт ба менежментийг бэхжүүлэх чиглэлээр чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

74. Санхүүгийн төлөвлөлт, менежментийн чиглэлээр сургалтанд хамрагдсан хот, орон нутгийн ажилтнуудын хувь (Percentage of cities/subnational staff trained in financial planning and management)

Энэхүү шалгуур үзүүлэлтийн талаар статистик мэдээлэл байхгүй тул гаргах боломжгүй.

### 2.3.3. Мэдээллийн Технологи ба Инноваци

#### 2.3.3.5. Засгийн газрын бүхий л түвшинд болон иргэний нийгмийн байгууллагын тоон мэдээлэл цуглуулах, ялган ангилах, дүн шинжилгээ хийх явцыг бэхжүүлэх

25. 100 хүн амд ногдох интернетийн үйлчилгээ, хурдаар (Fixed Internet broadband subscriptions per 100 inhabitants, by speed)

Хүснэгт. Интернет хэрэглэгчийн тоо, хурдаар (2020 оноор)

№	Хурд	Интернет хэрэглэгчийн тоо
1	10 Mbit/s дээш	250419
2	5-10 Mbit/s	20100
3	2 Mbit/s-5 Mbit/s	97858
4	1-2 Mbit/s	9907
5	512-1024 Kbit/s	1294
6	256-512 Kbit/s	146
7	256 Kbit/s	3
	<b>НИЙТ</b>	<b>379727</b>

Эх сурвалж: Харилцаа холбооны Зохицуулах хороо (<http://crc.gov.mn/>)



## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### БХБЯ

Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг, 2019 (<https://mcd.gov.mn/a/432>)  
“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн “Нутаг дэвсгэрийн түвшний хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ”, 2020  
“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн “Дундын тайлан”, 2020  
“Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар”, 2021  
“Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл”-ийн эхлэлийн, дунд шатны болон эцсийн тайлан, 2019-2021 (БХБЯ, ҮХГ, ЖАЙКА)  
“Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”-ийн “Эцсийн тайлан-1”, 2022  
“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн БХБЯ-ны 2016, 2017, 2018, 2019, 2020 оны биелэлт  
Барилга, хот байгуулалтын салбарт Жендерийн талаар баримтлах бодлого (2018-2025), 2018  
Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл, 2019  
Барилгын салбарын эрх зүйн актын эмхэтгэл, 2020  
Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн жагсаалт, 2019, БХТ  
Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн жагсаалт, 2020, БХТ  
БХБЯ (<https://mcd.gov.mn/>)

### БОАЖЯ

Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, 2015-2025 он  
Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2017-2018  
Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан, 2019  
Байгаль орчин, уур амьсгалын сан, Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, 2020 он  
(<http://www.ccrcc.mn/stat/file/u/ndcmongolia.pdf>)  
Монгол Улсын Тусгай хамгаалалттай газар (<http://mpa.gov.mn/page/list/10/29/law-page>)  
Цөлжилтийн мэдээллийн сан, 2020 (<https://eic.mn/dldbbase/>)  
БОАЖЯ (<https://met.gov.mn/>)

### ГХЯ

Монгол Улсын Гадаад бодлогын “Хөх ном”, 2017  
Монгол Улсын Гадаад бодлогын “Хөх ном”, 2018  
Монгол Улсын Гадаад бодлогын “Хөх ном”, 2019  
Монгол Улсын Гадаад бодлогын “Хөх ном”, 2020  
ГХЯ (<https://mfa.gov.mn/>)

### ГЗБГЗЗГ

Газрын нэгдмэл сангийн 2017 оны Улсын нэгдсэн тайлан  
Газрын нэгдмэл сангийн 2018 оны Улсын нэгдсэн тайлан  
Хот, суурины газрын ногоон байгууламжийн судалгаа”, 2018  
“Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”, 2018  
Газрын нэгдмэл сангийн 2019 оны Улсын нэгдсэн тайлан  
Газрын нэгдмэл сангийн 2020 оны Улсын нэгдсэн тайлан  
Газрын харилцааны шинэтгэлийн явц, үр дүн, 2016-2020  
Газрын нэгдмэл сангийн ангилал  
“2010 оноос хойш батлагдсан аймаг, сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дүгнэлт гаргаж, цаашид авах арга хэмжээний санал”, 2018  
Үндэсний геопортал (<https://nsdi.gov.mn/>)  
ГЗБГЗЗГ (<https://egazar.gov.mn/>)

### ДАЯН ДЭЛХИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ

“Монгол Улсын ногоон эрчим хүчний систем, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн хөгжил” Даян дэлхийн ногоон хөгжлийн институтийн Монгол Улсын эрчим хүчний салбарт хэрэгжүүлсэн онцлох үйл ажиллагаа, хөтөлбөрийн үр дүнгийн хураангуй, 2020 ([https://gggi.org/site/assets/uploads/2021/02/gggi\\_mon2.pdf](https://gggi.org/site/assets/uploads/2021/02/gggi_mon2.pdf))

## **ДЭЛХИЙН БАНК**

Монгол Улсад COVID-19-ийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа, 2021 (<https://www.worldbank.org/mn/country/mongolia/brief/monitoring-covid-19-impacts-on-households-in-mongolia>)

## **ЗТХЯ**

Зам, тээврийн салбарын 2020 оны статистик (<https://mrt.d.gov.mn/i/2599>)

Автотээврийн үндэсний төв (<https://www.transdep.mn/post.php?p=934>)

Засгийн газрын мэдээ сонин, 2019 (<https://ubinfo.mn/read/9731>)

ЗТХЯ (<https://mrt.d.gov.mn/>)

## **МОНГОЛ БАНК**

Монгол банкны Ерөнхийлөгчийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А-295 дугаар тушаал “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”, 2016

“Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”, 2018

Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-392 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”, 2020

Монгол банк (<https://www.mongolbank.mn/>)

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, 2019

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2016, 2017, 2018, 2019, 2020 оны биелэлт

“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017, 2018, 2019, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан

“Түрээсийн орон сууц” хөтөлбөр, 2015

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2016-2025), 2016

“Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, 2016

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017-2021), 2017

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”, 2017

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөр”, 2017

“Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”, 2017

“Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого”, 2018

“Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр, 2018

“Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”, 2019

“Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”, 2019

“150 мянган айл-Орон сууц” үндэсний хөтөлбөр, 2019

“Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”, 2019

“Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”, 2020

Монгол Улсын Засгийн газар (<https://mongolia.gov.mn/>)

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ**

Монгол Улсын хууль тогтоомж (<https://legalinfo.mn/mn/>, <http://forum.parliament.mn/>)

## **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН СҮЛЖЭЭ**

Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг тайлагнах иргэний нийгмийн байгууллагуудын нэгдсэн тайлан, 2019

## **МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ**

Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, МУИС, “Монгол Улсын бизнесийн орчны судалгаа”, 2017, 2020 (<https://www.mongolchamber.mn/>)

## **НЗДТГ**

“Улаанбаатар хотын 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага, 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол хураангуй тайлан”, I- IV боть, 2013

Улаанбаатар хотын эдийн засгийн хөгжлийн стратеги, НЭЗХГ, 2015

“Монгол Улсын нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал- 2017”, Нийслэлийн Статистикийн газар

“Дугуйн зам” дэд хөтөлбөр, 2017

“Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө -2030”, 2019

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт (2020 оны жилийн эцсийн байдлаар)

“Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний үзэл баримтлал, 2020  
(<https://home.uda.ub.gov.mn/>, <https://www.barilga.mn/n/11551/>)  
Нийслэлийн статистикийн газар (<http://ubstat.mn/>)  
Нийслэлийн статистикийн эмхэтгэл, 2017  
Нийслэлийн статистикийн эмхэтгэл, 2018  
Нийслэлийн статистикийн эмхэтгэл, 2019  
Нийслэлийн статистикийн эмхэтгэл, 2020  
Нийслэлийн статистикийн эмхэтгэл, 2021  
НХБХГазар (<https://home.uda.ub.gov.mn/>)  
Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар, 2020 он (<http://www.hia.ub.gov.mn>)  
Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв (<http://www.ubtraffic.mn>)  
“Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ (<https://park.ub.gov.mn/>)  
НЗДТГ (<https://ulaanbaatar.mn/>)

## **НҮБ**

НҮБ-Хабитат-2, Монгол Улсын Хот байгуулалтын тайлан, 2016  
НҮБ-Хабитат-3, “Хотжилтын шинэ хөтөлбөр”, 2016 (<http://habitat3.org/the-new-urban-agenda/>)  
“Хотжилтын шинэ хөтөлбөр”, түүний хэрэгжилтийг тайлагнах аргачлал, 2017  
(<https://www.urbanagendaplatform.org/>)  
“Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн мониторингийн үзүүлэлтүүд  
([https://unhabitat.org/sites/default/files/2020/10/nua-monitoring-framework-and-related-indicators\\_1.pdf](https://unhabitat.org/sites/default/files/2020/10/nua-monitoring-framework-and-related-indicators_1.pdf))  
“Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030” (<https://sustainabledevelopment.un.org/sdgs>)  
ТХЗ 11 Хяналт, үнэлгээний хүрээ (<https://unstats.un.org/sdgs/metadata/>)  
НҮБХХ-ийн “Монгол Улсын төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам” судалгаа, 2019  
НҮБ-ын Хүн амын сан, “Эм Эм Си Жи” ХХК, ЖҮХ, Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ  
НҮБ (<https://mongolia.un.org/mn>)

## **СЯ**

<https://mof.gov.mn/article/entry/surgalt>, 2019  
Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга, 2020  
СЯ (<https://mof.gov.mn/>)

## **УИХ**

“Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого”, 1999  
“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, 2001  
“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, 2010  
“Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2010  
“Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого”, 2014  
Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалт (<https://publicinvestment.gov.mn/>)  
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2016  
“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын 2017-2018 оны болон 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан  
УИХ (<http://www.parliament.mn/>)

## **ҮСХ**

“Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан”, 2017  
Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо, 2017  
Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2017  
Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2018  
Улаанбаатар хотын гадаад орчны агаарын бохирдол ба эрүүл мэнд, 2019  
“Монгол Улсын хөгжил олон улсын түвшинд, харьцуулсан судалгаа”, 2020  
Ажиллах хүчний судалгааны 2020 оны 4 дүгээр улирлын товч танилцуулга  
Төрийн санхүү - 2020 он  
Орлого, хэрэглээний тэгш бус байдал, 2020.  
Хүн ам, орон сууцны тооллого, Эдийн засгийн идэвх  
(<https://1212.mn/BookLibrary.aspx?category=001>)  
Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого  
Ажиллах хүчний судалгааны 2021 оны II улирлын товч танилцуулга, 2021  
([https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=LFS\\_2021Q2.pdf&In=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=LFS_2021Q2.pdf&In=Mn))

Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019  
Хатуу хог хаягдлын данс 2018-2019  
Статистикийн бизнес регистр, 2019, 2020  
([https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=BR\\_introduction2019.pdf&ln=Mn](https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=BR_introduction2019.pdf&ln=Mn))  
Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2020  
Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2021  
ҮСХ, ДБ, 2018. “Ядуурлын дүр төрх”-2018  
ҮСХ, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, 2020. Жендэрийн тэгш бус байдал  
ҮСХ (<https://www.nso.mn/>)  
Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг (<https://montsame.mn/mn/> )

#### **ХБНГУ-ЫН ФРИДРИХ-ЭБЕРТИЙН САН**

КОВИД-19 Бичил бизнес эрхлэгчдэд үзүүлж буй нөлөө, 2020  
(<http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/16946.pdf>)

#### **ХНХЯ**

ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, “Залуучуудын ажилгүйдэл, эдийн засгийн идэвхгүй байдлын судалгаа”, 2017  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх статистик тоо мэдээлэл, 2019 (<https://mlsp.gov.mn/content/detail/1173>)  
ХНХЯ, ЖАЙКА, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, 2020  
(<http://www.rilsp.gov.mn/sudalгаа.php>)  
ХНХЯ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, Нийгмийн халамжийн хөтөлбөрийн хэрэгжилтэд үзүүлэх КОВИД-19 цар тахлын нөлөөллийн шинжилгээ, 2021  
ХНХЯ-ны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Б.Майчимэг, “Ахмадын өдөр тохиож байгаатай холбогдуулан төрөөс ахмад настанд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” ярилцлагаас, 2021 (<https://mlsp.gov.mn/eng/content/detail/1546>)  
ХНХЯ (<https://www.mlsp.gov.mn/>)

#### **ХХААЯ**

Жижиг, дунд үйлдвэрийн танилцуулга (<https://mofa.gov.mn/exp/blog/25/173>)  
Жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын бодлого (<https://mofa.gov.mn/exp/blog/25/224>)  
Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, 2019 (<http://smefund.gov.mn/flipbook/#p=1>)  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (<http://www.rilsp.gov.mn/>)  
ХХААЯ (<https://www.mofa.gov.mn/>)  
Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв  
(<https://ecrc.mn/>, <http://aimagindex.mn/>)

#### **ЭХЯ**

Эрчим хүчний салбарын 2020 оны 12 дугаар сарын үйлдвэрлэлтийн мэдээ  
(<http://www.energy.gov.mn/c/1211>)  
Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2004. “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”  
Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2016. Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого  
ЭХЯ (<http://www.energy.gov.mn/> )

#### **ЭРҮҮЛ ХОТ ХӨТӨЛБӨРИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ТӨВ**

Монгол Улсын Эрүүл хотууд, 2021 ([www.healthycity.weebly.com](http://www.healthycity.weebly.com))

## ҮНДЭСНИЙ ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 87 дугаар тушаалаар байгуулсан “Хотжилтын шинэ хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцын 2017-2020 оны үндэсний тайланг боловсруулахад мэдээлэл, судалгаа, удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсэг:

### Дарга:

1. С. Магнайсүрэн, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга

Дэд дарга:

2. Ц.Баярбат, БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

### Гишүүд:

3. Б.Бямбажав, Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөх,

4. Б.Гүнчинхүү, ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын референт

5. Д.Болормаа, БХБЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч

6. А.Лхамсэржид, БХБЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч

7. Р.Батчимэг, БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

8. Ш.Цэрэндулам, БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга

9. А.Нарангаравуу, БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын мэргэжилтэн

10. Ч.Батболд, БШУЯ-ны Хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

11. Д.Эрдэнэ-Очир, ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын зөвлөх

12. Э.Мөнхнасан, ЗТХЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч

13. Д.Нямхүү, ХНХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч

14. А.Чулуунчимэг, ЭЗХЯ-ны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын мэргэжилтэн

15. Б.Тунгалаг, ЦХХХЯ-ны Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

16. Ч.Артаг, ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын мэргэжилтэн

17. Х.Оюунбаяр, ГЗБГЗЗГ-ын Хот байгуулалтын кадастрын хэлтсийн дарга

18. Б.Одбаатар, ГЗБГЗЗГ-ын Хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

19. А.Амарсанаа, НХБХГ-ын Ерөнхий архитекторын Ажлын албаны мэргэжилтэн

20. С.Давааням, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн дарга

21. Ш.Энхцэцэг, НҮБ-ын Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөрийн Монгол Улс дахь салбарын менежер

22. Э.Дондмаа, хот төлөвлөлтийн зөвлөх архитектор

23. А.Батцэнгэл, МАЭ-ийн дэд ерөнхийлөгч

24. П.Хаш-Эрдэнэ, “Эрүүл хот хөтөлбөрийг чадавхижуулах төв”-ийн менежер

### Нарийн бичгийн дарга:

25. Э.Ариунням, БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч

### Тайланг боловсруулсан Зөвлөх баг:

1. Б.Бямбажав, Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөх, зөвлөх инженер

2. Э.Дондмаа, хот төлөвлөлтийн зөвлөх архитектор
3. М.Гантөмөр, хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч
4. Ц.Тунгалаг, хот төлөвлөлтийн инженер, эдийн засагч
5. П.Энхээ, хот төлөвлөлтийн зөвлөх эдийн засагч

**Боловсруулахад оролцсон:**

1. П.Хаш-Эрдэнэ, “Эрүүл хот хөтөлбөрийг чадавхижуулах төв”-ийн менежер
2. Г.Балжмаа, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын Хүн амын нутагшилт, бүс нутгийн судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
3. С.Ганчимэг, орчуулагч
4. Б.Мөнгөнсаран, орчуулагч
5. Г.Батзаяа, орчуулагч

**Тайланг хэвлэлд бэлтгэсэн:**

Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

**Тайлангийн нүүр хуудасны загварыг бэлтгэсэн:**

Э.Ариунням, БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч

**Зөвлөх багт санхүүгийн дэмжлэг үзүүлсэн НҮБ-ын баг**

НҮБ-ын Хабитатын Монгол Улс дахь салбар

Ш.Энхцэцэг, НҮБ-ын Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөрийн Монгол Улс дахь салбарын менежер